

СТРАТЕГИЙН

THE MONGOLIAN JOURNAL OF STRATEGIC STUDIES

№83 /2022/

СУДАЛГАА

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Дарга

Б.Даваадорж
ССХ-ийн Захирал, профессор

Ерөнхий редактор

доктор Ж.Мэндээ
ССХ-ийн Дэд захирал, Эрдэмтэн нарийн
бичгийн дарга

Гишүүд

доктор, профессор З.Болдбаатар
доктор Э.Энхмаа
доктор Б.Отгонсүрэн
доктор Ц.Минжин
Н.Энхбаяр
Н.Соёлгэрэл

Нарийн бичгийн дарга

С.Буянхишиг

Редакцын хаяг:

Самбуугийн гудамж 11,
Засгийн газрын-11, 8 давхар
Утас: (976-51)264000
Факс: (976-11)324055

Шуудангийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар
Төв шуудан- 870

Захиалгын индекс:

200952

EDITOR'S BOARD

Editor in Chief

B.Davaadorj
Director Prof, ISS

Executive Editor

J.Mendee Dr.
Deputy Director and Dean, ISS

Members

Z.Boldbaatar Dr. Prof
E.Enkhmaa Dr.
B.Otgonsuren Dr.
Ts.Minjin Dr.
N.Enkhbayar
N.Soyolgerel

Secretary

S.Buyankhishig

Board Address:

8th floor, Government Building-11,
Sambuu Str. 11
Tel: (976-51)264000
Fax: (976-11)324055

Postal Address:

Central Post Office 870
Ulaanbaatar

Subscription index:

200952

Цахим хуудас: www.iss.gov.mn

Зохиогчийн эрх: @ Стратеги судалгааны хүрээлэн, 2022

Сэтгүүлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

Дугаар эрхэлсэн: Эдийн засгийн аюулгүй байдлын судалгааны төв

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Н.Энхбаяр

Дэлхийн эдийн засгийн төлөв:
Геополитикийн нөхцөл байдал, Монгол
Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

доктор Д.Ган-Очир

Эдийн засгийн аюулгүй байдлын
шинжилгээнд анхаарах асуудал: Онол
арга зүй

Э.Энхтайван

БНХАУ-ын 2022 оны эдийн засгийн
төлөв ба коксжих нүүрс, зэсийн эрэлт

Д.Батмөнх

Олон улсын худалдааны өнөөгийн
байдал, болзошгүй эрсдэлүүд

Ч.Цэцэгмаа

Түнш орнуудын импортын тарифын
бус зохицуулалт ба эдийн засгийн
аюулгүй байдал

П.Энхболор

Монгол Улсын эрчим хүчний
системд WAMPAC нэвтрүүлсэн
туршлага, аюулгүй байдлыг хангах арга
зам болох нь

Ш.Гантуяа

Үндэсний аюулгүй байдлыг
хөрөнгө оруулалтын бодлогоор хангах
онол арга зүйн асуудал

ГАДААД БОДЛОГО АЮУЛГҮЙ БАЙДАЛ

доктор, профессор З.Болдбаатар

Батлан хамгаалах эдийн засгийн
чадамжийг бэхжүүлэх боломж

CONTENT

ECONOMIC SECURITY

N.Enkhbayar

4 Global Economic Outlook, Geopolitics
Situation and it's Spillover Effects
for Mongolia

D.Gan-Ochir Sc.D

18 The State of Mongolia
Economic Security

E.Enkhtaivan

35 China's 2022 Economic Outlook: Coking
Coal and Copper Demand

D.Batmunkh

46 Current Situation of the International
Trade and its Risks

Ch.Tsetsegmaa

56 Non-Tariff Measures by Partner Countries
and Economic Security Issues

P.Enkhbolor

64 Energy Security Issues
of Mongolia

Sh.Gantuya

73 Impact Analysis on Investment Policy
to Provide National Security

EXTERNAL SECURITY

Z.Boldbaatar Dr. Prof

80 Strengthening Economic Potential
of the Defense

доктор Д.Дагийсүрэн	D.Dagiisuren Dr.
БНХАУ-ын ӨМӨЗО-ны XIV таван жилийн төлөвлөгөө ба Монгол Улсын шинэ сэргэлтийн бодлого	89 14th Five-Year Plan of Inner Mongolia, (P.R.China) and New Revival Policy of Mongolia
доктор Д.Эрдэнэцогт	D.Erdenetsogt Dr.
Мэдээллийн дайны асуудал	100 Information War
доктор Т.Мөнх-Оргил	T.Munkh-Orgil Dr.
Евразийн Эдийн Засгийн Холбоо, Монгол Улсын байр суурь	109 Eurasian Economic Union and Mongolia
З.Болор	Z.Bolor
Хагас дамжуулагчийн нийлүүлэлтийн аюулгүй байдал ба геополитикийн ач холбогдол	124 The Geopolitical Importance of Semiconductors and its Supply Chain
ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛ	INTERNAL SECURITY
доктор, профессор Ц.Даваадорж Д.Энхсайхан	Ts.Davaadorj Dr.Prof D.Enkhsaihan
Үндсэн хуульт байгууллын талаарх ойлголт, түүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд	131 The Constitutional Establishment and Negative Risks
доктор Д.Энхмаа	D.Enkhmaa Dr.
Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүнгээс	142 Evaluation of the Consequences of Law on Food Implementation
доктор Н.Удвал	N.Udval Sc.D
Монгол Улсын хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийн харьцуулсан судалгаа ба аюулын дүн шинжилгээ	154 Comparative Study and Threat Analysis on Human Security General Dimensions of Mongolia
Х.Номинболор	Kh.Nominbolor
Улаанбаатар хотын агаарын бохирдол, түүнийг бууруулах арга зам	171 Ways to Reduce Air Pollution in Ulaanbaatar City

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ 185 MEETING DOCUMENTS

ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Н.ЭНХБАЯР

ҮАБЗ-ийн ССХ-ийн

ЭЗАБСТ-ийн дарга

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ: ГЕОПОЛИТИКИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Abstract: Over the past two years, the spread of covid 19 has caused many challenges to the global economy and slowed growth.

International banks and financial institutions have been relatively optimistic about this year, but regional and global economies are facing new challenges due to unforeseen circumstances in the international geopolitical arena.

Russia's and Ukraine's economies are at risk of a slowdown this year due to disruptions in international commodity markets and trade networks, as well as Western economic sanctions against Russia.

This article discusses how the risks and consequences of these developments in these countries, which have extensive trade relations with Mongolia, could affect the Mongolian economy.

Keywords: economic growth, international trade, economic sanctions, geopolitics, spillover effect

Оршил

Өнгөрсөн хоёр жилд үргэлжилсэн ковидын халдварын тархалтын улмаас дэлхийн эдийн засагт олон талын хүндрэл бэрхшээл учирч, өсөлт саарч ирсэн.

Энэ оны тухайд Олон улсын банк санхүүгийн байгууллагууд харьцангуй өөдрөг байхаар төсөөллөө боловсруулан гаргаж ирсэн боловч олон улсын геополитикийн тавцанд үүсээд байгаа гэнэтийн хүчин зүйлийн улмаас бүс нутгийн болон дэлхийн эдийн засагт дахин шинэ бэрхшээл, хүндрэл тулгарч байна.

Олон улсын түүхий эдийн зах зээл, худалдааны сүлжээнд бий болж буй доголдол, өрнөдийн орнуудын зүгээс ОХУ-ын эсрэг тогтоож буй эдийн засгийн хориг арга хэмжээний улмаас ОХУ, Украин улсын эдийн засаг энэ онд ихээхэн саарч, хямралд орох эрсдэл үүсэж байна.

Монгол Улстай худалдааны өргөн харилцаатай эдгээр улсад болж буй үйл явцын улмаас үүсэх эрсдэл, хүндрэлийн дагавар нөлөөлөл нь Монгол Улсын эдийн засагт хэрхэн нөлөөлж болох асуудлыг энэхүү өгүүлэлд авч үзсэн.

Нэг. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2021-2022 оны өсөлтийн таамаглал

Дэлхий нийтийг хамарсан ковид цар тахлын улмаас дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч, олон улс орны эдийн засаг буурсан. 2020 оны эцсийн байдлаар дэлхийн эдийн засаг -4.4 хувиар буурсан гэж ОУВС-ийн шинжээчид тооцоолжээ.

Зураг 1. Дэлхийн эдийн засгийн 2021 оны өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Дэлхийн Эдийн засгийн тойм, 2021 оны зургаадугаар сар, ОУВС

Олон улсын банк санхүүгийн томоохон байгууллагууд болох ОУВС, Дэлхийн банк, ЭЗХАБ-ын судлаачид, шинжээчдийн 2021 оны I улиралд боловсруулан гаргасан 2020-2021 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг хэрхэн таамаглаж байсныг дараах хүснэгтээр үзүүлэв.

Зураг 2. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх банк санхүүгийн байгууллагуудын таамаглал



Эх сурвалж: OECD Economic Outlook, March 2021; Organization for Economic Cooperation and Development. March 2021; World Economic Outlook, Update, International Monetary Fund, October 2021; Global Economic Prospects, World Bank Group, January 2021.

Өнгөрсөн 2021 онд олон улсын банк санхүүгийн байгууллагууд, улс орнуудын Төв банк, Засгийн газруудын зүгээс ковидын эсрэг, эдийн засгийг дэмжих олон талын багц арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд улс орнууд, дэлхийн эдийн засгийн өсөлт сэргэж, ОУВС-ын шинжээчдийн таамаглалаар 2021 оны эдийн засгийн өсөлт 5.9, 2022 оны өсөлт 4.4 хувьд тус тус хүрэх боломжтой гэж үзсэн.¹

Зураг 3. Дэлхийн эдийн засгийн 2022 оны өсөлтийн таамаглал



Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн тойм, 2022 оны нэгдүгээр сар

Ковидын нөхцөлд буюу 2020 онд өсөлтэй гарсан цөөн тооны улсын нэг нь БНХАУ бөгөөд тус улсын эдийн засгийн өсөлт 2020 онд 2.8, 2021 онд 8.1 хувьд хүрч тус тус өссөн. БНХАУ-ын гадаад худалдааны нийт эргэлт 2021 онд 6.05 их наяд ам.долларт хүрсэн.

Өнгөрсөн 2021 оны байдлаар БНХАУ-ын гадаад худалдааны таван гол түнш орнуудад ASEAN-ны гишүүн орнууд, АНУ, Европын Холбоо, Япон, Өмнөд Солонгос улс багтаж байна.

Зураг 4. БНХАУ-ын 2021 оны гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: «Глобал таймс» сонин

¹ <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2022/01/25/world-economic-outlook-update-january-2022>

Зураг 5. БНХАУ-ын гадаад худалдааны гол түнш орнууд, бүс нутаг



Эх сурвалж: «Глобал таймс» сонин

Хоёр. Дэлхийн дэг журам ба улс орнууд, эвслийн хооронд үүссэн зөрчил, маргаантай асуудлууд

Дэлхийн II дайн өрнөж байх явцад холбоотон улс орнууд хамтран 1944 оны хавар хуралдаж дайны дараах дэлхийн дэг журам ямар байх, олон улсын худалдаа, төлбөр тооцооны шинэ тогтолцоог хэрхэн бий болгох асуудлыг хэлэлцсэн. Үүний үр дүнд 1944 оны долоодугаар сарын 1-22-ны өдрүүдэд АНУ-ын Нью-Хемпшир мужийн нутаг, Вашингтон ууланд орших Бреттон Вүүдс нэртэй амралтын газарт дэлхийн 44 улс орны төлөөлөгчид цуглан хуралдаж, уг хуралдаанаас Олон улсын банк санхүүгийн шинэ байгууллага болох ОУВС (IMF), Олон Улсын хөрөнгө оруулалт, шинэчлэлийн банкныг (IBRD) байгуулахаар тогтжээ. Энэхүү шийдвэрийн дагуу өнөөгийн Дэлхийн банкны үндсэн нэг бүтэц болох Олон Улсын хөрөнгө оруулалт, шинэчлэлийн банк 1946 оны нэгдүгээр сараас эхлэн үйл ажиллагаа явуулж дэлхийн II дайнд сүйдсэн Европын улс орнуудын эдийн засгийг сэргээн босгох үйл ажиллагаа буюу Маршаллын төлөвлөгөөг санхүүжүүлсэн юм.

Бреттон Вүүдсийн хэлэлцээрээр тогтсон нэг маш чухал шийдвэр бол нэг унц алтыг 35 ам.доллартой тэнцүү байхаар тогтоож, олон улсын төлбөр тооцооны үндсэн хэрэгсэл нь АНУ-ын доллар байна гэдэг асуудал дээр санал нэгджээ. Улмаар 1949 оны дөрөвдүгээр сард Умард Атлантын Цэргийн эвсэл (NATO) байгуулагдсанаар өнөөг хүртэл мөрдөгдөж ирсэн Дэлхийн дэг журам тогтсон гэж олон улсын судлаачид үздэг.

Хүйтэн дайн 1989 онд төгсгөл болж, ЗХУ задарснаар олон улсын харилцаанд харьцангуй тааламжтай уур амьсгал бүрдэж ирсэн. Гэвч энэ нөхцөл байдал удаан үргэлжлэлгүйгээр 2000-аад оноос хойш ОХУ, БНХАУ, Иран зэрэг хөгжиж байгаа зарим улс орон АНУ тэргүүтэй өрнөдийн улс оронтой гадаад бодлого, цэрэг улс төр, хүний эрх, эдийн засаг, худалдааны зэрэг олон асуудлаар зөрчилдөж ирсэн.

Энэ цаг үеэс Дэлхийн Шинэ дэг журам гэдэг ойлголт бий болж, БНХАУ, ОХУ, БНЭУ болон зарим хөгжиж буй улс орны зүгээс “Дэлхийн Шинэ дэг журам”-ыг тогтоох ёстой гэсэн байр суурийг ян бүрийн түвшинд илэрхийлэх болсон.

Улмаар 2001 оны зургаадугаар сард БНХАУ, ОХУ, БНЭУ, Казахстан, Узбекистан, Тажикстан, Киргизстан, Пакистан улс хамтран “Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага”-ыг үүсгэн байгуулсан нь энэхүү Шинэ дэг журам тогтоох ёстой гэсэн үзэл санааг улам дэлгэрүүлж эхэлсэн.


Зураг 6. Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага, гишүүн ба ажиглагч орнууд



Эх сурвалж: <https://www.jagranjosh.com/general-knowledge/shanghai-cooperation-organization-sco-1604471371-1>

Нөгөө талаас Европт хүйтэн дайны төгсгөл болж, хоёр Герман улс нэгдсэний дараа зүүн Европт ч тогтворгүй байдал үргэлжилж тус улс 1991-1992 онд Серби, Хорват, Словени, Умард Македон, Босния Герцоговина гэсэн зургаан тусгаар улс болон задарсан.

Зураг 7. Умард Атлантын Цэргийн эвсэл, түүний өргөжин тэлэлт



Эх сурвалж: https://en.wikipedia.org/wiki/Enlargement_of_NATO

Төв Азид ШХАБ-ыг үүсгэн байгуулж өргөжиж байх явцад Европ тивд Умард Атлантын цэргийн эвсэл хүрээгээ аажмаар өргөжин тэлж, 1999-2020 онд төв ба зүүн Европын 14 улс орныг эгнээндээ нэгтгэсэн юм.

Ийнхүү НАТО зүүн Европ тийш өргөжин тэлсэн үйл явцад ОХУ-ын зүгээс тааламжгүй хандаж байгаагаа удаа дараа илэрхийлж, олон улсын хурал зөвлөгөөнүүдэд үүнтэй санал нийлэхгүй байгааг, НАТО өргөжин тэлж байгаа нь ОХУ-ын ашиг сонирхолд нийцэхгүй байна гэдгийг тодорхой илэрхийлсээр ирсэн.

Гурав. Украинд болж буй үйл явдлын улмаас ОХУ, Украины эдийн засагт учирч буй хүндрэл, бэрхшээл, цаашдын хандлага

Украины нутагт 2022 оны хоёрдугаар сарын 25-ны өдрөөс эхэлсэн байлдааны үйл ажиллагаа сар гаруйн хугацаанд үргэлжилж, олон мянган хүний амь нас үрэгдэж, гэмтэж бэртсэний зэрэгцээ, гуравдугаар сарын 25-ны өдрийн байдлаар тус улсаас 3.6 сая хүн дүрвэн гараад байна.

Дайны улмаас Украины эдийн засаг ихээхэн сүйдэж, хот тосгод нь балгас, нурам болж байна. ОУВС-ын шинжээчдийн энэ сарын эхээр гаргасан тойм судалгаанд өгүүлснээр цаашид үйл явдал хэрхэн өрнөхөөс хамаарч Украин улсын эдийн засаг энэ оны эцэст 30 гаруй хувиар буурч, хямралд орох магадлалтай гэж үзсэн.


Украинд болж буй үйл явдалтай холбоотойгоор АНУ, Канад, Европын Холбоо, Япон, Өмнөд Солонгос, Австрали болон бусад улс орны зүгээс ОХУ-ын эсрэг хэд хэдэн багц хориг арга хэмжээг авч байна.

АНУ болон Их Британи улсын Засгийн газар ОХУ-ын Төв банк, арилжааны банкууд, томоохон компани, батлан хамгаалах салбарын үйлдвэр аж ахуйн газруудыг хамруулсан дараагийн хориг арга хэмжээг тогтоосныг 2022 гуравдугаар сарын 24-ний өдөр зарласан.

ОХУ-ын Төв банкны гадаад орнууд дахь валютын нөөцийг царцаасны зэрэгцээ тус банкны алтны нөөцийг олон улсын түвшинд арилжаалахыг хориглоод байна. Тус улсын банк санхүүгийн байгууллагуудыг олон улсын төлбөр тооцооны системээс хассан, зээлжих зэрэглэлийн Фитч, Мүүдийз, Стандарт энд Пүүрс зэрэг байгууллага ОХУ-ын Засгийн газар, Төв банк, Арилжааны банкууд, томоохон компаниуд, мужууд, хотуудын зээлжих зэрэглэлийг эрс бууруулж хамгийн тааруу дампуурлын түвшинд хүргэн тогтоосон. Энэ бүх хориг арга хэмжээний үр дагавар тус улсын эдийн засаг, санхүүгийн системд хүндээр тусна гэж олон улсын байгууллагууд, судлаачид үзсэн.


ОУВС-ын шинжээчдийн гаргасан тойм таамаглалд нөхцөл байдлаас хамаарч ОХУ-ын эдийн засаг энэ оны эцэст 10-аас дээш хувиар саарч, эдийн засгийн хямралтай нүүр тулах өндөр эрсдэлтэй, тус улсын банк, санхүүгийн байгууллагууд гадаад өр төлбөрийн улмаас дампууралд орох магадлал өндөр байна гэж үзэж байна.

Зураг 8. Нүүрсний экспортын тэргүүлэгч 10 улс




Эх сурвалж: Атлантический Зөвлөл Олон улсын гео-эдийн засгийн судалгааны төв, НҮБХХБ

Зураг 9. Төмрийн хүдрийн экспортын тэргүүлэгч 10 улс




Эх сурвалж: Атлантический Зөвлөл Олон улсын гео-эдийн засгийн судалгааны төв, НҮБХХБ

Зураг 10. Никелийн экспортын тэргүүлэгч 10 улс



Эх сурвалж: Атлантический Зөвлөл Олон улсын гео-эдийн засгийн судалгааны төв, НҮБХХБ

Зураг 11. Хөнгөн цагааны экспортын тэргүүлэгч 10 улс




Эх сурвалж: Атлантический Зөвлөл Олон улсын гео-эдийн засгийн судалгааны төв, НҮБХХБ

Дөрөв. Геополитикийн энэ үйл явцаас улбаалан бүс нутгийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

ОХУ нь дэлхийн зах зээлд газрын тос, шатдаг хий, төмрийн хүдэр, никель, паллади, паладуим, хөнгөн цагаан зэрэг уул уурхайн түүхий эд, улаан буудай, эрдэнэшишийн томоохон нийлүүлэгч байсаар ирсэн тул тус улсын эсрэг тогтоосон хориг, мөн ОХУ-ын Засгийн газраас тогтоосон экспортын хязгаарлалтын улмаас дэлхийн түүхий эдийн зах зээлд хомсдол үүсэж, түүхий эдийн үнэ ханш огцом өссөөр байна.²

Зураг 12. Дэлхийн үр тарианы зах зээлд ОХУ, Украины эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Арабын Шинэчлэл өөрчлөлтийн санаачилга


Өндөр хөгжилтэй орнууд, өрнөдийн орнуудын хувьд ОХУ-аас худалдан авч байсан түүхий эдийн импортыг бууруулж, өөр улсаас худалдан авах боломж гарц байгаа бол хөгжиж байгаа болон бага орлоготой орнуудын хувьд ийнхүү өөр эх үүсвэрээс худалдан авах тээвэрлэлтийн болон санхүүгийн боломж маш бага байна.

ОХУ, Украин улсаас дэлхийн үр тарианы зах зээлд нийлүүлэгдэх байсан үр тариа энэ онд нийлүүлэгдэхгүй байх, ихээхэн хэмжээгээр буурахаар байгаагийн улмаас үр тариа, хүнсний үнэ ханш хурдацтай өсөж, улмаар бага орлоготой Африк, Ойрх Дорнод, Төв Азийн зарим улс орнуудад ядуурал, өлсгөлөн нэмэгдэх эрсдэл маш өндөр байгааг НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас саяхан гаргасан мэдэгдэлд өгүүлсэн³.

² <https://www.arab-reform.net/publication/the-impact-of-the-ukraine-war-on-the-arab-region-food-insecurity-in-an-already-vulnerable-context/>

³ www.fao.org, <https://www.barrons.com/articles/great-resignation-51648145887>

Зураг 13. ОХУ, Украин улсын үр тарианы экспортоос өндөр хамаарал бүхий улс орнууд




Эх сурвалж: НҮБ-ын Хунс, хөдөө аж ахуйн байгууллага

Тав. Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн өсөлтийн таамаглал

Өнгөрсөн намар Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогын төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэн батлах явцад нөхцөл байдал харьцангуй тааламжтай байсан тул 2022 оны Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг Сангийн яам таван орчим хувьд хүрэх, ирэх 2022-2024 оны дундаж өсөлтийг 5.0 орчим хувьд гэсэн өөдрөг таамаглалыг боловсруулсан.

Зураг 14. Монгол Улсын 2022 оны төсвийн бодлого, эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн баримт бичиг

Энэхүү өөдрөг төсөөлөлд үндэслэн 2022 оны улсын төсвийн орлогыг өмнөх оныхоос 2.7 их наяд төгрөгөөр буюу 20 орчим хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Мөн улсын төсвийн зарлагыг ч ихээхэн өөдрөг төсөөлж өмнөх оны төсвөөс 15,3 хувиар нэмэгдүүлж, 18.2 их наяд төгрөгт хүргэхээр тооцож, баталсан.

Төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын хэмжээг ДНБ-ий -5.1 хувь буюу 2.4 их наяд төгрөг байхаар тооцсон. Гэвч бодит байдалд хэд хэдэн хүчин зүйлийн улмаас энэхүү таамаглал биелэгдэх боломжгүй, энэ оны төсвийн орлого тасалдах эрсдэл өндөр болж байна. Үүнд:

- Халдварын тархалт бүрэн намжаагүй, үргэлжилсэн хэвээр байгаа;
- БНХАУ-д Өвлийн Олимпийн наадмыг зохион байгуулсны улмаас хоёр сарын туршид хилийн боомтын үйл ажиллагааг хумьж, экспорт ихээхэн хэмжээгээр тасалдсан;
- Хятад улсын зарим мужид ковидын тархалт үргэлжилж, зарим хотод хөл хорио тогтоох арга хэмжээг одоо ч гэсэн авч байгаа тул тус улс хилийн хуурай боомтуудын үйл ажиллагааг нээхийг яарахгүй байгаа;
- Украинд болж буй үйл явдалтай холбоотой ОХУ эдийн засгийн хоригт орж, зарим нэр төрлийн түүхий эдийн экспортод хязгаарлалт тогтоосон;
- ОХУ-тай хийх улс хоорондын төлбөр тооцоо саатах, тасалдах эрсдэл нэмэгдсэн;
- Эдгээр үйл явдлын улмаас дэлхийн зах зээлд газрын тос, улаан буудай, хүнсний үнэ ханш хурдацтай өсөж байгаа,
- Тээвэр логистикийн тасалдал, хилийн боомтын үйл ажиллагааны тасалдлын улмаас импортоор авч байгаа түүхий эд, бараа, материалын тээвэрлэлтийн зардал өнгөрсөн оноос хойш хурдтай өсөн нэмэгдсээр байгаа зэрэг таагүй хүчин зүйлс нь Монгол Улсын экспортыг бууруулах, импортын өртгийг нэмэгдүүлэх, төсвийн орлогыг тасалдуулах эрсдэлтэй болж байна.

Зураг 15. Монгол Улсын 2022 оны төсвийн орлогын төсөөлөл



Эх сурвалж: Сангийн яам, “Иргэдийн төсөв 2022” товхимол


Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээллээс үзвэл оны эхний хоёр сард улсын инфляц 14.2 хувьд, Улаанбаатар хотын хэмжээнд 15.5 хувьд хүрч байна.

Гадаад худалдаа, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлаас хамааран Монгол банкны мөнгөний бодлогын хороо гуравдугаар сарын 23-24-ний өдрүүдэд хуралдаж Төв банкны бодлогын хүүг 2.5 нэгжээр нэмэгдүүлэн 9.5 хувьд хүргэн тогтоолоо. Гадаад зах зээлийн орчин нөхцөлөөс хамаарч төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэх, инфляц цаашид өсөн нэмэгдэх эрсдэлтэй байгаа нөхцөлд Төв банкны зүгээс ийнхүү бодлогын хүүгээ нэмэгдүүлэх арга хэмжээ авсан нь зөв зүйтэй, цаг үетэй нийцсэн арга хэмжээ юм.

ОХУ нь манай гадаад худалдааны нэг томоохон түнш бөгөөд 2021 оны статистикийн тоо мэдээллээр авч үзвэл Монгол Улсаас ОХУ-д 112.8 сая ам.долларын экспорт хийж, тус улсаас 1,960.6 сая ам.долларын бараа материал, түүхий эдийг импортоор худалдан авсан байна. ОХУ-ын Засгийн газраас тогтоол гаргаж тус улс зургаадугаар сарын 30-ныг хүртэл үр тариаг, наймдугаар сарын 31-нийг хүртэл элсэн чихрийг экспортод гаргахыг хориглосон, мөн түүнчлэн бордооны экспортод хязгаарлалт тогтоосон нь манай эдийн засагт тодорхой хэмжээний сөрөг үр дагавар учруулахаар байна.

Таваарын улаан буудайн хувьд энэ онд импортоор авах шаардлага байхгүй хэдий ч сайн чанарын үрийн будаа, бордоо авах эрэлт хэрэгцээ шаардлага байсаар байна. Мөн үүний зэрэгцээ уул уурхайн салбарт өргөн хэрэглэдэг тэсэлгээний бодисын түүхий эд ч дутагдах эрсдэл үүсэж болзошгүй байна.

Зураг 16. Монгол Улсын гадаад худалдааны үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, 2021 оны 12 дугаар сарын статистикийн мэдээлэл

Зургаа. Дүгнэлт

Дэлхийн зах зээлд нөхцөл байдал эрс өөрчлөгдөж ковидын эрсдэлээс гадна геополитикийн томоохон эрсдэл үүсээд байна.

Украинд болж буй дайны үйл ажиллагаа хэзээ намжих, сөргөлдөгч талууд хэзээ галаа зогсоож хэлэлцээний ширээний ард суухыг одоогоор олон улсын ямар ч байгууллага, судлаачид урьдчилан тааварлах боломжгүй байна.

Энэхүү дайн, сөргөлдөөн цаашид Украин, Беларусын хил залгаа улс орнуудад ч өргөжих эрсдэл байгаа тул НАТО-гийн зүгээс Зүүн Европын хэд хэдэн улс орнуудад цэргийн хүчээ зузаатгаж, шуурхай ажиллагааны багийг ч байгуулсан.

Хэдийгээр дайны гал зогсож, намжлаа ч гэсэн Өрнөдийн орнуудын зүгээс ОХУ болон Беларусь улсын эсрэг тогтоосон эдийн засгийн хориг арга хэмжээ нэг жил, түүнээс цааш ч үргэлжлэх өндөр магадлалтай гэж олон улсын судлаачид үзэж байна. Иймд ойрын сар, улиралд олон улсын геополитикийн эрсдэл маш өндөр байна гэдгийг төр засгийн бүхий түвшинд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

Монгол Улсын эдийн засаг гадаад зах зээлийн эрэлт, түүхий эдийн үнэ ханшийн савлагаа, байгаль цаг уурын өөрчлөлтөд ихээхэн эмзэг байсаар ирсэн гэдгийг олон улсын банк санхүүгийн байгууллагын судлаачид удаа дараа сануулсаар ирсэн.

Ийм нөхцөлд УИХ, Засгийн газар, Монгол банкнаас цаашид ямар арга хэмжээ авах нь зүйтэй вэ гэсэн асуудлаар судлаачийн байр суурийг илэрхийлбэл:

1. Макро эдийн засгийн ба геополитикийн өнөөгийн үүсээд байгаа нөхцөл байдлыг бүхэлд нь тооцоолох, мөн хувилбартай таамаглалыг боловсруулах,
2. Өнгөрсөн онд УИХ-аас батлан гаргасан Монгол Улсын 2022 оны төсөв, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогод тусгагдсан тооцоолол, таамаглал, Монгол Улсын 2022 оны хөгжлийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд бүрэн хэрэгжихгүй байх, тасалдах өндөр магадлалтай болохыг бүх түвшинд хүлээн зөвшөөрөх, нэг мөр ойлгох,
3. УИХ-ын хаврын чуулганы хуралдаанд Засгийн газраас өргөн барьж хэлэлцүүлэх Дунд хугацааны Төсвийн хүрээний төслийг өнөөгийн нөхцөл байдал, макро эдийн засгийн орчин нөхцөлд нийцүүлэн боловсруулах, цаг үеийн нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж болзошгүй байгаа тул 2-3 хувилбартай байдлаар макро эдийн засгийн төсөөлөл, тооцооллыг хийх,
4. Гадаад дотоод орчин нөхцөлийн улмаас санхүүгийн хүндрэлд орох өндөр магадлалтай жижиг дунд бизнес эрхлэгчдэд онцгой анхаарал хандуулж ойрын 2-3 жилийн хугацаанд орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг боловсруулж, холбогдох хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барьж хэлэлцүүлэх,
5. Монгол Улсын 2022 оны төсөвт тодотгол хийж төсвийн орлого ба зарлагыг бууруулах, төсвийн алдагдлыг хэмжээг ч бууруулах боломжийг судлан үзэх, гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байхад онцгой анхаарах,
6. Эрчим хүч, газрын тосны хамааралт байдлыг цаашид бууруулах дунд хугацааны төлөвлөгөө гарган УИХ-д өргөн барьж хэлэлцүүлэх,
7. Ирэх 2022-2023 оны өвлийн улирлын бэлтгэлийг хангахад хүндрэл учрах эрсдэл нэмэгдэж байгаа тул нийслэлийн нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтийг

нэн яаралтай хийх, ДЦС-уудын их ба урсгал засварын ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг яаралтай шийдвэрлэж, засварын ажлыг цаг хугацаанд чанартай гүйцэтгэх,

8. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт барьж эхлээд байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, дутагдаж буй хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар Олон Улсын банк санхүүгийн байгууллагууд, түншлэгч орнуудад шуурхай хандаж, энэ асуудлыг нэн яаралтай шийдвэрлэхэд онцгой анхаарч ажиллах,
9. Өнгөрсөн онд үйл ажиллагаа нь ихээхэн доголдол, тасалдал саатал үүсэж ирсэн Замын -Үүд хилийн боомтын үйл ажиллагааг хэвийн горимд оруулах, дээр дурдсан бүтээн байгуулалтын ажлуудад шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмжийг нэн яаралтай горимоор тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах,
10. Эрчим хүч, хүнсний аюулгүй байдал, хангамжийн доголдол үүсгэхгүй байх, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шинэ гарцуудыг шуурхай эрж хайх зэрэг олон талын арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна.

-
1. ОУВС, Дэлхийн Эдийн засгийн тойм, Global Economic Outlook October 2021,
 2. <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2021/10/12/world-economic-outlook-october-2021>
 3. ОУВС, Дэлхийн Эдийн засгийн тойм, Global Economic Outlook January 2022,
 4. <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2022/01/25/world-economic-outlook-update-january-2022>
 5. ЭЗХАБ, OECD Economic Outlook, March 2022.
 6. <https://www.oecd.org/economic-outlook/>
 7. НҮБ-ийн Хүнс, Хөдөө Аж ахуйн байгууллага, FAO, Global Food Monitor.
 8. <https://www.fao.org/worldfoodsituation/foodpricesindex/en/>
 9. FAO Cereal Supply and Demand Brief
 10. <https://www.fao.org/worldfoodsituation/csdb/en/>
 11. The Arab Reform Initiative. “The impact of the Ukraine war on the Arab region: Food insecurity in an already vulnerable context”,
 12. <https://www.arab-reform.net/publication/the-impact-of-the-ukraine-war-on-the-arab-region-food-insecurity-in-an-already-vulnerable-context/>

13. “Global Economic effects of COVID-19”, Congressional Research Service, Nov2021. <https://crsreports.congress.gov/product/details?prodcode=R46270>
14. NATO, NATO establishment, NATO expansion. <https://en.wikipedia.org/wiki/NATO>
15. Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага. SCO. <http://eng.sectsco.org>
16. U.S Treasury, U.S. Treasury Sanctions Russia’s Defense-Industrial Base, the Russian Duma and Its Members, and Sberbank CEO.
17. <https://home.treasury.gov/news/press-releases/jy0677>
18. UK Government, UK sanctions relating to Russia.
19. <https://www.gov.uk/government/collections/uk-sanctions-on-russia>
20. Сангийн яам, Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн баримт бичиг.
21. <https://mof.gov.mn/article/entry/tusuv2022>
22. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381595772311>
23. Монголбанк, Мөнгөний Бодлогын Мэдэгдэл. 2022 оны 3-р сарын 24-ний өдөр.
24. <https://www.mongolbank.mn/news.aspx?tid=1&id=2978>



Д.ГАН-ОЧИР (Sc.D)

Монгол банкны

Ерөнхий эдийн засагч

ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭНД АНХААРАХ АСУУДАЛ: ОНОЛ, АРГА ЗҮЙН ТОЙМ

***Хураангуй.** Энэхүү нийтлэлээр эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг тоймлон судалж, манай орны онцлогт тохирсон аюулгүй байдлын үнэлгээ, мониторингийн нэгэн шинэлэг арга зүйг танилцуулахыг зорив. Үндэсний аюулгүй байдлын талаарх олон төрлийн үзэл баримтлал нь судалгаа, шинжилгээний ялгаатай аргачлалууд хөгжихөд тусгалаа олж байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг эдийн засгийн бодлого, үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжилтийг үр дүнтэй хангах, явцын үнэлгээ, мониторинг хийх тал дээр учир дутагдалтай явж ирлээ. Иймд эдийн засгийн бие даасан байдал, эдийн засгийн аюулгүй байдалд үнэлгээ, мониторинг хийх арга зүйг тодорхойлж, тогтмол ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Монгол орны онцлог, тоон өгөгдлийн боломж, аргачлалын нийцтэй байдлыг харгалзан дүгнэхэд эдийн засгийн бие даасан байдлын индексийг Helmy (2017)-ийн аргаар тооцох, эдийн засгийн эмзэг байдал, дархлааны үнэлгээг Briguglio (2004) аргаар хийх, эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг Retter болон бусад (2020) аргаар шинжлэх бүрэн боломжтой гэж үзлээ.*

1. Удиртгал

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “...үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” гэж томъёолсон байдаг. Энд дурдагдсан язгуур ашиг сонирхол гэдэгт эдийн засгийн бие даасан байдлыг оруулсан бөгөөд эдийн засгийн аюулгүй байдал хэсэгт “Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн” гэж тодорхойлсон.

Засгийн газраас цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилго бүхий “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг өргөн барьж, Улсын Их Хурал (УИХ)-ын тогтоолоор 2021 оны 12 дугаар сард батлуулаад байна. Энэ баримт бичгийн нэг онцлог нь эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх асуудлыг ил тод зарлаж, олон нийтийн анхаарлын төв оруулж ирсэн явдал юм. Тус бодлогын баримт бичгийг УИХ-д танилцуулж, хэлэлцэх үеэр “Бие даасан байдал, эдийн засгийн тусгаар тогтнолын нэгэн багана нь эрчим хүчний хангамж юм”, “... аж үйлдвэржилтийн сэргэлт бол эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлын суурь баталгаа билээ.”, “... бензин шатахуунаа дотооддоо үйлдвэрлэдэг болох нь эдийн засгийн бие даасан байдлын чухал зорилтуудын нэг”, “Эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдал, цар тахлыг даван туулах үйлсэд иргэн, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч бүрийн идэвхтэй оролцоо чухал” гэсэн санаанууд дурдагдаж, олон нийтэд зарлагдсан.

Онол, практикийн түвшинд авч үзвэл эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн тулд эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн бодлогыг олон салбарт тодорхойлж, хэрэгжүүлэх ёстой болно. Энэ зорилгоор оновчтой бодлогууд тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг тогтмол хийх, түүн дээр үндэслэн өөрчлөлт, шинэчлэлийн тухай бүр хийх шаардлагатай. Үнэлгээ, мониторинг хийх арга зүйн хувьд өөрийн орны онцлог, нөхцөл байдалд бүрэн тохирсон байх нь чухал юм.

Дээрх агуулга, хэрэгцээ шаардлагын хүрээнд энэхүү нийтлэлээр эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг тоймлон судалж, манай орны онцлогт тохирсон аюулгүй байдлын үнэлгээ, мониторингийн нэгэн шинэлэг арга зүйг танилцуулахыг зорив.

Helmy (2017) 112 орны эдийн засгийн бие даасан байдлын индексийг тухайн улс орон 1) өөрийн үндсэн хэрэгцээ (хүнс, эрчим хүч, эрүүл мэнд)-гээ хангах хангалттай нөөцтэй эсэх; 2) эдийн засгийн хориг арга хэмжээ авах тохиолдолд тэсвэрлэх чадвар; 3) дотоод хөрөнгө дэх гадаадын эзэмшил гэсэн үзүүлэлтүүдэд суурилан тооцжээ. Энэхүү эдийн засгийн бие даасан байдлын индекс (ЕИ) нь тухайн улсын эдийн засгийн дархлаа (дасан зохицох чадвар) хаана байгаа, эдийн засгийн хувьд дангаараа үлдэх эсвэл хүчирхэг гүрнүүдээс шалтгаалж тийм бодлого баримтлах шаардлага гарах тохиолдолд ямар эрсдэлүүд хүлээгдэх талаарх мэдээллийг өгдөг. Иймд тус индекс нь эдийн засгийн бие даасан байдлын түвшнээ сайжруулахад шаардлагатай бодлого, арга хэмжээг тодорхойлоход туслах хэрэгсэл юм. Монгол Улс 2010-2013 оны тоон мэдээллийг ашигласан тооцоогоор ASSS (үндсэн хэрэгцээг дотоод нөөцөөр даван туулах чадамж) үзүүлэлтээр 0.825, ERSR (эдийн засгийн хориг тавигдах үед тэсвэрлэх чадамж) үзүүлэлтээр 0.399, NCS (дотоод хөрөнгүүдэд үндэсний хяналт тавих чадвар) үзүүлэлтээр 0.087, ерөнхий ЕИ (эдийн засгийн бие даасан байдал) үзүүлэлтээр 0.293 утга авч 112 орноос 50-д эрэмбэлэгдсэн байна. Эндээс харахад дотоод хөрөнгө дэх гадаадын эзэмшил, гадаад валютын нөөцийн хүрэлцээний харьцангуй доогуур түвшин (гадаад өрийн өндөр

түвшин ч энэ үзүүлэлтэд мөн хамаарна) нь Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг хойш татаж буй гол хүчин зүйлс болж байжээ.

Энэ нийтлэлийн үлдсэн хэсэг нь дараах бүтэцтэй. Хоёрдугаар хэсэгт, үндэсний аюулгүй байдлын онолын урсгалын түүхэн хувьсал, хөгжлийг тоймлон авч үзэв. Гуравдугаар хэсэгт, эдийн засгийн аюулгүй байдлын шинжилгээний аргачлалуудыг системчлэн авч үзэв. Дөрөвдүгээр хэсэгт, эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг хийх нэгэн шинэ арга зүйг танилцуулав. Эцэст нь, тавдугаар хэсэгт нэгтгэн дүгнэлээ.

2. Үндэсний аюулгүй байдлын онолын урсгалын түүхэн хувьсал, хөгжил

Академик судалгаа, шинжилгээнд «үндэсний аюулгүй байдал»-ын талаарх цор ганц, нэгдсэн тодорхойлолт байдаггүй. Түүний онолын урсгал түүхэн хугацаанд хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хөгжиж ирснийг энэ хэсэгт тоймлон авч үзье.

2.1 XIX зуун хүртэлх үндэсний аюулгүй байдлын талаарх сэтгэлгээ

Одоо бидний «үндэсний аюулгүй байдал» гэж нэрлэх болсон үзэл баримтлалыг эрт дээр үедээ судлан хэлэлцэж байсан эртний сэтгэгчид нь тухайн үеийн улс төрчид, философичид байжээ. Тэд хүн, хот, муж улс болон бусад оролцогчид хоорондын харилцаа, хамаарлыг тайлбарлах, дэлхий дээрх амьдрал хэрхэн явагдаж байгааг ойлгоход ихээхэн анхаарал хандуулж байсан. Эртний бүтээлүүдэд аюулгүй байдлын тухай бараг дурдагддаггүй хэдий ч улс орны аюулгүй байдалтай холбоотой асуудлууд хөндөгдөж иржээ. Тухайлбал, улс төрийн онолч Н.Макиавелл XVI зуунд бичсэн «Ханхүү» номдоо удирдагчийг “өөрт нь болон түүний хаант улсын аюулгүй байдалд заналхийлж буй хүмүүсээс өөрийн байр сууриа хамгаалахын тулд шаардлагатай бүх зүйлийг хийх чадвартай байх ёстой” гэж тодорхойлж байжээ (Ritter болон бусад 2020).

2.2 XX зуун дахь аюулгүй байдал, эдийн засаг хоорондын уялдаа холбоо

XIX зуун, XX зууны эхэн үед дайн, мөргөлдөөн, үндэстний-төр дэлгэрч байсантай зэрэгцэн муж улсууд, улс төрийн оролцогчдын хувьд бусад муж улсаас хараат байхыг эсэргүүцэх, харин үндэсний өөрөө өөрийгөө хамгаалахын ач холбогдлыг онцолсон реалист тайлбарууд давамгайлж байв.

Реализм. Каррын 1939 онд бичсэн “Хорин жилийн хямрал” ном хэвлэгдсэнээр сонгодог реализм албан ёсоор томъёологдсон гэж үздэг (Elman 2008). Хүн төрөлхтний төрөлхийн эрх мэдлийн төлөөх хүсэл, зан төлөвийн доройтлын талаарх Хоббес ба Макиавеллист үзэл баримтлалаас ялгаатай нь Карр “үндэсний аюулгүй байдлын сул байдал нь байгалийн баялаг, засгийн газрын бүтэц, зөрчилдөөнтэй үзэл суртал, тодорхой хувь лидерүүдийн эрх мэдлийн төлөөх шуналтай холбоотой” гэж үзсэн.

XX зууны хоёрдугаар хагаст Кеннет Вальц шинэ сэтгэлгээний сургуулийг бий болгож, Неореализм гэгддэг сонгодог реализмын үзэл баримтлалыг гарган тавьжээ. Энэ үзэл баримтлалд Анархи ертөнцөд оршин тогтнохын тулд муж улсууд өөрөө өөрийгөө авч явахаас өөр аргагүй юм гэж үздэг. Вальц эрх мэдлийн төлөөх хүсэл эрмэлзэлд бага ач холбогдол өгч, харин улс орнууд үндэсний аюулгүй байдлыг хангасны дараа эрх мэдлийн хойноос явдаг гэж үзсэн.

Дүгнэж хэлэхэд, реалист сэтгэлгээний хүрээнд үндэсний аюулгүй байдалтай холбоотой нийтлэг хэд хэдэн зарчим гарч ирдэг. Улс өөрийгөө хамгаалахын тулд улс доторх түрэмгийлэл, дайсагнашцаг улс орнуудаас ирэх аюул, түүнтэй холбоотой айдас, цэрэг арми болон аюулгүй байдлын зөрчилдөөн зэргийг шийдвэрлэхэд анхаарал хандуулах ёстой гэж үздэг. Дэлхийн II дайнаас өмнө «аюулгүй байдал» гэсэн нэр томъёо өргөн хэрэглэгдэж байсан бөгөөд «үндэсний аюулгүй байдал» нь реалист онолын дахь «аюулгүй байдал»-тай ижил утгатай гэж үзэх нь бий.

Либерализм. Реалист үзэл баримтлалаас гадна бусад сургуульд ч үндэсний аюулгүй байдлын тухай ярьж байжээ. И.Кантын философийн зохиолуудаар тодрон гарч ирсэн либерализм нь олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухаанд нөлөө үзүүлж эхэлжээ. Кантын дэвшүүлсэн суурь аргумент бол “хүчний тэнцвэрт байдал нь энхийг сахиулна; аливаа захирагчийн байлдан дагуулах хүсэл нь энх тайванд хүрэх эцсийн зорилготой байдаг” гэж үзэх явдал юм. Реализмын нэгэн адил либерализм нь олон дэд онолоос бүрддэг бөгөөд ерөнхийд нь авч үзвэл, либерализм нь төр ба олон улсын хоорондын хамаарал, улс ба бусад оролцогч хоорондын харилцан хамааралд илүүтэй анхаардаг.

Олон улсын харилцаа, улс төрийн хүрээнд либерализм нь олон улсын байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааны үр өгөөж (энэ нь эдийн засгийн хамтын ажиллагаа, олон улсын худалдаагаар дамждаг)-д төвлөрдөг. Либерализм нь хоорондоо нягт уялдаатай бусад онол дээр тулгуурладаг. Үүнд ардчилсан улсууд ижил үнэт зүйлтэй тул бие биетэйгээ дайтах магадлал багатай гэж үздэг ардчилсан энх тайвны онол, либерал институционализм (энэ нь олон улсын байгууллагууд мөргөлдөөнийг бууруулахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг) зэргийг дурдаж болно.

Конструктивизм. Олон улсын харилцаа, аюулгүй байдлын судалгааны сүүлийн үеийн бүтээлүүдэд нийгмийн конструктивизмын онолуудыг аюулгүй байдлын судалгаанд өргөн ашиглах болжээ. Энэ хандлага нь үндэсний аюулгүй байдлыг нийгмийн үзэгдэл гэж үздэг. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдал нь зарим хийсвэр шалгуураар тодорхойлогдохоос илүүтэй нийгмийн шинж байдал (ялгарал, хэм хэмжээ, соёл зэрэг)-д учрах аюул заналтай холбоотой гэж үздэг.

Критикал онол. Конструктивизмтэй нягт холбоотой үзэл баримтлал болох критикал онол нь хүйтэн дайны дараах үе дэх онолын томоохон урсгал болж гарч ирсэн. Энэ нь аюулгүй байдлын талаарх өмнөх тайлбаруудын орхигдуулсан зүйлсийг авч үздэг: аюулгүй байдал нь өөр өөр оролцогчдын хувьд ялгаатай утгатай гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ нь аюулгүй байдлын төр төвтэй уламжлалт хандлагад шүүмжлэлтэй ханддаг. Критикал онол нь феминист онол, постструктурализм ба колоничлолын дараах байдал зэрэг илүү өргөн хүрээтэй асуудлыг хамардаг онцлогтой байна.

Критикал улс төрийн эдийн засаг. Критикал улс төрийн эдийн засаг нь эдийн засаг, аюулгүй байдлын судлагдахууны огтлолцлын талаарх мэтгэлцээнд хүч түрэн гарч ирсэн онолын урсгал юм.

2.3 Илүү “хүн төвтэй” чиг хандлага руу шилжсэн нь

Аюулгүй байдал, тэр дундаа үндэсний аюулгүй байдалд хамаарах асуудал нь онолын үзэл баримтлал, тайлбараас гадна түүхэн үйл явдал, хөгжил зэрэг хүчин зүйлсээс хамаарч өөрчлөгдөж иржээ.

Олон улсын харилцаа, улс төрийн үзэгдлийг тайлбарлахыг оролдсон олон тооны онол урт хугацааны туршид хөгжиж ирсэн хэдий ч, үндэсний аюулгүй байдлын тодорхойлолтын талаарх судалгаа, шинжилгээний ажил харьцангуй бага байдаг ажээ. Аюулгүй байдалтай холбоотой ойлголтууд Дэлхийн II дайнаас өмнө давамгайлж байсан боловч, аюулгүй байдлыг тусгайлан судалсан бүтээл 1945 оныг хүртэл гараагүй байна.

1990-ээд оноос өмнө реалист сэтгэлгээ давамгайлж, үндэсний аюулгүй байдлыг явцуу хүрээнд тодорхойлж байв. Дэлхийн II дайны сүйрэл нь үндэсний аюулгүй байдалд дүн шинжилгээ хийх хандлагыг өөрчилсөн. Тухайлбал, хүчирхэг гүрнүүдийн хооронд урьд өмнө хэзээ ч байгаагүй цэргийн мөргөлдөөн болсны дараа үндэсний аюулгүй байдлын асуудлыг батлан хамгаалах, цөмийн зэвсэглэл талаас нь илүүтэй судлах болжээ. Хүйтэн дайны дараах бодлогын яриа хэлэлцүүлгүүд нь дорой хөгжил шунал хүслийг бий болгож, энэ нь заналхийлэл, айдсыг бий болгодог гэдгийг онцолж, аюулгүй байдлыг хангахын тулд улс орон хөгжих шаардлагатай гэдэг дээр төвлөрөх болжээ.

Дэлхийд шинэ дэг журам тогтсоноор 1990 оноос хойш үндэсний аюулгүй байдлыг шинээр тодорхойлох болсон байна. Дэлхийн улс төрийн сэтгэлгээ өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлын реалист ойлголтоос салж, аюулгүй байдлыг илүү өргөн хүрээтэй авч үзэж, өмнө нь үл тоомсорлож байсан бусад асуудлыг хамруулах болжээ. Дэлхийн даяаршил нь улс орнууд улам бүр бие биеэсээ хамааралтай болоход хүргэж, нэг улс дангаараа шийдвэр гаргахад улам бүр төвөгтэй болгож, улс орнуудын бие биетэйгээ харилцах арга хэлбэр өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Энэхүү улс орнуудын хооронд харилцан үйлчлэл, харилцан хамаарал нь олон улсад гарч буй өөрчлөлтийг үндэсний аюулгүй байдалд авч үзэх шаардлагыг улам бүр нэмэгдүүлжээ.

1990-ээд онд “зангилааны засаглал (nodal governance)” онолын чиг хандлага гарч ирснээр үндэсний аюулгүй байдлыг хариуцах гол институт нь төр гэж үздэг уламжлалт үзэл баримтлалд сорилт болсон. Үүний оронд аюулгүй байдлын засаглалыг олон талыг хамарсан, төрийн болон хувийн хэвшлийн монополт бус сүлжээ байх ёстой гэж үзэх хандлага дэлгэрчээ. Энэ тохиолдолд төрийн үүрэг, оролцоо багасаж, түүний нийгэм, эдийн засаг, улс төрийн үүрэг чиглэлийг аутсорсинг хийх байдлаар гүйцэтгүүлэх ёстой болох юм.

1970, 1980-аад оны эдийн засаг, байгаль орчны талаарх шинэ санаачилгууд, 1990-ээд оны үндэстэн дамнасан гэмт хэргийн талаарх асуудлууд нь аюулгүй байдлыг дахин тодорхойлох, үндэсний аюулгүй байдал болон үндэстэн дамнасан үйл явдал, хөгжил хоорондын уялдаа холбоонд анхаарал хандуулах шаардлагыг бий болгожээ. Ullman аюулгүй байдлын асуудлыг илүү өргөн хүрээнд авч үзсэн анхдагчдын нэг бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах гэдгийг “тус улсын оршин суугчдын амьдралын чанарыг доройтуулах” эсвэл “Засгийн газар эсвэл хувийн хэвшлийн бодлогын сонголтын хүрээг багасгах”-д хүргэх аюул заналаас сэргийлэх явдал гэж үзэж байв.

Дээрх хувьсал өөрчлөлтийн үр дүнд үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголтыг улам өргөжүүлж, “хүний аюулгүй байдал”-ын асуудлыг авч үзэх болжээ. Аюулгүй байдлын талаарх уламжлалт бус асуудлуудыг нэгтгэн “хүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёонд багтаах болсон байна. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь хувь хүний аюулгүй байдалд төвлөрөх ёстой гэж үзэх болсон. Энэ нь төр төвтэй үзэл баримтлалаас татгалзсан эрс өөрчлөлт байв. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн сайн сайхны төлөөх хамгийн том аюул бол харь орны цэрэг, арми биш, харин эдийн

засгийн уналт, улс төрийн дарангуйлал, бүтээгдэхүүний хомсдол, хэт их хүн ам, үндэстэн хоорондын өрсөлдөөн, байгалийн гамшигт үзэгдэл, терроризм, гэмт хэрэг, өвчин гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч эхэлжээ. Түүнчлэн ажилгүйдэл, өсөлтийн удаашрал зэрэг эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн тааруу байдал нь эргээд цэрэг, армийн чадавх сул байхад нөлөөлнө гэж үзэх хандлага ч давамгайлах боллоо.

Үндэсний аюулгүй байдлын хүний аюулгүй байдалд илүү анхаарсан тайлбар нь эдийн засгийн сул чадавх амьжиргааны түвшин буурах, хүмүүсийн өөрөө өөрийгөө бие даан авч явах чадварыг сулруулдаг гэж үздэг.

2.4 Үндэсний аюулгүй байдлын “өргөн” хүрээтэй тодорхойлолт нь эдийн засгийн асуудлыг багтаах болов

Дээрх хэсгүүдэд дурдсанчлан, “үндэсний аюулгүй байдал”-ын үзэл баримтлал цаг хугацааны туршид өөрчлөгдөхөд онолын урсгалууд (реализм болон либерализм) болон түүхэн үйл явдал, хөгжил нөлөөлсөн. Бодлогын баримт бичиг, академик бүтээлүүдийг ерөнхийд нь 1) үндэсний аюулгүй байдлыг харьцангуй “явцуу” тодорхойлж, төрийн аюулгүй байдал, түүний нутаг дэвсгэр, бүрэн эрхт байдлыг хамгаалах чадварт голлон анхаарах; эсвэл 2) төрийн үүргээс давсан байдлаар илүү “өргөн” хүрээтэй тодорхойлж, олон улсын систем дэх өөрчлөлт, улс төр, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн сайн сайхан байдал зэрэг бусад хүчин зүйлсийг оруулах гэсэн хоёр чиг хандлагад ангилж болохоор байна.

Buzan болон бусад (1998) нар аюулгүй байдлын тодорхойлолтыг өргөжүүлэхийг дэмжигчид бөгөөд аюулгүй байдлыг цэргийн (уламжлалт үзэл баримтлал), улс төр, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн гэсэн үндсэн таван чиглэлийн дагуу шинжлэн судлах ёстой гэж үзсэн. Үүнийг “Копенгагены сургууль” гэж нэрлэх нь бий.

Үндэсний аюулгүй байдлын талаарх эдгээр олон төрлийн үзэл баримтлал нь үндэсний эрсдэлийн үнэлгээний ялгаатай аргачлалуудад тусгалаа олсон. Дараагийн хэсэгт тухайн аргачлалуудыг тоймлон судаллаа.

3. Эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг хийх аргууд

Эдийн засгийн аюулгүй байдлыг судалдаг арга зүйн хандлагуудыг судлахаас өмнө аюулгүй байдал, түүний хамрах хүрээний талаарх ерөнхий ойлголтыг авч үзье.

Glaser (1997) аюулгүй байдал гэдгийг туйлын утгаар нь буюу аливаа эрсдэл байхгүй байх явдал гэж тодорхойлсон. Тэрээр аюулгүй байдлыг хангахын тулд аюулгүй байдлын үндсэн 5 дэд бүрдлийн асуудлыг шийдвэрлэх ёстой гэж үзжээ. Түүний судалгаанд суурилан аюулгүй байдлыг таван дэд бүрэлдэхүүн хэсэгт хуваасныг Зураг 1-д харуулав.

Зураг 1. Аюулгүй байдал




Эх сурвалж: Glaser (1997), Kremer-Matyskevici болон Cernius (2019)

Glaser (1997) аюулгүй байдлыг олон улсын болон үндэсний гэсэн үндсэн хоёр хэсэгт хувааж үзсэн. Олон улсын аюулгүй байдлыг глобал болон бүс нутгийн түвшинд ангилсан. *Глобал аюулгүй байдал* нь дэлхийг тогтворгүй болгож, глобал хямралыг өдөөж болзошгүй аюул заналын эсрэг чиглэсэн олон улсын болон байгаль орчны аюулгүй байдлын систем гэж үзсэн. *Бүс нутгийн аюулгүй байдал* нь улс орны язгуур ашиг сонирхлын аюулгүй байдал, бүс нутгийн хөгжил, санхүүгийн тогтвортой байдал, дэд бүтэц, бизнесийн хөгжлийг хангах эдийн засаг, экологи, хууль эрх зүй, геополитикийн болон бусад нөхцөлийн багц гэж тодорхойлжээ. Бүс нутгийн аюулгүй байдал нь тухайн нэг орны дотоод, гадаад аюулгүй байдалд нөлөөлнө. Үндэсний аюулгүй байдлыг дотор нь төрийн, нийгмийн, хувийн хэвшлийн гэж гурав ангилсан. *Төрийн аюулгүй байдал* нь дотоод, гадаад аюул заналын нөлөөг бууруулах, болзошгүй хамгаалалтад бэлтгэх явдал юм. *Нийгмийн аюулгүй байдал* нь болзошгүй нийгмийн хямралын эрсдэлийг бууруулах, орлогын тэг бус байдлыг багасгах, хүн амыг ядууралд орохоос сэргийлэх, улмаар нийгмийн эв нэгдлийг хангахад чиглэсэн халамжийн бодлого хэрэгжүүлэх явдал юм. *Хувийн аюулгүй байдлыг* аж ахуйн эрхлэгчийн болон хувь хүний аюулгүй байдал гэж хоёр хуваасан: аж ахуйн нэгжийн хувьд компанийн санхүүгийн тогтвортой байдал, хөгжил дэвшил; хувь хүний хувьд зөв зан үйлтэй байх зэргийг авч үзсэн.

Retter болон бусад (2011) нар 11 орон (Сингапур, Канад, Австрали, Дани, Англи, Швед, Герман, Франц, АНУ, ОХУ, БНХАУ)-ны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэр өргөн хүрээг хамардаг болон олон улсын/үндэсний асуудалд илүү ач холбогдол өгдөг байдлаар нь ангилан Зураг 2-т харуулсан үр дүнг гарган авчээ.

Зураг 2. Улс орнуудын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал




Эх сурвалж: Ritter болон бусад (2020). MNG-ийг судлаач зураг дээр нэмэв

Тэмдэглэгээ: SG-Сингапур, СА-Канад, AU-Австрали, DE-Дани, SE-Швед, UK-Англи, DK-Герман, FR-Франц, US-АНУ, CH-БНХАУ, RU-ОХУ, MNG-Монгол Улс.

Энд авч үзсэн ихэнх улс орон нь өргөн хүрээ (эдийн засгийн аюулгүй байдал, баялаг, нийгмийн тогтвортой байдал, байгаль орчны аюулгүй байдал болон бусад)-тэй, мөн олон улсын асуудалд илүүтэй төвлөрдөг бол, манай хоёр хөрш болох ОХУ болон БНХАУ-ын хувьд илүү явцуу хүрээ (батлан хамгаалах, цэрэг болон газар нутгийн аюулгүй байдал)-тэй, гэхдээ үндэсний дотоод асуудалдаа илүүтэй төвлөрдөг байна. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг илүү өргөн хүрээтэй авч үздэг буюу эдийн засгийн аюулгүй байдлыг тусад нь авч үздэг хандлага давамгайлж байна. Энд авч үзсэн барууны орнууд Их-20-д багтдаг тул олон улсын асуудалд өндөр ач холбогдол өгдөг байна. Харин Монгол Улсад өнөөдөр үйлчилж буй Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь баруун доод (өргөн хүрээтэй-үндэсний дотоод асуудалд төвлөрдөг) хэсэгт хамаарахаар байна.

Tamosiuniene болон Munteanu (2015) нар эдийн засгийн аюулгүй байдлыг судалдаг хандлагыг Зураг 3-т харуулсан байдлаар системчилсэн.

Зураг 3. Эдийн засгийн аюулгүй байдлын хандлага



Эх сурвалж: Tamosiuniene болон Munteanu (2015)

Тэдний ангиллаар эдийн засгийн аюулгүй байдлыг ерөнхийд нь макро эдийн засгийн болон хувь хүний хандлага гэж хуваасан. *Макро эдийн засгийн хандлага* нь “аюулгүй байдлыг авч үзэхдээ аюул заналаас илүүтэй эмзэг байдал, эрсдэлд илүүтэй анхаарал хандуулдаг” чиг хандлагад суурилсан бөгөөд макро эдийн засгийн тоон өгөгдлийн шинжилгээ, босго утгад суурилдаг. Энэ хандлага нь дотроо Оросын эдийн засгийн сургууль (эдийн засгийн аюулгүй байдлыг тоон утгаар хэмжихэд босго утга ашигладаг) болон Briguglio (2004)-ийн аргачлал гэж хоёр хуваагддаг. Л.Бригуглийн загвар нь эдийн засгийн аюулгүй байдлыг үндэсний эдийн засгийн эмзэг байдал болон шокыг тэсвэрлэх дархлаа талаас нь авч үздэг.

Эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээг босго утгатай харьцуулах замаар шинжилдэг Орос хэв маягийн аргачлал, түүнд ашиглах макро хувьсагчид, босго утгын талаар С.Цэцгээ (2008) дэлгэрэнгүй судалж, тайлбарласан байдаг. Харин Л.Бригуглийн аргачлалаар Монгол Улсын эдийн засагт хийсэн шинжилгээний үр дүн, санал зөвлөмжтэй Д.Ган-Очир (2012, 2017) судалгаанаас танилцах боломжтой. Манай орны хувьд гадаад өр, гадаад секторын эмзэг байдал өндөр тул түүнд мониторинг хийж, оновчтой бодлого, арга хэмжээ тодорхойлох тал дээр Л.Бригуглийн арга илүү тохиромжтой юм. Эдгээр судалгааны ажил нь Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдал өндөр хэвээр байгаа, тэр дундаа гадаад секторын хувьд гадаад өрийн өндөр түвшин, гадаад валютын нөөцийн хүрэлцээ, экспортын төвлөрөл, хэт хамааралтай байдлыг онцолсон бол санхүүгийн салбарын эмзэг байдлын хувьд чанаргүй зээл, пассивын долларжилтод анхаарал илүүтэй хандуулах шаардлагатайг тодорхойлсон. Түүнчлэн макро эдийн засгийн болон бүтцийн бодлогын хүрээнд анхаарах шаардлагатай олон асуудлыг гаргасан тавьсан.

Харин *хувь хүний эдийн засгийн аюулгүй байдлын (Англо-Саксон) хандлага* нь тухайн нэг хүний эдийн засгийн аюулгүй байдлыг өнөөгийн болон ойрын ирээдүйн амьжиргааны түвшинг хадгалахуйц тогтвортой орлого, бусад эх үүсвэртэй байх явдал гэж үздэг. Үүний тулд төлбөрийн чадвартай байх, тогтмол мөнгөн орлогын урсгалтай байх, хүмүүн капитал аа үр ашигтай ашиглах явдал чухал гэж үздэг (Tamosiunniene болон Munteanu 2015). Олон улсын хөдөлмөрийн байгууллага (2004) нь хувь хүний эдийн засгийн аюулгүй байдлыг үнэлэх нэг хандлагыг хөгжүүлсэн. Тус байгууллагын судлаачид “Илүү сайхан дэлхийн төлөөх эдийн засгийн аюулгүй байдал” тайландаа дэлхийн нийт хүн амын 85 хувийг хамрах 90 улс орны тоон өгөгдлийг ашиглан олон дэд, микро түвшний индексүүд тооцож, тэдгээрт үндэслэн ерөнхий индекс гарган үнэлгээ, шинжилгээ хийсний үндсэн дээр улс орнуудыг 4 хэсэг (хэмнэл тогтоогч, парагматист, уламжлалт, хийх зүйл их хийх шаардлагатай)-т хуваан ангилсан байдаг. Монгол Улс тус байгууллагад 1968 онд элссэнээс хойш гишүүн байгаа хэдий ч, тус тайланд Монголыг түүвэртээ оруулаагүй байна. Түүнчлэн хувь хүний эдийн засгийн аюулгүй байдлын хандлагыг АНУ-д эдийн засгийн аюулгүй байдлыг индекс тооцоход суурь болгон ашигладаг байна. Тухайн индекс нь эдийн засгийн аюулгүй байдал хангагдахгүй байх үзэгдэл бүх америкчуудад ажиглагдаж байгаа бөгөөд эмзэг бүлгийн иргэдэд илүү тод байгааг харуулдаг байна (Hacker болон бусад 2012).

4. Эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг хийх шинэ арга зүйг санал болгох нь

Энэ хэсэгт эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг хийхэд ашиглаж болох Rand Europe институтын судлаачид болох Retter болон бусад (2020) нарын Нидерланд улсын жишээг суурь болгон боловсруулсан нэгэн арга зүйг танилцуулж байна. Жижиг нээлттэй эдийн засагтай, том хүчирхэг гүрнүүдтэй худалдаа хийдэг, уул уурхай, худалдааны салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөртэй манай орны хувьд тухайн арга зүй нь тохиромжтой гэж үзсэн болно.

Тухайн арга зүйн ерөнхий бүдүүвчийг Зураг 4-т харуулав. Тус бүдүүвчийн төвд эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад эн тэргүүнд шаардлагатай чухал (стратегийн) салбар, дэд бүтэц, процессууд байрлана. Өөрөөр хэлбэл, эдгээр салбар, дэд бүтэц, процессыг оновчтой хөгжүүлж чадсанаар эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх юм.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дахь эдийн засгийн аюулгүй байдал, түүний доторх үндсэн бүрдлүүд болох чухал салбарууд, дэд бүтэц, процессуудыг олон улсын туршлагад нийцүүлэн сайжруулах боломжийн талаарх судалгааг Монгол банк дээр хийж байна. Харин энэ нийтлэлийн хувьд одоо үйлчилж буй үзэл баримтлалын хүрээнд үнэлгээ, мониторингийн аргачлалыг хэрхэн ашиглах боломжид анхаарсан болно.

УИХ-ын тогтоолоор 2010 онд баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын эдийн засгийн аюулгүй байдал хэсэгт “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална” мөн “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ” гэж заасан байдаг. Энэ нь бусад улс орны чухал (стратегийн) салбарыг сонгосон байдалтай ерөнхийдөө нийцтэй юм.

Эдгээрээс харахад манай орны хувьд эдийн засгийн аюулгүй байдлын хувьд чухал салбаруудад *эрчим хүчний салбар, эрдэс баялгийн салбар, санхүүгийн салбар, гадаад худалдааны салбар, зам тээврийн салбар, мэдээлэл, харилцаа холбооны салбар, хүнс, хөдөө аж ахуйн салбар* орохоор байна.

Зураг 4. Санал болгож буй аналитик арга зүйн хамрах хүрээ



Эх сурвалж: Retter болон бусад (2020)

Тухайн үзэл баримтлалд чухал дэд бүтцийг тусад нь ангилж, нэрлээгүй хэдий ч “Дэд бүтцийн салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгоно. Төмөр замын сүлжээг байгуулахдаа Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэнэ” гэсэн санаа бий. Харин “Шинэ сэргэлтийн бодлого”-д эдийн засгийн аюулгүй байдалд чухал гэж үзсэн дэд бүтэц, бүтээн байгуулалт, тэдгээрийн процессуудыг Засгийн газраас нэрлэжээ. Тухайлбал,

1. Боомтуудыг авто зам, төмөр зам, хурдны замаар цаг алдалгүй холбох¹, агаарын тээврийн салбарыг цоо шинэ шатанд гаргах;
2. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд, түүний дотор усан цахилгаан станцыг нэн тэргүүний зорилт болгож, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг дуусгаж, Эгийн голын усан цахилгаан станцыг эхлүүлэхийн төлөө бүх боломжоо дайчлан ажиллах, Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, Таван толгой, Багануур, Чойбалсангийн Дулааны цахилгаан станц, Амгалан цахилгаан станц зэрэг эхлүүлсэн бүтээн байгуулалтын ажлуудаа цаг алдалгүй дуусгаж, ашиглалтад оруулах;
3. Зэсээ баяжуулж, нүүрсээ угааж, алтаа цэвэршүүлж, газрын тосоо боловсруулж, дотоодын хүнсээ хангаж, түүхий эд нийлүүлэгч улсаас аж үйлдвэржсэн улс болох²;
4. Нийслэл Улаанбаатар хоттой дүйцэх хэмжээний шинэ суурьшлын бүсийг эртний нийслэл Хархорум хотыг түшиглэн шинээр байгуулах нарийвчилсан судалгааны ажлыг олон улсын хот байгуулалтын инженерүүдтэй хамтарч, 2022 онд багтаан эхлүүлэх, Хөшигийн хөндийд эдийн засгийн чөлөөт бүс, шинэ хот байгуулах, Богдхан уулыг тойрсон 136 километр төмөр замыг шинээр байгуулах, Улаанбаатар хотын Толгойт, Баянхошуу, Сэлбэ, Дарь-Эх зэрэг дэд төвийг холбосон 72 км Их тойруу хурдны зам барих;
5. Улаанбаатар хот болон аймаг, орон нутагт хог хаягдал дахин боловсруулах байгальд ээлтэй шинэ технологийн үйлдвэрүүдийг бүсчлэн байгуулах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийг усаар хангах, саарал усыг дахин боловсруулах, нуур цөөрөм үүсгэх зэрэг зорилтыг зарласан байна.

Зураг 4-т санал болгож буй арга зүйн хувьд эдийн засгийн аюулгүй байдал (үүний хойно чухал салбар, дэд бүтэц, процессуудын зорилт тавигдана) болон макро эдийн засгийн хувьсагчдын хоорондын хамаарлыг авч үздэг. Ингэхдээ эдийн засгийн аюулгүй байдалд хамгийн нөлөөтэй хувьсагчдыг макро эдийн засгийн онол, эдийн засгийн

¹ Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг ирэх онд бүрэн ашиглалтад оруулж, Ханги, Бичигт, Шивээ хүрэн, Арц суурь боомтыг төмөр замаар холбох ажлыг цаг алдалгүй эхлүүлэх, Ханги, Цагаан дэл, Бургастай, Цагааннуур, Тэс, Арц суурь, Ханх, Бага Илэнхи, Зэлтэр, Ульхан, Хавирга, Сүмбэр, Баянхошуу, Бичигт зэрэг боомтыг авто замаар холбох, Хилийн боомтыг хурдны замаар холбох ажлыг Алтанбулаг-Замын-Үүд боомтыг холбосон 987 километр хурдны замыг барихаас эхлэх, шинэ нисэх онгоцны буудлыг Ази, Европыг холбосон агаарын тээврийн дамжин өнгөрүүлэх төв болгон өргөжүүлэх зэрэг ажил эн тэргүүнд багтжээ.

² Эрдэнэтийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр болон Дархан-Сэлэнгийн бүсэд гангийн үйлдвэрүүд барьж, ашиглалтад оруулах, Дарханы арьс шир боловсруулах үйлдвэр болон татан авах дэд төвүүдийг байгуулах ажлыг зохион байгуулах, газрын тос боловсруулах үйлдвэрээ цаг алдалгүй ашиглалтад оруулж, бензин шатахуунаа дотооддоо үйлдвэрлэдэг болох зэрэг зорилт багтжээ.

өсөлтийн загварууд болон олон улсын эдийн засгийн онол, практикийн үндэслэлтэйгээр дараах байдлаар сонгосон:

- **Дотоодын хөрөнгө оруулалт, хэрэглээ.** Дотоод хөрөнгө оруулалт гэдэг нь дотоодын оролцогчид (хувь хүмүүс, компаниуд) санхүүгийн эсвэл бодит үйлдвэрлэлийн хөрөнгө эзэмшихийг хэлнэ; хэрэглээ гэдэг нь эдийн засгийн агентуудын хэрэгцээгээ хангахын тулд ашиглаж буй бараа, үйлчилгээний эцсийн хэрэглээг хэлнэ.
- **Ажил эрхлэлт.** Тухайн эдийн засагт гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж цалин, хөлс авдаг болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн тоог хэлнэ.
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО).** Тухайн нэг улсын харьяат (хувь хүн эсвэл компаниуд) гадаадад бодит хөрөнгө (жишээ нь, үйлдвэр, үйлчилгээний газар байгуулах) эзэмшихийг хэлнэ.
- **Глобал эдийн засгийн хандлага.** Дэлхийн макро эдийн засгийн хувьсагчдын урт хугацааны өөрчлөлт, хөдөлгөөнийг хэлнэ.
- **Төсвийн зарцуулалт, засгийн газрын зохицуулалт.** Төсвийн зарцуулалт гэдэг нь төрөөс бүх түвшинд зарцуулж буй мөнгөн зардлыг хэлнэ. Жишээ нь, бодит бараа, үйлчилгээ авах зардал, төрийн албан хаагчдын цалин, боловсрол, нийгмийн халамжийн зардал (тэтгэвэр, тэтгэмж), татаас, тухайн нэг салбарт олгосон дэмжлэгт зарцуулсан зардал болон өрийн хүүгийн төлбөр орно. Зохицуулалт гэдэг нь хувь хүн, компаниуд заавал дагаж мөрдөх үүрэгтэй төрөөс тогтоосон дүрэм, түүнийг хэрэгжүүлэх процедурыг хэлнэ.
- **Хүмүүн капитал.** Ур чадвартай мэргэшсэн хүмүүсийн нэмэлт бүтээмжийн өнөөгийн үнэ цэнийг хэлнэ. Хүмүүн капиталыг боловсрол, сургалт болон ажлын туршлагаар дамжуулан олж авдаг.
- **Олон улсын худалдаа.** Улс орнууд хоорондын харилцан ашигтай тохиролцооны үндсэн дээрх бараа, үйлчилгээний арилжааг хэлнэ.
- **Технологийн дэвшил.** Үйлдвэрлэлийн технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, үр дүнд нь орцууд өөрчлөгдөөгүй байхад илүү их гарц бий болох, ижил гарцыг цөөн тооны орцоос авах эсвэл шинэ төрлийн гарц үйлдвэрлэхийг ойлгоно.

Энэ арга зүйн бас нэг онцлог нь “эдийн засаг” болон “үндэсний аюулгүй байдал” хоёрын хоорондын холбоонд нөлөөлөх *эрсдэлийн векторуудын* багцыг тусгайлан авч үзсэн. Өөрөөр хэлбэл, макро хувьсагчид болон эдийн засгийн аюулгүй байдлын хоорондын “дундын орчин” бас чухал гэсэн практик санааг мөн шингээсэн. Ингэхдээ эрсдэлийн векторууд хэрхэн илэрч, макро эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлөх замаар аюулгүй байдалд аюул занал учруулж болохыг авч үздэг. Зураг 4-т улбар шараар харуулсан *эрсдэлийн векторуудыг* дараах байдлаар сонгоно:

- **Хөрөнгийн эзэмшил.** Дотоод эдийн засагт орж ирсэн ГШХО-ын хэмжээ их байхын хэрээр тухайн хөрөнгө оруулсан улс орнууд, компаниудтай илүү их харилцаа холбоотой байхад хүрнэ. Улмаар ГШХО-ын үйл ажиллагаа нь дотоод эдийн

засагт “хор хөнөөл” учруулах нэг суваг болох эрсдэлийг дагуулж байдаг. Тус хөрөнгө оруулалтаар дамжуулан гадаадын байгууллагууд дотоодын стратегийн чухал салбарууд (жишээ нь, харилцаа холбооны компаниуд, эрчим хүчний хангамж, түгээлтийн компаниуд гэх мэт)-ын үйл ажиллагаанд хяналт тогтоох, нөлөөлөх эрсдэлийг дагуулж болзошгүй. Энэ давуу байдлыг стратегийн хувьд эсвэл буруугаар ашиглах боломжтой (жишээ нь, эрчим хүч, дулааны хангамжийг тасалдуулах). Хэрэв үндэсний аюулгүй байдалтай холбоотой чухал салбаруудад хөрөнгө оруулалт хийхдээ хувийн компаниуд нууц мэдээлэл олж авах зорилготой байх тохиолдолд эрсдэл нь бүр нэмэгддэг. Чухал салбаруудад гадаадын төрийн өмчит компаниудын өмчлөл, нөлөөлөл нэмэгдэх тохиолдолд энэ нь арилжааны ашиг сонирхлоос илүүтэй геополитикийн сонирхол давамгайлж буйг илэрхийлнэ.

- **Тагнуул, нууц мэдээлэлд нэвтрэлт.** Гадаадын эзэмшил хувь өсөх болон ханган нийлүүлэгчээс хамааралтай байдал нэмэгдэхтэй холбоотой эрсдэлүүд нь тагнуулын зорилготой аюул занал (нууц мэдээлэл, тоон өгөгдлийг зөвшөөрөлгүй хүн, байгууллага олж авч хор хөнөөлтэй зорилгоор ашиглах)-ыг нэмэгдүүлнэ. ГШХО хийх, техник хангамж, программ хангамжийг тусламж хэлбэрээр өгөх, худалдах эсвэл чухал салбаруудад ажилд орох ажиллах замаар гадаадын оролцогчид (компани эсвэл хувь хүмүүс) стратегийн салбарууд, дэд бүтэц болон процессуудын дизайн, үйл ажиллагаа, менежментийн талаарх нууц мэдээллийг олж авах боломжтой болж, энэ мэдээллийг буруу зорилгоор ашиглаж болзошгүй бүлэгт дамжуулж болзошгүй байдаг.
- **Байгалийн нөөцөөс хамааралтай байдал.** Олон улсын худалдаа нь тухайн улс хэрэглээ, үйлдвэрлэлд шаардлагатай бүх нөөцөө олж авах, өөрт байгаа байгалийн баялаг, бүтээгдэхүүнээ гадагшаа худалдаж орлого олоход тусалдаг. Гэхдээ стратегийн импортын бүтээгдэхүүнийг цөөн нийлүүлэгчээс авдаг, экспортын бүтээгдэхүүний мөн цөөн худалдан авагчид борлуулдаг бол, үндэсний аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй хараат байдлыг бий болгоно. Тухайлбал, чухал салбаруудын хувьд импорт (жишээлбэл, эрчим хүчний импорт эсвэл үйлдвэрлэлд шаардлагатай нөөцийн импорт)-д хэт найдах нь үндэсний эдийн засгийн чухал салбаруудыг гадаад орны нөлөөнд хүргэж болзошгүй. Иймд эрчим хүчний хэрэгцээгээ дотооддоо хангадаг болох асуудал чухлаар тавигддаг. Түүнчлэн байгалийн баялгийн экспорт нэг худалдан авагч эсвэл үндэстнээс хамааралтай байх нь эмзэг байдлыг бий болгож болзошгүй. Үүний нэг жишээ нь, экспортын гол худалдан авагчийн хил дээр гацаа, саад үүсэх үед экспортын орлого буурч, эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхийг КОВИД-19 цар тахлын үед харж байна.
- **Нийлүүлэгчээс хамааралтай байдал.** Чухал дэд бүтэц, чухал салбарууд дахь ГШХО, олон улсын худалдаа (тухайн улсад орж ирэх бүтээгдэхүүн, үйлчилгээний импорт)-гаар дамжуулан ханган нийлүүлэгчид, нийлүүлэлтийн сүлжээнээс хараат байдалд хүргэж болзошгүй. Мөн л КОВИД-19 цар тахлын үед үйлдвэрлэлийн процесс дахь аль нэг чухал орц (жишээ нь, электрон бараа, машин үйлдвэрлэлд ашигладаг чипний хомсдол) нь нийлүүлэлтийн сүлжээ, нийлүүлэгчээс шалтгаалж тасалдах тохиолдол цөөнгүй гарч байна.

- **Засгийн газрын оролцоо.** Чухал дэд бүтэц, салбар, процесст зохицуулалт хийснээр Засгийн газрууд эдийн засгийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж, түүнтэй уялдуулан төсвийн зардлын хэмжээг тодорхойлох боломжтой. Засгийн газрын стратегийн салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ (төсвөөс болон бусад сувгаар) нь үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөтэй байх болно. Чухал ач холбогдол бүхий үндэсний дэд бүтэц, салбарууд, процессуудын дизайн, ашиглалт, менежмент дэх санхүүжилт нь эмзэг байдлаас хамгаалахад тусална. Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлогууд, эдгээр бодлогыг боловсруулах засгийн газрын чадавх нь үндэсний аюулгүй байдалд мөн нөлөөтэй. Худалдааны тариф салбар тогтоох, хүүгийн татаас олгох зэрэг бодлого нь эдийн засагт орж ирж буй хөрөнгийн хэмжээг хянах хэрэгсэл болж ашиглагддаг. Энэ нь ГШХО-ыг татах, дотоодын компаниудын өсөлт, өрхүүдийн санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөтэй. Иймд чухал дэд бүтэц, салбар, процессыг үр дүнтэй зохицуулах нь үндэсний аюулгүй байдалд ач холбогдолтой. Засгийн газар эдийн засгийн үйл ажиллагааг, тэр дундаа чухал салбар, процесс дэх зохицуулалтыг сайн хийгүйг зах зээлд шууд даатган орхих тохиолдолд зах зээлийн хүч нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдалд сөрөг үр дагавартай байж болзошгүй.
- **Авлигал, луйвар.** Авлига, луйвар нь зохицуулалт алдаатай болох, хэрэгжилтийг сул байлгах суурь шалтгаан тул чухал салбар, процесст олон төрлийн сөрөг нөлөө үзүүлнэ. Чухал процесс, салбарт авлига байсаар байх нь ил тод байдлыг бууруулах, ардчилсан зарчмыг гуйвуулах, төрийн үйлчилгээ, биет дэд бүтцийн чанар, хүртээмжийг бууруулах замаар үндэсний аюулгүй байдалд том аюул учруулна.
- **Нийгэм-эдийн засгийн тэгш бус байдал.** Нийгэм-эдийн засгийн тэгш бус байдал нь эдийн засгийн олон үйл явдлаар дамжин үндэстний аюулгүй байдалд аюул занал бий болгоно. Үүний сүүлийн жишээнд Казахстан улсад болсон үймээнийг нэрлэж болно. Нийгэм-эдийн засгийн тэгш бус байдлын эдийн засгийн шалтгаан нь доогуур ажил эрхлэлт, хэт чөлөөтэй олон улсын худалдаа, бүс нутгийн болон глобал хөгжлийн чиг хандлага, нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэж чадаагүй явдал юм. Үндэсний аюулгүй байдлын хүрээнд тэгш байдлыг хангах нь чухал дэд бүтэц, салбар болон процесс (ардчилсан институт, шийдвэр гаргалтын процесс)-ийг бий болгохтой адил чухал юм. Тэгш бус байдал даамжрах нь шийдвэрлэхэд төвөгтэй олон сорилтуудыг бий болгох, тодорхой бүлгүүдийн зөрчил, мөргөлдөөнийг эхлүүлэх, оролцоход түлхэц үзүүлж болзошгүй байдаг. Улс төрийн тогтворгүй байдал, дотоод зөрчилдөөн нь эргээд хөрөнгө оруулалтыг сааруулж, тухайн үндэстний эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.

Өнөө цаг дор глобал эдийн засгийн болон технологийн хөгжлийн чиг хандлагыг сайтар ойлгох нь эдийн засгийн бодлогыг зөв тодорхойлох, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах суурь нөхцөл юм. Иймд энэ хэсэгт санал болгож буй арга зүйн хувьд дотоод макро эдийн засгийн хувьсагчид, эрсдэлийн векторуудад, улмаар эдийн засгийн аюулгүй байдалд хүчтэй нөлөөтэй байх хоёр нэмэлт глобал чиг хандлагыг оруулж ирсэн:

- **Глобал болон бүс нутгийн геополитик (стратегу) болон макро эдийн засгийн чиг хандлага.** Глобалчлал, харилцан хамааралтай байдал, бүс нутгийн хөгжлийн

чиг хандлага, их гүрнүүдийн улс төр, эдийн засгийн прагматик гарч буй болон уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн аюулгүй байдалтай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж буй зэргийг авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

- **Технологийн болон мэдээллийн чиг хандлага.** Цахим шилжилт, аж үйлдвэрийн интернэт (industrial Internet of Things)-ийн өсөлт, мэдээллийн бүрэн бүтэн байдлын талаарх санаа зовоосон асуудал болон ардчилсан сонгууль, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг чухал процесс алдагдах зэрэг боломж, эрсдэлийг ч давхар харгалзах нь чухал боллоо.

Энэ хэсэгт танилцуулсан шинэ арга зүйг практик дээр эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг хийхэд ашиглах бүрэн боломжтой гэж үзэж байна. Үүний нэг жишээ нь, Монголын эдийн засгийн онцлог, түүнтэй холбоотой эдийн засгийн эрсдэлүүд (жижиг нээлттэй эдийн засаг), түүхий эдийн экспортод хэт төвлөрсөн, нэг зах зээлд экспортоо гаргадаг, шатахуунаа 100 хувь нэг улсаас, цахилгаан эрчим хүчний багагүй хувийг хоёр хөршөөс импортолдог, авто тээврийн салбарт гадаад компаниудын эзлэх хувь өндөр, дэд бүтцийн сул хөгжил, ГШХО нэг салбарт л төвлөрөн орж ирдгийн дээр ГШХО-ын бүтцэд цөөн улсын эзлэх хувийн жин өндөр, хүмүүн капиталын хөгжил сул, том төсөл, хөтөлбөрүүдэд гадаад ажиллах хүчний оролцоо өндөр зэрэг)-ийн талаарх үнэлгээ, тайлбар, шинжилгээг төстэй байдлаар бодит тоон өгөгдөл ашиглан Д.Ган-Очир (2020, 2022)-т дэлгэрэнгүй авч үзсэн явдал юм.

Дүгнэлт, санал

Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт, үзэл баримтлал түүхэн цаг хугацааны туршид хувьсан өөрчлөгдөж ирлээ. Онолын урсгалууд, түүхэн үйл явдал, хөгжил нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг дан ганц батлан хамгаалах, цэрэг арми гэсэн явцуу хүрээнд бус илүү өргөн хүрээтэй авч үзэх шаардлагыг бий болгож байна. Тэр дундаа улс орны эдийн засгийн чадавх нь цэрэг, арми, нийгэм, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх суурь нөхцөл тул эдийн засгийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг дэд, гэхдээ чухал бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх хандлага бүрэлдэн тогтоод байна.

Үндэсний аюулгүй байдлын талаарх олон төрлийн үзэл баримтлал нь судалгаа, шинжилгээний ялгаатай аргачлалууд хөгжихөд тусгалаа олж байна. Тухайлбал, эдийн засгийн аюулгүй байдлын хувьд макро эдийн засгийн хандлага (энэ нь дотроо Оросын босго утгын хандлага болон Briguglio (2004)-ийн эмзэг байдлын шинжилгээ) болон хувь хүний хандлага (Америк хандлага болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (2004)-ын аргачлал)-д хуваагдан, аль аль хандлага нь сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, практик ашиглагдаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь олон улсын нийтлэг чиг хандлагатай нийцтэй байгаа бөгөөд баримт бичгийн хувьд өргөн хүрээг хамарсан, үндэсний дотоод асуудалд илүүтэй төвлөрсөн гэсэн ангилалд багтахар байна. Харин тус үзэл баримтлалыг эдийн засгийн бодлого, үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжилтийг үр дүнтэй хангах, явцын үнэлгээ, мониторинг хийх тал дээр учир дутагдалтай явж ирлээ.

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх асуудлыг ил тод зарлан тунхаглаж байна. Бодлого зарлах нэг хэрэг, харин одоо бодлогын дизайн гарган

хэрэгжүүлж, үр дүн гарч эхлэхэд түүнд мониторинг хийж, шаардлагатай тохиолдолд бодлогын дизайны өөрчлөлтийг сайжруулах ёстой болно. Энэ зорилтын хүрээнд эдийн засгийн бие даасан байдал, эдийн засгийн аюулгүй байдалд үнэлгээ, мониторинг хийх арга зүйг тодорхойлж, тогтмол ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Манай орны орны онцлог, тоон өгөгдлийн боломж, аргачлалын нийцтэй байдлыг харгалзан дүгнэхэд эдийн засгийн бие даасан байдлын индексийг Helmy (2017)-ийн аргаар тооцох, эдийн засгийн эмзэг байдал, дархлааны үнэлгээг Briguglio (2004) аргаар хийх, эдийн засгийн аюулгүй байдлын үнэлгээ, мониторинг Retter болон бусад (2020) аргаар шинэчлэх бүрэн боломжтой байна. Иймд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, түүний дэргэдэх алба, хүрээлэнд эдгээр аргачлалыг өөрийн оронд нутагшуулан ашиглах, тогтмол давтамжтай үр дүнг гаргаж, үндэсний хэмжээний бодлого, шийдвэрт харгалзаж байхыг санал болгож байна.

Эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд тодорхойлогдож буй бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ, мониторинг хийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах бодлого, арга хэмжээг тодорхойлох хүрээнд эдгээр аргачлалыг ашиглан судалгаа, шинжилгээ хийх аянд цаашид нэгдэх болно.

-
1. Briguglio, L. (2004). 'Economic Vulnerability and Resilience: Concepts and Measurements'. In L. Briguglio and E. J. Kisanga (eds), *Economic Vulnerability and Resilience of Small States*. Malta: Islands and Small States Institute and London: Commonwealth Secretariat.
 2. Buzan, B, Ole, W and Wilde, J 1998, *Security: A New Framework for Analysis*, London: Lynne Rienner Publishers.
 3. Elman, C 2008, 'Realism.' in *Security Studies: An Introduction*, edited by Paul D. Williams. New York: Routledge.
 4. Д.Ган-Очир 2012, 'Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: Инфляц, эдийн засгийн өсөлтийн хөтөч үзүүлэлтийг тодорхойлох нь', Судалгааны ажлын эмхэтгэл, Дугаар 7, Монголбанк.
 5. Д.Ган-Очир 2017, 'Эдийн засгийн эмзэг байдал, цаашид анхаарах асуудлууд', Монголбанк, <https://mongolbank.mn/documents/prnews/2017/20170925_2.pdf>.
 6. Д.Ган-Очир 2020, Монголын хөгжлийн зам: Сургамж, Сорилт, Боломж, Улаанбаатар хот.
 7. Д.Ган-Очир 2022, Монголын эдийн засгийг тогтворжуулах бодлогын эрэлд: Загварчлал, Шинжилгээ, Шийдэл, Улаанбаатар хот.
 8. Hacker, J, Huber, G, Nichols, A, Rehm, P, Schlesinger, M, Valletta, R and Craig, S 2012, 'The economic security index: A new measure for research and policy analysis', Working Paper 2012-21, Federal Reserve Bank of San Francisco.
 9. International Labour Organization 2004, *Economic security for a better world*, International Labour Office, Geneva.
 10. Glaser, C 1997, 'The security dilemma revised', *World Politics*, vol. 50, no. 1, pp. 171-201.

11. Kremer-Matyskevic, I and Cernius, G 2019, 'Country's economic security: Theoretical Insights', MRU Repository, < <https://repository.mruni.eu/handle/007/16031>>.
12. Retter, L, Frinking, E, Hoorens, S, Lynch, A, Nederveen, F abd Phillips, W 2020, 'Relationships between the economy and national security', RAND Corporation, Cambridge: UK.
13. Tamosiunniene, R and Munteanu, C 2015, 'Current research approaches to economic security', New Challenges in Business Research: 1st International Conference on Business Management, pp. 55-58.
14. С.Цэцгээ 2008, Даяаршлын нөхцөл дэх үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, түүнийг хангах механизмыг боловсронгуй болгох нь: Онол, практик, дүгнэлт, Улаанбаатар хот.



Э.ЭНХТАЙВАН

ҮАБЗ-ийн ССХ-ийн

Шинжээч, докторант

БНХАУ-ЫН 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БА КОКСЖИХ НҮҮРС, ЗЭСИЙН ЭРЭЛТ

Abstract: *Mongolia's main economic drivers are its foreign trade, including exports of copper concentrate and coking coal. Our southern neighbor China, is the world's second-largest economy, and is a major recipient of these products, accounting for almost 17 percent of global coking coal imports and 50 percent of copper concentrate imports. Therefore, an in-depth analysis of China's economic outlook for 2022 and a forecast of coal and copper demand is important for Mongolia's short and medium-term economic policy.*

Keywords: *People's Republic of China, Economy, coking coal, copper concentrate, foreign trade*

Нэг. БНХАУ-ын 2021 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд үндэслэсэн, 2022 оны эдийн засгийн төлөвийг шинжлэх нь

БНХАУ нь дотоод дахь цар тахлын тархалтыг хатуу бодлогоор барьж, аж үйлдвэрлэл, экспортын өндөр өсөлтийг бий болгосноор эдийн засаг нь 2021 онд сүүлийн 10 жил дэх хамгийн өндөр өсөлтийг үзүүлж дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь 8.1 хувь буюу 3 их наяд ам.доллараар өсжээ. Харин 2022 онд 5.5 хувиар өсгөх зорилт дэвшүүлсэн байна¹.

Хятадын эдийн засгийн сэргэлтийн гол хөдөлгөгч хүч нь 2021 онд экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийн салбар байв. Хэдийгээр жилийн эцсийн гүйцэтгэлээр эдийн засгийн өндөр өсөлтийг үзүүлсэн боловч 2021 оны хоёрдугаар хагасаас Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарт үүссэн хүндрэл, бэрхшээл, цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хатуу арга хэмжээ, хөл хорио, түүнээс үүдэлтэй дотоодын зарлага-хэрэглээний сул өсөлт, экспортын дэмжлэг буурсан зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан ковидын дараах эдийн засгийн хурдтай өсөлт нь цаашид тогтворжих хандлага ажиглагдаж байна.

¹ China GDP: 2022 economic growth target is within reach, 'but it will come at a cost, <https://www.scmp.com/>

Тухайлбал, 2021 оны эхний гурван улиралд ДНБ нь 18.3, 7.9, 4.9 хувиар тус тус өссөн боловч IV улиралд 4 хувь болж буурсан. Мөн үйлчилгээ, дотоод хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт нь цар тахлын өмнөх үеэс бага байхын сацуу ДНБ-ий өсөлттэй адилаар оны эцэст мөн л буурчээ (Хүснэгт-1). Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүний сүүлийн хоёр жилийн гарцын дундаж өсөлт цар тахлын өмнөх 2019 оны үеэс давж, экспортын өсөлтийн хурд 2011 оноос хойших хамгийн дээд түвшиндээ хүрсэн.

**Хүснэгт 1 БНХАУ-ын Макро эдийн засгийн зарим үзүүлэлт
(2021 оны байдлаар, улирлаар)**

№	Үзүүлэлт	Эхний 3 улирлын дундаж өсөлт (хувь)	IV улирлын өсөлт (хувь)	Өөрчлөлт (хувь)
1	Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгө оруулалт	7.3	4.9	-2.4
2	Үл хөдлөх хөрөнгийн салбар дахь нийт хөрөнгө оруулалт	8.8	4.4	-4.4
3	Аж үйлдвэрийн нэмүү өртгийн өсөлт	9.6	11.8	+2.8
4	Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний нийт жижиглэнгийн борлуулалт	16.4	12.5	-2.9
5	Гадаад худалдаа	22.7	21.4	-1.3
6	Хятадын үйлдвэрлэлийн салбарын индекс (Purchasing Managers' Index-PMI)	50.1 (11-р сар)	50.3	0.2

Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний Статистикийн Товчооны дүн мэдээн дээр үндэслэн тооцов.

Хятадын Засгийн газрын зүгээс үл хөдлөх хөрөнгийн салбар дахь эрсдэлийг бууруулах зорилготой авсан хатуу арга хэмжээний үр дүнд нийт хөрөнгө оруулалт буурч, улмаар ДНБ-ий өсөлтийн хурд буурахад голлох нөлөөг үзүүлсэн байна (Зураг-1).

Зураг 1 Хятадын ДНБ-ий өсөлт ба эрэлтийн талын хүчин зүйлс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар




Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо

Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт. Хөрөнгө оруулалт (дэд бүтэц, машин, тоног

төхөөрөмж болон үл хөдлөх хөрөнгийн салбар) 2021 оны хоёрдугаар хагасаас буурч эхэлсэн бөгөөд үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалт энэ хугацаанд 15-4.4 хувь болж 10.6 пунктээр буурсан. Хэдийгээр Засгийн газраас үл хөдлөх хөрөнгийн салбар дахь өрийн хязгаарлалтыг IV улиралд сулруулсан ч салбарын хөрөнгө оруулалтын өсөлт эхний 11 сарын дундаж 6-4.4 хувь болж буурсан.

Нийт хөрөнгө оруулалт 2021 оны IV улирлын байдлаар 4.9 хувиар өссөн нь эхний 11 сарын дундаж 5.2 хувьтай харьцуулахад буурсан үр дүн байна. Үл хөдлөх хөрөнгийн салбарын эрсдэлийг бууруулахын тулд төв Засгийн газар болон орон нутгийн засаг, захиргаанаас салбар дахь далд хөрөнгө оруулалт, өрийг зохицуулж, орон сууцыг дамлан худалдаалахтай тэмцэх хүчтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, мөн газрын худалдааг хязгаарласны үр дүнд дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалт буурч жилийн эцэст 0.4 хувьд хүрчээ.

Зураг 2. Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт, өссөн дүнгээр, хувиар, (2021 оны байдлаар, сараар)



Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо

Хэдийгээр гол салбар дахь хөрөнгө оруулалт буурсан боловч гадаад худалдааны эрэлтийг даган аж үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдсээр байв. Аж үйлдвэрийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2021 онд өмнөх оныхоос 13.5 хувиар өссөн бөгөөд тусгай зориулалтын болон цахилгаан машин, механизмд оруулсан хөрөнгө оруулалт хамгийн их буюу өнгөрсөн оны мөн үеийнхээс 24.3 хувиар өссөн.

Гадаад худалдаа. Хятадын эдийн засгийн сэргэлтийг гол өдөөгч хүч нь гадаад худалдаа байсан бөгөөд 2021 оны гадаад худалдааны гүйцэтгэл өмнөх онтой харьцуулахад 30 хувиар өсжээ. Үүний үр дүнд дэлхийн экспортод Хятадын эзлэх хэмжээ 14.9 хувь болсон (2019 онд 13.1, 2020 онд 14.7 хувь). Олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд доголдол үүссэн байгаа өнөө үед Хятадын экспортын тээвэрлэлт харьцангуй хурдтай байсныг дурдах нь зүйтэй.

Хүснэгт 2. Хятадын гадаад худалдаа, (2021 оны байдлаар)

	Дүн (ам.доллар)	Жилийн өсөлт (хувь)
Нийт гадаад худалдаа	6.05 их наяд	30
Экспорт	3.36 их наяд	29.9
Импорт	2.69 их наяд	30.1
Гадаад худалдааны ашиг	676 тэрбум	26

Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо

Хэдийгээр нийт дүнгээр авч үзэхэд гүйцэтгэл сайн байсан хэдий ч өнгөрсөн оны сүүлийн улиралд экспорт болон импортын өсөлтийн хурд удааширч эхэлсэн байна (Зураг 3). Дэлхийн олон улс, ялангуяа хөгжингүй орнууд цар тахалтай дасан зохицох стратеги руу шилжиж, хөл хорио, хязгаарлалтууд суларч эхлэхтэй зэрэгцэн Хятадын бүтээгдэхүүний гадаад дахь эрэлт буурсан нь анхаарал татсан асуудал юм. Тухайлбал 2021 оны сүүлийн гурван сарын экспортын өсөлт өмнөх саруудаас буурчээ. Үүнд Хятадаас бараа бүтээгдэхүүн импортлогч хөгжингүй болон хөгжиж буй улсуудад эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний үнийн хурдацтай өсөлтөөс улбаатай инфляц, ажилгүйдэл нэмэгдэж, худалдан авах чадвар буурсан, иргэд ААН-ийн үйл ажиллагааг дэмжих сангийн бодлого суларсан нь голлон нөлөөлж байна. Энэхүү хандлага цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна.

Зураг 3. БНХАУ-ын гадаад худалдааны өсөлт, 2021 оны II хагас (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувиар



Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо

Нөгөө талаас импорт 12 дугаар сард 2021 оны мөн үеийнхээс 19.5 хувиар өссөн нь 12 дугаар сард 28 орчим хувиар өснө гэсэн хүлээлтээс 8.5 хувиар бага байгаа нь дотоод дахь эрэлт хэрэгцээ буурч байгааг илтгэсэн явдал юм. АНУ болон Хятадын гадаад худалдааны хэлэлцээрийн нэгдүгээр шат 2021 онд дууссан боловч АНУ нь Хятадын гадаад худалдааны хамгийн том түнш хэвээр байж, Хятадын экспорт 2021 онд 27.5 хувиар (576.11 тэрбум ам.доллар), импорт 32.7 хувиар (179.53 тэрбум ам.доллар) тус тус өсжээ. БНХАУ-ын АНУ-тай хийсэн худалдааны ашиг сүүлийн 2 жил дараалан өсөж 396.58 тэрбум ам.долларт хүрчээ². Түүнчлэн өнгөрсөн онд хоёр талын хурцадмал байдлыг

² Хоёр улсын худалдааны маргаанаас шалтгаалан 2018-2019 оны хооронд Хятадын АНУ-руу хийх экспорт 14.3 хувиар, импорт 13.3 хувиар тус тус буурсан.

үл харгалзан БНХАУ-ын Австрали руу хийсэн экспорт 24.2 хувиар өссөн бол импорт 40 хувиар мөн өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гарц. Хятадын аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний гарцыг 2020 онтой харьцуулахад 9.6 хувиар өсөхийн зэрэгцээ, сүүлийн хоёр жилийн дундаж өсөлт 6.1 хувь байгаа нь цар тахлын өмнөх 2019 оны түвшнийг давсан үзүүлэлт болсон байна. Бусад голлох макро эдийн засгийн үзүүлэлтүүд буурсан бол аж үйлдвэрийн үйлдвэрлэл 12 дугаар сард өмнөх сарын 3.8 хувийн өсөлтөөс давж 4.3 хувиар өссөн. Энэ нь цаашид эрчим хүч, чипний хомстлоос үүдэлтэй нийлүүлэлтийн хомстолыг зохицуулах, таагүй байдлыг бууруулах боломжтойг харууллаа.

Зураг 4. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гарцын өсөлт, хувиар




Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо

Дүгнэж хэлбэл, Хятадын экспортын өсөлт 2021 онд нийт эдийн засаг улам дордохоос сэргийлэх гол хэрэгсэл болж, аж үйлдвэрлэлийн салбарын өсөлтийг дэмжсэн. Гэсэн хэдий ч сүүлийн улиралд хөгжингүй орнууд эдийн засгийн өсөлтийг дэмжих, иргэдийн орлогыг дэмжих сангийн бодлогоо цуцалснаар экспортын өсөлт 2022 онд удаашрах шинж тэмдэг илэрч, гадаад эрэлт, аж үйлдвэрлэлийн өсөлтийн хурд буурах хандлагатай байна.

Дотоод хэрэглээ. 2021 оны IV улирлын байдлаар Хятадын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа өмнөх оноос 12.5 хувиар өссөн. 12 дугаар сард нийт жижиглэнгийн борлуулалт өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өссөн нь 11 дүгээр сарын 3.9 хувийн өсөлтөөс 2.2 пунктээр бага байгаагийн зэрэгцээ наймдугаар сараас хойших хамгийн бага өсөлт болж байна. Хятадын өрх, Засгийн газар, аж ахуй нэгжийн хэрэглээ (дотоод хэрэглээ) сулрахад 2021 оны эцэст дотоод дахь өвчлөл нэмэгдэж, хатуу хөл хориог хэсэгчлэн тогтоосон, Өвлийн олимпийн XXIV наадам зохион байгуулагдахтай холбоотойгоор хяналт, шалгалт нэмэгдүүлсэн зэрэг нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, нийтийн хоолны салбарын орлого 2021 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан. Хэдийгээр нийтийн хоолны салбарын орлого, жижиглэнгийн худалдааны орлого 2021 онд өмнөх онтой харьцуулахад 18.6, 11.8 хувиар

тус тус өссөн боловч салбаруудын сүүлийн хоёр жилийн дундаж өсөлт нь тус бүр -0.5, 4.5 хувь буюу цар тахлын өмнөх үеийнхээс доогуур хэвээр байгаа юм.

Зураг 5. Өргөн хэрэглээний барааны жижиглэнгийн худалдааны өсөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, (2021 оны байдлаар, сараар)



Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо

Өнгөрсөн онд тус улсын нэг хүнд ногдох ДНБ 12,551 ам.доллар болж, Дэлхийн банкны өндөр орлоготой орны босго руу дөхсөн. Гэтэл Хятадын өрхийн орлогын өсөлт 2021 оны IV улиралд (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) 5.4 хувь байгаа нь 2020 оны IV улирлын 6.3 хувьтай харьцуулахад бараг 1 пунктээр буурсан үзүүлэлт байлаа. 2022 оны эхний хагас жил, цаашилбал гуравдугаар улирлын төгсгөл хүртэл³ Хятадын төв Засгийн газраас баримталж буй “тэг ковид” бодлого үргэлжилбэл энэхүү хандлага эдийн засагт нь томоохон хүндрэлийг үүсгэж болзошгүй. Хятад улсын энэхүү хатуу бодлого дуусгавар болсны дараа өвчлөл, түүний хохирол хэр хэмжээнд хүрэх нь ч бас анхаарал татсан асуудал хэвээр байна.

Хятадын үйлдвэрлэлийн салбарын индекс. Хятадын үйлдвэрлэлийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (Purchasing Managers' Index) 2022 оны нэгдүгээр сард 50.1 хувьтай гарсан нь өнгөрөгч оны 12 сартай харьцуулахад 0.2 пунктээр буурчээ. 2021 оны 12 дугаар сартай харьцуулахад түүхий эдийн худалдан авалтын үнийн дүнг хэмждэг дэд үзүүлэлт 8.3 хувиар, барааны борлуулалтын үнийг хэмждэг дэд үзүүлэлт 5.4 хувиар өссөн байна. Харин шинэ захиалгыг хэмждэг дэд үзүүлэлт нэгдүгээр сард 0.4 хувиар буурч 49.3 болсон бөгөөд үйлдвэрлэлийн салбарын эрэлт буурч эхэлснийг илтгэж байна. Мөн үйлдвэрлэлийн бус салбарын PMI үзүүлэлт өмнөх сараас 1.6 хувиар буурч 51.1 болсон нь цар тахлын халдвар нэмэгдэж, хязгаарлалтын дэглэм тогтоох болсонтой холбоотой. 2022 оны нэгдүгээр сарын дүнг ерөнхийд нь авч үзвэл Хятадын дотоодын эрэлтийн өсөлт 2021 оны төгсгөл үетэй адилаар хангалтгүй хэвээр байна.

Хоёр. Хятадын коксжих нүүрсний зах зээлийн төлөв

Ерөнхий. Дэлхийн хэмжээнд нийлүүлсэн коксжих нүүрсний импорт 2021 онд 3 сая. тонноор (+1.0 хувь) нэмэгдэж 323 сая.тоннд хүрсэн. Өсөлттэй байгаа хэдий ч нийт импорт

³ Бүх Хятадын Коммунист намын XX их хурал хүртэл.


2019 оны түвшнээс доогуур хэвээр байна. Үүний зэрэгцээ коксжих нүүрсний ханш өнгөрсөн онд шинэ дээд амжилт тогтоосон бөгөөд үүнд цар тахлын дараах сэргэлтээс шалтгаалсан эрэлт, коксжих нүүрсний нийлүүлэлт буурсан зэрэг голлон нөлөөлжээ⁴. Хятадын хувьд 2021 оны 7 дугаар сараас хойш гангийн үйлдвэрлэл буурсантай холбоотойгоор коксжих нүүрсний хэрэгцээгээ бууруулсан ч коксжих нүүрсний үнэ дээд амжилт тогтоож, арбитраж хийх боломжийг үл харгалзан Австралийн нүүрсэнд хориг тавьсан хэвээр байлаа. Үүний зэрэгцээ БНСУ, Япон, Энэтхэг зэрэг орнуудын эдийн засаг, гангийн үйлдвэрлэл 2020 оны уналтаас сэргэж байгаа тул нүүрсний импорт нь нэмэгджээ.

Тухайлбал, Өмнөд Солонгосын импорт 6 сая.тонноор, Япон улсын импорт 4 сая. тонноор тус тус өссөн. Хятадын бүх төрлийн нүүрсний нийт импорт 2020 онтой харьцуулахад 6.6 хувиар өсөлттэй гарсан боловч коксжих нүүрсний импорт (54.7 сая. тонн) 24.6 хувиар буурсан байна. Гэхдээ коксжих нүүрсний импортын хэмжээ буурсан ч худалдан авалтын үнийн дүн нь зах зээлийн үнэтэй холбоотойгоор 30.5 хувиар нэмэгдэж 11 тэрбум ам.доллартой тэнцжээ⁵.

Сарын дүнгээр авч үзвэл Хятад улс өнгөрсөн оны 12 дугаар сард 7.49 сая.тонн коксжих нүүрс импортолсон нь өмнөх 11 дүгээр сарынхтай (7.74 сая.тонн) харьцуулахад 3.3 пунктээр буурсан байгаа бол 2020 оны сүүл сартай (3.56 сая.тонн) харьцуулахад хоёр дахин өссөн.

2022 онд ширэм, гангийн үйлдвэрлэл нь үргэлжлэн өргөжин тэлж, импортын мэдэгдэхүйц өсөлт явагдана гэж таамаглаж буй цорын ганц улс нь Энэтхэг байгаа ба тооцооллоор 2024 онд Энэтхэгийн импорт Хятадыг гүйцэх төлөвтэй байна.

Зураг 6. БНХАУ, БНЭУ, БНСУ, Япон улсын гангийн үйлдвэрлэл, (2021.02 сараас 2022.01 сар) (мянган. тонн)



Эх сурвалж: Дэлхийн гангийн холбооны тоон мэдээг ашиглан боловсруулав.

⁴ 2020 онд Хятадын коксжих нүүрсний импортын 50 орчим хувийг Австрали улс бүрдүүлж байсан бол 2020 оны 10 дугаар сараас албан бус хоригт орсон. Мөн Ковид-19-ийн тархалтаас шалтгаалж Монгол Улсын экспорт ч тасалдсан байна.

⁵ Хятадын гаалийн ерөнхий газар

Нийлүүлэлт. Орос-Украины хямрал хурцадмал байдалд шилжсэний үр дүнд ОХУ-ын коксжих нүүрсний Европын зах зээл рүү чиглэж байсан экспорт Ази руу, тэр дундаа БНХАУ-руу чиглэх дүр зурагтай байна. Энэ нь Ази, Номхон далайн бүс дэх коксжих нүүрсний нийлүүлэлтийн хүндрэлийг бууруулахад тус дөхөм болно. Өнгөрсөн онд ОХУ улс 31.81 сая.тонн коксжих нүүрс экспортолсон бөгөөд коксжих нүүрсний экспортынх нь гол таван чиглэлийн гурав нь Хятад, Өмнөд Солонгос, Япон зэрэг Азийн орнууд байлаа. Тус гурван улсад нийлүүлсэн коксжих нүүрсний хэмжээ 16.2 сая.тонн болсон нь Оросын нийт экспортын 50.9 хувийг бүрдүүлжээ (үүний 9.31 сая. тонныг Хятадад экспортолсон).

Харин ОХУ-ын экспортын Европын чиглэлийг авч үзвэл 6.82 сая.тонныг Украин 1.18 сая.тонныг Нидерланд, 0.52 сая.тонныг Турк, 0.25 сая.тонныг Марокко, 0.24 сая. тонныг Польш руу тус тус нийлүүлсэн⁶. Орос-Украины мөргөлдөөн нь Хар тэнгис дэх боомтуудын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлбөл Оросоос Турк руу чиглэсэн коксжих нүүрсний худалдааны урсгалд ч мөн нөлөөлж болзошгүй юм. Орос, Европын хооронд нүүрсний худалдаа зогсох магадлал бага байгаа ч банк, санхүүгийн системийн хориг арга хэмжээ нь дунд хугацаандаа худалдаанд нөлөөлөх нь дамжиггүй. Энэ нь цаашид мөргөлдөөний хугацаа, газарзүйн тархалтаас хамааран өргөжих төлөвтэй байна.

Хориг арга хэмжээ хурцдаж, урт хугацаанд үргэлжилбэл Өмнөд Солонгос, Япон улсуудын коксжих нүүрсний зах зээлийг⁷ Австралийн экспорт, эсрэгээрээ Австралийн Хятад дахь орон зайг⁸ ОХУ нөхөх төлөв ажиглагдаж байна. ОХУ ч мөн Хятадад нийлүүлэх бүх төрлийн нүүрснийхээ экспортыг 3-5 жилийн дотор 100 сая.тоннд хүргэхээр төлөвлөж байгаа нь 2021 оны 57 сая.тоннтой харьцуулахад огцом өсөлт болох юм⁹. ОХУ-аас Хятад руу нүүрсийг гол төлөв төмөр замаар тээвэрлэж байгаа бол нэмэлтээр далай болон ачааны машинаар тээвэрлэгддэг. Сүүлийн жилүүдэд Орос улс БНХАУ-тай нүүрсний нөөцийг хөгжүүлэх, тээврийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна. Оросын нүүрс үйлдвэрлэгчид Хятадаас ч нүүрсний захиалгаа идэвхтэй хайж байна. 2021 онд Хятадын бүх төрлийн нүүрсний импорт 324 сая.тонн болж, өнгөрсөн оныхоос 6.45 хувиар өссөн. Үүний 57 сая.тонныг ОХУ-аас нийлүүлсэн бөгөөд энэ нь тус зах зээлийн 17.6 хувь болж байна (Оросын нүүрсний Хятадын зах зээлд эзлэх хувь 2018 онд 9.7, 2019 онд 10.8, 2020 онд 13 хувь байсан). Хятад улс 2020 оны аравдугаар сараас Австралийн нүүрсний импортыг албан бусаар хориглож, цар тахлын шалтгаантайгаар Монголын экспорт саатсан боловч өвчлөл харьцангуй ихтэй ОХУ-ын экспорт өссөөр байна. Эдгээрийн үр дүнд ОХУ нь Индонезийн дараа Хятадад коксжих нүүрс нийлүүлэх хоёр дахь том улс болсон бөгөөд цаашид мөргөлдөөнөөс шалтгаалж богино хугацаандаа коксжих нүүрсний үнэ өндөр хэвээр байх боловч дунд болон урт хугацаандаа тогтворжих төлөвтэй байна.

⁶ ОХУ-ын Холбооны Гаалийн алба.

⁷ 2021 онд Оросын нүүрс Өмнөд Солонгосын нүүрсний импортын 17.5, Японы импортын 12.4 хувийг тус тус бүрдүүлсэн.

⁸ Хятад, Австралийн худалдааны маргааны улмаас хоёр улсын нүүрсний худалдааг царцаасны дараа Орос Хятадын коксжих нүүрсний хоёр дахь том эх үүсвэр болоод байна. Үүнд цар тахал, дэд бүтцийн хангалтгүй байдалтай холбоотойгоор Монголын нүүрсний экспорт ч тасалдсан нь нөлөөлжээ.

⁹ Россия может увеличить экспорт угля в Китай в два раза, до 100 млн т, <https://energypolicy.ru/>

Зураг 7. Коксжих нүүрсний нийлүүлэлт, 2020 он



Эх сурвалж: Австралийн Уул уурхайн яам

Хятадын дотоод нийлүүлэлт ба XIV 5 жилийн төлөвлөгөө (2021-2025 он). Хятадын XIV таван жилийн төлөвлөгөөгөөр ойрын жилүүдэд нүүрсийг орлуулшгүй эрчим хүчний эх үүсвэр гэж үзэж, нүүрсний олборлолтоо тогтворжуулж, 2025 он гэхэд дотоодоос 4100 сая.тонныг хангах төлөвтэй байна. Үүний зэрэгцээ нүүрсний жилийн дундаж хэрэглээг нэг хувиар өсгөж, 2025 онд 4200 сая.тоннд хүргэх зорилт тавьжээ. 13 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тусгагдсан чиглэлийн дагуу Хятадын уул уурхайн компаниуд уурхайнуудын аюулгүй ажиллагааг нэмэгдүүлж, автоматжуулах, дижитал болгох үйл явц үргэлжилсээр байгаа. Одоогийн байдлаар хамгийн том нүүрс олборлогч болох Шаньси муж 1000 сая.тонн олборлолтын дээд хэмжээг зарласан. Үүний зэрэгцээ, ӨМӨЗО, Шаньси, Шинжаан дахь уурхайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Хятадын нүүрсний олборлолт 2021 онд ойролцоогоор 4.3 хувиар, цаашид жил бүр 0.5 хувиар өсөх төлөвтэй байна.

Гурав. Зэсийн зах зээл

БНХАУ нь дэлхийн боловсруулсан зэсийн хагасыг хэрэглэдэг бол, зэсийн баяжмалын 50 гаруй хувийг хүлээн авагч улс юм. Зэсийн үнэ 2021 онд огцом сэргэж, түүхэн дэх дээд хэмжээнд хүрсэн. Ихэнх түүхий эдийн үнэтэй нэгэн адил зэсийн үнэ хэд хэдэн шалтгааны улмаас өссөн. Үүнд нийлүүлэлтийн талаас нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, олборлогч улсууд дахь “COVID-19”-ийн тархалт ба вакцинжуулалтын явц, Чили, Перу улсуудын олборлолт буурсан зэрэг нөлөөлжээ. Харин эрэлт талаасаа Хятадын болон хөгжингүй орнуудын эдийн засгийн идэвхжил, инфляцын хурдтай өсөлт болон ногоон технологи дахь хөрөнгө оруулалтын өсөлт нь голлох нөлөөг үзүүлсэн. Зэс бол чухал металл бөгөөд ногоон эрчим хүчний чиг хандлага цаашид өөрчлөгдөхгүй бол ирэх жилүүдэд хэрэглээ нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 8. Зэсийн хүдэр болон баяжмалын нийлүүлэлт, 2020 он



2021 оны оны байдлаар Хятадын боловсруулсан зэсийн импорт 2020 оныхоос 17.2 хувиар буурч, 5.53 сая.тоннд хүрсэн бол зэсийн баяжмалын импорт 7.6 хувиар нэмэгдэж, 23.4 сая.тонн боллоо. Өөрөөр хэлбэл, боловсруулсан зэсийн нийлүүлэлтийн тасалдал нь дотоодын үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломжийг олгосон байна. Үүний үр дүнд Хятадын боловсруулсан зэсийн экспорт 2021 онд 932.4 мянган тоннд хүрсэн нь түүхэн дээд үзүүлэлт байв. Үүнийг 2020 онд тус улсын боловсруулсан зэсийн экспорт 744.5 мянган тонн байсантай харьцуулахад даруй 25.2 хувиар өссөн үзүүлэлт билээ. Хятад улсын хувьд зэсийн экспортлогч гэхээсээ хэрэглэгч орон. Гэвч өнгөрсөн онд зэсийн ханш оргил түвшинд хүрч өссөн төдийгүй Лондоны металлын бирж болон Шанхайн бирж дэх ханшийн зөрүү багассан нь экспорт нэмэгдэх гол шалтгаан болжээ.

Нийлүүлэлт талаас нь авч үзвэл 2022 оны хувьд дэлхийн томоохон уурхайнуудын олборлолт нэмэгдэх хандлагатай байна. Тодруулбал дэлхийн хоёр дахь том зэсийн нөөцтэй Индонезийн Грасбергийн уурхайн гүний олборлолт эхэлж гарц нь 12 хувиар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс дахь Камоа-Какула уурхай, Чилийн QB2 зэсийн уурхай, Перу улсын Англо Американ компаний уурхайн олборлолт тус тус нэмэгдэх төлөвтэй байна¹⁰. Үүний зэрэгцээ нийлүүлэлтийн гинжин хэлхээний гацаа арилж байгаа тул энэ онд зэсийн хаягдал дахин боловсруулалт ч нэмэгдэнэ гэсэн тооцоотой байна.

Эрэлт талаас нь авч үзвэл Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хүндрэл бүрэн арилаагүй, дотоод хэрэглээ сул байгаа хэдий ч Хятадын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлогын үр дүнд үл хөдлөх хөрөнгийн салбар, дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалт өсч, орон сууцны эрэлт өсөх боломжтой байна¹¹. Нөгөө талд Хятадын цахилгаан машины борлуулалт өнгөрсөн онд 157.5 хувиар нэмэгдэж, 3,521,000 ширхэгт хүрсэн бол 2022 онд 5 сая ширхэг байх төлөвтэй байна. Хятадын Засгийн газар цахилгаан машины борлуулалтад олгодог татаасыг хоёр жилээр сунгаснаар борлуулалтыг дэмжихэд гол түлхэц үзүүлсэн байна¹². Энэ онд уг төрлийн

¹⁰ Copper market to be well supplied in 2022, <https://www.spglobal.com>

¹¹ Мөн 2022 онд Хятадын цар тахлын эсрэг бодлого зөөлөрвөл (тэг ковид бодлого) дотоод хэрэглээ өсөхийн зэрэгцээ инфляцын өсөлт явагдаж болзошгүй бөгөөд энэ нь орон сууцны эрэлтийг нэмэгдүүлэхийн боломжтой.

¹² Уг татаасын хэмжээ 2020 оны эцсээр дуусгавар болох байсан. Энэхүү татаасын ачаар цахилгаан машины борлуулалтын үнэ тус улсын дотоодод 5000-10000 ам.доллараар буурах нөхцөл бүрдэж байгаа ажээ. Хятад улс нь цахилгаан машины борлуулалтын дэлхийн зах зээлийн 60 орчим хувийг бүрдүүлдэг байна.

машины борлуулалт 5 сая ширхэгт хүрэх төлөвтэй байгаа ба татаасын хугацаа нэмж сунгагдахгүй бол борлуулалт тооцоолсноос ч илүү өсөх магадлал өндөр байна. Нөгөө талаас Хятадын зэс боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадал 2022 онд 660,000 тн/жил (I улиралд 400 мянган тонн/жил, II улиралд 80 мянган тн/жил, IV улиралд 180 мянган тн/жил)-ээр нэмэгдэх хүлээлттэй байгаа нь зэсийн хүдэр, баяжмалын эрэлтийг нэмэгдүүлэх эерэг хүлээлттэй байна.

Харин Хятадын экспортын захиалга буурч, дотоодын хэрэглээ төдийлөн нэмэгдэхгүй байгаа, зэсийг хөнгөн цагаанаар орлуулах боломж нэмэгдэж байгаатай холбоотойгоор гэр ахуйн цахилгаан хэрэгслийн салбар дахь зэсийн хэрэглээ бага зэрэг буурах төлөвтэй байна. Дэд бүтэц, шинэ эрчим хүчний салбар, дотоодын зэс боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлын өсөлт нь 2022 онд Хятадын зэсийн хүдэр, баяжмалын эрэлт нэмэгдэх дүр зургийг бий болгож байна.

Дүгнэлт

2021 оны жилийн эцсийн эдийн засгийн үзүүлэлтээс дүгнэхэд тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал, хувийн хэрэглээний сэргэлт харьцангуй бага, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй экспортыг дэмжих бодлогын хэрэгслийн нөлөө багассан зэргээс шалтгаалж Хятадын ковидын дараах эдийн засгийн өндөр өсөлтийн хурд бага зэрэг буурч, цаашид тогтворжих төлөвтэй.

Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбар дахь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт буурч байгаатай зэрэгцэн “Тэг ковид” бодлогын нөлөө, өрхийн орлогын өсөлт удаашралтай явагдаж байгаа нь дотоодын зах зээлийн эрэлтэд сөргөөр нөлөөлж байна. Хэдийгээр Хятадын экспортын гүйцэтгэл 2021 онд сайн байсан боловч тус оны IV улирлаас эхлэн удаашрах шинж тэмдэг ажиглагдаж эхэлсэн. Үүнд дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдал, өргөн цар хүрээтэй тархаж буй инфляц, цар тахлын гурав дахь давлагаа голлон нөлөөлжээ. Хятадын 2022 оны эдийн засгийн төлөв нь экспортын гүйцэтгэл, үл хөдлөх хөрөнгийн салбарын сэргэлтийн хурд, дотоодын хэрэглээ хэр хурдтай сэргэж чадах эсэхээс хамаарна. Хятадын албаныхны мэдэгдэж байгаагаар 2022 оны ДНБ-ий өсөлтийг 5.5 хувьд хүргэх төлөвлөгөөтэй байна. Дотоод дахь цар тахлын нөхцөл байдал, “тэг ковид” бодлогын үр дүнд үйлчилгээний салбар, дотоодын хэрэглээ, хөрөнгө оруулалт бүрэн сэргэж чадахааргүй байгаа боловч 2022 онд зэс, зэсийн баяжмал, зэсийн хүдрийн эрэлт өндөр хэвээр байх төлөвтэй. Харин ОХУ болон Украины хямралаас шалтгаалж цаашид ОХУ-ын коксжих нүүрсний экспорт Ази руу, тэр дундаа Хятад руу чиглэж, үнэ нь дунд хугацаандаа тогтворжих төлөв ажиглагдаж байна. Ойрын жилүүдэд зэсийн баяжмал, нүүрсний үнэ харьцангуй тогтвортой, өндөр байх төлөвтэй байгаа бөгөөд Монгол Улс экспортын тээвэрлэлт, сэлгэн ачилтын асуудлыг яаралтай шийдвэрлэж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах нь нэн чухал юм.



Д.БАТМӨНХ

ҮАБЗ-ийн ССХ-ийн Ахлах
шинжээч, докторант

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

Abstract: Obviously, these conditions in international trade will be a challenge for our country. In other words, today's geopolitics, integration slow down global trade and fragment it. In this article, we look at how to overcome these challenges.

Keywords: international trade

Орчин цагийн олон улсын гадаад худалдаанд өндөр хөгжилтэй улс орнууд гол хөдөлгөгч хүч нь болохоос гадна тэдгээрийн харилцааны эрх зүйн үндэс суурийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь хөгжиж буй болон хөгжлөөр доогуур улс орнуудад өөрийн тоглолтын дүрмийг хүлээн зөвшөөрүүлж ирсэн явдал юм. Үүнд Дэлхийн худалдааны байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлого (худалдаанд тавих квот, тарифын хязгаар) өндөр хөгжилтэй улс орнуудад илүү ашигтай байдаг.

Сүүлийн жилүүдэд АНУ болон БНХАУ-ын худалдааны зөрчлөөс үүдэн олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд томоохон өөрчлөлт гарч эхэлсэн. Үүнд мөн коронавирус тодорхой нөлөө үзүүлж байна.

Үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, нийлүүлэлтийн сүлжээ зэрэгт доголдол үүссэн нь зарим бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдлыг бий болов.

Олон улсын худалдаанд үүсээд буй эдгээр нөхцөл байдал манай улсын гадаад худалдаанд сорилт болох нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл өнөө цагийн геополитик, интеграц, аж үйлдвэржилт нь даяаршлыг сааруулж эргээд задрал, хуваагдах үйл явц болж байна.

Нийгэм-улс төрийн тогтолцоо, эдийн засгийн чадавх, үйлдвэржилт, техник,

технологи, инновац, байгалийн баялаг (үндсэн өгөгдөл), байршил зэрэг нь улс орны хөгжлийн түвшнийг тодорхойлохоос гадна олон улсын худалдаанд оролцогч талын байр суурийг мөн илэрхийлдэг. Иймээс олон улсын худалдаанд тулгарч буй эдгээр асуудлаас үүдэн ойрын ирээдүйд ямар сорилтуудтай тулгарч болох талаар уг нийтлэлд авч үзэв.

Олон улсын худалдааны нөхцөл байдал

Дэлхийн худалдааны байгууллага (WTO)-ын зүгээс олон улсын худалдааны тариф болон тарифын бус саад бэрхшээлийг хянах, зохицуулах үүрэг хүлээсэн байдаг. Гэтэл сүүлийн 10 жилийн дотор олон улсын худалдааны тариф болон тарифын бус саадын тоо ихээр нэмэгджээ.

Зураг 1. Гадаад худалдаанд саад учруулж буй хориг арга хэмжээ




Эх сурвалж: (globaltradealert, 2022)

Судалгаанаас үзэхэд дотоодын зах зээлээ хамгаалж гадаад худалдааны протекционист бодлогыг өндөр хөгжилтэй болон хөгжиж буй улс орнууд түлхүү баримталдаг. Хөгжингүй улс орны импортын тариф харьцангуй өндөр бөгөөд төрөл бүрийн квот тогтоох замаар хязгаарлалт тогтоодог бол хөгжиж буй улс орнууд засгийн газрын зүгээс татаас үзүүлэх замаар дотоодын зах зээлээ хамгаалж байна. Харин ядуу буурай улсын хувьд гадаад худалдаа харьцангуй либералчлагдсан тул дотоодын зах зээлээ хамгаалах боломж хомс юм. Дэлхийн худалдааны байгууллагын гаргасан мэдээнээс үзэхэд коронавирусийн үед олон улсын худалдаанд тулгарч байгаа саад бэрхшээлийн тоо үлэмж хэмжээгээр өсжээ.

Олон улсад үүсээд буй өнөөгийн нөхцөл байдалд Дэлхийн худалдааны байгууллагын зүгээс зохицуулах арга механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал, сүүлийн дөрвөн жил АНУ болон БНХАУ-ын хооронд худалдааны сергөлдөөнөөс үүдэлтэй маргаантай асуудлууд Дэлхийн худалдааны байгууллагад шийдвэрлэхийг хүлээсэн хэвээр байна. Мөн түүнчлэн 2014 оноос хойш ОХУ-д барууны орнуудын зүгээс үзүүлсэн худалдааны хориг арга хэмжээ нь улс төрийн шийдвэрээс үүдэлтэй тул Дэлхийн худалдааны байгууллагад удаа дараа хүсэлт, гомдол гаргасан боловч өнөөг хүртэл шийдвэрлэж чадаагүй байна.

Зураг 2. Протекционист бодлого хэрэгжүүлж буй улс (цайвраас гүн өнгө хамгийн их хязгаарлалт тогтоож буй тоо)




Эх сурвалж: (Globaltradealert, 2022)

Энэ нь олон улсад тогтоод байсан нэг туйлт дэглэм өөрчлөгдөж олон туйлт дэглэм тогтоож буй нөхцөлд улс орнуудын ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй маргаан улам бүр гүнзгийрч байгаа нь Дэлхийн худалдааны байгууллагад тулгарч буй сорилтын нэг юм. Үүнээс гадна гоц халдварт өвчний тоо нэмэгдэж, гарах давтамж ойрхон болж байгаа нь мөн олон улсын худалдаанд тулгарч буй сорилт болж байна.

Хэдийгээр Ковид-19 нь олон улсын худалдаанд таамаглаж байснаас харьцангуй эерэг үзүүлэлттэй гарсан боловч үзүүлэх нөлөө нь улс орон бүрт өөр өөр байна. Тухайлбал, 2020 оны байдлаар өндөр орлоготой улс оронд гадаад худалдаа 8, дундаас дээш орлоготой 5, дундаас доош орлоготой 12, бага орлоготой эдийн засагтай улс 12 хувиар тус тус буурсан байна. Өөрөөр хэлбэл, өндөр хөгжилтэй улс орон болон хөгжиж буй улс орнуудын хувьд гадаад худалдаа "Ковид-19"-ийн үед харьцангуй хүндрэл багатай байгаа бол ядуу буурай улс орнуудад маш их хүндрэл тусжээ.

Зураг 3. Олон улсын худалдаа "Ковид-19"-ийн үед, худалдааны эрчимжилтийн хувь, 2019-2020 оны харьцуулалт



Эх сурвалж: ITC trade statistics, 2021

“Ковид-19” эхлэх үед олон улсын худалдаа их хэмжээгээр буурна гэж таамаглаж байсан бол сүүлд Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан мэдээнд илүү эерэг төсөөлөл гарсан байна. Энэ нь дараах зүйлээс шалтгаалж байгаа талаар дэлхийн худалдааны байгууллагаас гарсан мэдээнд дурджээ.

Дэлхийн худалдааны байгууллагаас (WTO) гаргасан мэдээнээс үзэхэд олон улсын худалдаанд ирэх жилүүдэд дараах сорилтуудтай тулгарах тухай мэдээлсэн байна.

Байгалийн гамшиг, кибер довтолгоо, улс хоорондын мөргөлдөөний давтамж сүүлийн жилүүдэд ихсэж, илүү хор хөнөөлтэй болж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, технологийн хүртээмж, ашиглалт ихсэж, тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, геополитикийн хурцадмал байдал нь ирээдүйд олон улсын худалдаанд эрсдэлийг улам бүр нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Олон улсын худалдаанд үзүүлж буй шок нь шокийн ямар төрөл, анхны нөхцөл, хариу арга хэмжээ авч байгаа бодлогоос ихээхэн хамаарч байдаг. Зарим салбар зарим шоконд илүү эмзэг байдаг. Тухайлбал эмзэг бүлэг түүн дотор ядуу өрх харьцангуй хүнд өртөж байдаг.

Зарим хөгжиж буй улс орон байгалийн гамшигт харилцан адилгүй өртөж байгаа бөгөөд нийгэм-эдийн засгийн хямралд институц сул, эдийн засгийн суурь бэхжээгүй улс орнууд илүү өртөмтгий байна.

Хямралыг бага хохиролтой даван туулахад нэн тэргүүнд Засгийн газар, компаниуд, өрхүүд хэр зэрэг бэлтгэлтэй байгаа, урьдчилсан төлөвлөгөөг сайн боловсруулсан зэргээс хамаарч эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах боломжтой.

“Ковид-19”-ийн үед авч хэрэгжүүлсэн худалдааны арга хэмжээ амжилттай болсон нэг шалтгаан нь улс орнууд худалдааг либералчилсан явдал гэж дүгнэжээ.

Зураг 4. Олон улсын худалдааны 2022 оны прогно



Эх сурвалж: (WTO, 2021)

Үүнээс үзэхэд 2022 онд геополитикоос үүдэлтэй улс хоорондын мөргөлдөөн, уур

амьсгалын өөрчлөлтөөс улбаатай байгалийн гамшиг нь гадаад худалдааг либералчлах үйл явцыг удаашруулж, улс хоорондын хамтын ажиллагаанд том сорилт болох бөгөөд бараа бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдлыг бий болгохоор байна.

Ийм нөхцөлд Монгол Улсын гадаад худалдаа тухайн нөхцөл байдалд хэр зэрэг бэлтгэлтэй байгаа, өөрийн нөөц боломжоо зөв зохистой ашиглаж чадаж байна уу гэдэг нь манай улсын гадаад худалдааны сорилт болно.

Монгол Улсын худалдаанд тулгамдаж буй зарим асуудал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-т "Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.", 3.2.5.2-т "Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.", 3.2.5.3-т "Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална..." гэж тус тус заасан.

Өнөөгийн байдлаар манай улсын гадаад худалдаа коронавирусээс үүдэн маш эмзэг болоод байна. Тухайлбал, Нэгдсэн үндэсний Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO)-аас гаргасан ангиллаар Далайд гарцгүй улс орнуудын гадаад худалдааг харьцуулж үзвэл Монгол Улс 41 орноос наймдугаар байр буюу худалдаа өмнөх оноос 22 хувь буурсан нь их бууралттай оронд оржээ.

Хүснэгт 1. Коронавирусын үеийн далайд гарцгүй 41 улсын дунд Монгол Улсын худалдааны эргэлтийн өөрчлөлт

№	Улс	Мянган ам.доллар	2019/2020 хувь
1	Руанда	1,826,937	-58
2	Непал	8,926,644	-33
3	Мали	5,885,765	-32
4	Өмнөд Судан	1,618,467	-28
5	Азербайжан	24,470,355	-26
6	Болив	14,095,195	-25
7	Туркменистан	10,831,860	-23
8	Монгол	10,786,083	-22
9	Киргизстан	5,648,575	-18
10	Төв Африкийн Бүгд найрамдах улс	585,960	-15
11	Беларусь	61,946,874	-14
12	Афганистан	6,576,424	-14
13	Эсвитани	3,357,392	-13
14	Казахстан	85,031,108	-11
15	Малави	3,512,254	-9

Эх сурвалж: ITC trade statistics, 2021

Харин уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч орнууд дунд Монгол Улсын экспорт 20 хувиар буурсан нь мөн их хувь буурсан улсын тоонд оржээ.

Хүснэгт 2. Эрдэст бүтээгдэхүүний экспортоос хамааралтай улсын¹ дунд Монгол Улсын экспортын өөрчлөлт

№	Улс	Өсөлт бууралт, хувь			
		2017	2018	2019	2020
1	Руанда	71	7	14	-70
2	Мали	-33	90	0	-41
3	Эритриа	13	20	-3	-27
4	Гайана	24	-17	159	-27
5	Сьерра Лион	-73	22	271	-24
6	Гвиней	158	0	7	-21
7	Монгол	26	13	9	-20
8	Ботсвана	-19	3	-14	-19
9	Казахстан	31	26	-5	-19
10	Намиб	7	44	-14	-16
11	Перу	23	7	-4	-14
12	Суринам	17	4%	-3	-5
13	Чили	14	14%	-8	-2
14	Мауритани	19	6%	32	2
15	Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс	71	63%	-33	6
16	Замби	27	12%	-24	12
17	Тажикстан	9	9%	4	18
18	Буркина фасо	12	16%	0	34

Эх сурвалж: ITC trade statistics, 2021

Монгол Улсын гадаад худалдааны гол экспортын бүтээгдэхүүн болох нүүрс, зэс, төмрийн хүдрийн хэмжээ урьд жилүүдээс буурсан бөгөөд импортоор авч буй бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд мөн доголдол үүссэнээс дотоод зах зээлд үнийн хөөрөгдөл үүссэн.

Дэлхийн улс орнууд вирусээс үүдэлтэй хямралаас бүрэн гарч чадаагүй байхад олон улсад геополитикийн зөрчлөөс үүдсэн хямралыг дагуулах болов. Тухайлбал ОХУ-ын зүгээс өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс Украин улсад байлдааны тусгай ажиллагаа явуулсанд АНУ тэргүүтэй барууны улс орнуудын хориг арга хэмжээгээ улам тэлж банк, санхүүгийн салбарыг хамруулах болсон нь олон улсад эдийн засгийн хямрал үүсэх эрсдэлтэй юм. Мөн уг хориг арга хэмжээ олон улсын худалдаанд том сорилт болно. Тухайлбал манай улсын гадаад худалдаа болон олон улсын төлбөр тооцоонд хүндрэл учрах нь тодорхой юм.

Мөн Европын улс орнуудаас ирэх ачаа тээврийн сүлжээнд хүндрэл учирна. Манай улс Европоос 2021 онд 743 сая ам.долларын бүтээгдэхүүн худалдаж авсан нь нийт импортын 11 хувьд хүрсэн. Хэдий энэ тоо бага боловч Европын хөгжилтэй орнуудаас авч буй бүтээгдэхүүнүүд нь өөр бусад орноос авахад хүндрэлтэй өндөр технологийн, тоног төхөөрөмж, эм бэлдмэл байдаг. Үүнээс үүдээд олон улсын худалдаанд улс хоорондын

¹ Эрдэст бүтээгдэхүүний экспортоос хамааралтай улсын тодорхойлолт хувь хэмжээ хавсралт 1.


сөргөлдөөнөөс үүдэлтэй хямрал нь улам даамжрах хандлага ажиглагдах болсон.

Хэдийгээр олон улсын худалдаанд тулгарч буй эдгээр сорилт улс хоорондын худалдаанд хүндрэлтэй нөхцөлийг үүсгэх боловч нөгөө талаар бас боломжийг бий болгож байдаг. Жишээ нь АНУ болон БНХАУ-ын хоорондох худалдааны дайны улмаас олон улсын зах зээл дээрх хагас дамжуулагчийн хомстолыг бий болгож эхэлсэн. Энэ нь уг түүхий эдтэй жижиг эдийн засагтай улсуудад хөрөнгө оруулалтыг татах боломжийг нээж өгч байдаг. Харин үүнийг яаж өөртөө ашигтай байдлыг бий болгох нь тухай улсын төр засгийн явуулж байгаа бодлогоос шууд хамааралтай юм.

Монгол–Япон улсын эдийн Засгийн түншлэлийн хэлэлцээр

Монгол-Япон улсын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулаад зургаан жил болжээ. Тус хэлэлцээр байгуулснаас хойш хоёр улсын худалдаанд дорвитой өөрчлөлт гарч чадаагүй.

Зураг 5. Монгол Улс Япон улсаас импортолсон бараа бүтээгдэхүүний хэмжээ, сая ам.доллар, нийт импортод эзлэх хувь



Эх сурвалж: ГЕГ статистик 1996-2021 он

Япон улсаас гол төлөв авто машин болон хүнд машин механизм худалдаж авсан хэвээр байна. Харин хоёр улсын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хийсний дараа экспортод малын дайвар бүтээгдэхүүн болох өлөн гэдэс, давсаг, гүзээ зэрэг түлхүү зарагдах болжээ. Мөн уламжлалт ноос, ноолуур, сүлжмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээ дорвитой өсөөгүй байна.

Хоёр улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ хийгээд иргэд, ААН-үүд цаашид аваад явна гэхэд хүндрэлтэй гэдгийг статистик мэдээ харуулж байна. Иймээс төр засгаас аж үйлдвэрийн хөгжлийн бодлогыг тодорхой болгож, Япон улстай ямар салбарт түлхүү хамтарч ажиллах, хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэр зэрэг төрөл бүрийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байж илүү үр ашигтай болох юм. Тухайлбал, АНУ-ын зүгээс БНХАУ-д тавьсан хориг арга хэмжээний улмаас олон улсад хагас дамжуулагчийн хямрал үүссэн. Япон улс газрын ховор элементийн хэрэглээ их. Харин манай улс газрын ховор элементийн харьцангуй нөөц их байх магадлалтай улсын

тоонд ордог. Манай улсын хувьд газрын ховор элементийн нөөцийг бүрэн тогтоогдсон судалгаа, шинжилгээний ажлыг хийгээгүй байна. Үүнд гадаадын хөрөнгө оруулалт их дутагдалтай байдаг. Харин уг газрын ховор элементийг олборлож боловсруулахад Япон улсын хөрөнгө оруулалтыг татах боломжтой юм.


Зураг 6. Монгол Улсаас Япон улсад экспортолсон бүтээгдэхүүн, сая ам.доллар, нийт экспортод эзлэх хувь



Эх сурвалж: ГЕГ статистик 1996-2021 он

Газрын ховор элементийн хэрэглээ 2016 оны байдлаар БНХАУ 104, Япон 24, АНУ 20, Европын улс орнууд 7 мянган тонныг тус тус хэрэглэсэн байна. БНХАУ-ын газрын ховор элементийн хэрэглээ Япон улсаас 4.3, АНУ-аас 5.2, Европын улсаас 115.3 дахин их байна. Өөрөөр хэлбэл, БНХАУ-ын газрын ховор элементийн хэрэглээ эдгээр улс орныг нийлүүлсэн хэрэглээнээс 2 дахин их байна. Энэ байдал өнөөг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд жил ирэх тутам улам их нэмэгдэх хандлагатай байна.(Зураг 7)

Зураг 7. Газрын ховор элементийн хэрэглээ, улсаар, тонн



Эх сурвалж: Rare earth minerals 2020 | Statista

Дүгнэлт

Олон улсын тавцанд болж буй үйл явц улс орнуудын худалдааны хэвшмэл тогтолцоог бүхэлд нь өөрчлөх төлөвтэй. ХХ зууны сүүлээс эрчимтэй глобалчлал явагдаж байсан бол өнөө цагт үндсэндээ саарч үүний оронд жижиг, бүс нутгийн интеграц илүү чухал болж байна.

Гоц халдварт өвчлөлийн давтамж ойр ойрхон болж, илүү олон улс хамрах болсон нь олон улсын худалдаанд том сорилт болоод байна. Тухайлбал хамгийн сүүлд тохиосон ковид-19 цар тахлын үед олон улсын худалдаа маш эмзэг болохыг харууллаа.

Тэр тусмаа эрдэст бүтээгдэхүүнээс хэт хараат, үйлдвэрлэл хөгжөөгүй улс аливаа эдийн засгийн хямралд маш өндөр эрсдэлтэй байна.

Иймээс гадаад худалдааг эрчимжүүлэхийн тулд Монгол Улс:

1. Аж үйлдвэржилтийн бодлогоо тодорхой болгох шаардлагатай байна.
2. Гарах бүтээгдэхүүндээ тохируулж дэд бүтэц, тээвэр ложистикийн хөгжлийг тодорхой болох явдал юм.
3. Манайх эрдэс болон малын гаралтай түүхий эд голлож байгааг өөрчилж, эхний ээлжид ядаж хагас боловсруулсан бүтээгдэхүүн гаргах, улмаар нэмэгдсэн өртөг шингэсэн, бүрэн боловсруулсан бүтээгдэхүүний хувь хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг тууштай баримтлах хэрэгтэй. Үүний тулд экспортын чиглэлийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд тавьж хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ нь тарифын бус хориг саадыг багасгах төдийгүй гадаад худалдааны ашиг орлогыг нэмэгдүүлнэ.
4. Өндөр хөгжилтэй Япон зэрэг улсаас шинэ техник, технологийг орлуулж ирэхийг төр засгаас бодлогоор дэмжиж импортын хараат байдлыг багасгах боломжтой. Жишээ нь манай улс дотооддоо малын эм бэлдмэл, газар тариалангийн бордоо, ургамал хамгааллын бодис, барилгын чулуу, цемент, сүү, цагаан идээ, өндөг, зөгийн цэвэр бал, хүнсний ногоо, түүгээр хийсэн дарш, үр тариа зэрэг бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах боломжтой.
5. Манай улс газрын ховор элементийн нөөц байгаа боловч түүний талаар судалгааг маш бага хийсэн. Сүүлийн жилүүдэд газрын ховор элементийн зах зээлд үүсээд буй хомстолыг нөхөхийн тулд өндөр хөгжилтэй улсууд маш их хөрөнгө оруулалт хийж эхлээд байна. Энэ нь манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг татах нэг боломж юм.

-
1. Алтан-Оч Г., (PhD), Ц.Болормаа Ч.Онончимэг, Д.Халиун, Үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үйлдвэрлэлийн суурь зардлын үнэ тарифын зохицуулалт болон гадаадын зарим орны туршлага, судалгааны эмхэтгэл-13р боть, Улсын Их Хурлын Тамгын газар судалгааны хэлтэс.
 2. Норовдондог Ц. нар, (2013). Монгол Улсын үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт ба үнэлгээ, Судалгааны эмхэтгэл - боть 248 Улсын Их хурлын тамгын газрын судалгааны төв.
 3. ГЕГ. (2019). Гадаад худалдааны статистик мэдээ.
 4. Монгол банкны судалгааны ажил, Товхимол 14.
 5. Батхишиг. Б., (2018). Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал.
 6. “Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаанд үнэлгээ хийх, бодлогын тэргүүлэх чиглэл тодорхойлох аргачлал” болон “бодлогын зорилтуудын зорилтот түвшнийг тодорхойлох аргачлал”-ын танилцуулга.
 7. Нэмүү өртгийн сүлжээний мэдлэг, мэдээллийн индер (VCIP) төсөл, <http://www.vcmongolia.mn/default.aspx?page=1>.
 8. Экспортын замын зураг гарын авлага, Төслийн санхүүжүүлэгч Европын холбоо, 2019.
 9. Эрик С. Райнерд, Баян орон хэрхэн баялаг бүтээсэн бэ? Буурай орнууд яагаад ядуу хэвээр үлддэг вэ?
 10. Bloomberg телевизийн цахим хуудас.
 11. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn/>.



Ч.ЦЭЦЭГМАА

ҮАБЗ-ийн ССХ-ийн

Ахлах шинжээч

ТҮНШ ОРНУУДЫН ИМПОРТЫН ТАРИФЫН БУС ЗОХИЦУУЛАЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Abstracts: Although Mongolia is benefiting customs tariff preferences under the GSP, EPA and APTA, the export diversification and volume is insufficient and the export markets remains dependent on a few partner countries that protect their markets by non tariff measures such as SPS, TBT. Therefore, this article aims to explore ways to reduce non-tariff barriers on Mongolian exports by partner countries.

Keywords: WTO, trade agreement, non tariff measures, Sanitary and Phytosanitary Measures, Technical Barriers to Trade, export control,

Оршил

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэн цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна хэмээн дурдсан билээ¹. Гэвч энэхүү заалтуудын хэрэгжилт туйлын хангалтгүй хэвээр байгаа нь эдийн засгийн аюулгүй байдлын талаарх олон улсын болон үндэсний судлаачдын боловсруулсан холбогдох шалгуур үзүүлэлтүүдийн² биелэлтээс тодорхой байна. Тухайлбал, сүүлийн 10 жилд буюу 2011-2021 онд нийт экспортод түүхий эд дунджаар 30 хувьтай байх ёстой байхад Монгол Улсын хувьд 71-88, аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэр 60 хувьтай байхаас 21-36 хувийг эзэлж байна.³ Өөрөөр хэлбэл, бид нэмүү өртөг шингээгүй уул уурхай болон хөдөө аж ахуйн түүхий эдээ экспортолсоор байна гэсэн үг юм.

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ, 2010

² Д.Тунгалаг, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал, 2020

³ www.1212.mn судлаачийн тооцоолол

Монгол Улс түнш орнуудтай эдийн засгийн үйл ажиллагааны бодлого зохицуулалтын хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж байгаа боловч эдийн засгийн хамтын ажиллагааны түвшин хангалттай бус, тарифын болон тарифын бус саад тотгороос хамааран экспортын бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл төдийлөн нэмэгдэхгүй, экспортын зах зээл цөөн хэдэн орноос хамааралтай хэвээр байна. Иймд энэхүү нийтлэлээр гадаад худалдааны түнш орнуудын зүгээс Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнд хэрэгжүүлж буй тарифын бус саад тотгоруудыг багасгах арга замыг судлан гаргаж ирэхийг зорилоо.

Тарифын бус зохицуулалтын тухай

Монгол Улс 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллагад элсэн орсноор тус байгууллагын гишүүн 164 улстай хөнгөлөлттэй гаалийн буюу нэн тааламжтай тарифын хөнгөлөлт эдлэн худалдаа эрхлэх боломжтой болсон билээ. Түүнчлэн НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (UNCTAD)-ын санаачилгаар 1960 оноос хэрэгжүүлж эхэлсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем(ХЕС)-ийн дагуу өндөр хөгжилтэй 37 орноос (АНУ, Япон, ЕХ, Канад...) тарифын хөнгөлөлт олгож байна. Энэхүү хөнгөлөлтийн дагуу АНУ-д 3000 гаруй, ЕХ-д 7200 нэр төрлийн бүтээгдэхүүн гаалийн татваргүй экспортлох боломжтой юм.

Мөн Япон улстай 2015 онд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) байгуулснаар тус улсын зах зээлд 9300 нэр төрлийн бүтээгдэхүүн, 2019 онд Ази Номхон Далайн Худалдааны Хэлэлцээр (АНДХХ)-т нэгдсэнээр 10677 нэр төрлийн барааг Хятад, Бангладеш, Энэтхэг, Шри Ланка, Солонгос, Лаос улсын зах зээлд хөнгөлөлттэй тарифаар нэвтрэх боломжтой болсон байна.⁴

Дээрх байдлаас харахад Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүн өндөр хөгжилтэй түнш орнуудын зах зээл дээр дөрвөн төрлийн тарифын хөнгөлөлт эдлэн, ижил төрлийн бүтээгдэхүүнээс хямд өртгөөр нэвтрэх давуу талтай байгаа боловч өнөөг хүртэл экспортын зах зээл хязгаарлагдмал, нэр төрөл нэмэгдэхгүй, түүхий эд давамгайлсан хэвээр байгаа нь тарифын бус хязгаарлалтуудтай холбоотой юм.

Тарифын бус арга хэмжээнд олон улсын барааны худалдаанд эдийн засгийн үр нөлөө үзүүлэх боломжтой тарифаас бусад бодлогын арга хэмжээ хамаардаг бөгөөд дараах хэлбр болон арга хэмжээнүүд хамрагддаг байна.⁵

Шууд хязгаарлалт

- Импортын квотын систем;
- Экспортын сайн дурын хязгаарлалт;
- Импортын лицензийн систем;

Шууд бус буюу дам тарифын бус хязгаарлалт

- Гадаад валютын хяналт;
- Импортын татварын барьцаа;
- Экспорт импортод төр дангаар ноёрхох;
- Доод үнийн хязгаарлалт бий болгох;
- Засгийн газрын ялгавартай худалдан авалтын бодлого;

⁴ <https://mfa.gov.mn>

⁵ <https://unctad.org/topic/trade-analysis/non-tariff-measures>

- Дотоод татвар;
- “Дотоод”-жуулах шаардлага;
- Худалдааг хуулиар хамгаалах бодлого;
- Захиргааны журам ба үйлчилгээний худалдааны саад;
- Гаалийн хил нэвтрэх явцыг сааруулах замаар экспорт, импортыг хязгаарлах;
- Технологийн стандартын саад;
- Аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын саад;
- Байгаль хамгааллын саад;

ДХБ-ын хүрээнд тарифын бус зохицуулалтуудыг дараах хэлэлцээрээр зохицуулж байгаа бөгөөд эдгээр хэлэлцээрийг гишүүн орнууд хэлэлцэн тохирч, харилцан хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хэрэгжүүлж байна. Хэлэлцээртэй холбоотой арга хэмжээг тухай бүр мэдэгдэл хүргүүлэн гишүүн орнуудад урьдчилан мэдээлдэг байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр;
- Эрүүл ахуй хорио цээрийн тухай хэлэлцээр;
- Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр;
- Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр;
- Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр;
- Импортын лицензийн тухай хэлэлцээр;
- Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр;

Монгол Улсын хувьд дээрх зохицуулалтуудыг худалдааны үйл ажиллагаанд өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд 2021 онд “ДХБ-ын хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам”-ыг Засгийн газраас баталсан байна.⁶

Чөлөөт худалдааны хэлэлцээр ба тарифын бус зохицуулалт

Чөлөөт худалдааны хэлэлцээрт оролцогч талууд гаалийн тарифыг харилцан буулган зах зээлээ нээж байгаа мэт боловч тарифын бус зохицуулалтаар тухайн салбар, хэрэглэгчийн эрх ашиг зэргийг хамгаалсан байдаг. Тухайлбал, Монгол Улс Япон Улстай байгуулсан Эдийн Засгийн Түншлэлийн Хэлэлцээрт эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тавдугаар бүлэгт, техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний зохицуулалтыг зургаадугаар бүлэгт тусгасан байна. Түүнчлэн хүнсний бүтээгдэхүүний нэмэлт гэрчилгээ, гарал үүслийг хэрхэн тодорхойлох баталгаажуулах тухай тусгажээ.

Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан улс орнуудын туршлагаас харахад тарифын бус арга хэмжээг худалдааг хязгаарлах бус техникийн болон бодлогын зохицуулалт байдлаар хэрэглэхээр холбогдох хэсгүүдэд заасан байдаг. Тухайлбал, стандарт, техникийн болон байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага гэх мэт асуудлууд нь ТВТ буюу техникийн саад тотгорын, SPS буюу эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хэсэг дээр, шударга бус хямд үнийн асуудал нь татаас, демпингийн хэсэг дээр, квотыг маш цөөн тооны бараан дээр тарифын квот байдлаар хэрэглэж байна.

Тарифын бус арга хэмжээг ихэнх орнуудад худалдаа эдийн засаг, стандарт хэмжил зүй, эрүүл мэнд, байгаль орчин болон эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын төв байгууллагууд хэрэгжүүлдэг байна (Хүснэгт 1). Ихэнх оронд гадаад худалдааг бие

⁶ <https://legalinfo.mn/annex/details/11590?lawid=16042>

даасан төрийн захиргааны төв байгууллага болох яам, агентлаг хариуцан ажиллаж байгаа нь худалдааны үйл ажиллагаанд ихээхэн анхаарал хандуулсны жишээ юм.

Хүснэгт 1. Тарифын зохицуулалт хэрэгжүүлэгч байгууллагууд


	Тарифын бус арга хэмжээнүүд	Хэрэгжүүлэгч байгууллага
1	Эрүүл ахуй хорио цээрийн арга хэмжээ	Хөдөө аж ахуйн яам; Стандартчиллын агентлаг; Эрүүл мэндийн яам
2	Худалдаан дахь техникийн саад тотгор	Стандартчиллын агентлаг; Эрүүл мэндийн яам; Байгаль орчны яам; Эрчим хүчний яам; Худалдаа / Аж үйлдвэрийн яам
3	Ачилтын өмнөх хяналт шалгалт	Гаалийн газар; Стандартчиллын агентлаг
4	Худалдааг хамгаалах арга хэмжээ	Худалдаа / Аж үйлдвэр / Эдийн засгийн яам; Гадаад харилцааны яам
5	Импортын тусгай зөвшөөрөл, квот, хориг, тоо хэмжээний хяналтын арга хэмжээ болон эрүүл ахуй хорио цээрийн арга хэмжээ болон худалдааны техникийн саадаас бусад хориглолтын арга хэмжээ	Сангийн яам; Худалдаа / Аж үйлдвэр / Эдийн засгийн яам
6	Үнийн хяналтын арга хэмжээ, нэмэлт татвар, хураамж	Худалдаа / Аж үйлдвэр / Эдийн засгийн яам; Гаалийн газар
7	Санхүүгийн арга хэмжээ	Сангийн яам; Үндэсний банк
8	Өрсөлдөөнд нөлөөлөх арга хэмжээ	Худалдаа / Аж үйлдвэр / Эдийн засгийн яам
9	Худалдаа хөрөнгө оруулалтын арга хэмжээ	Худалдаа / аж үйлдвэр / эдийн засгийн яам
10	Экспортын арга хэмжээ	Худалдаа/аж үйлдвэр/эдийн засгийн яам; Гаалийн газар

Эх сурвалж: UNCTAD, *Guidelines for the collection of data on official non-tariff measures, 2021*

COVID-19 цар тахлын үед дэлхийн 140 гаруй улс худалдааны бодлогын тарифын бус арга хэмжээг ашигласан байна. Эдгээр арга хэмжээний ихэнх нь зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүний хүртээмж, аюулгүй байдлыг хангах зэрэг хууль ёсны бодлогын үүднээс авч хэрэгжүүлсэн байна.⁷

ДХБ-ын гишүүн орнуудын хүрээнд 2010-2021 онд хэрэгжүүлсэн тарифын бус арга хэмжээний ихэнхийг эрүүл ахуй хорио цээр, демпингийн эсрэг, худалдааны хамгаалалтын арга хэмжээ зонхилсон бөгөөд тоо хэмжээ үнийн дүнгийн хязгаарлалт буюу квотын хязгаарлалтыг 2017 оноос хойш шинээр хэрэгжүүлээгүй байна (Зураг 1).

Зураг 1. Тарифын бус арга хэмжээнүүд, 2010-2021 он



Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

⁷ UNCTAD research paper, COVID-19 Non-Tariff Measures: The Good and the Bad, through a Sustainable Development Lens, 2021

Түнш орнуудын зүгээс хэрэгжүүлж буй тарифын бус хязгаарлалтууд

Хятад Улсын хувьд манай экспортын бараанд нийт 5691 тарифын бус зохицуулалт хэрэгжүүлж байна (Хүснэгт 2). Эдгээр нь ихэвчлэн ДХБ-ын бүх гишүүн орнуудын түвшинд үйлчлэх бөгөөд Монгол Улстай байгуулсан хоёр талын хэлэлцээр цөөхөн байна. Харин ОХУ-ын хувьд Монгол Улстай хоёр талын хэлэлцээр идэвхтэй байгуулсан байна. Хөрш орнуудын зүгээс Монгол Улсын экспортын бараанд барааны худалдааны үйл ажиллагааг зохицуулах журам болон эрүүл ахуй хорио цээрийн зохицуулалт хамгийн ихээр хэрэгжүүлж байна.


Хүснэгт 2. Тарифын бус зохицуулалтууд, 2021 он

	Үйлчлэх хүрээ	Арга хэмжээний хүрээ	ОУ-ын нэршил	ОХУ	Хятад
1	Бүх орнууд	Экспортын зохицуулалтын арга хэмжээ	EXP	24	684
2		Бусад арга хэмжээ	OTH	1	57
3		Ачилтын өмнөх хяналт шалгалт	INSP	7	69
4		Үнийн хяналт	PC	3	49
5		Тоо хэмжээний хяналт	QC	18	283
6		Эрүүл ахуй хорио цээр	SPS	118	588
7		Худалдаан дахь техникийн саад тотгор	TBT	307	3954
8	Хоёр талт	Экспортын зохицуулалт	EXP	10	5
9		Ачилтын өмнөх хяналт шалгалт	INSP	3	1
10		Тоо хэмжээний хяналт	QC	3	
11		Эрүүл ахуй хорио цээр	SPS	11	
12		Худалдаан дахь техникийн саад тотгор	TBT	5	
13		Үнийн хяналт	PC		1
		Нийт		510	5691

Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

Хятад Улсын зүгээс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зэрэг зорилгоор химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, малын гаралтай бүтээгдэхүүн зэрэгт эрүүл ахуй хорио цээр, экспортын үйл ажиллагаатай холбогдох зохицуулалтыг хамгийн их хэрэглэсэн байна (Зураг 2). Өөрөөр хэлбэл, бид Хятад улстай хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар эдгээр тарифын бус зохицуулалтуудыг багасгах боломжтой юм.

Зураг 2. Хятад улсын импортын тарифын бус арга хэмжээнүүд, барааны бүлгээр, 2021 он




Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал

2021 оны байдлаар экспортын бусад түнш орнуудын зүгээс Монгол Улсад хэрэгжүүлж буй тарифын бус зохицуулалтын хувьд АНУ хамгийн их буюу 3204 эрүүл ахуй хорио цээрийн, 1941 худалдааны үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээ хэрэгжүүлжээ (Зураг 3). Монгол Улсын хувьд хэдийгээр АНУ-ын зах зээлд 3000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн гаалийн татваргүйгээр экспортлох боломжтой боловч өнөөгийн байдлаар цөөн тооны сүлжмэл бүтээгдэхүүн, хайлуур жонш, вольфрамын баяжмал, гар урлалын бүтээгдэхүүн зэрэг экспортолж байна.

АНУ-ын зүгээс хэрэгжүүлж байгаа ХЕС-ийн тарифын хөнгөлөлт нь нэг талын хөнгөлөлт бөгөөд нийт 134 оронд зэрэг үйлчлэх юм. Энэхүү хөнгөлөлтөд манай сонирхлын бүтээгдэхүүн болох оёмол бүтээгдэхүүн (барааны код 6210), ноолууран цамц (барааны код 6110), арьс ширэн бүтээгдэхүүний нэр төрлөөс бага хамрагдсан бөгөөд нэр төрлийг өргөжүүлэх, тарифын бус зохицуулалтыг багасгахад хоёр талын худалдааны хэлэлцээр чухал үүрэгтэй юм. Өнөөгийн байдлаар тус улстай Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр (TIFA)-ийг 2004 оноос байгуулан хэрэгжүүлж байна. Энэ нь чөлөөт худалдааны хэлэлцээрийн өмнөх үе шат юм.

**Зураг 3. Бусад түнш орнуудын тарифын бус зохицуулалтууд,
Монгол Улс, 2021 он**



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа Хөгжлийн бага хурал

Япон Улсын хувьд Монгол Улсад ХЕС-ийн тарифын хөнгөлөлтийн дагуу 3000, ЭЗТХ-ийн дагуу 9300 бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй экспортлох боломж олгож байгаа боловч хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбараа илүү хамгаалсан 811 эрүүл ахуй хорио цээрийн, 932 худалдааны үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Дүгнэлт

Монгол Улсаас түнш орнуудын зах зээлд экспортолж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй байгаа бөгөөд экспортод нэмүү үнэ цэнэ шингээгүй түүхий эд зонхилсон хэвээр байна. Энэ нь түнш орнуудын зүгээс хэрэгжүүлж буй тарифын болон тарифын бус арга хэмжээнээс хамааралтай юм. Тарифын бус зохицуулалт тухайн орны хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхай зэрэг салбарт чиглэн хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад илүү анхаарсан байна. Тарифын бус арга хэмжээг бууруулах үүднээс Монгол Улсын МХЕГ, СХЗҮТ болон холбогдох бусад байгууллагад түнш орнуудын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг илүү сайжруулах шаардлагатай юм.

Түүнчлэн одоо хэрэгжүүлж байгаа Эдийн Засгийн Түншлэлийн Хэлэлцээр, Ази номхон далайн худалдааны хэлэлцээр болон ДХБ-ын гишүүн орнуудын тарифын бус

арга хэмжээний мэдэгдлүүдийг тухай бүр бизнес эрхлэгчдэд монгол хэл дээр орчуулан мэдээлж байх нь зүйтэй юм. Мэдээлэл дутмагаас ашиглалт хангалтгүй байна.

Улс орнууд гаалийн тарифаа буулгаж зах зээлээ нээж байгаа хэдий ч тарифын бус зохицуулалт болох эрүүл ахуй, чанар, стандарт, техникийн нөхцөлөөр зах зээлээ хамгаалан, энэхүү сонирхлоо чөлөөт худалдааны хэлэлцээр, гаалийн холбоо байгуулах замаар хэлэлцээ хийж, тохиролцох үйл явц бүс нутгийн хэмжээнд эрчтэй явагдаж байна. Иймд Монгол Улсын хувьд чөлөөт худалдааны хэлэлцээрийн багийн чадавхыг сайжруулан худалдааны түнш орнуудын тарифын бус хориг саадыг үе шаттайгаар бууруулах нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

-
1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ, 2010
 2. WTO, Trade policy review, 2021
 3. UNCTAD, Guidelines for the collection of data on official non-tariff measures, 2021
 4. UNCTAD, Non tariff measures from A to Z, 2022
 5. UNCTAD research paper, COVID-19 Non-Tariff Measures: The Good and the Bad, through a Sustainable Development Lens, 2021
 6. ДХБ, Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд, 2000
 7. Д.Тунгалаг, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал, 2020
 8. <https://unctad.org/topic/trade-analysis/non-tariff-measures>
 9. <https://i-tip.wto.org/goods>
 10. <https://mfa.gov.mn>
 11. <https://legalinfo.mn>



П.ЭНХБОЛОР

Диспетчерийн Үндэсний төв
ТӨХХК *

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД WAMPAC СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛСЭН ТУРШЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ЗАМ БОЛОХ НЬ

Хураангуй: Цахилгаан механик шилжилтийн болон тогтворжсон горимын үед эрчим хүчний системийн төлөв байдлыг тухайн агиинд нь WAMS системээр хяналт шинжилгээ хийх нь дэлхий нийтэд нийтлэг хэрэглээ болж байна. Эрчим хүчний тогтворжилтыг хангах цогц аваар эсэргүүцэх төвлөрсөн автоматикийн системийг (АПНУ) бий болгох нь томоохон хэмжээний төсөл боловсруулж шийдвэрлэх асуудал бөгөөд үүнийг бүрэн хэрэгжүүлсэн туршилага ховор байгаа ба ихэнх нь туршилтын төслүүд байна. Монгол Улсын эрчим хүчний системд бодитойгоор хэрэгжүүлэн хяналт, хамгаалалт, диспетчерийн шуурхай удирдлага, горимын тооцооны программын үнэмшилийг шалгах, тогтворжилт алдагдахаас сэргийлэх автоматикийн системд ашиглагдаж байгаа энэхүү төсөл нь энэ төрлийн системийг хэрэгжүүлэх гэж байгаа бусад оронд үнэ цэнэтэй туршилага болно гэж үзлээ.

Үүний үр дүнд Монгол Улсын эрчим хүчний системд WAMPAC системийг бий болгох төслийг хэрэгжүүлсэн.

Түлхүүр үгс: WAMPAC, WAMS, PMU, PDC, APLS, RTAC, Протокол, АРОЛ, цагийн синхрончлогдсон вектор хэмжлэг, системийн тогтворжилт, бодит чадлаар хязгаарлах автоматик.

Нэг. Оршил

Монгол Улсын эрчим хүчний систем нь эх үүсвэрийн дутагдалтай, тогтворжилтын нөөцгүй, тогтворжилт алдагдахаас сэргийлэх автоматикийн системгүй энэ хүндрэлтэй үед эрчим хүчний хэрэглээ нь жил бүр 8-10 орчим хувиар тасралтгүй өсөн нэмэгдэж байна.

* Бусад гишүүн: Г.Балжинням, Б.Эрхэмзаяа, Ч.Амарсанаа - Диспетчерийн Үндэсний Төв ТӨХХК, Н.Батбаяр - Цахилгаан Дамжуулах Үндэсний Систем ТӨХК

Эрчим хүчний нэгдсэн сүлжээний тогтвортой байдлыг хангах үүргийнхээ хүрээнд Диспетчерийн Үндэсний Төв ТӨХК-аас санаачлан цагийн синхрончлогдсон вектор хэмжлэг (ЦСВХ) дээр суурилагдсан шилжилтийн горимын хяналт мэдээллийн системийг (ШГХМС) бий болгох 2 үе шаттай төслийг санаачилсан.

Эхний шатанд 110,220 кВ-ын 14 транзит шугам, системийн тогтворжилтод нөлөөлөх ТЭЦ-3, ТЭЦ-4-ийн 8 генератор, 2 автотрансформатор бүхий 24 цэгийг хянах хяналт мэдээллийн WAMS систем.

Хоёрдугаар шатанд эхний шатанд үүссэн WAMS системийг автомат удирдлага хийх боломжтой тоон сигнал дамжуулах 60870-104 протокол, RTAC- аар өргөтгөж тогтворжилт алдагдахаас сэргийлэх WAMPAC систем болгон өргөжүүлэх.

Хоёр. Төслийн зорилго болон даалгавар

Монгол Улсын эрчим хүчний систем нь ОХУ-ын эрчим хүчний системтэй 220 кВ-ын 2 хэлхээт 257, 258-р ЦДАШ-аар холбогдон ажилладаг ба энэ шугамаар дамжих чадлын зөвшөөрөгдөх хэмжээг нэмэгдүүлэхийн тулд зөвшөөрөгдөх чадлыг хэтрүүлэхгүй байлгах, систем хооронд савлалт үүсгэхгүй статик тогтворжилтыг хангах автоматикийг бий болгох шаардлагатай болсон.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд WAMS системийн LSAP (Load Shedding Active Power) функцийн тусламжтайгаар системийн хяналт хийж байгаа цэгүүдээс 110 кВ-ын 14 шугамыг сонгож авсан ба 257,258-аар ЦДАШ-ын зөвшөөрөгдөх утгын хазайлтаас шалтгаалан 5 шатлалаар ачаалал хасах үйлдлийн дарааллыг тогтоож өгсөн.

Хүснэгт 1

Шатлал	Дэд станцын нэр	Ачаалал хязгаарлах ЦДАШ-ын нэр	Үйлчлэх хугацаа (сек)
1	220 кВ «Чойр»	Төмөртэй, МАК, Бор Өндөр	10
2	220 кВ «Дархан»	Хөтөл-А, Хөтөл-Б, Үйлдвэр-А, Үйлдвэр-Б	20
3	220 кВ «Эрдэнэт»	Булган-А, Булган-Б	25
4	220 кВ «Улаанбаатар»	137, 138	30
5	ТЭЦ-4	Яармаг-А, Яармаг-Б, 118	35

Дээрх ажлын даалгавар биелэгдсэнээр “Дархан-Селендумын” хяналтын зангилаан дээр бодит чадлыг тогтоосон утганд барих тогтворжилтыг хангах төвлөрсөн автоматикийн систем бий болж, WAMS түвшнээс WAMPAC системийг бий болох боломжтой юм.

Гурав. Төслийн хэрэгжилтийн үйл явц

Төслийн нэгдүгээр шатны даалгаврын хүрээнд эрчим хүчний системийн тогтворжилтын төлөв байдлыг хэвийн болон шилжилтийн горимын үед тасралтгүй хянах 24 цэгийг хамарсан WAMS системийг бий болгосон.

Энэ систем нь мэдээлэл цуглуулах ухаалаг төхөөрөмжүүдээс ЦСВХ-ийн өгөгдөл цуглуулах боловсруулах, хадгалах, аваарын бичлэгийг авах зэрэг олон түвшний автоматжуулсан систем юм.

Систем нь хоёр түвшнээс бүрдэнэ:

1. Эрчим хүчний объектын түвшин (эх үүсгүүр болон дэд станц);
2. Диспетчерийн удирдлагын түвшин (ДҮТ ТӨХК);

Объектын есөн түвшинд нийт 3 ш PDC, холболтуудыг хянах 24 ш PMU төхөөрөмжийг суурилуулсан.

Цагийн синхрончлогдсон вектор хэмжигдэхүүнийг хэмжих үүрэг бүхий гурван төрлийн PMU төхөөрөмж ашигласан:

- Синхрон генераторуудын роторын гүйдэл хүчдэлийг хянах зорилгоор ОДС СО ЕЭС (ОХУ-ын Эрчим Хүчний Нэгдсэн Сүлжээний Системийн Операторын Төв Диспетчерийн Алба) ны шаардлагад нийцсэн хэмжилтийн шалгуурыг хангасан үндэсний хэмжилзүйн баталгаатай Олон Улсын Си ангилалд багтсан үзүүлэлт бүхий ПАРМА РП4.12 төрлийн тусгай зориулалтын PMU-г генераторын холболтуудад болон улс хоорондын 220 кВ-ын шугамд суурилуулсан;
- Төслийн зардлыг бууруулах зорилгоор тухайн дэд станцад аваарын бүртгүүрийн зорилгоор ашиглагдаж байсан ПАРМА РП4.11 төрлийн төхөөрөмжид цагийн синхрончлогдсон вектор хэмжигдэхүүний өгөгдөл цуглуулах нэмэлт ПУ16/32М4 тоноглож ашигласан. Мөн ОДС СО ЕЭС (ОХУ-ын Эрчим Хүчний Нэгдсэн Сүлжээний Системийн Операторын Төв Диспетчерийн Алба) ны шаардлагад нийцсэн хэмжилттийн шалгуурыг хангасан үндэсний хэмжилзүйн баталгаатай Олон Улсын Си ангилалд багтсан үзүүлэлттэй;
- Төслийн зардлыг автотрансформатор, шугамуудын хамгаалалтад ашиглагдаж байсан өөртөө PMU функц бүхий (synchrophasor) АНУ-ын SEL-311C, SEL-487E гэсэн реле хамгаалалтын төхөөрөмжийг ашигласан;

Цагийн синхрончлогдсон вектор хэмжигдэхүүнийг системд дамжуулах, мэдээлэл цуглуулах, боловсруулах, өгөгдлийг 180 хоног хүртэл хадгалах, шилжилтийн горимыг хянах, IEC 61850-8-1 протоколоор хэмжилт болон автомат удирдлагын функцийг гүйцэтгэх үүрэг бүхий TRANSWAVE тусгай зориулалтын программ бүхий үйлдвэрийн зориулалттай PDC серверийг объектын түвшинд 3 онцгой байршилд ашигласан.

Системийн дээд түвшин буюу ДҮТ ТӨХК-ийн төв байранд төв PDC суурилагдсан бөгөөд үндсэн болон бэлтгэл шийдэлтэйгээр 2 ш ашиглалтад оруулсан.

Энэ нь системд дараах үүргийг гүйцэтгэнэ.

- Объектын түвшний PMU, PDC-ээс мэдээлэл цуглуулах;
- ЦСВХ-ээс ирж буй өгөгдлийг стандартын шаардлагад нийцсэн боловсруулалт, хадгалалт, хяналт хийх;
- Шилжилтийн горимын үеийн процессын үед параметрийн өөрчлөлтийг илрүүлэх, үйл явцын тайланг зохих стандартаар гаргах;
- Үндсэн PDC дээр ЦСВХ-ийг хадгалах хугацаа 180 хоног шилжилтийн горимын өөрчлөлтийн бичлэг (аваарын горим) хадгалах хугацаа хязгааргүй.

Үндсэн PDC дээр Бүгд Найрамдах Словен Улсын ELPROS компанийн WAMPAC түвшний WAProtector программ хангамж суурилагдсан. Энэ программ нь ЦСВХ-ээс

дамжуулсан том хэмжээний мэдээллийг тухайн агшинд (real time) боловсруулалт хийж шаардлагатай алгоритмын түвшинд ажиллах өндөр түвшний цогц программ хангамж юм.

Хүснэгт 2. WAProtector программын боломжит функц, үүрэг

Функцийн нэр	Зориулалт
Гормын параметрийн хяналт	Системийн тухайн цэг дээрх хүчдэлийн түвшин, давтамж тэдгээрийн өөрчлөлтийн хурдыг хянах.
Фазын (Роторын) өнцгийн хяналт	Системийн тухайн цэг дээрх параметрийн фазын өнцгийг хянах.
Нам давтамж түүний эх үүсвэрийг тодорхойлох хяналт	Системийн тухайн цэг дээрх нам давтамжийн хэлбэлзлийн түвшин, замхралын зэрэг, шинж чанарын хяналт.
Эрчим хүчний систем дэх богино залгааг илрүүлэх модуль.	Системийн тухайн цэг дээрх хүчдэлийн түвшин, давтамж тэдгээрийн өөрчлөлтийн хурд
Богино залгааг илрүүлэх модуль	Эрчим хүчний системийн богино залгааны горимыг илрүүлж, түүний төрлийг тодорхойлох.

WAProtector программын функц болон модулиуд нь тухайн агшинд идэвхжих (пускын) эрхтэнтэй байх ба дараах зорилгоор ашиглагдана.

- Хэрэглэгчийн график интерфэйсээр аваарын болон урьдчилсан (аваарын өмнөх дараах) гэх мэт бусад бүхий л горимын үеийн шинж чанар, дохиоллыг хэрэглэгчид зориулсан график дүрслэл болон дуу, тоо, дүрслэлийн боломжит хэлбэрээр харуулах;
- IEC60870-5-101/104, DNP3 ба IEC60870-6/TASE.2/ICCP, 61850-8-1 протоколуудыг ашиглан одоо байгаа контроллерууд болон объектын түвшний хяналтын терминалууд руу удирдлагын дохиог илгээх;

Аваарын төлөв байдал үүссэн үед системд бүртгэгдсэн үйл явдлаас хамгийн ач холбогдолтой бичлэгийг багтаасан хураангуй тайланг заагдсан хугацааны интервалд автоматаар гаргах боломжтой.

Тайланг тухайн төлөв байдлын үеийн, эсвэл зориуд тохируулсан, өдөр бүрийн, долоо хоног бүрийн гэх мэтээр үүсгэж болно.

Жишээ болгож 2020 оны долоодугаар сарын 18-ны өдөр 258-р ЦДАШ дээр гарсан нэг фазын богино залгааны үеийн WAProtector программ дээр автоматаар бий болсон тайланг зураг 1 дээр үзүүлэв.

Компанийн нэр:	Диспетчерийн үндэсний төв
Компанийн хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Чингисийн өргөн чөлөө, Хан-уул дүүрэг, 3 хороо, Засгийн газрын 14 байр
Хот:	Улаанбаатар
Улс:	Монгол Улс
Утасны дугаар:	+70041371
Факсны дугаар:	+70043467
Вэб хуудас:	http://www.ndc.energy.mn

	Огноо:	Tone:		Огноо:	Цаг:
Хаанаас:	2020-07-18	05:29:59	Хаашаа:	2020-07-18	05:30:02
Хаанаас (UTC):	2020-07-17	21:29:59	Хаашаа (UTC):	2020-07-17	21:30:02

Үйл явдал эхлэх цаг:	2020-07-18 05:30:00,300
Тайлант хугацаа:	00:00:03.0800000
Хүсэлтийн дагуу гаргасан тайлан:	AUTO-SYSTEM
Төхөөрөмж:	WAProtector

Short Circuit Locator: Short Circuit Locator/ShortCircuitLocator

Үндсэн тэмдэглэгээ

N	Байршил	Үйл явдлын цаг	SC Type	Х а м г и й н хүчтэй	Хариу өгөх хугацаа [s]	RTE
1	220Кв Дархан	2020-07-18 05:30:00,300	B-E	Худал	0.080	Худал
2	220Кв Дархан	2020-07-18 05:30:00,300	B-E	Үнэн	0.100	Худал

Оргил цэгүүд


N	Байршил	Pre-Va [kV]	Pre-Vb [kV]	Pre-Vc[kV]	Va [kV]	Vb[kV]	Vc[kV]
1	220Кв Дархан	134.64	135.19	134.39	136.19	73.11	140.97
2	220Кв Дархан	134.91	135.38	134.46	131.90	73.13	141.10
N	Байршил	Pre-Ia [A]	Pre-Ib[A]	Pre-Ic [A]	Ia [A]	Ib[A]	Ic [A]
1	220Кв Дархан	83	89	83	41	1250	120
2	220Кв Дархан	83	90	84	124	282	136

Байршлын түүх

N	Байршил	Module Id
1	220Кв Дархан	Darhan L-258 P\Tasks/Out/Darhan L-258 ShortCircuitDetectorI
2	220Кв Дархан	Darhan L-257 P\Tasks/Out/Darhan L-257 ShortCircuitDetector

Хүчдэл А

Зураг 1. Богино холболтыг илрүүлэх модулийн тайлангийн хэсэг




Төслийн хоёрдугаар шатанд бий болгосон WAMS систем дээрээ тулгуурлан 257, 258-р шугамын ачааллыг автоматаар хөнгөлөх төвлөрсөн автоматикийн системийг бий болгон (АРОЛ) WAMPAC түвшинд хүргэх зорилт тавьсан. WAMPAC-ийн бүтцийн схемийг зураг 2-т үзүүлэв.

257, 258-р ЦДАШ-ын төлөв байдлыг агуулсан ЦСВХ-ийн өгөгдлийг Дархан хотын 220 кВ дэд станц дээр тухайн шугамуудад суурилагдсан ПАРМА РП4.12 РМУ төхөөрөмжөөс IEEE C37.118.2-2011 протоколоор Диспетчерийн Үндэсний Төвийн WAProtector программ бүхий төв сервер дээр хүлээн авснаар ОХУ, Монгол Улсын эрчим хүчний систем хооронд дамжих чадлыг “Селендум-Дархан” хэсэг дээр тухайн агшинд нь хянах боломжтой.

WAProtector программ нь IEE 60870-5-104 протоколоор удирдах үйлдлийг объектын түвшинд байгаа SEL-3505-3 RTAC контроллерт дамжуулна.

RTAC нь тоон гаралтаараа сонгосон 110 кВ-ын шугамыг таслах үйлчлэлийг гаралтын релегээр дамжуулан гүйцэтгэнэ.

Зураг 2. WAMPAC-ийн бүтцийн диаграм



WAProtector программ дээр хэрэгжүүлсэн 257, 258-ийн ачаалал хөнгөлөх АРОЛ автоматик нь богино залгааны үед ажиллахгүй байх богино залгааг илрүүлэх модул ашигласан хоригтой.


Мөн систем нь буруу ажиллахаас сэргийлсэн дараах нөхцөлүүдтэй.

- Системийг бүрдүүлэгч элементүүдийн тэжээлийг залгаж таслах үед;
- Шуурхай удирдлагын хэлхээнд алдаа гарсан үед;
- Хүчдэл ба гүйдлийн хэлхээнд алдаа гарсан үед;
- Хүчдэлийн хэлхээнд алдагдал гарах үед;
- Системд орсон төхөөрөмжүүдийг дахин ачаалах үед;
- Тохиргоог өөрчлөх үед;

- ЦСВХ-ийн өгөгдөл дутуу байх үед.

АРОЛ автоматикийн ажиллагааны хяналтыг WAProtector программ дээр тусгайлан дэлгэцийн дүрслэлийн багцыг боловсруулсан. WAProtector дээр боловсруулсан багц дүрслэлийн нэг хэсгийг зураг-3 т үзүүлээ.

Зураг 3. WAProtector дэлгэцийн хэлбэр



WAMPAC системийг ашиглалтад оруулснаас хойш уг систем нь манай эрчим хүчний системд үүссэн нийт дөрвөн удаагийн доголдол, сүлжээний уналтаас амжилттай хамгаалжээ. Тухайлбал:

- **2021 оны зургаадугаар сарын 25-ны өдөр.** ОХУ-аас импортоор 57МВт чадлыг авч байсан, ТЭЦ-4-ийн Рнийлбэр=482.1МВт байсан бөгөөд 16:41:47 цагт ТЭЦ-4-ийн Зуух№4 нь сийрэгжилтийн хамгаалалтаар зогссоноор ОХУ-аас авах импортын чадлын хэмжээ 200МВт болсноор АРОЛ автоматик ажиллаж нийт 48.71МВт ачаалал хөнгөлсөн байна.
- **2021 оны наймдугаар сарын 02-ны өдөр.** ОХУ-аас импортоор 201,1МВт чадлыг авч байсан, ТЭЦ-4-ийн Р нийлбэр=287МВт байсан бөгөөд 11:57:09 цагт ТЭЦ-4-ийн Зуух №3 нь галын дөлийн хамгаалалтаар зогссоноор ОХУ-аас авах импортын чадлын хэмжээ 269МВт болсноор АРОЛ автоматик ажиллаж нийт 42 МВт ачаалал хөнгөлсөн.
- **2021 оны наймдугаар сарын 02-ны өдөр.** ОХУ-аас импортоор 150,5МВт чадлыг авч байсан, ТЭЦ-4-ийн Рнийлбэр=462,2МВт байсан бөгөөд 10:27:22 цагт ТЭЦ-4-ийн Зуух №6 нь тэжээлийн усны 6К-303 хаалт хаагдаж, түвшин буурах хамгаалалтаар зогссоноор ОХУ-аас авах импортын чадлын хэмжээ 8 269МВт болсноор АРОЛ автоматик ажиллаж нийт 36.2 МВт ачаалал хөнгөлсөн.

- **2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр.** ОХУ-аас импортоор 176,7МВт чадлыг авч байсан, ТЭЦ-4-ийн Рнийлбэр=595,9МВт байсан бөгөөд 20:04:00 цагт ТЭЦ-4-ийн ТГ№7 өдөөлтийн хамгаалалт зогссоноор ОХУ-аас авах импортын чадлын хэмжээ 260МВт болсноор АРОЛ автоматик ажиллаж 38,1 МВт ачаалал хөнгөлсөн.

WAMS систем нэвтэрснээр:

- Нэгдсэн сүлжээнд үүссэн богино залгааг шууд илрүүлж тухайн үеийн параметрийн утга, үргэлжилсэн хугацаа, гэмтлийн хэлбэр зэргийг тодорхойлсон тайланг гаргана.
- Эрчим хүчний системийн тогтвортой ажиллагааг давтамж, хүчдэл, роторын өнцөг, чадал, тэдгээрийн өөрчлөлтийн хурд зэрэг горимын параметраар тасралтгүй хянана.
- Тогтворжилт алдагдахаас сэргийлэх орчин үеийн WAMPAC түвшний төвлөрсөн автоматикийн системийг бий болгоно.
- Эрчим хүчний системийн горимын тооцооны программын үнэмшлийг WAMS хэмжилтэд тулгуурлан математик загварчлалыг тасралтгүй сайжруулна.
- WAMS системээр эрчим хүчний чанар, найдвартай ажиллагааны төлөв байдалд тасралтгүй хяналт хийснээр олон улсын стандартын өндөр шаардлага, эрчим хүчний тасалдалгүй байдал, аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьдаг гадаадын хөрөнгө оруулалттай Оюутолгой гэх мэт ийн эрчим хүчний томоохон хэрэглэгчдийг эрчим хүчээр бүрэн хангах үед тавигдах техникийн шаардлага, горим тохируулгын систем, үүсч болох хүндрэлүүдийг урьдчилан тооцохоос гадна гэнэтийн саатлын үед гадны экспертүүдтэй хамтран ажиллах үед тэдний шаардлагад нийцсэн тооцооны программын симуляцийн өгөгдөл мэдээлэл бүрэн хангагдсан байна.
- WAMS систем нэвтэрснээр эрчим хүчний судалгаа шинжилгээ бүхий л чиглэлээр хөгжиж мэргэжилтнүүдийн чадавх дээшилсэн, мөн түүнчлэн манай эрчим хүчний инженерүүдийн гаргасан тооцоо судалгааг олон улсад хүлээн зөвшөөрч эхэлсэн байна.

Цаашид Монгол Улсын эрчим хүчний систем бүс нутгийн болон Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдон удирдлагын түвшинд хамтран ажиллах боломжтой юм.

Дөрөв. Дүгнэлт

Төслийн үр дүнд Монгол Улсын эрчим хүчний системд тогтворжилт алдагдахаас сэргийлэх орчин үеийн төвлөрсөн автоматикийн системийг бий болгох эхлэлийг тавьж WAMPAC системийг үүсгэснээр дараах асуудлуудыг шийдвэрлэж эхлээд байна. Үүнд:

- Тогтворжсон ба шилжилтийн гэх мэт бүхий л төрлийн горимд цагийн синхрончлогдсон өндөр нарийвчлалтай вектор хэмжилтийг хүлээн авах шинэ төрлийн хяналтын системийг эрчим хүчний системд нэвтрүүлснээр найдвартай ажиллагаа дээшилнэ;
- Төвлөрсөн нэг техникийн болон программ хангамжийн платформ дээр хэд хэдэн

автоматжуулсан системийг хэрэгжүүлснээр (Шилжилтийн горимын хяналт мэдээлэл СМПР, Аваарын процессыг бүртгэх РАС, тогтворжилтыг хангах автоматик АПНУ, Хэвийн горимын хяналт, Горим тохируулгын систем) шинэ системийг бий болгох зардал мөн үйл ажиллагааны зардлыг бууруулна;

- Өдөөлтийн систем, турбины тохируулгын системийг WAMS системийн хяналтад тулгуурласан зөв тавилаар тохируулсанаар синхрон генератороос үүсэх нам давтамжийн хэлбэлзэл гэх мэт хэвийн бус горимд тоноглол ажиллаж механик нөөц буурахаас урьдчилан сэргийлнэ;
- Нам давтамжтай хэлбэлзлийн эх үүсвэрийг илрүүлэх, тэдгээрийн шинж чанарыг тухайн агшинд тодорхойлох, түүнээс сэргийлэх техникийн арга хэмжээг авах аргачлалыг боловсруулах;

Энэхүү төслийг хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын эрчим хүчний системийн тогтвортой байдлыг хангах, цаашид учирч болох аливаа гэнэтийн осол аваар й, саатлаас нийт эрчим хүчний системийг хамгаалахад чухал ач холбогдолтой, томоохон хүчин зүйл болсон. Цаашид WAMS системийн хяналтыг нийт эрчим хүчний системд илүү өргөн хүрээтэй нэвтрүүлэх шаардлагатай.

-
1. ГОСТ Р 59364-2021. Нэгдсэн эрчим хүчний систем ба тусгаарлагдсан үйл ажиллагаатай эрчим хүчний систем. Релений хамгаалалт ба автоматжуулалт. Шилжилтийн горимын хяналтын систем. Шилжилтийн горимын хяналтын систем. Норм ба шаардлага -Москва: Техникийн зохицуулалт, хэмжил зүйн үндэсний газар, 2021. - 45 х.
 2. ГОСТ Р 59365-2021. Нэгдсэн эрчим хүчний систем ба тусгаарлагдсан үйл ажиллагаатай эрчим хүчний систем. Релений хамгаалалт ба автоматжуулалт. Шилжилтийн горимын хяналтын систем. Шилжилтийн горимын хяналтын систем. Стандарт ба шаардлага - Москва: Техникийн зохицуулалт, хэмжилзүйн үндэсний газар, 2021. - 15 х.



Ш.ГАНТУЯА

ҮБХИС АБДС-ийн Багш,
докторант

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГООР ХАНГАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Abstract: Based on the formulas of national security and investment theory and the study of nature, the logical relationship between them can be determined. We can see that this relationship can be expressed through development policies, the nature of national security and investment, the link between security and development shown in Figure 1, and the following theoretical and methodological conclusions.

Keywords: Impact, analysis, investment, policy, provide, national, security

Үндсэн хэсэг

Дэлхийн эдийн засгийн тогтолцооны даяаршлын үйл явц нь хямрал, түүнийг дагасан шинэ аюул заналыг ҮАБ-д учруулж болох тул үүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг төр авч хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Үндэсний аюулгүй байдлаа хангахуйц хамгаалалтын шинж чанартай төрийн бодлогын нэг бол эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх явдал юм. Хөрөнгө оруулалт бол үндэсний эдийн засгийн бодлогын стратегийн хүрээнд хэрэгжих ёстой улс орны нийгэм эдийн засгийн тэргүүн зэргийн асуудал юм. Аюулгүй байдлын асуудлууд шууд хөрөнгө оруулалттай зайлшгүй холбоотой. Тухайлбал, импортын болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын экспортын хэмжээ зэрэг нь дотоодын хөрөнгө оруулалтын идэвхжилт, хөрөнгө оруулалтын уур амьсгалын хүчин зүйлүүд, гадаадын түүний дотор үндэстэн дамнасан холимог компаниудыг татах, үйлчлэх, харилцан үр ашигтай харилцан ажиллах чадвараас хамаардаг байна. Энд хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогоор дотоод, гадаад хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгох нь чухал байна.

Ингэхдээ хөрөнгө оруулалтын хурдацтай, дээд зэргийн үр ашигтай үйл ажиллагаагаар дамжуулан үндэсний язгуур ашиг сонирхол, үнэт зүйлсийг баталгаатай хамгаалах нь үндэсний эдийн засгийн хөгжилтэй холбогдож, харилцан уялдаатай орших тул үндэсний аюулгүй байдлын гол чиглэмж, шалгуур нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах явдал болно. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл нь “Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг” бий болгоход оршино¹ гэж үзэл баримтлалын 3.2.-т тодорхойлсон байдаг.

Үндэсний аюулгүй байдал ба хөрөнгө оруулалтын харилцан хамаарлын мөн чанарыг гаргах судалгааны хувьд нэгд, үндэсний аюулгүй байдлын онолын томьёолол, мөн чанарыг судлах, хоёрт, хөрөнгө оруулалтын онолын томьёолол, мөн чанарыг судлах, гуравт, тэдгээрийн онолын суурь ойлголтод үндэслэн хамаарлыг нь тодорхойлох логик дараалал бүхий арга зүйг баримтлалаа.

Ийм арга зүй нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө гүнзгий судалсан, шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын суурь бааз шаардлагатай бөгөөд ийм шаардлага онолын үндэслэлтэй тодорхойлолт л аливаа асуудалд харилцан ойлголцол болон нэгдсэн хандлага бий болгож чаддагтай болон өнөө үед “аюулгүй байдал” гэсэн хамгийн ерөнхий суурь ойлголтын талаар янз бүрийн томьёолол тохиолдож, энэ нь үндэсний аюулгүй байдал гэдэг ойлголтын аппаратыг бий болгож мөрдөхөд зарим талаар сөрөг үр дагавар авчирч байгаатай холбоотой юм. Гол шалтгаан нь тухайн асуудлыг хариуцан боловсруулсан хүмүүсийн дунд аюулгүй байдлын онол, арга зүйн танин мэдэхүйн ойлголт цэгцрээгүйтэй холбоотойгоор агуулгын алдаатай дүгнэлт хийгдэж байгаатай холбоотой юм.²

Үндэсний аюулгүй байдлын онолын томьёолол, мөн чанар

Аюулгүй байдлын хамгийн ерөнхий ойлголт олон үйл явцад хэрэглэгддэг бөгөөд аюулгүй байдлын зөвхөн тодорхой тохиолдолд байдаг онцгой шинжийг тусгахын зэрэгцээ төрөл бүрийн салбарт энэ ойлголтыг ашиглах боломжийг агуулж байдаг.

Судалгаанаас үзэхэд аюулгүй байдлын хамгийн ерөнхий ойлголт гурван төлөв байдлыг илэрхийлж байна. Үүнд:

1. Аюул заналаас ангид, өөрөөр хэлбэл аюул занал байхгүй байдал;
2. Хамгаалагдсан байдал;
3. Хөгжлийн нөхцөл.

Хэл шинжлэлийн философи утга талаас өгсөн тодорхойлолт нь нэг талаас “аюулгүй-аюул байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй; аюулгүй байдал-осол, түгшүүргүй байх төлөв” гэж зөвхөн аюул занал байхгүй байдлыг илэрхийлсэн бол нөгөө талаас “аюулгүй байдал-аюул байхгүй, бүтэн байлгах, найдвартай байдал”³ гэж аюул занал байхгүй,

¹ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он

² О.Үржин. Монгол Улсын аюулгүй байдлын орчны үнэлгээ-2030

³ Далийн тайлбар тольд

хамгаалагдсан байдал, хөгжлийн нөхцөл зэргийг аль алиныг нь илэрхийлсэн өргөн хүрээгээр өгөгдсөн байдаг.

Онолын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах системийн зорилго үндэсний ашиг сонирхлыг хангахад чиглэдэг учраас гадаад ба дотоод аюулгүй байдлыг хангах дэд системүүдийн нэгдмэл шинж нь үндэсний ашиг сонирхлыг хангах удирдлага, зохицуулалтын үр дүнгээр илэрхийлэгдэнэ. Ийм үр дүнг хангах арга зүйн үндэс нь: гадаад аюулгүй байдлын хувьд аливаа улс оршин байгаа цагт түүний ашиг сонирхол байсаар байх, ... гадаад бодлого зөв байх цорын ганц шалгуур нь тухайн бодлого үндэсний ашиг сонирхлоор илэрхийлэгдсэн байх, ... гадаад бодлогын зорилго нь үндэсний ашиг сонирхлын үндсэнд боловсруулагдаж идэвхтэй хүчин чадлаар дэмжигдэх, үндэсний ашиг сонирхол нь үндэсний аюулгүй байдлын үндсэн дээр боловсруулагдах ёстой⁴ зэрэг олон улсын харилцааны онолын томъёоллоор тодорхойлогдож байна.

Манай улсын тулгуур баримт бичгүүдэд “ашиг сонирхол” хоршоо үгийг олон янзаар хэрэглэсэн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль⁵-д “ашиг сонирхол”, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал⁶-д “Үндэсний язгуур ашиг сонирхол”, “үндэсний ашиг сонирхол”, “нийтлэг ашиг сонирхол”, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль⁷-д “үндэсний язгуур ашиг сонирхол” гэсэн нэр томъёог тус тус ашигласан байна.

Чингэхдээ бид эдгээр ойлголт үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс “үндэсний язгуур ашиг сонирхол”-д өөрөөр хэлбэл “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана”⁸ ойлголтод захирагдах зүй тогтолтой байна гэдгийг үндэс болголоо.

Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн бодлого, үйл ажиллагаа улс орны хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай шууд хамааралтай бөгөөд хөгжлийн аюул заналаас хамгаалагдсан нөхцөлийг бүрдүүлсэн байдлаар аюулгүй байдлын түвшинг тодорхойлж болохыг бид дээр өгүүлсэн билээ. Иймд үндэсний аюулгүй байдлыг хангах системийн хувьд аюулгүй байдал ба хөгжлийн хоорондын уялдаа холбооны үндсэн агуулгыг мэдэж байх шаардлагатай юм. Тэдгээрийн уялдаа холбооны ерөнхий ойлголтыг 1.1 дүгээр зураг дээр үзүүлээ.

⁴ Hans J.Morgenthau. Politics Among Nations. The Struggle for Power and Peace. Fourth Edition.N.Y., 1967, p.541-544

⁵ Монгол Улсын Үндсэн хууль. Зургаадугаар зүйл.4 заалт; Арван зургаадугаар зүйл 11 заалт; арван долоодугаар зүйл. 2 заалт;

⁶ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 сарын 15 өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. Гурав. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам. 3.2.4.4 заалт; 3.3.1.2 заалт; 3.3.3.2 заалт; 3.3.3.5 заалт;

⁷ Монгол Улсын Их хурлаар 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 3дугаар зүйл. 3.2.заалт; 9дүгээр зүйл. 9.1. заалт;

⁸ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 сарын 15 өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”.

Зураг 1. Аюулгүй байдал ба хөгжлийн уялдаа холбоо



Зургаас дараах үндсэн агуулгыг харж болно. Үүнд:

1. Аливаа системийн аюулгүй байдал алдагдах нь хөгжлийн хөтөлбөрт саад болдог бөгөөд олон арван жилийн хөгжил, түүний санаачилгыг сулруулдаг.
2. Аливаа системийн аюулгүй байдал алдагдсаны дараа хөгжлийн хөтөлбөрүүдийг санаачлах ач холбогдол бүхий боломж нээгддэг.
3. Хөгжлийн хөтөлбөрүүд нь тодорхой хүрээний аюултай байдлыг даах, эрсдэлийг өөртөө хүлээн авах мэдрэмжийг нэмэгдүүлэх боломжтой.
4. Хөгжлийн хөтөлбөрийг аюултай байдал ба түүний үр дагаврыг бууруулахад чиглүүлэн боловсруулах бүх талын боломж бий.

Шийдвэр гаргагчдаас аюулгүй байдал ба хөгжил хоорондын уялдаа холбоонд төдийлөн анхаарал тавьдаггүй бөгөөд шийдвэр гаргагчдад итгэл үзүүлсэн хүмүүст уршиг тарьдаг байна.

Дэлхий дахинд бий болж буй нийгэм эдийн засаг, улс төрийн шинэ нөхцөл байдал нь аливаа улсын өмнө шинэ орчин, шинэ хандлага, сорилт, сургамжийг бий болгож, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх гадаад, дотоод олон хүчин зүйлийг үүсгэж байна. Иймд тусгаар тогтносон улс бүрийн эн тэргүүний шаардлагатай асуудал бол Үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийг олон улсын харилцааны өөрчлөлт, шинэчлэлтийн хандлага, өөрийн орны өвөрмөц онцлог, харьцангуй давуу талд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэхэд оршино.

Хөрөнгө оруулалтын онолын томьёолол, мөн чанар

Хөрөнгө оруулалтын талаар хэд хэдэн чиглэлээр өгсөн тодорхойлолт байна. Тухайлбал, ерөнхий утгаар нь “Хөрөнгө оруулалт гэдэг бол ашиг олох болон өөр ашигтай үр дүнд хүрэх зорилго бүхий бусад үйл ажиллагаа, үйлдвэрийн газарт үйлдвэрлэл эрхлэгчээс нийлүүлж байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө түүний дотроос мөнгөн үнэлгээгээр илэрхийлэгдэх хөрөнгийн эрх, бусад эрх зэргийг хэлнэ”⁹ гэж, зах зээлийн

⁹ “Об инвестиционной деятельности в Российской Федерации, осуществляемой в форме капитальных вложений”

эдийн засагт хөрөнгө оруулалт гэдэг нь “investment” буюу ашиг, орлого олох эсвэл өөр тааламжтай үр дүнд хүрэх зорилгоор пүүс компанид оруулж байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө, түүний дотроос мөнгөн үнэлгээгээр илэрхийлэгдэх хөрөнгийн эрх зэрэг үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагааг ойлгож болно” гэж, Ц.Аюурзана “Хөрөнгө оруулалт бол хөгжлийн түлхүүр юм. Үйлдвэрлэл үйлчилгээний үр ашгийг дээшлүүлж, хүнд хүрэх өгөөжийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогыг өсгөх зорилгоор урьдчилан оруулж байгаа хөрөнгө капиталыг хөрөнгө оруулалт гэнэ. Энэ нь зөвхөн мөнгөн хөрөнгө төдийгүй хувь оролцоо, хувьцаа ба бусад үнэт цаас, шинэ технологи, машин тоног төхөөрөмж, лиценз, зээл, бусад эд хөрөнгө, түүнчлэн эд хөрөнгө эзэмших эрх, оюуны өмч хөрөнгө байж болно»¹⁰ гэж, мөн түүнчлэн Харвардын их сургуулийн Бизнесийн удирдлагын сургуулийн доктор Эрик Хелферт «Хөрөнгө оруулалт бол аливаа бизнесийн хөдөлгөгч хүч юм. Энэ нь удирдлагын боловсруулсан сонгон шалгаруулалтад суурилсан дараах 3 төрлийн хөрөнгийг шинээр олж авах буюу үргэлжлүүлэн ашиглах төсөл төлөвлөгөөнд тулгуурлана. Үүнд:

1. Ажлын капитал
2. Барилга, машин, тоног төхөөрөмж, конторын тавилга
3. Судалгаа ба боловсруулалт, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний боловсруулалт, урамшуулал ба хөнгөлөлт зэрэг үндсэн зардлын хөтөлбөр зэрэг болно гэж тус тус тодорхойлсон байна.

Эдгээр тодорхойлолтоос дараах дүгнэлтүүд хийх боломж харагдаж байна:

- Хөрөнгө оруулалтын зорилго нь ашиг олох болон бусад ашигтай /тааламжтай/ үр дүнд хүрэхэд оршиж байна. Эндээс хөрөнгө оруулалтын зорилго нь зөвхөн ашиг олоход бус бас өөр ашигтай, тааламжтай үр дүнд хүрэхэд чиглэгдэхийг харуулж байна.
- Оруулж буй хөрөнгө нь мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө, түүний дотроос мөнгөн үнэлгээгээр илэрхийлэгдэх хөрөнгийн эрх зэрэг байх бөгөөд хөгжлийн тодорхой зорилго, тооцох үр дүнд чиглэн зарцуулагдах байх ёстой байна.

Судалгаанаас үзэхэд зөвхөн нэг тодорхой зорилгыг агуулсан, өөрөөр хэлбэл ашиг олох эсвэл өөр ашигтай, тааламжтай үр дүнд хүрэхэд чиглэсэн зорилго бүхий хөрөнгө оруулалтын талаар өгөгдсөн тодорхойлолт бас байна. Тухайлбал, “Хөрөнгө оруулалт гэдэг бол мөнгийг ашиглаж ашиг орлого олохыг хэлнэ”¹¹ гэж эдийн засгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, мөн “Оюуны хөрөнгө оруулалт нь сургалт, судалгаа, туршилт, шинжлэх ухааны зохион бүтээл, лиценз зэрэгт хөрөнгө оруулахыг хэлнэ” гэж нийгмийн хөгжлийн таатай үр дүнд хүрэхэд чиглэсэн тодорхойлолт байна.

Үндэсний аюулгүй байдал ба хөрөнгө оруулалтын хамаарал

Үндэсний аюулгүй байдал ба хөрөнгө оруулалтын онолын томьёолол, мөн чанарын судалгаан дээрээ тулгуурлан тэдгээрийн хоорондын хамаарлын логик уялдааг тодорхойлж болно. Энэ хамаарал нь хөгжлийн бодлогоор дамжин илрэх боломжтойг бид үндэсний аюулгүй байдлын ба хөрөнгө оруулалтын мөн чанар зураг 1 дээр үзүүлсэн аюулгүй байдал ба хөгжлийн уялдаа холбоосын зураглал болон дараах онол, арга зүйн гаргалгаанаас харж болно.

Передачный закон от 25.02.99 №39-ФЗ. Нормативные акты для бухгалтера-1999 №7.

¹⁰ Ц.Аюурзана “Санхүүгийн менежмент”, УБ, 2007 он, 127-р тал

¹¹ The World Book Encyclopedia

Үндэсний аюулгүй байдал болон улс орны хөгжил хоёр хоорондоо нягт холбоотой, салангид хэрэгжиж чадахгүй ээдрээтэй диалектик шинжтэй, өөрийн мөн чанар агуулгаар үргэлж сэргөлдөх хандлагатай байх бөгөөд сэргөлдөөн нь эрсдэлээр дамжин илэрч байдаг. Аюулгүй байдал нь системийн байгаа тогтвортой байдлыг хадгалж, аливаа төрлийн, ялангуяа эрсдэлтэй шинэ санаануудыг хязгаарлахыг шаарддаг бол хөгжил нь нийгмийн үйл ажиллагааны бүхий л хүрээнд байнгын өргөжилт, шинэчлэл, инновацийг шаардана. Системийн *аюулгүй байдал, хөгжил хоёрын харилцан холбооны ээдрээтэй диалектик шинжийг эрсдэл*¹² илэрхийлнэ.

Энэ нийтлэг ойлголтын өнцгөөс аюулгүй байдал ба хөгжлийн хамаарлын харилцан шүтэлцээ бүхий зүй тогтлыг олон талаас нь шинжиж болно. Тухайлбал, манайд тулгамдсан асуудлын нэг болсон ядуурлаар жишээ авбал: нэгд, ядуурал бол нийгэмд заналхийлж буй объектив аюул занал мөн; хоёрт, ядуурал бол байгалийн аюулт үзэгдэл, халдварт өвчин, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг олон аюул заналд өртөх эмзэг нөхцөл байдлыг бий болгоно; гуравт, ядуурал өөрөө эдийн засгийн хямрал, засаглалын сул дорой байдал, ажилгүйдэл, төрийн өндөр албан тушаалтнуудын авлигад автагдсан зэрэг объектив, субъектив олон хүчин зүйлүүдийн үр дагавар байж болно. Тиймээс үндэсний аюулгүй байдал ба түүнд оруулах хөрөнгө оруулалтын хоорондын хамаарлын мөн чанарыг хөрөнгө оруулалтын үр дүнгийн эрсдэлийг тооцож, түүнийг бууруулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн олон улсын жишгийн дагуу боловсруулсан тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх замаар илэрхийлж болно.

Тогтвортой хөгжлийн талаар нэгэн ижил утга агуулгыг илэрхийлсэн хэд хэдэн тодорхойлолт байна. Тухайлбал, нэгд, тогтвортой хөгжил нь байгаль, нийгмийн аль ч төвшний ямар ч төвөгтэй системийн хөгжлийг хангахдаа түүнийг аюулгүй байдлыг хадгалж, өнөөгийн болон хойч үеийнхээ “амьдралын чанар”-ыг хэвийн төвшинд байлгах үйл явц; хоёрт, тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийн хэрэгцээг хангахыг хэлнэ”¹³; гуравт,... тухайн үеийнхээ эрэлт, хэрэгцээг хангахын дээр ирээдүйн залгамж үеийнхэнд эрэлт хэрэгцээгээ хангахад нь аливаа дарамт учруулахааргүй тийм хөгжлийг тогтвортой хөгжил гэнэ”¹⁴.

Энэ системлэг ойлголтын хүрээнд дэлхийн хамтын нийгэмлэгээс хэрэгжүүлсэн аюулгүй байдал ба хөгжлийн харилцан уялдааны зохицуулалтыг нөхцөлдүүлсэн синергетикийн үйл явцын хоёр тодорхой баримтын жишээ бол нэгд, “эрсдэлгүй амьдрах” гэсэн бүтэшгүй оролдлогоос татгалзаж “эрсдэлтэй зохицож амьдарч сурах” асуудал дэвшигдэж, үр дүнд нь аюулгүй байдлыг хангах систем дэх эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулах удирдлагын параметрийг өөрчлөх замаар тогтвортой хөгжлийг хангах хэрэгцээ, шаардлага бий болсон; хоёрт, аюулгүй байдлыг хангах системийн хүрээнд дэлхийн нийтээр хамтын хөгжлийн механизмыг бий болгох эхлэл тавигдаж, үр дүнд нь: Бразилын нийслэл Рио де Жанейро хотноо 1992 онд болсон “Хөгжил, хүрээлэн буй орчин” сэдэвт дэлхийн бага хурлаар “Тогтвортой хөгжил” загварыг баталсан явдал

¹² Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я., ШУА., УБ., 2008, 3278 х., т.3211. Эрсдэл-ерсдэх үйлийн нэр, эрсдэл багатай-ерсдэх нь бага, эрсдэлтэй-ерсдэл ихтэй.

¹³ Бидний хамтын ирээдүй, Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн даян дэлхийн комиссын тайлан, 1987.

¹⁴ Брутландын Комиссын 1987 оны тайлан.

юм. Энэ нь аюулгүй байдал ба хөгжлийн харилцан хамаарлын зохицуулалтыг эрсдэлийг бууруулах өнцгөөс харж боловсруулсан шийдэл юм.

Зураг 2. Тогтвортой хөгжлийн загвар



Тогтвортой хөгжлийн гурвалжин загвар нь аюулгүй байдлын үүднээс нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, экосистемийг хадгалах гэсэн гурван асуудлыг нэг нь нөгөөгөө золиослохгүй байхаар харилцан хамааралд нь зохицуулах чухал шийдэл юм.

Эндээс хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, хүрээлэн буй орчны тэнцвэрийг алдагдуулахгүйгээр тааламжтай үр дүнд хүргэсэн үр өгөөж өгч байвал үндэсний аюулгүй байдалд тодорхой хувь нэмэр оруулж байна гэсэн үг.

Дүгнэлт

Үндэсний аюулгүй байдал ба хөрөнгө оруулалтын харилцан хамаарлын мөн чанарын тухайд: Үндэсний аюулгүй байдал ба хөрөнгө оруулалтын хамаарлын мөн чанарыг үндэсний аюулгүй байдал ба хөрөнгө оруулалтын онолын суурь ойлголтод үндэслэн системийн хандлагын арга зүйгээр тодорхойлсон нь судалж буй асуудлын шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын аппаратыг бий болгосон. Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн бодлого, үйл ажиллагаа улс орны хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай шууд хамааралтай бөгөөд хөгжлийн аюул заналаас хамгаалагдсан нөхцөлийг бүрдүүлсэн байдлаар аюулгүй байдлын түвшин тодорхойлогдох ёстой байна. Үүний мөн чанар нь нэг талаас хөгжил эмзэг байдлыг ихэсгэдэг ба аюулгүй байдал хөгжилд саад болдог сөрөг тал болон нөгөө талаас хөгжил эмзэг байдлыг багасгаж болох ба аюулгүй байдал хөгжилд түлхэж өгөх боломжтой байх эерэг тал хоорондын оновчтой шийдлээс хамаарах зүй тогтолтой холбогдож байна. Онол арга зүйн судалгааны үр дүнд: **Нэгд:** Хөрөнгө оруулалтын бодлого нь Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тус улсын гадаад, дотоод нөхцөл байдал нь хөрөнгө оруулалтын бодлогын зорилго, зарчим чиглэлийг тодорхойлох үндэс болно. **Хоёрт:** Хөрөнгө оруулалт нь аливаа системийн бизнесийн хөдөлгөгч хүч, тогтвортой хөгжлийн түлхүүр бөгөөд шинжлэх ухаан, техникийн дэвшил, инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх өөр өөрийн зорилго, эрх, үүрэг бүхий олон субъектүүдийн үйл ажиллагааг системийн зорилго, үр дүнд төвлөрүүлэн зангидаж төлөвлөх, удирдах цогц хэрэгсэл мөн гэсэн дүгнэлтийг хийж байна.

ГАДААД АЮУЛГҮЙ БАЙДАЛ



З.БОЛДБААТАР (Ph.D)
ҮБХИС-ийн Профессор

БАТЛАН ХАМГААЛАХ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАМЖИЙГ БЭХЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Abstract: *This article is about the issues of effective implementation of the security and defense objectives set by the government and the creation of economic opportunities. It was also suggested that defense budget planning should be improved in line with professional army standards, that a defense budget law should be enacted, and a domestic investment policy should be developed to ensure national security. Specific proposals have been made on ways and opportunities to increase the country's defense economic potential.*

Keywords: *national security, security, defense budget, domestic investment, defense economic potential, implementation of security and defense objectives, government, professional army standards, etc.*

Улс орны хөгжил, үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байдаг зүй тогтолтой. Аливаа улс орны батлан хамгаалах эдийн засаг нь тухайн улс орны хөгжилд тулгуурладаг. Улс орныг батлан хамгаалах нь ямар ч улсын хувьд үндэсний язгуур эрх ашгийн амин чухал асуудал байсаар ирсэн. Монголын төрөөс улс орноо батлан хамгаалах зорилтоо бүх ард түмний оролцоо, орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, түүнийг хангах стратегийг тодорхойлоод байна. Энэхүү стратегийг тодорхойлсноос хойш 20 гаруй жил өнгөрч байгаа боловч батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо жинхэнэ утгаараа бүрэлдэн төлөвшиж чадаагүй байна. Манай улсын гадаад харилцаа өргөжин тэлж, аюулгүй байдлын орчин өөрчлөгдөж, уламжлалт болон уламжлал бус аюулын шинэ хэлбэр, хүчин зүйлүүд бий болж байгаа нь улс орны аюулгүй байдлын асуудлыг батлан хамгаалах эрх ашгийн өөрчлөлттэй нийцүүлэн, батлан хамгаалах тогтолцоог өргөн хүрээгээр бэхжүүлэх шаардлага бий болоод байна.

Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх нь улс орны үндэсний аюулгүй байдлын амин чухал эрх ашгийн хүрээнд хамаардаг, цаг хугацаатай уралдан хийж гүйцэтгэх ёстой тулгамдсан асуудал гэж үзэж байгаа болно. Улс орны батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх асуудал нь үндэсний аюулгүй байдлын бодлого, улс орны эдийн засгийн бодлого, гадаад бодлого болон нийгмийн олон талт бодлого дээр тулгуурлаж, харилцан шүтэлцэж хэрэгждэг зүй тогтолтой байдаг. Улс орны оршин тогтнох аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь батлан хамгаалах тогтолцоогоор дамжин шийдвэрлэгдэж байдаг.

Үндэсний язгуур эрх ашгийн үүднээс хэрэгжүүлэх аюулгүй байдлын өргөн хүрээтэй үйл ажиллагаа, төрөөс удирдамжилсан албан ёсны мэдэгдлүүд, Засгийн газраас батлан гаргаж, үндэсний хэмжээнд дэмжсэн зорилтууд зэргийг багтаан ойлгодог үндэсний бодлогын цөм нь улс орныг батлан хамгаалах асуудал байдаг. Тийм ч учраас төрийн зүгээс батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх үүрэгтэй байдаг боловч энэ нь тэр бүр бодитоор, нөхцөл байдлыг мэдэж, ойлгож, шуурхай арга хэмжээ авч, хэрэгжиж чадахгүй байдал байсаар байна.

Батлан хамгаалах нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үндэсний аюулгүй байдлын хүрээнд улс орноо гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах, түүний бэлтгэлийг хангах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх төрийн цэргийн аюулгүй байдлыг хангах асуудал гэж үзэж байна.

Батлан хамгаалах нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм эрх зүй, цэргийн нэгдмэл арга хэмжээ, харилцан уялдаатай цогц үйл ажиллагаа болж хэрэгждэг. Батлан хамгаалах үйл ажиллагаа нь улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэрэг-техник, иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, эрүүлжүүлэх агуулга бүхий өргөн хүрээтэй арга хэмжээнүүдийг хамардаг.

Энэхүү зорилтын эцсийн үр дүн нь улс орноо батлан хамгаалах олон талт боломж, чадавхаар илэрдэг. Батлан хамгаалах чадавх гэдэг нь аливаа болзошгүй хямралт байдлын үед урьдчилан сэргийлэх, хамгаалахад улс орны бэлтгэгдсэн байдлын түвшин гэж үздэг нийтлэг ойлголт байдаг ч энэ нь батлан хамгаалах үйл ажиллагааны тогтолцооны эцсийн үр дүнг харуулсан үзүүлэлт юм. Энэхүү чадавх нь улс орны материалын болон оюун санааны хөгжлийн хүрсэн түвшнээс ихээхэн хамаардаг бөгөөд засаглалын менежментийн чадамж, улс орны эдийн засаг, шинжлэх ухаан технологи, цэргийн зэрэг чадавх нь цогц байдгаараа онцлогтой байдаг.

Иймээс батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь эдгээр чадавхыг хэрхэн тооцож, уялдуулан зохион байгуулж, бэхжүүлж түүний эдийн засгийн үндэс, боломжийг хэрхэн бүрдүүлж, хэрэгжүүлснээс ихээхэн хамааралтай болж байгаа болно. Батлан хамгаалах үйл ажиллагаа өөрөө нийгмийн нэг бүтээгдэхүүн, эд, эс мөн бөгөөд бодлогын, нийгмийн хөгжлийн үйл явцад идэвхтэй оролцдог институт гэж үзэж байна. Нөгөө талаар батлан хамгаалах нь зөвхөн батлан хамгаалах бүтцийн хүрээнд төдийгүй, төр ба нийгмийн өөр бусад олон субъектын үйл ажиллагаанд хамтарч, харилцан хэрэгждэг.

Батлан хамгаалах нь улс орны цэргийн аюулгүй байдлыг хангаж, төр, улсын өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд цэргийн байгууллагуудыг байгуулах, бэлтгэх, зэвсэгт хүчирхийллийн хэрэгслийг хэрэглэхтэй холбоотойгоор баримтлах чиглэл, үйл ажиллагааг агуулж багтаадаг.

Манай улс 1990-ээд оноос эхлэн ардчилал, зах зээлийн шинэ тогтолцоонд шилжсэнээр улс орны батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, зэвсэгт хүчний байгуулалтад зарчмын шинэ өөрчлөлтүүд орж эхэлсэн билээ. Энэхүү өөрчлөлт, шинэ бодлого чиглэлүүдийг хангахаар өнгөрсөн хугацаанд нэлээд олон хөтөлбөр, төлөвлөлтүүд хийгдсэн ч батлан хамгаалах эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх тодорхой бодитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж чадаагүйгээс болж тэр бүр зорилтоо бүрэн дүүрэн хангаж, үр дүнд хүрч чадаагүй гэж үзэх үндэстэй байгаа болно.

Зураг 1. Батлан хамгаалах, зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөрүүд



Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, бодит ажил хэрэг болгоход батлан хамгаалах эдийн засгийн чадамжийг сайжруулж, бэхжүүлэх асуудал ихээхэн чухлаар тавигдах болоод байна. Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, онол, арга зүйн үндсийг боловсруулахаас эхлээд, түүнийг хэрэгжүүлэх үе шатууд болон улс оронд учирч болзошгүй бүх хувилбарын арга хэмжээ, төрөөс баталж албажуулсан хөтөлбөр, тэдгээрт төсөв, хөрөнгө шаардлагатай байдаг бөгөөд энэ хэрэгцээг хангах эдийн засгийн боломж өөрөө хязгаарлагдмал байсаар байна. Батлан хамгаалах эдийн засгийн чадавх сул, бууны сумаа ч үйлдвэрлэдэггүй манай мэтийн улсын батлан хамгаалах чадамж, гадаад улс оронтой байгуулсан цэрэг-техникийн хамтын ажиллагааны үр өгөөжөөс ихээхэн хамааралтай байгаа нь батлан хамгаалах эдийн засгийн менежмент тааруухан, зоримог шинэ бодлого, стратеги, арга замуудыг гаргах шаардлага байгааг харуулж байна.


Бид өнгөрсөн хугацаанд гадаадын улсаас зэвсэг, техникийн тусламжууд авсан ч хуучирсан, одоогийн тавигдаж буй шаардлагыг хангахгүй, түүн дээр ажиллах хүний нөөц дутагдалтай, сэлбэг хэрэгслийн хамааралт байдал, хуучирсан зэвсэглэл техникт сэргээн сайжруулалт хийх шаардлагатай гээд нэлээдгүй асуудал байгаа нь бидний ажлын арга, хандлага буруу, бүх талын тооцоо, судалгаа хийгдээгүй хэт ерөнхий байдлаар явж ирснийг харуулж байна. Харин 2020 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлд Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэг техникээр хангах, бодлогыг дэс дараатай хэрэгжүүлэх, цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх гэсэн зорилтууд туссан нь батлан хамгаалах эдийн засгийн

боломжуудыг нэмэгдүүлэх, шинэ эх үүсвэрүүдийг бий болгох хэрэгцээг бий болгож байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн ард түмэн олонхоороо дэмжсэн мөрийн хөтөлбөрийн 2.2.4-т Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэн, аливаа аюултай тэмцэх үндэсний чадамжийг нэмэгдүүлнэ... орон нутгийн хамгаалалтын цэгцтэй тогтолцоог бүрдүүлнэ гэж тусгасан нь эдийн засгийн чадамжийг бий болгох нэг нөхцөлийг бий болгож байна гэж үзэж байна.

Батлан хамгаалах эдийн засгийн боломж хязгаарлагдмал нөхцөлд батлан хамгаалахын эдийн засгийн менежментийн үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч батлан хамгаалах эдийн засгийн нөөцийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох; төсөв, хөрөнгийн боломжит эх үүсвэрийг зөв тодорхойлон олж бүрдүүлэх; зөв зохистой арвилан хэмнэлтийн бодлого гаргах; техник технологи, инновацийн хөрөнгө оруулалт хийх; манай улсын хөрөнгө оруулалтын хуулиар олгосон боломжуудыг ашиглах; боловсон хүчний оюуны нөөцийн чадамжуудыг бүрэн ашиглах нь зүйтэй. Мөн аюулгүй байдлын гадаад хүчин зүйлүүдийг өөрийн талд боломж болгож ашиглах; аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр хамтын ажиллагаатай улс орнууд болон цэрэг, техникийн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийг Засгийн газрын түвшинд байгуулсан улсуудтай хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах; Засгийн газрын зүгээс үзүүлэх батлан даалтын боломжийг олон улсын хууль эрх зүйн хүрээнд ашиглах зэрэг олон талт боломжийг нарийн тооцоо, судалгаанд тулгуурлан зөв ашиглах гэх мэт эдийн засгийн удирдлагын шинэ арга замыг бий болгох хэрэгцээ байсаар байна.

Цаашдаа бид төсөвтөө захирагдаж язгуур эрх ашиг, оршин тогтнохуйн аюулгүй байдлаа хангах уу, өөр боломжит арга замуудаар асуудлаа шийдэх үү гэдэг хүндхэн сорилтын өмнө тулж ирлээ. Манай улсын эдийн засгийн бүтэц ихээхэн эмзэг, зөвхөн түүхий эдийн экспорт дээр суурилсан байдалтай байна. Иймээс төсвийн зардал нь хэт ихсэх, гадаад өрийн хэмжээ нэмэгдэх, нэг орноос эдийн засгийн хараат болох зэрэг нь улс орны оршин тогтнохуйн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх эрсдэлийг улам ихээр бий болгож байгаа юм.

Зураг 2. Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын ба валютын нөөцийн хэмжээ (сая ам.доллараар)




Хөрөнгө оруулалтын өсөлт нь улс орны хөгжилтийн бодлогыг дэмжиж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах баталгаа болдог ч энэ нь үндэсний аюулгүй байдлыг хангах язгуур эрх ашгуудтай жигд уялдаж чадахгүй байна. Олон улсын жишгээр ДНБ-д хөрөнгө

оруулалтын эзлэх хувь 25 хувиас доош байвал эдийн засагт нөлөөлөх сөрөг хүчин зүйл их байдаг гэж үздэг. Монгол Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын дийлэнх уул уурхайн салбарт чиглэж байгаа нь учир дутагдалтай. Эдийн засгийг төрөлжүүлэх үүднээс хөрөнгө оруулалтыг өндөр технологид суурилсан боловсруулах үйлдвэрлэлд чиглүүлж, уул уурхайгаас орж буй орлогын тодорхой хувиар үндэсний аюулгүй байдлын язгуур эрх ашгийг хангах чиг үүрэгтэй байгууллагуудад хөрөнгө оруулалт хийж, дэмжих нь зүйтэй юм.


Хөрөнгө оруулалтын үр дүнд үндэсний хэмжээний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын эдийн засгийн чадамж нэмэгдэж, орчин үед тавигдаж байгаа мэргэжлийн шаардлагуудыг хангахаас гадна үндэсний аюулгүй байдлыг хангах олон талт ажиллагааны үр дүн сайжрах нөхцөл бүрдэх болно. Улс төр, нийгмийн амьдралын өнөөгийн бодит байдал, нийгмийн сүлжээгээр яваад байгаа мэдээллүүдээс дүгнэж үзэхэд л худалдаа хөгжлийн банкны 2.3 их наяд, гадаадын офшор дансанд хууль бусаар байршуулсан 15 гаруй их наяд төгрөгийн асуудал бол үндэсний хөгжил, эдийн засгийн нөөц боломжоо, дотооддоо тодорхой бодлого, зорилготой ашиглаагүйн тод илрэл юм.

Улс орны хөгжил, үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэхдээ улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашгийн хэрэгцээ шаардлагыг үндсэндээ харгалзаж, эрсдэлүүдийг тооцож үзэхгүй байна гэж дүгнэж болохоор дүр зураг өнгөрснөөс харагдаж байгаа билээ. Учир нь улс орны хөгжлийн стратегийн байгууламжуудын хүрээнд эдийн засагт өгөөжтэй бүтээн байгуулалтын асуудлууд тодорхой болж, төлөвшиж, түүнээс олох орлогын тодорхой хэсгийг дотоодын хөрөнгө оруулалтаар батлан хамгаалах үйл ажиллагаанд зориулдаг тогтолцоог бүрдүүлж чадаагүй өнөөг хүрлээ. Тухайлбал улс орны хэмжээний бүтээн байгуулалт болох уул уурхай, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл харилцаа, алт, уран болон түүхийн эдийн олборлолтын чиглэлээрх батлан хамгаалах бодлого, байр суурь, батлан хамгаалахад үзүүлэх эдийн засгийн тооцоо судалгаа, үр дүн тодорхойгүй байгаа бөгөөд цэргийн хүч хэрэгслийг зөвхөн стратегийн бүтээн байгуулалтад оролцох ажиллах хүч гэж харсан хандлага төр, нийгэмд байна гэж үзэж дүгнэж болохоор байна. Стратегийн бүтээн байгуулалтын ажлын улсын төсөвт оруулах ашгаас батлан хамгаалах, зэвсэгт хүчний эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой дотоодын хөрөнгө оруулалтын бодлого гаргах цаг үе, шаардлага нөхцөл бий болоод байгаа болно.

**Зураг 3. Монгол Улсын батлан хамгаалах төсөв
2020-2022 оны байдлаар (тэрбум төгрөг)**



Монгол Улсын төсөвт болон ДНБ-д эзлэх батлан хамгаалах төсөв 2020-2022 оны байдлаар (хувиар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам

Манай улсын батлан хамгаалах зардалд хуваарилж буй төсөв нь дэлхийн бусад оронтой харьцуулахад хамаагүй бага байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын зардал үндсэндээ тавигддаггүй, улс орон эдийн засгийн гүнзгий хямралд өртвөл манай батлан хамгаалахын төсөв багасах байдал үүсэж болох талтай бөгөөд үүнийг одоогоос тооцож,

нэг хэсэг хугацаанд бие дааж үүрэг гүйцэтгэх боломжийг бий болгох, бүр цаашдаа эдийн засгийн хямралт байдлаас хамааралгүй байх бодлого, арга замыг бий болгох боломжуудыг судалж, бүрдүүлэх ёстой гэж үзэж байна. Хэрэв ийм үед ямар нэг хямралт байдлыг далимдуулан аюул, занал гаднаас янз бүрийн хэлбэрээр үүсвэл бид төсөв зардал байхгүй, ард иргэд, газар нутгаа та бүхэнд өгье гэх үү, эсвэл гаднаас тусламж ирнэ гээд хүлээгээд цаг алдаад байхуу гээд олон асуудал үүсэж болзошгүй байгаа юм. Иймд дээрх нөхцөл байдлыг үнэлж, урьдчилсан арга хэмжээ авах, төсвийн боломжуудыг бий болгож, болзошгүй эрсдэлүүдийг олон хувилбараар тооцсон байх ёстой. Үүнд, одоогоос анхаарч батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, олонт талт арга хэмжээнүүдийг үе шаттай, дэс дараатай цаг алдалгүй авах хэрэгтэй гэж үзэж байна. Учир нь манай аюулгүй байдлын гадаад орчин эмзэг, цэргийн том бүлэглэлүүд, цөмийн зэвсгийн хүрээлэлд бид байгаагаас гадна дэлхийн шинэ



хүйтэн дайны анхны шинжүүд илэрсээр байгаа болон урд хөршийн орон зайгаа эдийн засгийн аргаар тэлэх, хүн амынхаа өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах далд бодлого, цэрэг, зэвсгийн их хүчирхэгжилтийг нь үл анхаарч ач холбогдол өгөхгүй орхиж болохгүй гэж үзэж байна.

Манай улс эдийн засгийн шинэ харилцаанд ороод 30 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа ч батлан хамгаалах эдийн засгийн оновчтой, үр дүнтэй тогтолцоо, удирдлагыг бий болгох асуудал одоо болтол төлөвшиж чадаагүй, бие даасан батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн эхний алхмууд ч хийгдээгүй байсаар байна. Дээрх нөхцөл байдлыг бүрдүүлэх эрх зүйн орчин харьцангуй бүрдсэн гэж үзэх үндэс байгаа ч түүнийг хэрэгжүүлэх, төрийн, төсвийн, эдийн засгийн бодлогын дэмжлэг цэргийн мэргэжлийн тодорхой чиглэлүүдээр бодитой биеллээ олж чадахгүй байгаа юм.

Батлан хамгаалах эдийн засгийн тогтолцоо, удирдлагыг Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн “Бүсчилсэн хөгжил-тогтвортой хөгжил” санаачилгын хүрээнд олон талт бодлогоор бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, орон нутгийн хамгаалалтын стратегийг бодит ажил болгох боломжийг судалж, хэрэгжүүлэх шаардлага байж болох юм гэж үзэж байна.

Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг бий болгоход орон нутаг, аймгийн цэрэг-стратегийн болон эдийн засгийн онцлогуудыг ихээхэн анхаарч ашиглах нь зүйтэй юм. Батлан хамгаалах эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэхийг бүх талаас нь анхаарч, сайтар бодож төлөвлөж, Израйл улсын туршлагаас санаа авч дотоод нөөц боломжоо ашиглан хэрэгжүүлэх хэрэгцээ байсаар байна. Бид улс орны эдийн засгийн хүнд үед батлан хамгаалах эдийн засгийг бэхжүүлэхдээ эдийн засгийн бус аргуудаар сайжруулах асуудлуудыг ч давхар судалж үзэх нь зүйтэй байж болох юм.

Төрийн “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт... батлан хамгаалах хэрэгцээг хангах эдийн засгийн чадавхыг бүрдүүлнэ ... цэргийн зэвсэг, техник худалдан авахад зориулан батлан хамгаалах зардлын тодорхой хэсгийг жил бүр улсын төсөвт тусгаж байна... гэсэн заалтууд, Батлан хамгаалах хуулийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх, зэвсэг техникийг шинэчлэх төсвийг шийдвэрлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх, мөн хуулийн 13 дугаар зүйлийн Засгийн газрын бүрэн эрхийн 13.1.10-т зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байх, 13.1.11-т цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэгслэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах хадгалах журмыг тогтоох, мөн хуулийн Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн 14.1.4-т батлан хамгаалах болон зэвсэгт хүчний хангалт үйлчилгээний зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах, 14.1.7-д батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, мөн хуулийн Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний чиг үүргийн 15.3.14-т цэргийн зориулалттай зэвсэг, сум, галт хэрэгсэл үйлдвэрлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах заалтууд тусгагдсан ч түүнийг хэрэгжүүлэх, батлан хамгаалах эдийн засгийн цэгцтэй менежментийн асуудал тулгамдсан хэвээр.

Өнөөгийн нөхцөлд батлан хамгаалах эдийн засгийн тулгамдсан нэн тэргүүн зэргийн асуудал бол зэвсэгт хүчний зэвсэглэл, байлдааны техникийг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах, цэргийн бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлуудыг сайжруулах явдал бөгөөд эхний элжинд удирдлага, мэдээлэл, холбоо, тагнуул, авиац, агаарын довтолгооноос хамгаалах цэргийн техникийг шинэчлэх томоохон цэрэг-техникийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай нь судалгаанаас харагдаж байгаа болно. Хүчирхэг зэвсэг, техниктэй улсуудын хүрээлэлд байдаг бид ямар цэрэг-техникийн бодлоготой байвал бидэнд ашигтай, ямар зэвсэглэлтэй байвал аюулгүй байдлын шаардлагыг хангах вэ гээд бодож тунгаан далайцтай бодлого, стратеги гаргах хэрэгцээ байсаар байна. Энэхүү зэвсэглэл техникийн шинэчлэлээс улбаалж, цэргийн сургалт бэлтгэл, цэргийн алба хаагчдын хөгжил, тэдэнд тавигдах мэргэжлийн шаардлага, цэргийн байгууллагуудын бүтэц, үүрэг, зориулалтууд хамаарч байдаг.

Батлан хамгаалах төсвийн 90 орчим хувь нь хэрэглээний төсөв байгаа бөгөөд үүнд цэргийн зэвсэглэл техникийн болон бэлэн байдал, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх гэх мэт үндсэн асуудлуудад хуваарилагдсан зардал байхгүй гэж үзэж болохоор тусгагдсан байдаг нь нууц биш юм. Эдүгээ батлан хамгаалах төсвийн төлөвлөлт, иргэний байгууллагуудын нийтлэг жишгээр хийгддэг байдал хэвээр. Төсвийн төлөвлөлтөд цэргийн мэргэжлийн онцлогийг тусгайлан тусгасан зүйл заалт оруулж, суулгаж чаддаггүй байдал байсаар байна. Иймд батлан хамгаалах төсвийн зардлын ангиллыг мэргэжлийн цэргийн жишигт нийцүүлж хийх шаардлага байгаа бөгөөд батлан хамгаалах төсвийн тухай хууль санаачилж, боловсруулах шаардлага, хэрэгцээ байна гэж үзэж байна.

Цаашдаа батлан хамгаалах зардлын урт хугацааны санхүүжилтийн төлөв байдлыг бодитой судалж, улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх батлан хамгаалах төсвийг хоёр хувьд хүргэж, мэргэжлийн армийн чиглэл рүү эргэлт буцалтгүй шилжих шаардлагатай байгаа бөгөөд энэ талаар батлан хамгаалах бодлогын үндэс төрийн бодлогын баримт бичигт тодорхой туссаныг бодит ажил болгох нь зүйтэй. Тухайлбал, гадаад улс орнуудын хамтын ажиллагааны хүрээнд техник, технологи, тоног төхөөрөмжийн зээл, тусламж, хандив, хамтарч цэрэг батлан хамгаалахын зориулалттай үйлдвэр байгуулах гэх мэт улс орны эдийн засгийн чадамж хязгаарлагдмал байгаа энэ нөхцөлд батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бүхий боломжийг цаг хугацаатай өрсөлдөн бий болгож, ашиглах хэрэгтэй ба үүнийг дотоодын хөрөнгө оруулалтаар шийдэх арга замыг судалж бий болгох ёстой гэж үзэж байна.

Дэлхийн болон хөрш орнуудын цэргийн төсвийн зарцуулалт нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд улс орны батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх зайлшгүй нөхцөл байдал үүсээд байгаад анхаарах цаг болжээ гэж дүгнэж байгаа юм.

Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологиудыг эзэмших, хөгжүүлэх, батлан хамгаалах болон цэргийн зориулалт бүхий жижиг, дунд үйлдвэрлэлийг бий болгож, бүх талаар дэмжин хөгжүүлэх, цэргийн зэвсэглэл, техникийн ажилтнуудын нөөцийг бүрэн дүүрэн ашиглаж, тэднийг цаашид хөгжүүлэх талаар одоогоос системтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх, цэргийн зэвсэглэл, техникийн чиглэлийн судалгааны ажлуудыг өргөн хүрээнд хийх шаардлага байсаар байна.

Дүгнэлт

Аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр төрийн бодлого, зорилт болгон дэвшүүлсэн арга хэмжээнүүдийг бодит ажил болгоход төрийн зүгээс үзүүлэх төсвийн болон эдийн засгийн дэмжлэг хэрэгтэй байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Манай улсын аюулгүй байдлыг бид өөрсдөө хангаж, бэхжүүлэхээс гадаадын хүмүүс үүнийг хийхгүй гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд үндсэндээ ардчилал, хөгжлийн тухай ярьсаар байгаад үндэсний язгуур эрх ашгийнхаа үндсэн асуудлуудад бага анхаарч явж иржээ. Энэ бүхэн нь эдийн засгийн үр дүнтэй, бүх зүйлийг бодолцсон төлөвлөлт байхгүй, хэт ерөнхий явж ирсэнтэй холбоотойгоос гадна аюулгүй байдлын гадаад орчны эрсдэл харьцангуй бага байсантай холбож үзэх үндэстэй байгаа юм. Төрийн бодлогын аюулгүй байдлын хөтөлбөрүүдийн хэрэгжилтүүдээс үзэхэд бодлогын зорилтуудаа хэрэгжүүлэх төсвийн төлөвлөлт, дэмжлэгүүдийг тухайн салбарын төсөвт тусгайлан суулгаж өгдөггүй байдал байсаар байна. Иймд аюулгүй байдал, батлан хамгаалах эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх дотоодын эдийн засаг, төсвийн бодлого гаргаж хэрэгжүүлэх шаардлага, цаг үе бий болсон байна. Бид эдийн засгийн хязгаарлагдмал байдалдаа захирагдаж үндэсний язгуур эрх ашиг, оршин тогтнохуйн аюулгүй байдлаа хангах уу, өөр боломжит арга замуудаар асуудлаа шийдэх үү гэдэг хүндхэн сорилтын өмнө бид тулж ирээд байна.



Д.ДАГИЙСҮРЭН (Ph.D)
 ҮАБЗ-ийн ССХ-ийн
 Ахлах шинжээч

БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ XIV ТАВАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БА МОНГОЛ УЛСЫН ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

Abstract: *The Inner Mongolia Autonomous Region of the People's Republic of China is an important subject for the economic and social development of our country as it has the longest border with Mongolia and is home to the largest number of Mongolians.*

Inner Mongolia covers an area of 1.18 million square kilometers and covers 12.3 percent of China's territory and one-fifth of China's mainland border (more than 4,200 km), making it a key base for China's openness policy. 17 percent or 4.58 million of Inner Mongolia's 25.396 million people are ethnic Mongolians who are similar in history, language, culture, customs, and economy to our country. The State Council of the People's Republic of China has included Inner Mongolia in its development program for the western and northern regions. Inner Mongolia has issued the "8337" development program since 2013. State Council's general policy and the five-year plan of the Autonomous Region are both the main development policy documents.

Therefore, this article summarizes the main content of Inner Mongolia's 14th Five-Year Plan, clarifies bilateral economic relations and future priorities, and addresses infrastructure development, including port infrastructure development

Keywords: *plan, investment, infrastructure, port*

БНХАУ-ЫН ӨМӨЗО¹-Ы XIII ТАВАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ОЛОЛТ, АМЖИЛТ

Өвөр Монголын эдийн засгийн үзүүлэлт сүүлийн жилүүдэд нэмэгдэж буй бөгөөд XIII таван жилийн хугацаанд ДНБ нь 1.736 тэрбум юань болж дунджаар 4.3 хувиар өсөж, нэг хүнд ногдох ДНБ 10 мянган юаниас давсан хэмээн Өвөр Монголын даргын ажлын тайланд дурджээ.²

¹ Цаашид БНХАУ-ын ӨМӨЗО-ыг Өвөр Монгол гэх болно.

² 2021年内蒙古自治区政府工作报告 http://www.nmg.xinhuanet.com/xwzx/ttxw/2021-02/01/c_1127049726.htm

Өвөр Монголын ард иргэдийн амьжиргаанд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж, ажил эрхлэлтийн түвшин дээшилж, нэг хүнд ногдох орлогын хэмжээ өссөнөөр амьжиргааны түвшин сайжирч байна. Энэ нь хот, хөдөөг хамарсан нийгмийн хамгааллын болон төрийн үйлчилгээний тогтолцоог тасралтгүй сайжруулж ирсний илрэл юм. Тухайлбал, XIII таван жилийн хугацаанд 3681 тосгон, 57 хошууны 802 мянган иргэдийг ядуурлаас ангижруулснаа зарласан бол 124 мянга гаруй иргэдийг нүүлгэн шилжүүлж 53 мянган байшин барилга барьж, хөдөлмөрийн чадвартай иргэдэд зориулж тусгай хөтөлбөрүүд хэрэгжүүлснээр 403 мянган иргэн амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр орлоготой болжээ. Ядуурлыг бууруулах салбарт 2020 онд нийт 11.2 тэрбум юанийн хөрөнгө оруулалтыг хийж, ядуурлыг бууруулах 6751 төслийг хэрэгжүүлсэн байна. Ядуу иргэдийн орлого 2015 онд 3019 юань байсан бол 2020 онд 13159 юань болж жилд дунджаар 34.2 хувиар өсжээ.³

Тус ӨЗО бизнесийн орчныг сайжруулах, төвлөрлийг сааруулж үйлчилгээг оновчтой болгох, нэг цонхны үйлчилгээ гэх мэт бодлого хэрэгжүүлснээр цахим цогц үйлчилгээний түвшин 91 хувьд хүрчээ.

Таван жилийн хугацаанд нийт 1 сая 248 мянган ажлын байр, 2020 онд 232 мянган ажлын байрыг шинээр бий болгосноор 105 мянган иргэн ажилтай болж хэрэглээний зардал нь өмнөх оныхоос 1.9 хувиар өссөн бөгөөд хотын иргэдийнх 1.6, хөдөө тосгодынх 2.7 хувиар тус тус өсжээ. Хүн амын хотжилтын түвшин 64.1 хувьд хүрсэн байна.⁴ Докторын зэрэг олгох эрхтэй сургуулийн тоо 32-42 болж нэмэгджээ. Хошуу, тосгоны нэгдсэн эмнэлгүүд хоёрдугаар түвшнээс дээш стандартад хүрч мянган хүн амд ногдох эмнэлгийн орны тоо болон эмч нарын тоо улсын дундаж түвшнээс давсан үзүүлэлттэй байна.

БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс Өвөр Монголын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд XIII таван жилийн хугацаанд төмөр замын бүтээн байгуулалтад нийт 54.2 тэрбум юанийн хөрөнгө оруулалтыг хийснээр 2020 оны эцэс гэхэд төмөр замын нийт урт 15 мянган км-т хүрсэн нь 2015 оныхоос 10.5 хувиар нэмэгдэж, нийт төмөр замын 10.6 хувийг эзэлж улсын хэмжээнд тэргүүлжээ. Тунляо-Шинь Ян хүрэх хурдны төмөр замыг 2018 оны сүүлээр ашиглалтад оруулж, Хөх хот - Бээжин хүрэх хурдны төмөр замыг 2019 онд ашиглалтад оруулжээ.

Зам тээвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтад 448 тэрбум 500 сая юанийн хөрөнгө оруулснаар Өвөр Монголын 12 аймаг хот 6985 км хурдны замаар холбогдож, 103 хошуу нэгдүгээр зэрэглэлээс дээших, тосгон бүр хатуу хучилттай авто замаар тус тус холбогдож, нийт зам тээврийн сүлжээний урт 225 мянган километр хүрч 2015 оныхоос 35 мянган км-ээр нэмэгдсэн байна.

Хөх хотын шинэ онгоцны буудлын барилгын ажил эхэлж, Хөлөнбуйр, Бугат, Тунляо хотын онгоцны буудлын сэргээн засварлах ажлыг дуусгаснаар ерөнхий зориулалтын 15, иргэний зориулалттай 40 нисэх онгоцны буудалтай болжээ. Тиан Зиао агаарын компанийг байгуулж Жалантун, Улаанхот, Ордос хотод нисэхийн сургалтын баазыг байгуулжээ.

³ 内蒙古自治区国民经济和社会发展 第十四个五年规划和2035年 http://www.nmg.gov.cn/zwggk/zfxgk/zfxgkml/202102/t20210210_887052.html

⁴ 内蒙古自治区国民经济和社会发展 第十四个五年规划和2035年 http://www.nmg.gov.cn/zwggk/zfxgk/zfxgkml/202102/t20210210_887052.html

Шар мөрний үерийн аюулаас урьдчилан сэргийлэх хамгаалалтын ажлын хоёр дахь үе шат, Инчуожилао, Дунтайзи зэрэг усан сангийн барилгын ажлыг эхлүүлсэн байна.

Бүс нутгийн 5G суурин станцын тоо 10 мянга давсан. Көшикөтэнгээс Бээжин хүртэлх нүүрснээс хий гарган дамжуулах хоолой ашиглалтад орсон. Хөх хотын метроны I, II шугамын эхний үе шатыг барьж ашиглалтад оруулсан.

Аялал жуулчлал, цахим худалдаа, үйлчилгээний салбарыг хөгжүүлж, хэрэглээний хүрээг өргөжүүлсэн байна. Тухайлбал, XIII таван жилийн хугацаанд 540 сая дотоод, гадаадын жуулчдыг хүлээн авч, жуулчлалын орлого нь 150 сая юаньд хүрч жуулчдын тоо 13.9, аялал жуулчлалын орлого 18.9 хувиар тус тус өсжээ.

Өвөр Монгол нь үндэсний хэмжээний экологийн нөхөн сэргээлтийн төслүүдийг тууштай хэрэгжүүлж, бэлчээр болон цөлжсөн талбайн нөхөн сэргээлтээр улсдаа тэргүүлж, ой мод болон бэлчээрийн эзлэх талбай 23, 45 хувьд тус тус хүрч, 372 цэцэрлэгт хүрээлэнг байгуулжээ.

Цөлжилт болон цөлжсөн газар нутгийн хэмжээ хоёр дахин багасжээ. Кубүчи цөлийн менежментийн үйл ажиллагаа НҮБ-ын Байгаль орчны шагнал хүртсэн бөгөөд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцид оролцогч талуудын XIII хурлыг ӨМӨЗО-нд зохион байгуулсан. Өвөр Монгол нь эко уул уурхай, эко үйлдвэрлэлийг хөгжүүлж эко ногоон бүс болохыг эрмэлзэж байна. Хотуудын агаарын чанар сайтай өдрийн тоо 90.8 хувьд хүрсэн гэсэн амжилт, ололттойгоор XIII таван жилээ үджээ.

Өвөр Монголын XIV таван жилийн төлөвлөгөө дэх зорилтууд

Өвөр Монгол XIV таван жилийн хугацаанд хүн төвтэй бодлогоо улам эрчимжүүлж, экологи байгаль орчинд ээлтэй бодлогыг дэмжиж, аж үйлдвэрийн салбарт судалгаа шинжилгээ хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, технологийн шинэчлэлийг хийж мэдээлэлжсэн, хиймэл оюун ухааныг нэвтрүүлсэн ухаалаг үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр тусгажээ. Үүний хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- Бугатын ховор метал, Хөх хотын Жиншан, Ордос гэсэн үндэсний дэвшилтэт технологийн аж үйлдвэрийг хөгжүүлж улсын хэмжээнд дээгүүрт оруулахыг эрмэлзэнэ.
- Дэвшилтэт шинэ технологийн үйлдвэр болон шинжлэх ухаанч жижиг дунд үйлдвэрүүдийг хоёр дахин нэмэгдүүлж 2025 он гэхэд 2000 болон 4000 тус тус болгож нэмэгдүүлнэ.
- Чадварлаг боловсон хүчнийг 3.5 саяд хүргэнэ.
- 2025 он гэхэд суурь тэтгэврийн даатгалд хамрагдагсдын тоог 16.3 сая, ажилгүйдлийн даатгалд хамрагдагсдын тоог 2.9 сая, хөдөлмөрийн хохирлын даатгалд хамрагдагсдын тоог 3.4 саяд хүргэнэ.
- Байгаль орчныг хамгаалах талаар ой модны экологийн бүтээн байгуулалтыг 50 сая м² (нэг га = 15 м²), тал нутгийн экологийн бүтээн байгуулалтыг 75 сая м² болгож, ойн хамрах хүрээг 23.5 хувь болгож Хятадын хойд хэсэгт экологийн тэнцвэртэй бүсийг бий болгоно.⁵
- Үйлдвэрлэлийн хог хаягдлыг дахин боловсруулах ажлыг эрчимжүүлж, дахин ашиглаж болох нөөцийг бүрдүүлнэ. 2025 он гэхэд үйлдвэрлэлийн хатуу хог

⁵ 内蒙古规划今后5年内森林覆盖率达23.5%
http://www.gov.cn/xinwen/2021-01/05/content_5577262.htm

хаягдлыг ашиглалтын хэмжээг 50-аас дээш хувьд хүргэнэ.

- Манжуур, Эрээн боомт хотыг түшиглэн бага хэрэглээтэй, бохирдол бага ялгаруулдаг, өндөр үр ашиг бүхий ногоон аж үйлдвэрийг хөгжүүлэх.
- Бугат, Ордосыг түшиглэн эрчим хүч, стратегийн нөөцийн бааз байгуулж, Хөх хот, Улаан цавыг түшиглэн ложистик, боомт, үндэсний бие даасан инновацын үлгэр жишээ бүс байгуулна.
- Дэд бүтцийн бүтээн байгуулалтын хувьд ухаалаг тээврийн дэд бүтэц, ухаалаг эрчим хүчний дэд бүтцийг дижитал технологитой хослуулж, дижитал уурхай, дижитал эрчим хүчийг эрчимтэй хөгжүүлж дижитал сүлжээ, дижитал газрын тосны хоолойн сүлжээг байгуулна.
- 2025 он гэхэд шинэ эрчим хүчийг суурилагдсан эрчим хүчний 50-аас дээш хувьд хүргэнэ.
- Эрчим хүчний дэд бүтцийн шинэчлэлийг дэмжиж баруун Өвөр Монголын “хэвтээ ба таван босоо”, зүүн Өвөр Монголын “найман хэвтээ, хоёр босоо” үндсэн сүлжээний бүтцийг байгуулж, Гандиэраас Чуанчан хүртэлх, Нингөрээс Жубаожуан хүртэлх, Балингээс Жинша хүртэлх 500 кв цахилгаан дамжуулах төслүүдийг ахиулж, баруун Өвөр Монголын цахилгаан сүлжээ ба Хойд Хятадын үндсэн сүлжээтэй холбох асуудлыг үндсэнд нь шийдвэрлэх.
- Баруун Өвөр Монголоос Хөбэй, Тианжин, Анхуй, Хөнан, Хөбэй хүртэл цахилгаан дамжуулалт хийх.
- Өвөр Монголд хийжүүлэх төслийг хэрэгжүүлж, байгалийн хийн үйлдвэрлэх чадавхыг дээшлүүлж, Сулигө, Даниуди, Дуншөнгийн хийн ордуудад байгалийн хийн хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх.
- Сунюан -Байчөн-Улаан хот хүртэлх байгалийн хийн хоолойг барих, Хятад-Оросын зүүн чиглэлийн байгалийн хий дамжуулах хоолойн Хөлөнбуйрын хэсгийг барих.
- Баян овоо болон Бугатын газрын ховор элементийг үр ашигтай, ногоон аргаар олборлох ажлыг дэмжиж хайгуул боловсруулалтын ажлыг эрчимжүүлж 2025 он гэхэд ховор элементийн үйлдвэрлэлийг 100 мянган тоннд хүргэж улсын газрын ховор элементийн үйлдвэрлэлийн бааз болгох.
- Синь Ань ууланд том туннел барихаар төлөвлөж буй бөгөөд цаашдаа тус ӨЗО гурван хэмжээст, харилцан уялдаатай, чанар, үр ашигтай, тав тухтай, ухаалаг, аюулгүй, эко зам тээврийн сүлжээтэй болох.
- Өндөр чанартай, үр ашигтай газар тариалан мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хангамжийн бүтцийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, байгальд ээлтэй хөдөө аж ахуйг хөгжүүлж аюулгүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх.
- 2025 он гэхэд стандартын тариалангийн талбайн хэмжээг 55 сая гаруй мү-д хүргэнэ. Үхэр, хонины мах сүүний үйлдвэрлэлийн томоохон тойргуудыг байгуулж, сүүний гарцыг 10 сая тоннд хүргэхийг зорьж, улсын түвшний орчин үеийн хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн найман парк бий болгоно. Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын хувь хэмжээг 70 хувьд хүргэнэ.
- Аж үйлдвэрүүдийг техник технологийн ухаалаг системээр тоноглож үйл ажиллагааны мэдээлэл цуглуулах, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахад онлайн хяналт тавих, аваар ослын үед хариу арга хэмжээ авах, тээвэр ложистикийн

зохицуулалт, диспетчерийн үйлчилгээ гэх мэтэд хиймэл оюун ухаан, 5G системийн хэрэглээг 2025 он гэхэд 100 хувь хамруулна.

- Хурдны төмөр замын уртыг 2000 гаруй км-т хүргэхээр төлөвлөсөн. Одоогоор Өвөрмонголд баригдаж буй хурдны галт тэрэгний нэгэн том төсөл болох «Бугат-Инъчаний хурдны галт тэрэг»-ний 54 тэрбум гаруй юанийн 513 км төслийг 2018 оны найм дугаар сард эхлүүлсэн бөгөөд 2023 онд ашиглалтад оруулах юм. XIV таван жилийн хугацаанд соёл болон аялал жуулчлалыг уялдуулан хөгжүүлж, Өвөр Монголыг соёл ба жуулчлалын гол бүс нутаг болгоно гэжээ.

Монгол Улс болон Өвөр Монголын эдийн засгийн харилцаа

Өвөр Монгол нь одоогоор дэлхийн 160 гаруй улс орон бүс нутагтай худалдааны харилцаатай байгаа бөгөөд 2013-2020 оны хооронд “Бүс ба зам” дагуух орнуудтай хийсэн худалдааны дүн нь 250.144 тэрбум юаньд хүрсэн нь нийт гадаад худалдааны 29.51 хувийг эзэлсэн байна.⁶

Өвөр Монголын гадаад худалдаа 2021 онд 123 тэрбум 560 сая юаньд хүрч, 2020 оны мөн үеийнхээс 17.2 хувиар өсжээ.⁷ Тус ӨЗО-ны зэсийн хүдэр, төмрийн хүдрийн импорт ихээхэн өссөн бол нүүрсний импорт бага зэрэг буурчээ. Тухайлбал,

- Зэсийн хүдэр 19.61 тэрбум юань болж 50.3 хувиар;
- Төмрийн хүдэр 13.42 тэрбум юань болж 38.2 хувиар өссөн бол;
- Нүүрс 10.45 тэрбум юань болж 21 хувиар буурчээ.

Харин Монгол Улс, Өвөр Монгол хоорондын худалдаа 2021 онд 31.270 тэрбум юаньд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар нэмэгдэж, Өвөр Монголын нийт гадаад худалдааны 25.3 хувийг эзэлсэн байна. Үүнд: Экспорт 3 тэрбум 830 сая юань болж, 27.63 хувиар өссөн бол импорт 27.44 тэрбум юань болж, 10.7 хувиар өссөн байна.

Өвөр Монголын Монгол Улстай хийх гадаад худалдаанд түүхий эдийн импорт зонхилдог бөгөөд зэс, төмрийн хүдэр, нүүрс гэсэн гурван түүхий эд нийт импортын 91.9 хувийг бүрдүүлжээ. Тухайлбал,

- Зэсийн хүдэр 12.24 тэрбум юань болж 64.7;
- Төмрийн хүдэр 3.19 тэрбум юань болж 21.6 хувиар өссөн бол;
- Нүүрсний импорт 9.81 тэрбум юань болж 20.1 хувиар буурчээ.

Харин экспортын голлох бүтээгдэхүүнүүд нь механик, цахилгаан бүтээгдэхүүн, ган, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн байдаг ба нийт экспортын дүнгийн 59.3 хувийг эзэлж байна.

- Механик болон цахилгаан бүтээгдэхүүний экспорт 1.590 сая юань болж 52.6;
- Гангийн бүтээгдэхүүний экспорт 450 сая юань болж 58.3;
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт 230 сая юань болж 2.8 хувиар тус тус өссөн байна.

Манай улсын ӨМӨЗО-той худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд түлхэц өгч буй нэгэн арга хэмжээ бол “Монгол-Хятадын Экспо” юм. Тус арга хэмжээг Өвөр Монголын томоохон хотуудад 2015 оноос хойш хоёр жил тутамд зохион байгуулж байна.

⁶ “一带一路”建设引领 内蒙古构建对外开放新格局

<http://huhehaote.pbc.gov.cn/huhehaote/129784/4196518/index.html>

⁷ 自治区政府新闻办召开2021年自治区外贸情况新闻发布会

https://www.nmg.gov.cn/zwgk/xwfb/fbh/bmxwfbh/202201/t20220120_1997839.html

2015 оны экспод Монгол Улсаас 250 аж ахуй нэгж оролцож, 1.2 сая юанийн борлуулалт хийсэн бол 2017 оныход нийт 400 аж ахуйн нэгж оролцож 6.2 сая юанийн бүтээгдэхүүн борлуулжээ.

Монгол-Хятадын 2019 онд болсон гурав дахь удаагийн Экспогийн “Хөрөнгө оруулалтын төсөл танилцуулах” хэсгийн үндсэн томоохон арга хэмжээ болох “Бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-д 600 гаруй төлөөлөгч оролцож Монгол Улсын Засгийн газраас 15 томоохон төсөл хөтөлбөрийг хөрөнгө оруулагчдад танилцуулж, Монгол Улсын 43 гаруй байгууллагын төлөөлөл 56 гаруй төслийг танилцуулж 50 гаруй хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт гарын үсэг зурсан байна.⁸ Харамсалтай нь сүүлийн жилүүдэд цар тахлын улмаас зохион байгуулаагүй. Цаашид тус арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, хоёр талын төдийгүй бүс нутгийн орнуудын эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны үр ашигтай талбар болгоход Монгол Улсын зүгээс анхаарч оролцоогоо улам нэмэгдүүлэх нь зүйтэй.

Өвөр Монголын мах, сүү сүүн, ноолуур зэрэг хүнс барааны бүтээгдэхүүн нь Монгол Улсын экспортын бүтээгдэхүүнтэй ижил төстэй болж буйг харгалзан Монгол Улс хүнсний экспортын бүтээгдэхүүн болох мах, сүү, цагаан идээнийхээ чанар стандартыг сайжруулж нутаг ус, гарал үүслээр нь ангилан Монгол Улсын “Брэнд” бүтээгдэхүүн болгон Өвөр Монголын бүтээгдэхүүнүүдийн ижилслээс ялгарлыг бий болгож, түүнээс хүртэх өгөөж, боломжийг дээшлүүлэх нь чухал байна.

Тухайлбал, Өвөр Монгол бараа бүтээгдэхүүнийхээ ялгарлыг бий болгож тусгай брэнд бүтээгдэхүүнтэй болж түүнийгээ гадаад зах зээлд таниулахад ихээхэн анхаарч байгааг XIV таван жилийн төлөвлөгөөндөө Шилийн голын хонь, Хөлөнбуйрын бэлчээрийн хонь, Жавуда хонь, Хоркин үхэр, Улаанцавын төмс, Синь Аний будаа гэх мэт үндэсний брэндийг сурталчлан таниулж, Или, Мөнньоу зэрэг үйлдвэрийг илүү чадавхжуулж, олон улсад нэртэй сүүн бүтээгдэхүүний брэндийг бий болгоно гэж зааснаас харж болохоор байна.

Өвөр Монголын гадаад руу чиглэсэн хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж буй бөгөөд Европ, Африк, Азийн “Бүс ба зам” дагуух 25 улсад 330 компани байгуулсан нь нийт хилийн чанадад хөрөнгө оруулсан компаниудын 69.77 хувийг эзэлж байна. Үүнээс ОХУ Монгол Улсад 272 компани байгуулсан нь нийт байгуулсан компанийн 82.42 хувийг эзэлж байна. Өвөр Монгол “Бүс ба зам” дагуух улсад 43 салбарт хөрөнгө оруулснаас 53.33 хувийг хайгуул, уул уурхай, хөдөө аж ахуй, ой, мал аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт эзэлж байна. Тухайлбал, Или групп 2014 оноос Шинэ Зеландад гурван тэрбум юанийн хөрөнгө оруулалт хийсэн бол 2018 онд Тайландын Индонезид байдаг хамгийн том зайрмагийн үйлдвэрийг худалдаж авахаа зарласан. Өвөр Монголын “Хойд нутгийн боомт олон улсын ложистик” ХХК нь Орос, Монгол Улсад ложистикийн парк барихад 31.5 сая юанийн хөрөнгө оруулахаар төлөвлөж байна. Энэхүү ложистикийн парк баригдсанаар Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын үйл явцыг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулах юм.⁹

⁸ 41 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай 53 хамтын ажиллагааны гэрээ байгуулах төслийг эхлүүлнэ. <https://nda.gov.mn/1567.html>

⁹ “一带一路”建设引领 内蒙古构建对外开放新格局 <http://huhehaote.pbc.gov.cn/huhehaote/129784/4196518/index.html>

“Өвөр Монгол нь 2019 оны зургаадугаар сарын байдлаар Монгол Улсын ашигт малтмалын нөөцийг ашиглах, анагаах ухааны технологийн судалгаа, боловсруулалт, цөлжилтийг бууруулах судалгаа, үйлдвэрлэлийн инкубатор, хамтарсан лаборатори, технологи гэх мэт 226 төсөлд хөрөнгө оруулжээ. Мөн 41 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай 53 хамтын ажиллагааны гэрээ байгуулах төслийг эхлүүлж, нийт 59.9 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай 63 хэлэлцээрийн төслийг эхлүүлнэ” хэмээн Өвөр Монголын хөгжил шинэтгэлийн хорооны дарга Гүн Мин Жүн мэдээлжээ.¹⁰

Өвөр Монголын хөрөнгө оруулалтын ихэнх хувийг эзэлж буй салбарууд нь манай улсын гол аж үйлдвэрүүдэд хамаарах салбарууд байгааг харгалзан эдгээр салбарт хөрөнгө оруулалт татах, тэдний туршлагаас судлах, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх талаар хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлэх нь зүйтэй. Хэдийгээр Өвөр Монгол нүүрсний цэвэр, үр ашигтай хэрэглээг дэмжин, ган, барилгын материал, химийн үйлдвэрүүдэд нүүрсний хэрэглээг бууруулах, хязгаарлах, хуучирсан болон илүүдэл үйлдвэрлэлийн хүчин чадлыг арилгах ажлыг эрчимжүүлэх бодлого баримталж байгаа ч ойрын жилүүдэд нүүрсний хэрэглээ нь тийм ихээр хумигдахгүй болов уу.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-д экспортлох нүүрсний зах зээлийн өрсөлдөөн улам ширүүсэж буй тул Монгол Улс нүүрсний экспортоо баталгаажуулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх явдал чухал байна. Энэхүү өрсөлдөөнд манай улс амжилттай оролцох гол нөхцөл нь улс төрийн ойлголцол, төмөр зам, тээвэр ложистик, боомтын хүчин чадлаа нэмэгдүүлэх явдал юм.

Тиймээс хил орчмын дэд бүтэц, түүн дотроо боомтын шинэчлэлийн талаар хоёр талын бодлогын баримт бичгүүдэд хэрхэн төлөвлөгдсөнийг тодруулъя.

Хоёр талын бодлогын баримт бичигт тусгагдсан боомт, эрчим хүчний дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагаануудын харьцуулалт

Монгол Улс болон БНХАУ нь НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос санаачлан гаргасан “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-г нэгдсэн. Энэхүү хэлэлцээрт Азийн 27 орны хуурай боомтыг тусгасан байдаг бөгөөд Монгол Улсын Алтанбулаг, Сайншанд, Улаанбаатар, Замын-Үүд, Чойбалсан зэрэг байршилд хуурай боомт байгуулах боломжтой гэж үзжээ.

Монгол Улсын Засгийн газраас цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилго бүхий “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг батлан гаргасан. Шинэ сэргэлтийн бодлого нь боомтын, эрчим хүчний, аж үйлдвэржилт, хот, хөдөөгийн, ногоон хөгжлийн, төрийн бүтээмжийн сэргэлт гэсэн үндсэн зургаан багц асуудлаас бүрдэж буй юм. Манай улсын шинэ сэргэлтийн бодлого дахь боомт болон эрчим хүчний сэргэлтийн бодлогын төлөвлөгөөг урд хөршийн Өвөр Монголын XIV таван жилийн төлөвлөгөөтэй харьцуулан үзье.

¹⁰ 41 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай 53 хамтын ажиллагааны гэрээ байгуулах төслийг эхлүүлнэ <https://nda.gov.mn/1567.html>

Хүснэгт 1

Монгол Улсын шинэ сэргэлтийн бодлого	Өвөр Монголын XIV таван жилийн төлөвлөгөө
Ханги, Цагаандэл, Бургастай, Цагааннуур, Тэс, Арцсуурь, Ханх, Бага Илэнхи, Зэлтэр, Хавирга, Сүмбэр, Баянхошуу, Бичигт зэрэг боомтыг авто замаар холбож, бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг үе шаттайгаар сайжруулах	Ганц мод-Гашуун сухайт, Сэхээ-Шивээ хүрэн, Зүүн хатавч-Бичигтийн төмөр замын боомт барих ажлыг урагшлуулна.
Алтанбулаг- Замын-Үүд боомтуудыг холбосон 987 километр хурдны зам барих	Ганц мод- Гашуун сухайт - Таван толгой хүртэл хил дамнасан зам барих ажлыг урагшлуулна.
Шинэ онгоцны буудлыг Ази, Европыг холбосон агаарын тээврийн дамжин өнгөрүүлэх төв болгон өргөжүүлнэ.	Хөх хот болон бусад олон улсын нисэх онгоцны буудлын ложистик паркуудыг барих ажлыг хурдасгаж, Орос, Монголын томоохон хотууд руу нисэх маршрутыг олон болгож байнгын үйл ажиллагаанд оруулна. Улаан цав, Тунляод агаарын боомт нээх ажлыг урагшлуулж, Хөх хот гэх мэт олон улсын агаарын экспресс ачааны төвүүдийн барилгын ажлыг түргэтгэж ачааг түгээх чадварыг сайжруулах.
Зүүн Хойд Азийн супер сүлжээнд холбогдож, хоёр хөршийг холбосон өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулах	Хил дамнасан цахилгаан дамжуулах байгууламжийг бий болгож Хятад Монголын цахилгааны сүлжээг олшруулах талаар судална. Монгол, Орос, Европ руу чиглэсэн шилэн кабелийн байгууламжийг урагшлуулах.

Хоёр талын баримт бичгийг харьцуулан боловсруулав.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зүйлсийг ажихад хоёр талын боомт болон эрчим хүчний салбарын хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүд ерөнхийдөө дүйж байна. Өнөөгийн байдлаар Өвөр Монгол 19 боомттой бөгөөд төмөр зам, хурдны зам, агаарын тээвэр зэрэг чиглэлд гурван хэмжээст боомтын хэв маягийг бүрдүүлжээ.

“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т улс орнууд хуурай боомтуудаа харилцан уялдаатай хөгжүүлж, үйл ажиллагааны ижил стандартыг бий болгож ажиллахын чухлыг онцолсон байдаг.

Тэгвэл БНХАУ боомтын дэд бүтцээ сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн ажлуудыг тодруулж үзье.

Боомтын бүтээн байгуулалтад БНХАУ-ын хэрэгжүүлсэн бодлого

БНХАУ XIII таван жилийн төлөвлөгөөний хугацаанд улсын хэмжээнд нийт 28

боомтыг шинээр нээж, 38 боомтын үйл ажиллагааг өргөжүүлж нээлттэй болгосон байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд Төрийн зөвшөөрөл бүхий гадаадад нээлттэй 313 боомт байна. XIII таван жилийн хугацаанд хөгжил шинэчлэлийн хорооноос баталсан 950 сая юанийн төсвөөр 55 улсын боомтын хянан шалгах дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дэмжиж, 2020 онд Төв хорооны яаралтай шийдвэрээр таван сая юанийн тусгайлсан төсөв баталж 49 боомтын шинэ КОВИД-19 халдвараас сэргийлэх ажлыг дэмжихээр болжээ.

БНХАУ-ын боомтын шинэчлэлийн хүрээнд хийсэн ажлуудаас тоймловол:

1. Хилийн шалган нэвтрүүлэлт, хорио цээрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудыг Гаалийн ерөнхий газрын харьяанд нэгтгэж гаалийн үүрэг болон хилийн шалган нэвтрүүлэлт, хорио цээрийн нэгдмэл цогц байдлыг хангасан байна.
2. Улсын боомтын дэд бүтцийг бүтээн байгуулах хянан шалгах стандарт болон боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын хянан шалгах тусгай удирдлагын түр журмыг батлан хэрэгжүүлж, боомтын хянан шалгах тоног төхөөрөмжийг сайжруулж хэрэглээг нэмэгдүүлсэн. Ачаа барааны гүйлгээний баазуудад тусгай төмөр замыг нэмэлтээр барьсан.
3. Олон улсын худалдааны “Нэг цонх”-ны бодлогыг цогцоор нь хэрэгжүүлж, үе шаттайгаар ахиулж дижитал боомтын системийг бүрэн цахимжуулжээ.
4. Боомтын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх дүрмийг баталж, боомтын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх тусгайлсан сургалт болон онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний сургуулилт зэргийг зохион байгуулсан.
5. Шаардлагатай баримт бичгийн тоог багасгаж, явцыг оновчтой болгож, өртгийг багасгах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж, 2020 оны эцэс гэхэд импорттой холбоотой хяналтын гэрчилгээ 86 төрлөөс 41 болж, бараа бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх хугацаа 2017 онтой харьцуулахад нэг дахин багассан байна.
6. Иргэдийн хилээр нэвтрэхэд хүлээх хугацаа 30 минутаас хэтрэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
7. Боомтын чадавхыг сайжруулахын тулд XIII таван жилийн хугацаанд нийт долоон боомтыг хааж, дөрвөн боомтыг нэгтгэж, анх удаа боомтын үйл ажиллагааг оролт, гаралт бүхий хэлбэрээр зохицуулав.
8. Боомтын олон улсын хамтын ажиллагаанд шинэ ахиц гаргаж Орос, Казахстан, Монгол, Вьетнам зэрэг улсын боомтын асуудал эрхэлсэн газар нэгжүүдтэй боомтын хамтын ажиллагааны урт хугацааны механизмыг байгуулж, Хятад-Орос, Хятад-Казахстан, Хятад-Монголын хоёр талын Засгийн газар хоорондын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

БНХАУ-ын дээрх хэрэгжүүлсэн арга хэмжээнээс үзэхэд тус улс боомтын “хатуу” ба “зөөлөн” дэд бүтэцтэй холбоотой асуудлуудаа үндсэндээ шийдэж олон улсын хэлэлцээр дэх үүргээ биелүүлж байна гэж үзэж байна.

Монгол Улсын хил гааль, боомтын дэд бүтцийг сайжруулах тал дээр хийж буй ажлууд

Манай Улс гадаад худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг

нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилттой уялдуулан хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын стандартын дагуу хөгжүүлэх асуудлыг нэгдсэн бодлоготойгоор зохион байгуулах шаардлага тулгарч буй юм.

Монгол Улсын “Хилийн боомтын тухай” хуулийг 2013 онд баталснаар Засгийн газраас 26 боомтын захиргааг харьяалуулан Боомтын нэгдсэн захиргааг байгуулсан боловч төсвийн хүрэлцээгүй байдлаас болж татан буулгаж¹¹ хилийн боомтын үндэсний зөвлөлтэй болсон.

Монгол Улсын Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнийн 2022 оны хоёрдугаар сарын 03-08-ны өдрүүдэд БНХАУ-д ажлын айлчлал хийх үедээ “БНХАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын хамтарсан мэдэгдэл”-д тохиролцсон төмөр замын боомтуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, олон талт тээврийн сувгийг бий болгож, хоёр орны эдийн засаг, худалдааны бодит хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлнэ¹² гэж заажээ. Сэхээ-Шивээ хүрэн, Зүүн хатавч-Бичигт боомтын төмөр замын боомтыг баталгаажуулах зорилгоор нот бичиг солилцож, Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох зэс, коксжсон нүүрсний экспортын 50 гаруй хувийг дангаараа эзэлдэг Гашуун сухайт-Ганц мод болон Шивээ хүрэн-Сэхээ, Бичигт-Зүүн хатавч боомтын төмөр замын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг эцэслэн тохиролцов.

2019 онд гаалийн шинэчлэлд улсын төсвөөс 65.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 22.1 тэрбум төгрөгийг барилга байгууламжийг шинээр барих, 14.3 тэрбум төгрөгийг лабораторийн тоног төхөөрөмжид, 26.9 тэрбум төгрөгийг гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжид зарцуулжээ.¹³

БНХАУ-ын Засгийн газрын 201 сая юанийн буцалтгүй тусламжаар Замын-Үүд боомтод шинээр зорчигч тээврийн 30, ачаа тээврийн 28 барилга, дэд бүтэц ногоон байгууламж барих юм. БНХАУ-ын Засгийн газрын 148 сая юань буюу 55.3 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Гашуун сухайт боомтын өргөтгөлийн ажлыг хийж байгаа. Энэ оны нэг дүгээр сард болсон Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо, Хөшигийн хөндий зэрэг боомтын бүтээн байгуулалт, шинэчлэлийн ажлыг энэ онд бүрэн дуусгахаар төлөвлөж буй талаар мэдэгджээ.¹⁴

Урд хөрш рүү гаргах нүүрсний тээврийн төмөр зам тавьж байгаа бөгөөд Гашуун сухайт боомтод анхны чингэлэг терминалын бүтээн байгуулалтыг 2021 оны долоодугаар сард эхлүүлж, 10 дугаар сард туршсан.¹⁵

Боомтуудад цахим системийг нэвтрүүлснээр ААН-үүдэд үзүүлдэг 33, иргэдэд үзүүлдэг 14 үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж, есөн зөвшөөрлийг мөн цахимжуулжээ. Мөн энэ жилийг “Мэдээллийн соёлыг нэвтрүүлж, мэдээллийн экосистемийг бүрдүүлэх замаар гаалийн байгууллагын үйл ажиллагааг дижитал болгон хувиргах” ажлын жил болгон зарласан байна.

¹¹ Боомтууд эзэнгүйдэж байна. <https://ikon.mn/n/ekg>

¹² Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан мэдэгдэл <https://www.montsame.mn/mn/read/288828>

¹³ Гашуунсухайт боомтын шинэчлэлийн бүтээн байгуулалт гуравдугаар сард эхэлнэ. <http://bloombergtv.mn/gashuunsukhait-boomтын-шинэчлэлийн-бүтээн-байгуулалт-гуравдугаар-сард-эхэлнэ/?cid=187>

¹⁴ Хил боомтуудын шинэчлэлийг энэ онд бүрэн дуусгана <https://www.montsame.mn/mn/read/286363>

¹⁵ Хил боомтуудын шинэчлэлийг энэ онд бүрэн дуусгана <https://www.montsame.mn/mn/read/28411C6363>

Манай улсын хувьд боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд тодорхой ажлуудыг хийсээр байгаа нь сайшаалтай боловч хуурай боомт нь чингэлэг болон бусад төрлийн ачаатай харьцах, нэгтгэх, хадгалах, шилжүүлэх дэд бүтэц, тоног төхөөрөмжтэй байх ёстой, ачаа тээврийг хилээр нэвтрүүлэх эрх мэдэл, чадавх, байгууламжтай байх ёстой гэх мэт маш олон шаардлага байдаг бөгөөд тэдгээр олон улсын шаардлагад нийцэх хэмжээнд хүрээгүй байна.

Дүгнэлт

Өвөр Монгол ирэх таван жилд хүн төвтэй хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгаж, дундаж орлоготой иргэдийн хүрээг нэмэгдүүлж, эдийн засгийн ерөнхий чадамжаа дээшлүүлэхийн тулд үр ашигтай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэглээг тасралтгүй өсгөх, инноваци хөгжлийг чухалчилж, шинжлэх ухаан, технологид суурилсан орчин үеийн аж үйлдвэр, дэд бүтцийн системийг улам боловсронгуй болгох зорилт дэвшүүлж салбар бүрийн зорилтоо илүү нарийн төлөвлөжээ.

Боомтын үйл ажиллагаа бол хоёр талын оролцоотой, жигд, тэнцвэртэй үйл ажиллагаа хангагдсан байхыг шаарддаг цогц үйл ажиллагаа юм. БНХАУ-ын боомтын дэд бүтцийн хөгжил харьцангуй сайн байна.

Харин манай улсын боомтуудын үйл ажиллагаа тогтворжоогүй, дэд бүтэц сул байгаа нь манай улсад тулгарч буй томоохон сорилт болж байна. Тиймээс бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх санхүүгийн нөхцөл боломжийг эрэлхийлж, хянан чиглүүлэх удирдлагын цогц системийг бүрдүүлж, нарийн төлөвлөгөө боловсруулан ажилласнаар боомтын сэргэлтийн бодлого амжилттай хэрэгжих юм.

-
1. 2021年内蒙古自治区政府工作报告
 2. 内蒙古自治区国民经济和社会发展 第十四个五年规划和2035年
 3. 内蒙古规划今后5年内森林覆盖率达23.5%
 4. “一带一路”建设引领 内蒙古构建对外开放新格局
 5. <http://huhehaote.pbc.gov.cn/huhehaote/129784/4196518/index.html>
 6. 自治区政府新闻办召开2021年自治区外贸情况新闻发布会
 7. https://www.nmg.gov.cn/zwgk/xwfb/fbh/bmxwfbh/202201/t20220120_1997839.html
 8. “一带一路”建设引领 内蒙古构建对外开放新格局
 9. <http://huhehaote.pbc.gov.cn/huhehaote/129784/4196518/index.html>
 10. 41 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай 53 хамтын ажиллагааны гэрээ байгуулах төслийг эхлүүлнэ <https://nda.gov.mn/1567.html>
 11. 41 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай 53 хамтын ажиллагааны гэрээ байгуулах төслийг эхлүүлнэ <https://nda.gov.mn/1567.html>
 12. Төсвийн тогтвортой байлын зөвлөлөөс Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлт өгсөн дүгнэлт, санал 5 дугаар нүүр
 13. Боомтууд эзэнгүйдэж байна. <https://ikon.mn/n/ekg>
 14. Иж бүрэн стратегийн түншлэлийн хамтарсан тунхаглал /бүрэн эхээрээ/ <https://news.mn/t/671953/>
 15. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан мэдэгдэл <https://www.montsame.mn/mn/read/288828>



Д.ЭРДЭНЭЦОГТ (Ph.D)

ҮАБЗ-ийн ССХ-ийн

Ахлах шинжээч, Хими биологийн
хаягдлын бүсийн шинжээч

МЭДЭЭЛЛИЙН ДАЙНЫ АСУУДАЛ

Abstract: The current submission of countries to the information war is due to the outdated provisions of international human rights law, space, communication, and humanitarian laws, which seem to have almost confirmed the information war. However, in the national interest, the issues of disseminating false information and influencing social and political life in Mongolia should be clearly reflected in the National Security Concept. The main technology of information warfare is to create confusion, doubt, surprise, and resentment among the people by spreading false informations of opposing parties.

Therefore, it is necessary to develop and create a legal environment and system against information warfare, strengthen trust between governments and citizens, expand the goals of existing organizations in the security sector, create new positions if necessary, and rely on foreign experience, cooperation, projects and financial support.

Keywords: Information war, warfare, international law, false information, media, internet

Мэдээллийн дайны олон улсын эрх зүйн асуудал

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2001 оны илтгэлд мэдээллийн дайныг мэдээллийн орон зай дахь хувь хүн, нийгэм, төрд учирч буй гол аюул заналхийлэл гэж тодорхойлсон нь цаашид мэдээллийн дайны эсрэг олон улсын конвенцийг бий болгох, ялангуяа кибер орон зайн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг зүй ёсоор шаардаж байна.

Кибер гэмт хэргийн Будапештийн конвенц нь интернэт болон бусад компьютерын сүлжээгээр үйлдэгдсэн гэмт хэргийн тухай анхны олон улсын гэрээ юм. Тус конвенц нь зохиогчийн эрхийн зөрчил, компьютерын луйвар, хүүхдийн садар самуун, сүлжээний

аюулгүй байдлын зөрчлийг авч үздэг ч мэдээллийн дайны эсрэг олон улсын эрх зүйд хамаарахгүй байна.

НАТО-гийн орнуудын мэдээллийн ажиллагааны Таллинны гарын авлага нь кибер үйл ажиллагааны олон улсын эрх зүй, бодлого, хуулийн удирдамж заавар болж ирсэн ч нөгөө талаасаа дайсагнагч улсын аливаа технологийн дамжуулалтыг хакердах, тасалдуулах үйл ажиллагаанд энэ дүрмийг хэрэглэж болно хэмээн мэдээллийн дайныг зөвтгөсөн заалт нь өөрөө асуудал дагуулж байна. Мөн Таллинн-2 гарын авлагын 93.5 дугаар хэсэгт зааснаар энгийн иргэд, зорилтот хүмүүст хэвлэх хуудас тараах, суртал ухуулгын нэвтрүүлэг хийх зэрэг сэтгэл зүйн ажиллагаа явуулахыг хориглохгүй байх заалтыг худал үнэн янз бүрийн мэдээлэл авах олон улсын хүний эрхтэй холбон тайлбарлаж байна.

НАТО-гийн гишүүн улсуудын шинжээчдийн бүлэг олон улсын эрх зүй, кибер ажиллагаа, цахим орон зай дахь төрийн хариуцлага, НҮБ-ын түвшний хэлэлцүүлэг, мэдэгдэл, Засгийн газар, аж үйлдвэр, иргэний нийгмийн оролцогчдын эрдэм шинжилгээний нийтлэл, олон талт санаачилгад тулгуурлан Таллинн-3 гарын авлагыг шинээр боловсруулахаар төлөвлөж байна. Шинээр гарах Таллинн-3 дүрмээр бол дайсагнагч улсын аливаа технологийн дамжуулалтыг хакердах, тасалдуулж болох мэдээллийн дайны тус ажиллагаа нь энгийн иргэдэд биет хохирол учруулсан бол олон улсын хүмүүнлэгийн хууль эсвэл дайны тухай хуулийн дагуу уг ажиллагааг хууль бус гэж үзэх төлөвтэй байна. Биет бус хохирол хэмээх нэр томъёонд дайсны эсрэг явуулсан суртал ухуулга нь гүтгэн доромжилсон, нэр хүндэд сэв суулгасан, олон нийтийг үнэн бодит мэдээлэл, баримтаас салгах үүднээс явуулсан биет бус хохирлыг хэлэх юм.

Харин дайсны стратегийн чухал программ хангамжийн системд хортой, вирус нэвтрүүлэх замаар дайсны кибер орон зайд халдсан тохиолдолд тус биет бус хохирол нь дэд бүтцэд гэмтэл учруулах, хүний амь нас хохирох зэргээр тодорхой хэмжээний биет хохирол болон хувирах магадлалтай гэж үзэж байна. Тухайлбал, дайсны тийрэлтэт сөнөөгч онгоцны сүлжээг хакердаж, хортой программаар довтлох нь онгоцыг сүйрүүлж, хүний амь насыг хохироох аюултай жишээг дурдаж болно.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үед ч ташаа мэдээлэл цацагдаж, олон тооны сөрөг үр дагаврыг дагуулж байгаа нь олон улсын хууль эрх зүйн зохицуулалтыг шаардаж байна. Тухайлбал, цэвэр метанол спиртээр хоолойгоо зайлах нь Ковид-19-ийн эсрэг тустай гэх ташаа мэдээлэлд өртөж, үүний улмаас амь нас эрүүл мэндээр хохирсон бол тэрхүү мэдээллийг тараасан хүнд арга хэмжээг авах ёстой болж байна.

Иймэрхүү жишээгээр бодит байдал дээр мэдээллийн дайны үйл ажиллагааг зохицуулах олон улсын эрх зүйд ихээхэн цоорхой байсаар байна. Үүнээс гадна НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд, “Хүн бүрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь аливаа хөндлөнгийн оролцоогүйгээр, аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр, хил хязгаар харгалзахгүйгээр мэдээллийг хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг агуулдаг хэмээн заасан нь хувь хүний үнэн худал мэдээлэл хүртэх эрх чөлөөнд хэн ч хөндлөнгөөс оролцох ёсгүй байх зарчмыг харуулж байна. Энэхүү эрх чөлөөг мэдээллийн дайнд ашиглахаас сэргийлж чадах цорын ганц арга бол олон улсын эрх зүйн протоколын дагуу уг мэдээлэл нь худал, гүтгэлэг хэмээн үзэж шүүхэд нэхэмжлэл гаргах явдал гэж үзэж байна.

Иймээс мэдээллийн дайны худал гүтгэлэг мэдээллийг ч сонсох хүний эрх, эрх чөлөөний НҮБ-ын Хүний эрхийн тухай хуулийн 19 дүгээр зүйл нь мэдээллийн дайныг зохицуулах, хянахад саад болж, олон улсын эрх зүйд тодорхой хүндрэл учруулж байна. Тиймээс ялангуяа их гүрнүүд жижиг улсын эсрэг мэдээллийн ажиллагаа явуулахдаа уг олон улсын хууль эрх зүйн зүйл заалтыг хүний эрхийн талбар, хүний эрхийн бас нэг хамгаалалт болов. Үүнээс гадна мэдээллийн дайн нь сансар огторгуйд дамжих радио долгион дамжуулах замаар сансар огторгуйн олон улсын гэрээний зарчмын дагуу явагдаж байна. Уг олон улсын гэрээгээр сансар бол хүн төрөлхтний нийтлэг өмч, хүн төрөлхтөн чөлөөтэй, үнэ төлбөргүй сансар огторгуйг ашиглах боломжтой гээд заачихсан нь улс гүрнүүд сансрын орон зай, хиймэл дагуулыг мэдээллийн дайн явуулах бас нэг талбар болгон ашиглаж байна.

Өөрөөр хэлбэл, олон улсын сансрын эрх зүй нь шууд бус утгаараа мэдээллийн дайныг явуулах бас нэг эрх зүйн хамгаалалт болж байна. Дээрх учир шалтгааны улмаас олон улсын эрх зүйд мэдээллийн дайны ажиллагаанд хяналт тавих явдал нэлээд асуудалтай ч, жижиг буурай орнуудын эсрэг мэдээллийн эсвэл эрлийз дайны ажиллагааг хянах зорилгоор шинэ хууль тогтоомж, дүрэм, зарчмуудыг батлах, мөн шинэ конвенцийн төслийг боловсруулах шаардлагатай.

Мэдээллийн дайныг зохицуулах олон улсын эрх зүйн орчин бүрдээгүй ихэнх улс орнууд уг асуудлыг мэдээлэл кибер аюулгүй байдлынхаа хүрээнд хамруулж байгаа бол зарим улс орон мэдээллийн дайны эсрэг тусгайлан хариуцсан агентлаг байгуулж, хууль санаачилж гарган хэрэгжүүлж байна. Тухайлбал, хуурамч ташаа төөрөгдүүлсэн мэдээлэл санаатайгаар цацаж, улмаар улс орны аюулгүй байдал, нийгэм улс төр, сонгуулийн үр дүнд нөлөөлөх, гадаадын сөргөлдөгч хүчний улс төрийн оролцоог бууруулах зорилгоор Тайвань улс мэдээллийн дайны Нэвчилтийн эсрэг хуулийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн бол Швед улс 2022 оны нэгдүгээр сарын 1-нээс ташаа мэдээлэлтэй тэмцэх зорилготой Сэтгэл зүйн хамгаалалтын агентлагийг шинээр байгууллаа.

Тайванийн мэдээллийн дайны Нэвчилтийн эсрэг хууль

Хүмүүсийг улс төрийн санаачлагаар лоббидох, улс төрийн хандив өгөх, цуглаан, нийгмийн хэв журам, сонгууль, бүх нийтийн санал асуулгад саад учруулах зорилгоор мөнгө өгч, авах зэрэг гадаадын дайсагнагч хүчний хөндлөнгийн оролцоог хориглосон нийт 12 зүйлтэй Тайванийн мэдээллийн дайны нэвчилтийн эсрэг хуулийг (цаашид Нэвчилтийн эсрэг хууль гэх) нь 2019 оны 12 дугаар сарын 31-нд баталж, 2020 оны нэгдүгээр сарын 15-наас хүчин төгөлдөр үйлчилж байна.

Нэвчилтийн эсрэг хуулийг гадаадын дайсагнагч хүчин тус улсын нийгэм улс төрийн амьдралд нэвчин орж, хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг хангах, бүрэн эрхт байдал, либерал ардчилсан үндсэн хуулийн дэг журмыг хамгаалах зорилгоор батлан гаргажээ.

Дайсагнагч хүчин гэдэг ойлголтод тус улстай дайтаж, сөргөлдөөнтэй байгаа улс орон, улс төрийн байгууллага, бүлэглэл төдийгүй Тайванийн тусгаар тогтнолд аюул учруулахын тулд энх тайвны бус арга хэрэгслийг ашиглахыг дэмжиж буй улс орон, улс төрийн байгууллага, бүлэглэлийг мөн адил хамааруулжээ.

Нэвчилтийн эх сурвалж гэдэгт гадаадын дайсагнагч хүчний Засгийн газар, түүний харьяа байгууллага, институци, улс төрийн намууд, улс төрийн зорилготой байгууллага, бүлэглэлүүд болон тэдгээрийг дэмжиж буй этгээдийн гар хөл болон илгээгдсэн хүмүүсийг хэлж байна.

Хуулийн гол санаа нь гаднын дайсагнагч хүчний зүгээс Тайванийн дотоод улс төрийн амьдралд нэвчин орж ирэхийг таслан зогсоох, улс төр, сонгууль, санал асуулгатай холбоотой үйл ажиллагаанд хандивлах, итгэмжлэх, санхүүжүүлэхийг хатуу хориглох, энэхүү хуулийн заалтыг зөрчсөн хүмүүст таван жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оноох, мөн 10 сая тайвань доллараас илүүгүй торгууль ногдуулахыг хуульчилжээ. Тухайлбал, Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Төрийн өндөр албан тушаалтныг сонгох, эгүүлэн татах хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг хэн нэгэнд даатгах, даалгах, санхүүжүүлэхийг хатуу хоригложээ. Мөн гаднын дайсагнагч хүчний зүгээс тус улсын нийгэм улс төрд нэвчиж лобби үйлдэх, зааварчлах, итгэмжлэх, санхүүжүүлэх зэрэг хориглосон заалтыг зөрчсөн бол 500 мянган тайвань доллараас багагүй, харин таван сая тайвань доллараас ихгүй торгууль ногдуулахаар заажээ. Улмаар Үндэсний аюулгүй байдал, төрийн нууцтай холбоотой үндэсний батлан хамгаалах, гадаад харилцаа, эх газрын асуудлаар лобби хийсэн этгээдийг гурван жилээс дээшгүй хугацаагаар хорих ялаар шийтгэх, мөн таван саяас дээшгүй тайвань доллараар торгох шийтгэл ногдуулахаар тусгажээ.

Тайванийн эрх баригчид Нэвчилтийн эсрэг хуулийг баталснаар сөрөг хүчин болон эх газрын хятадыг дэмжигчдийн зүгээс багагүй эсэргүүцэлтэй тулгараад байна. Тухайлбал, тус хууль батлагдан гарсны дараа эх газрын хятадыг дэмжигч мэдээллийн хэрэгсэл болох Мастер Чэйн компани Тайванийн зах зээлээс гарсан бол БНХАУ-д байрладаг Тайванийн зарим аж ахуйн нэгж, аж үйлдвэрийн байгууллагууд, Жижиг, дунд үйлдвэрүүдийн үндэсний холбоо, Эх газар дахь Тайванийн хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжүүдийн холбоо зэрэг нь энэхүү хуулийг эсэргүүцсэн байна.

Уг хуулийг 2020 оны нэгдүгээр сарын 11-нд Тайваньд болсон Ерөнхийлөгчийн болон хууль тогтоох байгууллагын сонгуулийн санал хураалтын өмнөхөн хэрэгжүүлж байгаа нь тус хуулийг улс төрийн хэрэгсэл болгон ашиглаж байна хэмээн сөрөг хүчний зүгээс шүүмжилж байна.

Мөн тэдний зүгээс тус хуулийг Төрийн байгууллагуудын уялдаа холбоогүй, хэрэгжүүлэх арга хэрэгслэлийг тогтоогоогүй, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих захиргааны агентлагийг томилоогүй, мэдээлэлд хүртээмжтэй байх хүний эрхийг зөрчсөн гэх зэрэг шүүмжлэлийг дагуулж байна.

Европын Холбооны хуурамч мэдээллийн эсрэг санаачлага нь хуурамч мэдээ, онлайн худал мэдээлэлд тавих хяналт, үнэлэлт, дүгнэлтийн хэвлэлийн тойм юм. Гэвч европын олон нийтийн зүгээс энэхүү хуурамч мэдээллийн хяналтын үйл явц нь Европын Холбооны үндсэн эрхийн дүрмийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газраас иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, иргэдийн сонсох эрх, иргэдийн бодит шударга шийдвэр гаргах сэдлийг нь хангаж чадахгүй байна гэсэн олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч байна.

Энэхүү тойм нь нийтлэлчдэд “худал мэдээлэл тараадаг” гэх нэр хоч өгч, агуулгыг

нь “худал мэдээлэл” хэмээн зарлах нь ардчиллын гол цөм болсон сэтгүүлчдийн эрхэнд халдаж, нийтлэлийн агуулгыг хянахыг зорьж байна хэмээн буруушааж байна.

Либерал ардчилал нь чөлөөт хэвлэл, үзэл бодлоо чөлөөтэй солилцох, тэр дундаа үнэн худал нь мэдэгдэхгүй таагүй, гутамшигтай, эсвэл шууд худал гэж үзсэн мэдээг хүртэх эрхтэй ч Европын Холбооны хуурамч мэдээллийн тойм нь сэтгүүлчид болон иргэдийн үг хэлэх эрх чөлөө, сайн засаглалтай байх эрхэнд заналхийлж байна гэж олон нийт дургүйцэж байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол Европын ардчиллын үндэс суурь учраас Оросын хуурамч мэдээ төдийгүй цахим ертөнцөөр худал ташаа мэдээлэл тараах бүх хэлбэрийг эсэргүүцэх аливаа арга хэмжээ нь Европын иргэдийн үндсэн эрхэнд нийцэж байгаа эсэхийг батлах ёстой, олон нийтээс аль ч мэдээллийг нуун дарагдуулсны төлөө Европын Комисс хариуцлага хүлээлгэх ёстой гэж мөн европын олон нийт үзэж байна.

Хуурамч мэдээллийн эсрэг Финландын санаачлага нь Финландын засгийн газраас 2014 онд эхлүүлсэн Оросын хуурамч мэдээллийн эсрэг санаачилга бөгөөд иргэд, оршин суугчид, оюутнууд, сэтгүүлчид, улс төрчдөд үндэстнийг хагалан бутаргах зорилготой худал хуурамч мэдээлэлтэй хэрхэн тэмцэхийг зааж сургадаг сургалтын хөтөлбөр юм.

Насанд хүрэгчдийн боловсролын төвд тэдэнд өнөөдрийн болон маргаашийн нарийн төвөгтэй цахим орчинд хуурамч мэдээг хэрхэн илрүүлэхийг зааж, Финландын бүх насны иргэдийн хэвлэл мэдээллийн боловсрол, мэдээллийн дайны даван туулах чадварыг бэхжүүлж байна. Үндэстний мэдээллийн дайныг даван туулах нэг гол үзүүлэлт нь хэвлэл мэдээллийн боловсрол бөгөөд Финланд уг үзүүлэлтээр Европт нэгдүгээр байранд орж байна.

Шведийн Сэтгэл зүйн хамгаалалтын агентлаг

Сэтгэл зүйн хамгаалалтын агентлагийн үндсэн зорилго нь Шведийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх ташаа мэдээллийг олж илрүүлэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах замаар нээлттэй, ардчилсан нийгэм, чөлөөт үзэл бодлыг хамгаалах явдал юм. Мөн Шведийн сэтгэл зүйн хамгаалалтын үйл ажиллагааг бусад оролцогчид, агентлаг, хотын захиргаа, бүс нутаг, компани, байгууллагууд хооронд зохицуулах, дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх замаар хүн амынхаа худал хуурмаг мэдээллийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд оршиж байна. Шведийн Сэтгэл зүйн хамгаалалтын агентлаг нь Солна хотын Карлстад дүүрэгт байрладаг. Ерөнхий захирал Хенрик Ландерхолм нь армийн бэлтгэл офицер, Ойрх Дорнодод элчин сайдаар ажиллаж байсан туршлагатай. Тус агентлаг нь 45 албан хаагчтай, захиргаа, үйл ажиллагаа, чадавхыг бэхжүүлэх гэсэн гурван хэлтэстэй.

Захиргааны хэлтэс нь агентлагийн захиргааны үйл явцыг үр ашигтай, хууль ёсны дагуу найдвартай удирдах, төлөвлөлт, хяналт, санхүүгийн удирдлага, хүний нөөц, хууль эрх зүй, харилцаа холбоо зэрэг чиглэлээр агентлагийг бүхэлд нь дэмжиж ажиллах үүрэгтэй.

Үйл ажиллагааны хэлтэс нь Шведийн үндэсний ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх ташаа мэдээлэл болон бусад төөрөгдүүлсэн мэдээллийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах чиглэлээр ажилладаг. Мөн нийгэм дэх эмзэг байдалд

заналхийлж болзошгүй оролцогчид, үйл ажиллагааны талаар нөхцөл байдлын дүн шинжилгээ, тайлан гаргах, холбогдох эсрэг арга хэмжээг санал болгох үүрэгтэй. Тус хэлтэс нь бусад холбогдох байгууллагуудтай хамтран мэдээллийн зүй бус нөлөөллийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах арга, технологийг бас боловсруулдаг.

Чадавхыг бэхжүүлэх хэлтэс нь нийгмийн сэтгэл зүйн хамгаалалтын ерөнхий чадавхыг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр ажилладаг. Үүнд хүн ам, агентлаг, хотын захиргаа, хэвлэл мэдээлэл, сайн дурын батлан хамгаалах байгууллага, иргэний нийгэмд дэмжлэг үзүүлэх, мөн эдгээр талуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг.

Шведийн Сэтгэл зүйн хамгаалалтын агентлаг нь хүчирхэг, орчин үеийн нийтийн хамгаалалтын чухал хэсэг болох Шведийн сэтгэлзүйн хамгаалалтыг зохицуулах, хөгжүүлэх ажлыг удирдан чиглүүлж, урьдчилан сэргийлэх болон үйл ажиллагааны аль алиныг нь хослуулдаг. Шведийн сэтгэл зүйн хамгаалалтын зорилго нь иргэд худал хуурмагт авталгүй нээлттэй, чөлөөтэй ардчилсан үзэл бодолтой байж Шведийн эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалах явдал гэж үзэж байна.

Худал ташаа мэдээлэл нь улс орны сэтгэл зүйн даван туулах чадвар, хүн амын өөрийгөө хамгаалах хүсэл зоригийг сулруулах, хүмүүсийн үзэл бодол, зан үйл, шийдвэр гаргахад зүй бусаар нөлөөлж иргэдийн түгшүүрт байдал, үзэн ядалт, эргэлзээг нэмэгдүүлж, нийгмийг илүү эмзэг болгодог байна. Үүнийг нийгэм, улс төрийн бие даасан шийдвэр гаргахад заналхийлэх, саад учруулахыг хүссэн гадна дотны ашиг хонжоо сонирхогчид овжин ашигласнаар иргэдийн амь нас, эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа, ардчилал, хууль дээдлэх ёс, хүний эрх, эрх чөлөө зэрэг үнэт зүйлсэд сөргөөр нөлөөлдөг байна. Тиймээс сэтгэл зүйн хамгаалалтаар хүн амын нөлөөллийн кампанит ажил явуулах, худал мэдээллийг илрүүлэх, эсэргүүцэх чадварыг бэхжүүлэх замаар нийгэмд худал мэдээллийг эсэргүүцэх, түүнээс хамгаалах хүсэл эрмэлзлийг бий болгох шаардлага тулгардаг байна.

Сэтгэл зүйн шинэ агентлаг байгуулсан Шведийн туршлагаас харахад иргэдийн сэтгэл зүйн хамгаалалтыг үндэсний батлан хамгаалалт, аюулгүй байдлын нэг үндсэн хэсэг болгон төрийн бодлого, үйл ажиллагаа болгон хэрэгжүүлж байна. Тус агентлагийн үйл ажиллагаа нь Швед улс дахь Гитлерийн сэтгэл зүйн дайны эсрэг, хүйтэн дайны коммунизмын үзэл суртлын эсрэг авч хэрэгжүүлж байсан сэтгэлзүйн хамгаалалтын туршлага, сургамж болон өнөөгийн мэдээллийн дайны эсрэг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагад тулгуурлаж байна.

Шведийн Сэтгэл зүйн хамгаалалтын агентлаг нь сургалт, дадлага, судалгаа хийх, олон улсын хамтын ажиллагаа явуулах замаар урт хугацааны болон урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллахын зэрэгцээ арга зүйг судалж, хөгжүүлж, нийт хүн ам, холбогдох оролцогчдод үнэн зөв мэдлэгийг түгээдэг онцлогтой. Шведийн хүчирхэг сэтгэл зүйн хамгаалалт нь зөвхөн тус агентлагийн асуудал биш, нийт Засгийн газар, агентлаг, хотын захиргаа, байгууллага, хувь хүн бүрийн хамтын чармайлтаар бий болдог зүйл юм.

Шведийн сэтгэл зүйн хамгаалалт нь тус улсад чиглэсэн төөрөгдүүлсэн мэдээллээр зүй бус нөлөө үзүүлэхийг эсэргүүцэх нийгмийн чадварыг бий болгож, хуурамч мэдээлэл, суртал ухуулга, сэтгэл зүйн дайнд хамтын эсэргүүцлээр халдагч этгээдээс төр иргэний шийдвэр, үзэл бодолд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх явдал гэж үзэж байна.

Хуурамч мэдээллийг санаатайгаар тараагчид Шведийн нээлттэй ардчилсан нийгэмд итгэх итгэлийг алдагдуулах, сэтгэлийн түгшүүр төрүүлэх, нийгмийн асуудлыг туйлшруулах зэрэг аргыг чөлөөт индэр болгон ашигладаг тул үндэсний хэмжээнд стресс, хямралд хүргэж болзошгүй ноцтой үйл явдлуудад нэрвэгдэх үед иргэд холбогдох агентлаг болон бусад хариуцлагатай албан тушаалтны баталгаажуулсан мэдээллийг бүх төрлийн сувгаар авах боломжтой юм.

Австралийн Мэдээллийн дайны газар нь 2017 онд Батлан хамгаалах яамны харьяанд үндэсний ашиг сонирхолд халдсан заналхийлэлтэй тэмцэх зорилгоор байгуулагдсан. Мэдээллийн дайны газар нь мэдээллийн дайны хамтарсан салбар, сансар харилцаа холбооны салбар, хамтарсан команд удирдлага харилцаа холбоо компьютерын салбар, хамтарсан чадавхын салбараас бүрддэг.

Тус газар байлдааны чадвар болон Австралийн үндэсний ашиг сонирхолд өсөн нэмэгдэж буй мэдээллийн дайны аюулын эсрэг тэмцэх байлдааны чадварыг дээшлүүлэх, хүч хэрэгслэл нөөцөөр хангах, сүлжээний системийг хамгаалах, сургалтын арга хэмжээ зохион байгуулах, мэдээллийн дайны чадавхыг бэхжүүлэх үндсэн үүрэгтэй. Үндсэн үүргээ биелүүлэхийн тулд салбар шинжлэх ухаан, бизнес, корпорацууд болон бусад төрийн байгууллагатай нягт хамтран ажилладаг. 2024 он хүртэл ирэх гурван жилийн хугацаанд дээд түвшний кибер мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад чиглэсэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж амжилттай нэр дэвшигч оюутнуудын сургалтын төлбөрийг 12 сарын турш төлж, кибер ажлын туршлага, кибер зааварчилгаа, сургалтад хамруулж ажилд ороход нь дэмжлэг үзүүлж байна.

Европын Холбооны Гибрид аюул заналхийлэлтэй тэмцэх төв нь Финландын нийслэл Хельсинки хотод байгуулагдсан, Оросын эсрэг мэдээллийн болон сэтгэл зүйн дайнд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой. Одоогийн байдлаар тус төвийн үйл ажиллагаанд Европын Холбоо, НАТО-гийн 29 улс оролцдог. Тус төвийн үндсэн үүрэг бол оролцогч орнуудыг мэдээллийн дайны эрлийз аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхыг бэхжүүлэх, шилдэг туршлага сургамжийг хуваалцах, шинэ санаа, арга барилыг нэвтрүүлэх, турших, сургалт, дадлага зохион байгуулах явдал юм.

Мэдээллийн дайны аюул эрсдэл сорилтууд

Мэдээллийн дайны судалгаа шинжилгээ туршлага сургамжаас дүгнэхэд, их гүрнүүдийн зүгээс жижиг буурай хөгжиж буй орнуудад хийх мэдээллийн дайнаар дараах аюул эрсдэл сорилтыг учруулж болзошгүй юм. Үүнд:

- Гадаад улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зайд түгээж буй тэдний үнэт зүйлс, үзэл суртлын ухуулга сурталчилгаа нь нийгмийн ухамсарт хэвийн үзэгдэл, хууль ёсны болж суурьших;
- Мэдээллийн дайнаар иргэний ардчилсан нийгмийн нэр хүндийг гутаах замаар иргэдийн ардчилал эрх чөлөөнд итгэх итгэлийг алдагдуулах;
- Үндэсний ардчилсан уламжлалт шинжийг агуулсан төрийн тогтолцоо нь захиргаадлын дарангуйлалын тогтолцоо болж хувирах;
- Цахим орон зайд эсэргүүцлийн сүлжээний бүлгүүд, улс төрийн цахим орон зайн лидерүүд бий болж, тэдний зүгээс төрийн удирдлагын байгууллагуудад дарамт


шахалт үзүүлж хүн амыг хувьсгалд уриалан дуудах;

- Хүн амын дунд гутрангүй үзэл, эсэргүүцэл, бухимдлын уур амьсгалыг бий болгож, нийгмийн идэвхийг ардын ардчилсан үндэсний хувьсгал нэрээр ухуулан сурталчлах;
- Олон нийтийг цахим орон зайд гарын үсэг цуглуулах, санал авах зэргээр дайчлаж, олон нийтийн эсэргүүцлийн жагсаал цуглааныг цахим орчин болон гудамж талбайд нэгэн зэрэг өрнүүлэх;
- Тайван замаар засгийн эрхийг булаан авах, ард түмний зөвшилцлийн Засгийн газар байгуулах, ерөнхийлөгчийн болон парламентын ээлжит бус сонгууль явуулах зэрэг байж болно.

Мэдээллийн дайныг даван туулах чадвар гэж түүний аюул заналхийллийг иргэдийн оюун ухаан, сэтгэл санаа, мэдлэг боловсрол, танин мэдэхүй, нийгмийн тогтолцооны хүчээр даван туулах, мэдээллийн нөлөөлөлд өртөхөөс өмнөх нөхцөл байдалдаа хурдан түргэн эргэн орох, мэдээллийн дайралтад тогтвортой байх үндэсний чадавхыг хэлнэ.

Австралийн Лоуи Институтийн Азийн улс орнуудын цэрэг эдийн засаг улс төр дипломат соёлын нөлөөнөөс үүдэлтэй учирч болзошгүй аливаа эрсдэл сорилтыг даван туулах чадварыг найман сэдэвчилсэн нийт 131 үзүүлэлтээр үнэлж гаргасан судалгаагаар Монгол Улс бүс нутагтаа хамгийн сүүлийн байр эзэлж байгаа нь мэдээллийн дайнд өртөх эмзэг байдлыг харуулж байна (зураг дээр).

Зураг. ЗХА-ийн орнуудын эрсдэл сорилтыг даван туулах чадварын эрэмбэ



Монгол Улс дахь авлига ядуурал нийгмийн шударга бус байдлын өндөр түвшин, улс төр, бизнэсийн бүлэглэл хоорондын зөрчилдөөн, иргэдийн төрийн байгууллага, нам улс төрд итгэх итгэлгүй байдал, байгалийн баялгаас хараат байдал зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл нь мэдээллийн дайнд өртөх эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна.

Дүгнэлт

Улс орнуудын мэдээллийн дайны эсрэг өнөөгийн хүлцэнгүй байдал нь олон улсын хүний эрх, сансар, мэдээлэл харилцаа холбооны эрх зүй, хүмүүнлэгийн эрх зүйн мэдээллийн дайныг бараг баталгаажуулсан гэмээр хоцрогдсон зүйл заалттай холбоотой байна. Гэсэн хэдий ч үндэсний язгуур эрх ашгийн үүднээс, Монгол Улсад худал ташаа мэдээлэл тараах, нийгэм улс төрийн амьдралд гаднаас нөлөөлөх зэрэг асуудлыг шинээр боловсруулах Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Мэдээллийн аюулгүй байдлын хэсэгт тодорхой тусгаж, хууль эрх зүйн орчин, хариуцах байгууллага, бодлого, үйл ажиллагаа зэргийг цогцоор шийдвэрлэх нь зүйтэй.

Төрийн болон төрийн өндөр албан тушаалтан, сөргөлдөгч талуудын худал үнэн, хууль бус үйлдэл, ичгүүртэй баримт материалыг олзворлон нийтэд цацсанаар иргэдийн дунд төөрөгдөл, эргэлзээ, гайхах, зэвүүцэх сэтгэгдлийг төрүүлж хүн амын дунд зөрчилдөөнийг бий болгож, нийгмийг эмх замбараагүй байдалд хүргэх нь мэдээллийн дайны үндсэн технологи юм.

Тиймээс мэдээллийн дайны эсрэг хууль эрх зүйн орчин, тогтолцоог боловсруулж бий болгох, төр иргэд хоорондын итгэлцлэлийг бэхжүүлэх, аюулгүй байдлын салбар дахь одоогийн байгууллагуудын зорилтыг өргөжүүлэх, шаардлагатай бол шинээр бүтэц орон тоо байгуулах, гадаадын туршлага сургамж, хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэгт тулгуурлах зэрэг нь мэдээллийн дайнаас урьдчилан сэргийлэх, түүнийг даван туулах үндэсний чадварыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Гэхдээ мэдээллийн дайны эсрэг хамгийн гол дархлаа нь үндэсний эв нэгдэл уламжлал, үндэсний онцлог сэтгэхүй, эх оронч үзэл, нүүдлийн соёл иргэншил, үндэсний ухамсар ёс суртахуун түүх соёл зэрэг монголчууд бидний үнэт зүйлс юм.

1. Томас Р. “Зэвсгийн систем ба мэдээллийн дайн” илтгэл, 1976 он.
2. ОХУ-ын Батлан хамгаалах яамны цахим нэвтэрхий толь. <https://encyclopedia.mil.ru>
3. БНХАУ-ын Байду интернет нэвтэрхий толь, <https://baike.baidu.com/item/%E4%BF%A1%E6%81%AF%E6%88%98/1304409>
4. АНУ-ын Агаарын цэргийн хүчний зорилго, 2021 он, <https://www.airforce-technology.com/news/us-air-force-new-mission-statement/>
5. <https://www.kremlinwatch.eu/countries-compared-states/armenia/>
6. Чехийн Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны сонгуулийн үеэр худал мэдээлэл цацагдаж эхэллээ. <https://www.rferl.org/a/fake-news-kicks-into-high-gear-czech-presidential-vote/28987922.html>
7. <https://www.reuters.com/article/us-asean-singapore-russia-idUSKB>
8. Тайванийн Нэвчилтийн эсрэг хуулийг сөрөг хүчин эсэргүүцэж байна, 2020 он, <https://thediplomat.com/2020/01/taiwan-passes-anti-infiltration-act-ahead-of-election-amid-opposition-protests/>
9. Шведийн Сэтгэл зүйн хамгаалалтын агентлагийн албан ёсны вэб хуудас, 2022 он, <https://www.mpf.se/en/>
10. Сингапурын Кибер хамгаалалтын байгууллагын албан ёсны вэб хуудас, 2022 он, <https://www.csa.gov.sg/>
11. Оросын мэдээллийн дайн, 2020 он, <https://jsis.washington.edu/news/a-russian-federation-information-warfare-primer/>
12. Стратегийн судалгаа сэтгүүл. №82/2021. Хуудас 99-101
13. Азийн хүчний индекс-2021 судалгааны тайлан, <https://power.lowyinstitute.org/>



Т.МӨНХ-ОРГИЛ (Ph.D)

УБХИС-ийн БХЭШХ-ийн Эрдэм
шинжилгээний ажилтан

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ

Abstract: Memorandum of Understanding in 2015. The parties established a joint working group to hold the first meeting in 2015 in Ulaanbaatar and the second meeting in 2016 in Moscow to study the possibility of concluding a Free Trade Agreement between Mongolia and the EAEU. The first consultative meeting on the issue was held in 2020, which requires depth research in this area.

Keywords: Eurasia, economy, free trade, security, trade.

Хураангуй. Бүс нутгууд дахь хөгжлийн явц эрчимжиж улс орнуудын эдийн засаг харилцан хамааралтай болж хамтын ажиллагаа нь өргөжин, эдийн засгийн интеграци улам бүр эрчимтэй явагдаж байна. Дэлхийн бөмбөрцгийн хамгийн том геоэдийн засгийн бүс бол Европ, Ази хоёр тивийг агуулсан асар том хуурай газар билээ. Евразид дэлхийн хүн амын 72.5 хувь (Европт 12.5, Азид 60 хувь) болох таван тэрбум хүн оршин сууж дэлхийн ДНБ-ий 60 хувийг үйлдвэрлэхийн зэрэгцээ дэлхийн эрчим хүчний мэдэгдэж байгаа нөөцийн дөрөвний гурав нь энэ бүс нутагт төвлөрдөг байна. Евразийн бүс нутагт эдийн засгийн өндөр хөгжилтэй зургаан орон байхаас гадна байгалийн баялаг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт үндсэн тоглогч болох ихэнх улс орон байршсан байдаг. Евразийн бүс нутагт нийгэм эдийн засгийн 320 гаруй эвсэл холбоод байна. Үүний нэг нь Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) юм. Монгол Улс болон ЕАЭЗХ 2015 онд хамтран ажиллах тухай Санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд талууд хамтарсан ажлын хэсэг байгуулж, анхдугаар хуралдааныг 2015 онд Улаанбаатарт, хоёрдугаар хуралдааныг 2016 онд Москвад, Монгол Улс, ЕАЭЗХ-ны хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан ажлын хэсгийг байгуулах асуудлаарх анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2020 онд тус тус зохион байгуулсан зэрэг нь энэ чиглэлээр судалгааны ажил явуулах шаардлагатайг харуулж байна. Иймд ЕАЭЗХ-той хамтран ажиллах хүрээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зарим тулгуур асуудлыг судлах, цаашид баримтлах чиглэл, арга замыг тодорхойлоход энэхүү судалгааны ажил чиглэгдэж байна.

Үндсэн хэсэг

Беларусь, Казакстан болон ОХУ ЕАЭЗХ-г 2015 оны нэгдүгээр сарын 1-нд байгуулж өмнөх Гаалийн холбооны болон интеграцийн чиглэлээрх бүх хэлэлцээрийг кодчилж өргөжүүлсэн. Энэ холбоонд 2015 оны нэгдүгээр сард Армен, 2015 оны тавдугаар сарын 8-нд Киргизстан нэгдсэн. ЕАЭЗХ нь «дөрвөн эрх чөлөө» буюу бүтээгдэхүүний, үйлчилгээний, ажиллах хүчний хөдөлгөөнийг чөлөөтэй болгох, макро эдийн засгийн нэгдсэн бодлогыг бий болгох замаар нэг валютын системд шилжих зорилготойгоор байгуулагдсан. ЕАЭЗХ-ны гэрээнд макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төсвийн алдагдлыг ДНБ-ий гурван хувь, улсын өрийн хэмжээ ДНБ-ий 50 хувь, инфляц жилийн 5 хувиас хэтрэхгүй байх босгыг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж өгсөн байдаг.

ЕАЭЗХ нь 183 сая хэрэглэгчтэй нэг зах зээл бүхий Гаалийн холбоог байгуулснаар ДНБ 2016 онд ойролцоогоор 2.2 их наяд ам.доллар болж өсөж, дэлхийн импортын 2.3, дэлхийн экспортын 3.7 хувийг тус тус бүрдүүлжээ¹. Эдийн засгийн идэвхтэй хүн ам 92.9 сая бөгөөд ажилгүйдлийн түвшин 5.3 хувь байгаа нь АНУ-ын 6.2 хувьтай харьцуулахад харьцангуй бага байна. Энэ холбоо нь дэлхийн хэмжээнд эрчим хүч, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй гэсэн гурван тэргүүлэх салбартай. Тухайлбал, дэлхий, эрчим хүчний салбарын хэмжээнд газрын тос 14.6 (эхний байранд), байгалийн хий 18.4 (хоёрдугаарт), эрчим хүч 5.1 (дөрөвдүгээрт), боловсруулах үйлдвэрлэлийн хувьд ган 4.5 (тавдугаарт), ашигт малтмалын бордоо 10.8 (хоёрдугаарт), путгамал төмөр 4.5 (гуравдугаарт), хөдөө аж ахуй 5.5, сүүний үйлдвэрлэл 7 хувийг тус тус эзэлж байна.

ЕАЭЗХ-ны гишүүд бусад орны хооронд хоёр талт болон олон талт ЧХХ-үүдийг хийж худалдаа, эдийн засгийн салбаруудыг өргөжүүлсээр байна.

Хүснэгт 1. ЕАЭЗХ-ны орнуудын худалдааны хэлэлцээр²

Гишүүд	Хоёр талын худалдааны хэлэлцээрийн тоо	Олон талт ЧХХ-ийн тоо
Беларусь	12	7
Казахстан	7	8
Орос	8	7
Армен	8	5
Киргизстан	5	5

ЕАЭЗХ Вьетнам, Сингапур, Серби улстай ЧХХ-үүд, Ирантай богино хугацааны хэлэлцээрүүд, БНХАУ-тай хөнгөлөлтгүй хоёр гэрээ хэрэгжүүлж байна. Вьетнам нь тус холбооны хамгийн анхны ЧХХ байгуулсан улс учраас ЕАЭЗХ-Вьетнам ЧХХ-ийн явцыг шинжилье.

Вьетнамын тарифын амлалтын хуваарь нь 14,158 барааны ангиллын жагсаалттай. Үүнээс 2015 онд гэрээний хэрэгжилтийг хангуулах явцад 4959 ангиллын тарифыг хассан. Түүнчлэн 2020, 2025, 2027 онд дараах түвшинд хүртэл тус тус хасахаар болсон.

¹ Eurasian Economic Commission website

² ARIC website, <https://aric.adb.org/fta-group>.

Хүснэгт 2. Вьетнам, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын тарифын амлалт³

Он	2016	2020	2025	2027
Тарифаас чөлөөлөгдсөн	4,959	7200	8,253	8,280
Нэмэлт тарифын хасалт хийгдсэн	0	2,241	1,053	27
Нийт тарифын ангилал*	9,471	9,471	9,471	9,471
Тарифаас чөлөөлөгдсөн хувь	52	76	87	87
Тарифаас бүрэн чөлөөлөгдөөгүй хувь,	48	24	13	13

Вьетнамын тарифын үүргийн хуваарьт нийт 9471 төрлийн ангиллаас 8280 тарифын шугам 2027 он гэхэд 0 хувь болж буурах хүртэлх амлалтуудыг хийсэн байна.

ЕАЭЗХ-Вьетнам ЧХХ нь Вьетнамд эдийн засгаа өсгөх, илүү олон ажлын байрыг бий болгох, худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг дэмжих, ЕАЭЗХ-ны орнуудтай эдийн засгийн харилцаагаа түргэсгэх боломжийг олгоно гэж Вьетнам үзсэн. Вьетнам нь ЕАЭЗХ-Вьетнам ЧХХ-ийн амлалтын дагуу тарифыг бууруулах хуваарийн дагуу импортын тарифын ангиллыг бараг 90 хувийг 0 хувь болгон бууруулж эсвэл бүрмөсөн хасах болно. Энэхүү механизмыг нэвтрүүлсний үр дүн нь Вьетнам улс ЕАЭЗХ-ны нийт таван орны ДНБ-ий хэмжээ 2.2 их наяд ам.доллар, 183 сая гаруй хэрэглэгчтэй томоохон ирээдүйтэй нийтлэг зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлнэ гэж өөдрөг тооцоолсон. Ялангуяа далайн бүтээгдэхүүний экспорт энэ ЧХХ-ээс хамгийн их ашиг хүртэх ёстой бөгөөд импортын 0 хувийн тарифыг эдлэхэд Вьетнамын загасны аж ахуй илүү өрсөлдөх чадвартай байх болно гэж үзэж байна. Гэхдээ энэ нь хялбар шийдэгдэх асуудал биш Вьетнамын далайн хоол сам хорхой, загасыг багтаасан далайн бүтээгдэхүүний хүргэлт, эрүүл ахуй, чанарыг баталгаажуулсан тохиолдолд л зах зээлд өргөнөөр хүлээн зөвшөөрөгдөх юм.

Мөн Вьетнам нь худалдааны хамгаалалт, гарал үүслийн зарчим, гаалийн менежмент, техникийн саад бэрхшээл, хүнсний аюулгүй байдал, хорио цээрийн арга хэмжээ, засгийн газрын худалдан авалт, оюуны өмч, тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагааг өргөжүүлснээр давуу талыг эдлэх боломжтой. Энэ нь Вьетнамд эдийн засгаа цаашид бэхжүүлэх эдгээр гол чиглэлийг хөгжүүлэх, түүнчлэн хоёр талын худалдааны үйл ажиллагааг оновчтой дэмжих боломжийг олгох бөгөөд ингэснээр худалдааны хэмжээг нэмэгдүүлэх төдийгүй талууд хөрөнгө оруулалт, технологи, мэргэшсэн боловсон хүчний талаар таатай нөхцөлийг бүрдүүлэх, цаашлаад Вьетнам ЕХ-ны зах зээлд илүү их нэвтрэх боломжтой гэж үзэж байна⁴.

Нөгөөтэйгүүр, энэхүү чөлөөт худалдааны бүсэд хөл тавихад Вьетнамд зарим бэрхшээлтэй тулгарах болно. Тухайлбал, ЕАЭЗХ-ны зах зээлд гарахын тулд бүх бүтээгдэхүүн нь тодорхой стандартыг хангасан байх ёстой бөгөөд үүнийг ЕАЭЗХ-ны тал тодорхойлдог бөгөөд ЕАЭЗХ-Вьетнам ЧХХ-ийн дагуу Вьетнам нь гарал үүслийн дүрэм /ГҮД/ ба оюуны өмчийн эрх /ОӨЭ/-ийн тухай амлалтаа биелүүлэх ёстой. Мөн ЕАЭЗХ-ны зах зээл дээрх давуу эрх олж авахын ГҮД-ийг хангаж, давуу эрхийн гэрчилгээ авах ёстой. Үүнээс гадна Вьетнам дахь жижиг, дунд үйлдвэрүүд ЕАЭЗХ-ны

³ <http://wtocentre.iift.ac.in/>

⁴ <https://en.vietnamplus.vn/opportunities-challenges-lie-ahead-under-euvietnam-fta/94084.vnp>

зах зээлд нэвтэрч, дотоодын эрэлт хэрэгцээг хангахын тулд ЕАЭЗХ-ны компаниудтай өрсөлдөх ёстой. Вьетнамын аж ахуйн нэгжүүд тасралтгүй хүчин чармайлт гаргаж, өндөр чанартай, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх стратеги, арга хэмжээг хүлээн зөвшөөрөхөөс өөр сонголтгүй бөгөөд ингэх нь Вьетнамыг дэлхийн эдийн засгийн зах зээлд эрчимтэй интеграцчилахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Түүнчлэн, үйлдвэрлэлийн салбартай холбоотой, ялангуяа оёмол, нэхмэл, гутлын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд дэлхийн үйлдвэрлэлийн өндөр өртөг, хангамжийн сүлжээнд шинэчлэгдэхэд өөрсдийгөө бэлтгэх ёстой. Тэд импортын материалаас бага хамааралтай байх ёстой бөгөөд тогтвортой хөгжлийг баталгаажуулахын тулд илүү өргөн нийлүүлэгчтэй байх ёстой. Цаашилбал, тарифын бууралтаас үл хамааран Вьетнамын экспортлогчид ЕАЭЗХ-Вьетнам ЧХХ-ийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээнд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Вьетнам бол АНУ-ын зах зээлд нэхмэл, хувцасны хоёр дахь том нийлүүлэгч болж энэ зах зээл дэх Хятадын эзлэх хувийг 60-42 хувь болгон бууруулсан байна. Тиймээс ЕАЭЗХ-ны гишүүн орнууд Вьетнамын бүтээгдэхүүний зах зээлийг нээх нь тэдний дотоодын аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулах вий гэсэн болгоомжлол бий болсонтой холбоотойгоор ЕАЭЗХ Вьетнамын оёдлын болон нэхмэл бүтээгдэхүүний экспортод тэг тарифын бодлогыг зогсоох тухай шийдвэр гаргасан байдаг.

Мөн Вьетнамын бизнес эрхлэгчид ЕАЭЗХ-ны гарал үүслийн өвөрмөц шаардлагын дагуу хэд хэдэн хатуу журмыг дагаж мөрдөх ёстой болдог. Тухайлбал, ЕАЭЗХ-Вьетнам ЧХХ-ийн дагуу ачааг хувааж ачихыг хориглодог тул үйлдвэрүүд нь өөр өөр улс оронд эсхүл үндэстэн дамнасан компанид харьяалагддаг ч гэсэн чингэлгүүдийг зөвхөн Вьетнамаас л ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад шууд ачуулах ёстой, бөгөөд заавал нэн таатай хэлэлцээрийн урьдчилсан нөхцөл болох гарал үүслийн гэрчилгээ шаарддаг байна.

ЕАЭЗХ-ны гишүүн орнууд Холбоонд нэгдсэн өөр өөрсдийн ашиг сонирхол байна. Тухайлбал, Беларусь ЕАЭЗХ-д элссэн гол шалтгаан нэн хэрэгцээтэй санхүүгийн эх үүсвэрийг олж авах, болон ОХУ-аас хямд эрчим хүч авах сонирхолтой байсан. Гаалийн татварыг тэглэсний дараа Беларусь Оросоос нэг тонн газрын тосыг ердөө 30 орчим ам.доллараар авдаг байв. Үүнтэй адил 1000 куб метрт ногдох хийн дундаж өртөг 2011 онд 265 байсан бол 2012 онд ердөө 165 ам.доллар болтлоо буурчээ. Үүний эсрэгээр Украин гэх мэт гишүүн бус орон 414 ам.доллар төлдөг. Беларусь газрын тосноос бараг 7.5 сая ам.долларын ашиг олсон гэж үздэг. ОХУ-ын энэхүү эрчим хүчний дэмжлэгээр Беларусь 2011 оны эдийн засгийн хямралаас гарсан. ДНБ 2012 онд ойролцоогоор 5.5 хувиар өсөж, аж үйлдвэрийн үйлдвэрлэл 9.1 хувиар өссөн байна. Гаалийн тарифгүйгээс болж ОХУ-ын зах зээлд ногдох татвар, газрын тосны үйлдвэрлэл кокс, нефтийн бүтээгдэхүүн, цөмийн бодис 17.2 хувиар, химийн бодисын үйлдвэрлэл 19.6 хувиар өссөн байна. Беларусь дахь Оросын шууд хөрөнгө оруулалт 593 сая ам.доллар болж өссөн нь ТУХН-ийн орнуудтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болжээ. ОХУ-аас орж ирсэн ГШХО-ын энэ урсгал Беларусьт эдийн засгийн байдлаа сайжруулах, эдийн засгаа шинэчлэхэд чухал түлхэц болсон. Гэсэн хэдий ч эдийн засгийн нийтлэг орон зайн (ТЭХС)- гэрээтэй холбоотойгоор Беларусь улс эдийн засгийн бодлогын шинэчлэлийн механизмаа алдсан гэж үздэг. Тухайлбал, эрчим хүчний давуу эрхийн хэлэлцээрээс Беларусийг гаргаж, Оросоос бүрэн хамааралтай болгож, гишүүн орнуудын зах зээлээс бусад зах зээлд

нефтийн бүтээгдэхүүнийг экспортлох эрхийг хассан. Интеграцийн хэт туйлшралаас болж Беларусь үндэсний мөнгөн тэмдэгтээ ч үнэгүйдүүлсэн байна.

Казахстан, Оросын эдийн засаг, худалдааны харилцаа 2010 онд ГХ хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа сайжирсан. Казахстан 2011 онд гаалийн татвараас 700 тэрбум тенге олж байсан бол 2015 онд нэг их наяд 142 тэрбум тенге олсон гэж мэдэгджээ. Казахстаны инфляцийн түвшин хамгийн бага буюу 4.6 хувь болтлоо буурсан. Гадаадын хөрөнгө оруулалт 2011 онд 19.85 тэрбум ам.долларт хүрч дээд амжилт тогтоосон нь ялангуяа машин боловсруулах, цахилгаан, электроникийн салбар, зам тээвэр, хөдөө аж ахуйн салбар зэрэг тус улсын боловсруулах үйлдвэрүүдэд үр өгөөжөө өгчээ. Бусад судлаач Казахстаны Холбооны Улсад элсэх асуудлыг өөдрөгөөр илэрхийлж байна. Эдийн засгийн нэг орон зай нь эдийн засаг, аж үйлдвэр, хөдөө аж ахуйгаа шинэчлэхэд тусалж, өөрийн 160 сая хүнээс гадна зах зээлд нэвтрэх замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлсэн.

Гишүүн орнуудын аль аль нь интеграцийн процессоос эдийн засгийн томоохон ашиг олж чадаагүй байгааг харуулж байна; харин ч тэдний эдийн засгийн байдал дордсоор байна. Оросын эдийн засгийн хямрал, барууны орнуудын эдийн засгийн хориг арга хэмжээ, рублийн ханшийн уналт, олон улсын зах зээл дээрх газрын тосны үнэ огцом буурсан нь Казахстаны эдийн засагт ноцтой нөлөөлж, валютаа үнэгүйдүүлэхэд хүргэсэн. Тухайлбал, 2014 оны эхээр 19, 2015 онд дахин 23 хувиар тус тус өссөн байна. Үүнээс болж Казахстаны ОХУ болон бусад ГХ-ны гишүүдтэй хийсэн худалдаа мэдэгдэхүйц буурч, харин Хятадтай хийсэн худалдааны эргэлт 2014 онд 20 хувиар өссөн байна. Казахстаны ОХУ-д экспортолж буй экспорт 2010 онтой харьцуулахад 2013 онд 5.57 - 7.04 хувь, ОХУ-аас импортолсон хугацаанд 22.7 - 36.19 хувь болж өссөн тус тус байна. Гэсэн хэдий ч ОХУ-тай хийсэн худалдааны нийт хэмжээ 21.1 хувь болж буурсан бол Хятад ОХУ-ыг гүйцэж, Казахстаны 2013 оны худалдааны 24.1 хувиар нэгдүгээрт эрэмбэлэгджээ⁵.

Гишүүн орнуудын харилцан худалдаа, хөрөнгө оруулалтын хувьд ОХУ нь Беларусийн худалдааны гол түнш бөгөөд Беларусийн экспорт, импортын 50 гаруй хувийг эзэлдэг. Гэсэн хэдий ч Беларусийн Орос руу хийх экспорт 2011 онд 4.7 хувь байсан бол 2014 онд 3.8 хувь болж буурсан байна. ЕАЭХ-ны гишүүн орнуудын гадаад худалдааны хэмжээ 2013 онд 64.52 тэрбум ам.доллар байсан бол 2014 онд 57.45 тэрбум ам.доллар болж буурсан бөгөөд ойрын ирээдүйд улам буурах төлөвтэй байна. Судлаачид дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдлаас болж 2012-2015 оны хооронд худалдааны нийт хэмжээ болон гишүүн орнуудын хоорондын худалдаа хоёулаа тоон үзүүлэлтээр буурсан гэж үзсэн байна. Гэхдээ чанарын үнэлгээний хувьд гишүүн орнуудын харилцан худалдааны бүтэц зарим тохиолдолд сайжирсан байна. Жишээлбэл, гишүүн орнуудын хоорондын худалдааны хэмжээ 2014 онд 12.3 хувь байсан бол 2015 онд 13.5 хувь болж өссөн байна. Үүнтэй адил гишүүн орнуудын худалдааны тэнцэлд зарим бүтцийн өөрчлөлт ажиглагдсан. ЕАЭХ-ны гишүүн орнуудтай Беларусийн харилцан худалдааны алдагдал 2011 онд 10.4 тэрбум ам.доллар, 2015 онд 6.2 тэрбум ам.доллар болж буурсан. Экспорт, импортын хувьд экспортын хэмжээ нь ЕАЭХ-ны орнуудын нийт экспортын эзлэх хувьтай тэнцэж, 2014 онд 9.5 хувь байснаа 2015 онд 10.8 хувь болж эерэг үзүүлэлт гарсан төдийгүй харилцан худалдааны импорт нь нийт импортын хувьтай харьцуулбал 2014 онд 15.8 хувиас 2015 онд 18 хувь болж өсөж байжээ.

⁵ Дэлхийн нэгдсэн худалдааны шийдэл, 2013

Дэлхийн өрсөлдөх чадварыг сайжруулах улс төрийн систем, манлайллын хэв маягаас үл хамааран ЕАЭЗХ-ны гишүүн орнууд чөлөөт худалдааг дэмжих, эдийн засгийн өсөлт, хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтыг татах ая тухтай уур амьсгалыг бүрдүүлэх зорилго, зорилтыг чөлөөтэй зах зээлийн эдийн засгийг баримталдаг.

Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд дурдсанаар Армен 85, Киргиз Улс 108, ОХУ 53, Казахстаныг 50 дугаар байрт эрэмбэлсэн байна. Чөлөөт худалдааны талаарх арга хэмжээ гишүүн орнуудад харилцан адилгүй байна. Тухайлбал Беларусьт эдийн засгийн нөхцөл байдал улам дордож байгаад ГХ болон Оросыг буруутгаж байна. Гэсэн хэдий ч Беларусийн ЕАЭЗХ-д элсэх бодит үр ашиг нь зардлаас илүү байгаа бөгөөд «Бизнес эрхлэхэд хялбар байдал» зэрэглэлийн дагуу сүүлийн 4-5 жилийн хугацаанд зарим ахиц дэвшил гарсан байна. Тухайлбал Беларусь 2010 онд 67-оос (182 улсаас) 2014 онд 57 болж (189 улсаас) байсан бол Казахстан мөн хугацаанд 58 үндэстнээс 77 руу унаж, Засгийн газар зохицуулалтын бодлого алдагдаж “тенге” хямрал (Казахстаны үндэсний мөнгөн тэмдэгт) болсон. Үүнийг улс төрийн тогтворгүй байдал, дотоод зөрчил, иргэний дайн, олон улсын эдийн засгийн тодорхойгүй байдал, гадаадын бизнес, хөрөнгө оруулалтын аюулгүй байдал хангалтгүй байгаа зэрэг нь бизнесийн орчин муудаж байгаатай холбоотой гэж үзэж байна. Харин ОХУ мөн хугацаанд 122-62 дугаар байр руу шилжсэнээр мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасан нь тогтвортой Засгийн газартай холбоотой гэж үзэж болох юм.

ОХУ-ын Засгийн газар гадаадын бизнес, хөрөнгө оруулалтыг татахын тулд либерал шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах талаар олон арга хэмжээ, санаачилгыг гаргасан. ОХУ-ын «Бизнес эрхлэхэд хялбар байдал»-ын зэрэглэл мэдэгдэхүйц сайжирсан боловч бодит байдал дээр Москваг барууны орнууд тусгаарлаж, АНУ, Европын зарим улс орон эдийн засгийн хориг арга хэмжээ авсан тул гадаадын бизнес, хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байна. Хэдийгээр ЕАЭЗХ-ны ахиц дэвшлийг үнэлэхэд эрт байгаа боловч тус байгууллага тодорхой амжилтад хүрсэн бололтой. Наад зах нь Беларусь, Казахстан, Орос гэсэн анхны гурван гишүүн орны хүлээж байснаар нефть, хий, цахилгаан эрчим хүчний салбарт нийтлэг зах зээлийг бий болгосон.

Гэсэн хэдий ч ЕАЭЗХ-нд зарим хүндрэлтэй асуудал байна. Тухайлбал, ОХУ Крымийг эзэлж, Украины зүүн хэсэгт салан тусгаарлах хөдөлгөөнийг дэмжиж байгаагийн хариуд барууны орнууд Оросыг хориг тавьж, эсрэг арга хэмжээ авсны хариуд Орос барууны орнуудын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний импортод хориг тавьжээ. ОХУ ЕАЭЗХ-ны бусад гишүүд үүнтэй ижил төстэй хориг арга хэмжээ авна гэж таамаглаж байсан боловч энэ нь бүтээгүй учраас Орос ЕАЭЗХ-ны бусад гишүүн орны экспортын талаар гомдол гаргаж зарим зах зээлээ хааж гишүүдийн экспортыг хохироосон. Жишээлбэл, ОХУ Беларусийн зарим мах, сүүн бүтээгдэхүүн нь Оросын стандартад нийцэхгүй тул хэрэглээнд аюултай гэж мэдэгдэж, улмаар эдгээр бүтээгдэхүүнийг импортлохыг хориглосон.

Орос Беларусийг Оросын хориг арга хэмжээнд хамрагдсан барууны барааг шилжүүлж, савласан гэж буруутгах, Казахстан улс ОХУ-ын чанарын стандартыг зөрчсөн гэж буруутгаж Оросын зарим махан бүтээгдэхүүнийг зах зээлээс хассан. Үүнтэй ижил хоригийг Киргизээс Оросын зах зээлд орж ирсэн сонгосон бараанд тавьсан зэргээр бусад гишүүн орон өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор арга хэмжээ авсан. Жишээлбэл, Казахстан дотоодын зах зээлээ Оросын газрын тосны бүтээгдэхүүний

илүүдлээс хамгаалахын тулд Оросын шатахуун, хийн импортыг зогсоосон байдаг.

ОХУ-ын судлаач Есдаулетова ЕАЭЗХ-г амжилттай нэгтгэхэд учирч байгаа таван асуудлыг тодорхойлсон байна. Үүнд:

- Хэт олон зохицуулалт шаарддаг олон тооны эдийн засгийн салбарууд,
- Интеграцийн хурд,
- Гурвын бүтэлгүйтэл SES-ийн зах зээл рүү чиглүүлэх улс орнуудын гадаад худалдааг эдийн засгийн нэг орон зайд шилжүүлэх гэсэн гурван улсын бүтэлгүй оролдлого,
- Эдийн засгийн нэг орон зайн орнуудын үйлдвэрлэлийн төрөлжсөн бус шинж чанар,
- Гишүүн гурван улсын хоорондох тарифыг зохицуулах, тэнцвэржүүлэх бодлогын алдаа зэрэг байна гэж үзсэн.

ЕАЭЗХ-ны таван гишүүн улс нь газар нутаг, хүн ам, эдийн засгийн цар хүрээгээрээ эрс ялгаатай. Эвслийн хамгийн том улс болох ОХУ нь нутаг дэвсгэрийн хувьд хамгийн жижиг Армениас 574 дахин том бөгөөд үүнтэй адил Оросын ДНБ Армениас 170 дахин их юм. ОХУ-ын ДНБ-ий нийт хэмжээ нь бусад дөрвөн гишүүн орны ДНБ-ээс зургаа дахин их байна. Армен, Беларусь, Казахстан, Киргизстан зэрэг дөрвөн улсын нийт хүн амын тоо 42 сая хүрэхгүй байхад ОХУ-ын хүн ам ойролцоогоор 144 сая байна. Армен, Киргиз улс нь сул дорой тул улс төр, аюулгүй байдал, стратегийн ашиг сонирхолд анхаарлаа хандуулахаас гадна Оросоос хөнгөлөлттэй үнээр нефть, хий авах асуудалд илүүтэй анхаарч Оросын давамгайлах байр суурийг эсэргүүцэх сонирхол байхгүй байна. Холбооны үйл ажиллагааны бүх салбарт ОХУ давамгайлж байгаа нь гишүүн орнуудын дунд хэт тэнцвэргүй байдал үүсэх магадлалтай байгаа гэсэн болгоомжлолыг бий болгодог.

ЕАЭЗХ-нд Хятадын сонирхол. БНХАУ нь ЕАЭЗХ-ны гишүүн орнууд, тэр дундаа ОХУ-тай нэвтрэх эдийн засаг, хөрөнгө оруулалтын харилцааг дэмжих замаар өөрийн стратегийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхийг хичээж байна. БНХАУ-ын удирдагч Си Зиньпин 2013 онд Казахстанд айлчлах үеэрээ Хятадыг Европтой холбоход Төв Азийн орнуудыг татан оролцуулах “Торгоны замын эдийн засгийн бүс” байгуулснаа зарласан байдаг. Энэ нь Хятадын санаачилсан Торгоны замын эдийн засгийн бүс нь эдийн засгийн болон стратегийн нөлөөгөөр Төв Азийн орнуудад өөрийн байр суурийг бэхжүүлэхийг сонирхсоор ирсэнтэй холбоотой.

ЕАЭЗХ ба “Торгоны зам” санаачилгын хооронд Төв Азид мөргөлдөөн үүсэх магадлал байж болох юм. Учир нь хэрэгжүүлэх явц, механизм нь харилцан адилгүй боловч хоёулаа эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцийн ижил төстэй зорилготой юм. Төв Азийн чиглэлд Хятадын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, бүтээн босголтын түрэлтээр хуучин ЗХУ-ын нөлөөний болоод бүрэлдэхүүнд байсан улсууд Хятадын геостратегийн нөлөөнд автаж ОХУ-ыг түгшээх болсон. Үүнтэй улбаатай ОХУ нь аман дээрээ Хятадын “Бүс, зам”-ын санаачилгыг ЕАЭЗХ, ШХАБ-ын үйл ажиллагаатай уялдуулах нь зүйтэй гэж байгаа ч бодит байдалд уг санаачилгын хэрэгжилтийг аль болох хойш нь татаж байна хэмээн зарим судлаач дүгнэж байна.

Хятад улс ЕАЭЗХ-д шууд аюул занал учруулахгүй байж магадгүй, гэхдээ эдийн засгийн идэвхтэй байдал нь бүс нутаг дах хамгийн чухал худалдаа, хөрөнгө оруулалтын түнш болсон нь ЕАЭЗХ-ны гишүүдийн, ялангуяа Төв Азийн орнуудын анхаарал, амлалтыг өөрт ашигтайгаар эргүүлж болзошгүй юм. Өрнөдийн орнууд эдийн засгийн хориг арга хэмжээ авсны дараа В.Путин Хятадтай тогтоосон шинэ нөхөрлөлөө онцлон тэмдэглэж, хэд хэдэн худалдааны хэлэлцээр байгуулсны нэг нь 30 жилийн хугацаатай 400 тэрбум долларын байгалийн хийн хэлэлцээр юм. БНХАУ-аас ОХУ-д суугаа Элчин сайд Ли Хуэй Хятад, ЕАЭЗХ-ны хооронд худалдааны чөлөөт бүсийг гэрээг аль болох түргэн байгуулах шаардлагатай байгааг чухалчлан “...Чөлөөт худалдааны бүс байгуулах хэлэлцээрийг урагшлуулан, нэг нэгнийхээ зах зээлд нэвтрэх үйл явцыг бэхжүүлэх хэрэгтэй. Дэлхийн хөгжлийн суурь нь чөлөөт худалдааны салбар дах түншлэл, бүс нутгийн хамтын ажиллагааны түвшнээ нэмэгдүүлэх явдал тус уг чиг хандлагыг харгалзан хэлэлцээрээ удаахгүй баймаар байна. Аль болох түргэн гэрээ байгуулж, хамтын ажиллагааны түвшнээ нэмэгдүүлэх хэрэгтэй байна...” гэж онцолсон нь судлаачдын дээрх дүгнэлттэй холбоотой байж болох талтай.

Төв Ази дахь Хятадын уламжлалт болон түүхэн нөлөөл нь Оросынхоос бага ч тухайн бүс нутгийн ШХАБ-ын гишүүн орнууд нь БНХАУ-ын хувьд стратегийн чухал ач холбогдолтой юм.

Бүс нутаг дах өмнөх интеграцийн үйл явцын туршлага болон бусад бүс нутгийн интеграцийн санаачилгууд дээр үндэслэн ЕАЭЗХ-ны ирээдүй нь боломжит гурван чиглэлээс аль нэгэнд нь шилжиж магадгүй гэж таамаглаж байна. Үүнд;

Нэгд. ЕАЭЗХ нь одоогийн хязгаарлагдмал, идэвхгүй хэлбэрийн түвшиндээ үйл ажиллагаагаа үргэлжлүүлж одоогийн нөхцөл байдалд илүү их хямралд өртөж болзошгүй юм. Энэ нь чиг үүргээ хязгаарлагдмал үйл ажиллагаагаар хязгаарлах бөгөөд одоо байгаа сул дорой гишүүн орнууд Москвагаас аль болох ихийг олж авахыг хичээдэг бүс нутгийн сул байгууллага хэвээр байх болно. Тухайлбал, Армен, Беларусь, Киргизстан нь жижиг, буурай хөгжилтэй гишүүд бөгөөд тэдний ашиг сонирхолд нийцсэн л бол тэд Холбоонд үлдэх болно. Тиймээс шинжээчдийн үзэж байгаагаар ЕАЭЗХ “үгүй болохгүй” гэхдээ хамгийн идэвхгүй байгууллага болно гэж үзэж байна.

Хоёрт. ОХУ улс төрийн, үзэл суртлын болон цэргийн аюулгүй байдлын заналхийлэл, шахалтаас татгалзаж, Украинтай зөрчилдөж байгаа асуудлаа шийдвэрлэж, ЕХ болон барууны улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, итгэлцлийг бий болговол Барууны хориг арга хэмжээг цуцалж, үндэсний мөнгөн тэмдэгт тогтвортой болж, гишүүн орнуудын эдийн засаг хөгжиж ЕАЭЗХ-ны байр суурь бэхжих болно. Энэ нөхцөлд олон улсын болон бүс нутгийн гүрнүүд ЕАЭЗХ-г хүлээн зөвшөөрч, гишүүн орнуудын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааны хамтын ажиллагааг нэмэгдүүлэх болно. Хамгийн гол нь энэхүү хамтын ажиллагаа нь гишүүн орнуудын хоорондын итгэлцлийг дээшлүүлж, бүс нутгийн ард иргэдийн сайн сайхны төлөө эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих замаар бий болно. Гэсэн хэдий ч энэ нь өнөөгийн нөхцөл байдалд бодит бус төсөөлөл байж болох юм. ЕАЭЗХ-ны ирээдүй Оросын стратегиас шууд хамаарна.

Гуравт. ЕАЭЗХ нь Хятадыг нэгтгэж, өөр нэг интеграцид хөтлөх боломжтой гэж үзэж

байна. Хятад Еврази дахь эдийн засгийн интеграцийн үйл явцыг анхааралтай ажиглаж, Оростой шууд зөрчилдөхгүйгээр Төв Азийн орнуудтай газрын тос, байгалийн хийн салбарт нэвтрэн эдийн засгийн харилцааг хөгжүүлэх өөрийн стратегиа боловсруулж ирсэн. Хятад сүүлийн жилүүдэд Төв Азийн орнуудын худалдаа, хөрөнгө оруулалтын гол түнш болжээ. Бээжин 2013 онд өөрийн интеграцийн төлөвлөгөө болох Торгоны замын эдийн засгийн бүсийг санал болгож, бүс нутгийн улс орнуудыг энэхүү өргөн цар хүрээтэй эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцож, ойр дотно интеграцчиллын санаачилгыг сонгож магадгүй юм. Украины хямралын дараа Хятад улс маш болгоомжтой, няхуур бодлогыг баримталж, ОХУ-д тусламж санал болгож, хэд хэдэн газрын тос, байгалийн хийн гэрээнд гарын үсэг зурж, улс төр, эдийн засаг, цэргийн салбарт цаашид хамтран ажиллахаа амласан. ЕАЭЗХ-ны таван гишүүнээс Казахстан, Киргизстан, ОХУ нь ШХАБ-ын идэвхтэй, Беларусь ажиглагч, Армен бол яриа хэлэлцээрийн гишүүн юм. Тиймээс ЕАЭЗХ ноцтой асуудалд орвол гишүүд нь ШХАБ-тай нэгдэж, илүү өргөн, өргөтгөсөн хүрээнд ажиллахаар шийдэж магадгүй юм. Өмнө дурдсанчлан Энэтхэг (ШХАБ-ын шинэ гишүүн), Иран, Монгол Улс (ШХАБ-ын ажиглагчид) ЕАЭЗХ-той гэрээ байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн тул хоёр байгууллагын ирээдүйн болзошгүй интеграцлал нь ноцтой эсэргүүцэлтэй тулгарахгүй байж болзошгүй.

Монгол Улс болон ЕАЭЗХ 2015 онд хамтран ажиллах тухай Санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд талууд хамтарсан ажлын хэсэг байгуулж, анхдугаар хуралдааныг 2015 онд Улаанбаатарт, хоёрдугаар хуралдааныг 2016 онд Москвад, Монгол Улс, ЕАЭЗХ-ны хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан ажлын хэсгийг байгуулах асуудлаарх анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2020 онд тус тус зохион байгуулсан зэрэг нь энэ чиглэлээр судалгааны ажил явуулах шаардлагатайг харуулж байна. Иймд ЕАЭЗХ-той хамтран ажиллах хүрээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зарим тулгуур асуудлыг судлах, цаашид баримтлах чиглэл, арга замыг тодорхойлоход энэхүү судалгааны ажил чиглэгдэж байна. Манай улс гадаад худалдаа, интеграцийн бодлогын чиглэлээр эдийн засгийн салбарт олон улсын тэнцвэртэй, найрсаг харилцааг хөгжүүлэх, хамтран ажиллах, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох замаар улс орны эдийн засгийн бие даасан байдлыг хамгаалж, олон улсын түвшин дэх байр суурийг бататгах чиглэлийг баримталж байна. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нэгэн чухал арга хэрэгсэл нь гадаад худалдаа, интеграцийн оновчтой бодлого гэж томьёолж түүний зорилтыг 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна” гэж заасан байна. Гадаад эдийн засгийн харилцааг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чухал арга хэрэгсэл гэж үзэн 3.2.5.2-т “Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан байна.

Манай Улсын нийт гадаад худалдааны бараа эргэлтийн 70-80 хувь нь БНХАУ, ОХУ-д ногдож байна. Манай улсын нийт экспортын дийлэнх хувь нь БНХАУ-д ногдож, 2010-2019 онд дунджаар нийт экспортын 86.3 хувь тус улсад ногдож байна. Ялангуяа уул уурхайн салбарын өсөлт өндөр байсан 2011, 2012 онд нийт экспортын 92.4 хувийг БНХАУ-д экспортолж байсан. Монгол Улс 2019 онд 6.1 тэрбум ам.долларын бараа,

бүтээгдэхүүн импортолсон нь 2016 оноос 82.5 хувиар өсөж, 2012 оноос 4.8 хувиар буурсан, 2010 оноос 1.9 дахин өссөн байна. Импортын өсөлтөд дизелийн түлш, авто бензин болон тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. ОХУ-аас нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас суудлын автомашин, БНХАУ-аас цахилгаан эрчим хүч, ачааны тэрэг, олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүнүүдийг голлон импортолж байна. Импортын бүтцийг улсаар авч үзвэл 2019 онд нийт импортын 33.6 хувь нь БНХАУ-д, 28.2 хувь нь ОХУ-д, 9.6 хувь нь Япон улсад, 4.7 хувь нь АНУ-д, 4.4 хувь нь БНСУ-д, 3.1 хувь нь ХБНГУ-д ногдож байгаа бөгөөд эдгээр улстай хийсэн импортын худалдаа нь импортын үнийн дүнгийн 83.6 хувийг эзэлж байна. Импортын дүнд эрдэс бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зонхилох хандлага хэвээр байна. Импортод 2010-2019 онд дунджаар эрдэс бүтээгдэхүүн 23.6, машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги 21.8, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 16.0, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.5, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 7.4 хувийг тус тус эзэлсэн байна.

Энэхүү эдийн засгийн бүтэц болон төлөв байдлаас харахад экспортын бүтцэд томоохон өөрчлөлт хийхгүйгээр ЕАЭЗХ-ны ЧХХ-т нэгдэх нь өрөөсгөл бөгөөд давуу гэхээсээ сул талыг дагуулах эрсдэлтэй юм.

Үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур болох эдийн засгийн аюулгүй байдлаа үндэсний язгуур эрх ашигтайгаа нийцүүлэн хангах зорилтыг улс орон бүр өөр өөрийн онцлогт тохирсон бодлого, үзэл баримтлалаар хэрэгжүүлж байгаа юм. Үүнээс шалтгаалан эдийн засгийн аюулгүй байдлын агуулгыг тодорхойлоход улс орнуудын байр суурь ч харилцан адилгүй байна. Хөгжингүй орнууд зах зээлээ хамгаалах, эдийн засгийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд голлон анхаарч байхад, хөгжиж буй улс орнууд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, ядуурал, ажилгүйдлийг багасгахад хүчин чармайлтаа төвлөрүүлж байна. Тухайлбал, АНУ, БНХАУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй улсууд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараараа тэргүүлэхийг эрмэлзэж байхад, Казахстан Улсын хувьд эдийн засгийн аюулгүй байдал гэсэн нэр томьёо нь эдийн засгийн тогтвортой өсөлт, олон улсын зах зээл дэх баттай байр суурийн тухай санааг илэрхийлсэн жирийн утгаар хэрэглэгддэг бөгөөд үүнийгээ хангахын тулд байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн экспортлохыг аль болох багасгах, экспортыг хөгжүүлэх хэтийн зорилт нь өндөр үнэтэй экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх, үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь өрсөлдөх чадвараа өсгөхийн тулд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг боловсруулах аж үйлдвэрлэлийг шинэчлэхэд зориулан үүнийгээ төрийн бодлого болгон хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд төрийн урт, дунд, богино хугацааны бодлогууд нь тогтворгүй, залгамж чанаргүй гэж дотоод, гадаадын судлаачид, олон улсын байгууллагууд үздэг. Энэ нь ч үе үеийн засгийн бодлого хоорондоо уялдаа холбоогүй, нэгдсэн бодлогод зангиддаггүйтэй холбоотой бөгөөд үр дүнд нь Монгол Улсад засаглалын, эдийн засгийн, нийгмийн хямрал үргэлжилсээр байна. Энэхүү нийгэм эдийн засгийн хямралыг үр дагаврыг өнөөгийн эдийн засгийн статистик үзүүлэлтээс тодорхой харж болно. Манай улсын эдийн засаг төрөлжөөгүй зөвхөн уул уурхайгаас хамааралтай, түлш болон эрчим хүч экспортлогч орны монополь эрхэнд орсон, зарим төрлийн хүнс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн тухайлбал, цагаан будаа, жимс жимсгэнэ, цаашлаад эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүн, авто машин, хүнд машин механизмын импортоос бүрэн хараат

байдалтай байна. Энэ эмзэг байдлыг дотооддоо шийдвэрлэхгүйгээр ЧХХ-ийг байгуулах нь эдийн засгийн дарамтад орох, цаашлаад үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх сөрөг үр дагавартай юм.

Монгол Улсын төрөөс баримталж байгаа аюулгүй байдлын болон эдийн засгийн гол гол бодлогуудад эдийн засгийн аюулгүй байдлыг хангах асуудлыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд;

1. УИХ-аас 2001 онд баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшнийг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино.⁶,
2. 2010 онд баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн⁷ гээд “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална”⁸,
3. 2011 онд баталсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д “Монгол Улс дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ, эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ”⁹ гээд эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ¹⁰ гэж заасан нь улс орны гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн аюулгүй байдлыг чухалчлах нь зүйтэйг тодорхойлсон байна.
4. 2015 онд баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т “Батлан хамгаалах үйл ажиллагаа гэж үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг

⁶ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001;

⁷ эш: ¹-ийг үз;

⁸ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010;

⁹ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011, Available from World Wide Web: <http://www.legalinfo.mn/annex/details/3362lawid=6340>

¹⁰ эш: ³⁹-ийг үз.

хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн”¹¹,

5. 2016 онд баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ”¹²,
6. 2018 онд баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д шударга ёс, сахилга хариуцлагатай, тогтвортой төрийн тогтолцоог бэхжүүлж, нэгдсэн бодлогоор эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлж, иргэдийнхээ амьдралын түвшнийг сайжруулахад оршино¹³
7. 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д “Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана”¹⁴ гэж эдийн засгийн аюулгүй байдлыг хөгжлийн бодлогод суулгаж өгсөн нь төрийн бодлогын цогц байдлыг хангаж, Монгол Улсын хувьд эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын чухал тулгуур болж байгааг илэрхийлсэн байна.

Гэсэн хэдий ч үндэсний аюулгүй байдал болон эдийн засгийн талаарх төрийн бодлогын нэгдмэл байдал, уялдаа холбоо болон тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь ЭЗАБ-ыг гадаад, дотоод эрсдэлд хүргэж байна. Энэ бүгдээс эдийн засгийн хөгжлийг олон тулгууртай болгох, ялангуяа ХАА-г хөгжүүлэх, түүнийг улс орны тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулан нэгдсэн бодлогод зангидаж, хөгжлийн урт, дунд болон богино хугацааны бодлогын нэгдмэл байдал, уялдаа, залгамж чанар, хэрэгжилтийг хангах нь тулгамдсан асуудал болоод байна.

Эдийн засгийг олон тулгуурт болгох нь бүсчилсэн хөгжлийн бодлоготой шууд холбоотой асуудал юм. Монгол Улсын хувьд бүсчилсэн хөгжлийн бодлого бол хөгжлийн ирээдүй төдийгүй үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол гарц юм. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хөрш болон дэлхийн улс орнуудтай, олон улсын хөгжил, хөрөнгө оруулалтын байгууллагуудтай хамтран ажиллах, бүс нутгийн интеграцитай нийцүүлэх, хоршиход анхаарах нь чухал юм. Монгол Улс бүс нутгийн интеграцид амжилттай оролцохын тулд юуны өмнө дотоодын эдийн засгийг олон тулгуурт болгох, түүнийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах, Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Алсын

¹¹ Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс, 2015; Available from World Wide Web: <http://www.legalinfo.mn/annex/details/6917?lawid=11382>

¹² Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016;

¹³ Гурван тулгуурт хөгжлийн бодлого, 2018;

¹⁴ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” <https://www.legalinfo.mn/law/details/15406>

хараа-2050, Батлан хамгаалах бодлогын үндэс, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэгт тулгуурлан үндэсний аюулгүй байдлын эрх ашигтай нийцүүлэн шийдвэрлэх шаардлагатай юм. Ингээд дараах ерөнхий зөвлөмжийг санал болгож байна.

Ерөнхий зөвлөмж

Зөвлөмж	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ
Эдийн засгийн аюулгүй байдлын түвшинг тогтоох эрх зүйн баримт бичгийг боловсруулах	Эдийн засгийн аюулгүй байдлын талаар судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гарган санал боловсруулах журам болон нэгжийн бүтцийг бий болгох асуудлыг шийдвэрлэх
Улсын хэмжээнд бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ орон нутгийн материаллаг нөөцөд тулгуурласан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний төрлийг дагнаж гаршуулах, олон улсын стандартад нийцүүлэхэд анхаарах	ЕАЭЗХ-той ЧХХ байгуулахаас өмнө үндэсний үйлдвэрлэлийг чадавхжуулахад үйлдвэрлэлийн бааз, хүний нөөцийн асуудлаар хөгжиж буй орнуудтай хамтран ажиллах, хамтарсан үйлдвэрүүдийг байгуулах
Хил залгаа болон хил орчмын бүс нутагтай хамтын ажиллагааг хөгжүүлэх	Хөрш болон ЕАЭЗХ-ны орнуудын зах зээлийг судлах, тухайн зах зээлд гарах орон зай, боломжийг судлах
Бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа дэд бүтцийн асуудалд идэвхтэй байр суурийг бий болгох	Тээвэр холбоо, байгалийн хий, газрын тосны, эрчим хүчний коридорын чиглэлээр ОХУ болон Казакстан улстай хамтран ажиллах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
Монгол Улсын макро эдийн засаг болон бүс нутгийн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх стратеги боловсруулах	Өрсөлдөх хүчин чадлыг дээшлүүлэх хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлгээний аргыг боловсруулах, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх
Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэд “Алсын хараа-2050” тусгасан хөтөлбөрүүдийг бодитой хэрэгжих боломжийг бүрдүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох	Бүс, аймгуудын гадаад болон дотоод хамтын ажиллагааны боломжийг эдийн засгийн болон аюулгүй байдлын хүрээнд тодорхойлох, үнэлгээ хийх

ЕАЭЗХ-ны гол гишүүн орон болох ОХУ-тай манай улс хамтын ажиллагааны чиглэлээр нэлээдгүй гэрээ хэлэлцээр байгуулсан байдаг. Тухайлбал, Монгол Улс болон ОХУ-ын 2000 оны Улаанбаатарын тунхаглал, 2006 онд Москвагийн тунхаглалд тус тус гарын үсэг зурснаар Монгол-Оросын харилцааны мөн чанарыг стратегийн түншлэлийн хэмжээнд тогтоох, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай 2009 оны тунхаглал болон 2019 онд Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ тус тус байгуулсан байна.

Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээний аравдугаар зүйлд “Талууд бие биедээ нээлттэй эдийн засгийн бодлого явуулж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг, үүний дотор эдийн засгийн онцгой бүс байгуулж ажиллуулах, түүнчлэн энэ чиглэлд туршлага солилцох зэргээр хөгжүүлж, мөн хоёр талын худалдааг хурдацтай хөгжүүлэх, бизнесийн болон бусад аж ахуйн үйл ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан хамгаалах, иргэн, үйлдвэр болон эдийн засгийн хамтын ажиллагааны бусад субъектийн хооронд төрөл бүрийн хэлбэрээр хорших болон шууд харилцаа тогтоохыг дэмжинэ. Талууд хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ”¹⁵ гэж тусгасан байна. Стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаа нь бүх талыг хамарсан, тасралтгүй үргэлжлэх, эрчимтэй хөгжих харилцаа гэдэг нь хугацаагүйгээр байгуулсан энэхүү гэрээний дагуу талууд тогтвортой, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэглэснээс харагдаж байна. Тиймээс энэхүү гэрээний хүрээнд дотоодын эдийн засгийн үйлдвэрлэлийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ЕАЭЗХ-той ЧХХ байгуулахаас урьд тавигдах чухал асуудал юм. ОХУ-ын гаалийн тариф болон татварын хураамж зэрэгтэй холбоотой эдийн засгийн хамтын ажиллагааны хууль, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь бидний өмнөх чухал асуудал юм.

Дүгнэлт

ОХУ энэ Холбоог байгуулах санаачилгыг гартаа авч, бусад гишүүнд орон зай, үүрэг саналгүйгээр зөрчилдөөнийг зохион байгуулах, өргөжүүлэх, зохицуулах, шийдвэрлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү интеграцийн үйл явц дахь Оросын манлайлал нь бүх гишүүн оронд таалагдаагүй байж болох ч эсэргүүцэлтэй тулгараагүй юм. Гэхдээ Орос Крымийг эзэлж, зүүн Украин дахь салан тусгаарлагчдын хөдөлгөөнийг дэмжиж, үүний улмаас Барууны орнууд хориг арга хэмжээ авахад ЕАЭЗХ-ны бусад гишүүн орон Москваг дэмжээгүй. Мөн Холбооны тавьсан зорилго, гишүүн орнуудын ашиг сонирхол, зорилтод сул, ялгаатай талууд нэлээдгүй байгаа тул эдийн засгийн интеграцийн хүчин чармайлт үр дүн багатай байна. ОХУ ЕАЭЗХ-ийг улс төр, аюулгүй байдал, стратегийн ашиг сонирхолдоо ашиглахаас гадна Оросын нэр хүнд, манлайллыг дэлхий нийтэд харуулах хэрэгсэл болгохыг хүсэж байгааг үгүйсгэхгүй. Эдийн засгийн интеграцийг хүчтэй дэмжигч Казахстан улс төр, үзэл суртлын болон бусад дарамт шахалтгүйгээр эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын асуудалд илүү анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Казахстаны ЕАЭЗХ-д байгаа гол зорилго нь чөлөөт худалдаа, хөрөнгө, хүний ур чадвар, хөрөнгө оруулалтын чөлөөт хөдөлгөөнийг дэмжих явдал юм. Армен, Беларусь, Киргиз зэрэг жижиг улс эдийн засаг, аюулгүй байдлын хувьд Оросоос хамгийн их ашиг хүртэнэ гэсэн хүлээлттэй байдаг.

Гэсэн хэдий ч Орос энэ чиглэлээр манлайлалд бэлэн биш байгаа нь гишүүдийн дунд хурцадмал байдал, зөрчилдөөн үүсгэхээс гадна янз бүрийн шалтаг гаргаж, гишүүн орнуудад үзүүлэх тусламж болон тэдэнд ашигтай нөхцөл, байдлыг хязгаарладаг байна. Тухайлбал, гишүүн орнууд ОУ-ын дүрэм, бодлогыг дагаж мөрдөх тал дээр давхар стандартыг баримтлуулж байгаад Оросыг буруутгаж байна. ОХУ нь гишүүн орнуудаа Төв Азийн орнуудтай худалдаа хийхэд дотоод худалдааны саад бэрхшээл, хязгаарлалт

¹⁵ file:///C:/Users/MO/Downloads/1510.pdf

тогтоож, ажиллах хүч, хөрөнгө оруулалт, чөлөөт хөдөлгөөнийг хязгаарлаж байна. Үүний зэрэгцээ, Орос өөрөө Холбооны гишүүн улс орнуудтайгаа хууль эрх зүй, эдийн засгийн дүрэм, журмыг дагаж мөрдөхгүй байж ЕАЭЗХ-д элсэх шинэ гишүүдэд хөнгөлөлт амласаар байна. Гэхдээ олон улсын газрын тосны үнийн хэлбэлзлээс шалтгаалсан Оросын эдийн засгийн нөхцөл байдлаас ЕАЭЗХ-ны чадавх шууд хамааралтай байна. Иймээс ЕАЭЗХ-ны өнөөгийн байдал, хэтийн төлөв нь ОХУ-ын олон улсын тавцан дах улс төрийн бодлого, бүс нутаг дахь байр суурь зэргийг харгалзан үзэх нь Монгол Улсын хувьд чухал асуудлын нэг юм.

-
1. Монгол Улсын Үндсэн хууль;
 2. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын тухай хууль
 3. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал;
 4. Монгол Улсын Гадаад бодлогын Үзэл баримтлал;
 5. Н.Батжаргал, “Олон улсын харилцааны орчин үеийн онолын товч тойм”;
 6. Treaty on the eurasian economic union
 7. J. Mendee, Renewed Geopolitical Rivalries: Challenges and Options for Mongolia
 8. Economic Times “US, India, Japan, Australia for ASEAN-led mechanism to promote rules-based order in Indo-Pacific”
 9. <http://www.eurasiancommission.org/en/docs/Lists/List/AllItems.aspx>
 10. Integration process in the Eurasian Economic Union (EAEU): Interstate relations instead of supranationality under the conditions of multipolarity, <https://www.revistaespacios.com/a18y39n11/a18y39n11p11.pdf>
 11. The foreign policy concept of the Russian Federation, <https://fas.org/nuke/guide/russia/doctrine/econcept.htm>
 12. About the Eurasian Economic Commission. (2017). Electronic Resource: <http://www.eurasiancommission.org/ru/Pages/about.aspx>
 13. Allen, R. L. (1963). Review of The theory of economic integration, by Bela Balassa. Economic Development and Cultural Change.
 14. Amr, S.H. (2013). Theories of Economic Integration: A Survey of the Economic and Political Literature. International Journal of Economy, Management and Social Sciences.
 15. The Theory of Economic Integration. Homewood, Illinois: Richard D. Irwin. Inc. Google Scholar. Bulatoy, A.S., & Liyentsey, N.N. (2008).
 16. World Economy and international economic relations. Moscow: Magistr, pp. Globalization, economic interdependence and new agreements: trade policy in the era of mega-regionals. German Institute for International and Security Affairs and Konrad-Adenauer-Stiftung.



З.БОЛОР

ҮАБЗ-ийн ССХ-ийн
Шинжээч

ХАГАС ДАМЖУУЛАГЧИЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ГЕОПОЛИТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Abstract: *As one of the most globalized and interdependent industries, semiconductors are not only the drivers of digitalization anything that's computerized such as processors, chips, smartphones, computers, tablets, but it also an important source of medical and military equipment.*

Given its market dominance by a handful of companies in Taiwan, South Korea, and the United States and pandemic influence, the world has been witnessing the shortage of semiconductors and its critical components supply is externally dependent and increasingly vulnerable. The Taiwanese Semiconductor Manufacturing Company (TSMC) which is building semiconductor plants both in US and Japan, found itself at the heart of the intensifying US-China technology rivalry.

Furthermore, the countries are paying more attention to securing their supply chain, providing support through investment and policy, and joint initiatives. This paper aims to assess the semiconductor market, supply chain, policies as well as its leverage on international relations.

Keywords: *Semi-conductor, supply chain, Great power competition, Taiwan*

Оршил

Ухаалаг утас, компьютер, интернэтийн тоног төхөөрөмж зэрэг компьютержсэн бүхий л зүйлд хагас дамжуулагчийг ашиглахаас гадна эмнэлгийн болон цэргийн тоног төхөөрөмжийн чухал эх үүсвэр тул технологийн инновац, эдийн засгийн салбараас гадна улс төр, дипломат харилцаанд нөлөөлж, үндэсний аюулгүй байдалд эзлэх байр суурь улам бүр нэмэгдсээр байна.

Өдгөө Тайвань, БНСУ, АНУ-ын цөөн тооны компаниудын гарт зах зээл төвлөрч, хагас дамжуулагчийн чухал бүрэлдэхүүн хэсгийн нийлүүлэлт гаднаас хамааралтай байх нь

бусдаас хараат, эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байна. Иймээс улс орнууд нийлүүлэлтийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн анхаарч, хөрөнгө оруулалт, бодлогоор дэмжихийн зэрэгцээ хамтран үйлдвэр байгуулах болон санаачилга дэвшүүлэх боллоо.


БНХАУ-ын хувьд дэлхийн зах зээлд харьцангуй бага хувийг эзэлж байгаа боловч чип хэрэглээгээ дотоодоос хангах амбицтай зорилт тавьж байгаа билээ. Нөгөөтэйгүүр, хямд ажиллах хүч, үйлдвэрлэлийг түшиглэн АНУ-ын зах зээл хумигдаж Ази руу шилжиж байна.

АНУ, БНХАУ-ын хооронд салбар бүрд өрсөлдөж буй энэ үед дэлхийн хамгийн том гэрээт чип үйлдвэрлэгч Тайванийн хагас дамжуулагчийн үйлдвэр “TSMC” АНУ-д болон Японд хагас дамжуулагчийн үйлдвэр барьж байгаа нь өрсөлдөөний гол цэг болгож байна. Иймд хагас дамжуулагчийн нийлүүлэлт, зах зээл, холбогдох улс орнуудын баримталж буй бодлого, олон улсын харилцаанд хэрхэн нөлөөлж буйг авч үзлээ.

Хагас дамжуулагчийн хомсдол

Хагас дамжуулагчийг ухаалаг утас, компьютер, таблет, машин, угаалгын машин, телевизор, LED гэрэл зэрэг компьютержсэн бүхий л зүйлд ашигладаг цахилгаан дамжуулагч ¹ билээ. Үүнээс гадна “F-35” сөнөөгч онгоц зэрэг батлан хамгаалахын бүхий л тоног төхөөрөмж, ажиллагаа, харилцаа холбоо, навигацийн системийг хагас дамжуулагчгүйгээр төсөөлшгүй юм.

Зураг 1: Хагас дамжуулагчийн зориулалт (хувиар)



Эх сурвалж: Semiconductor Industry Association, 2020


5G төхөөрөмжүүд болон бусад дэвшилтэт технологи нэвтэрч хагас дамжуулагчийн эцсийн бүтээгдэхүүн асар хурдацтай хөгжиж, салбарын орлогын дийлэнх буюу 78 хувийг санах ой, логик чип, санах ойн хамгаалалтын нэгж (MPU)-ээс бүрдэж байна.

¹ Merriden Varrall, “The geopolitics of semiconductors, fundamental building blocks of our world”, KPMG, Jun 25, 2021

Дэлхий дахинд чипний эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байгааг чар тахлын улмаас хөл хорионд гэрээс ажиллах, сурах шаардлага гарч, хагас дамжуулагчийн чухал бүрэлдэхүүн хэсгийн нийлүүлэлт хомсдолд орсон. Улмаар автомашин, ухаалаг утас үйлдвэрлэгчид болон бусад салбарын үйл ажиллагаанд нөлөөлж, их хэмжээний алдагдалд оруулжээ. Тухайлбал, хагас дамжуулагчийг захиалаад нийлүүлэх хугацаа 22 долоо хоног болсон бол автомашин үйлдвэрлэгчид гэхэд 2021 онд 7.7 саяар цөөн машин үйлдвэрлэсэн нь 210 тэрбум ам. долларын алдагдалтай ажилласан байна. Урьдчилсан тооцоогоор 2023 он хүртэл хомсдол үргэлжлэх² төлөвтэй байгаа юм.

Ерөнхийдөө хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн хүчин чадлаар Тайванийн “TSMC”, БНСУ-ын “Самсунг”, АНУ-ын “Интел” зэрэг цөөн тооны компанийн гарт төвлөрч ирсэн бол үйлдвэрлэлд нэн шаардлагатай цахиурын нөөцийн дийлэнх буюу 64 хувийг БНХАУ, ОХУ 9 хувь, Япон 7 хувь, АНУ, Норвеги тус тус 5 хувийг нийлүүлдэг.

Зураг 2. Хагас дамжуулагчийн зах зээл



Эх сурвалж: Semiconductor Industry Association, 2020

Түүнчлэн хагас дамжуулагчийн чухал бүрэлдэхүүн хэсгийн нийлүүлэлт гаднаас хэт хамааралтай байх нь аюулгүй байдалд эрсдэл учруулж буй. Үүнд: Нэгдүгээрт, дэлхийд өрсөлдөх үндэсний хүчин чадлын чухал эх үүсвэр технологийн инновац, дэвшил давуу байдал бий болгодог. Хоёрдугаарт, Дэлхийн ДНБ-ы 22.5 хувийг дижитал эдийн засаг бүрдүүлж байгаа бөгөөд 0.4 их наяд ам. долларын зах зээл бүхий хагас дамжуулагчийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж, 2035 он гэхэд 1 их наяд ам. долларт хүрэх аж. Гуравдугаарт, “F-35” сөнөөгч онгоц

зэрэг батлан хамгаалахын бүхий л ажиллагаа, харилцаа холбоо, навигацийн системийн үндсэн суурь³ нь хагас дамжуулагч юм.

Ийнхүү улс орнууд хагас дамжуулагчийн нийлүүлэлтийн сүлжээг хангах чиглэлээр болон дотоодын үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтаа нэмж эхэлсэн.

Олон улсын байдал ба нийлүүлэлт

Хагас дамжуулагчийн зах зээлд өрсөлдөхөд технологийн инновац, нөү хао, чадварлаг хүний нөөц, санхүү зэрэг олон бэрхшээлтэй учирдаг.

Юуны түрүүнд хагас дамжуулагчийн төрөл дотроос процессор, чип тогтмол сайжруулалт буюу аль болох олон транзистрыг цахиур хавтанд багтаахад өрсөлдөх⁴ шаардлагатай болдог. Жишээлбэл, 1990-ээд оны сүүлээр дундаж процессор долоон сая

² JP Morgan, “Supply Chain Issues and Autos: When Will the Chip Shortage End?”, Dec 1, 2021

³ Yoshiaki Takayama, “Semi-conductor supply chains in the era of great power competition”, The Japan Institute of International Affairs, Strategic comments, Oct 25, 2021

⁴ More Moore races

транзистортой байсан бол 2018 онд ухаалаг гар утасны процессор 7 тэрбум транзистораас бүрдэж байгаа нь технологийн дэвшлийг харуулж байна.

Мөн 1990-ээд онд 20 гаруй компани 180 нанометр⁵ үйлдвэрлэж байсан бол өдгөө Тайванийн “TSMC” болон БНСУ-ын Самсунг 5 нанометр чип үйлдвэрлэх чадвартай.

Хүснэгт 1. Хагас дамжуулагчийн зах зээл

		АНУ	БНСУ	Тайвань	БНХАУ	Япон
Зах зээл (%)		4	20	7	9	10
Дизайн		+	+			
Үйлдвэрлэл	Логик чип (нанометр) зэлэх хувь (%)	12 нм 7.8%	7 нм 16%	7 нм, 5 нм TSMC -54.6% 3нм (2024)	14 нм 4.5%	
	Санах ойн чип		65 %			+
	Угсралт	+	+	+		

Эх сурвалж: Холбогдох эх сурвалжаас түүвэрлэн боловсруулав

Цаашид Тайванийн компанид гурван нанометр чип үйлдвэрлэхэд 20 тэрбум ам.доллар шаардагдах бол үүнд ашиглагдах ганц тоног төхөөрөмж 120 сая ам.долларын өртөгтэйгөөс гадна чадварлаг хүний нөөцөд тулгуурласан 600 гаруй үйлдвэрлэлийн үе шатыг дамждаг.

Одоогийн байдлаар хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн дизайнаар АНУ давамгайлдаг бол Тайвань үйлдвэрлэлээр, БНСУ санах ойн чип, Япон түүхий эд, материалаар тэргүүлж байна.

АНУ. Хямд ажиллах хүчийг түшиглэсэн Зүүн Азийн орнууд буюу БНСУ, Тайвань, БНХАУ хагас дамжуулагчийн зах зээлд өрсөлдөх болсноор АНУ-ын зах зээл хумигдсаар⁶ байна. Учир нь АНУ-д хагас дамжуулагчийн үйлдвэр Азийн орноос 30 хувиар илүү зардалтай, үйл ажиллагааг жигдэртэл дор хаяж 10 жил шаардагдах⁷ аж.

Ж.Байден Ерөнхийлөгчийн Засгийн газрын зүгээс хагас дамжуулагчийн асуудалд онцгойлон анхаарч, 50 тэрбум ам.долларын тэтгэмж олгохоос гадна гол компани “Интел” хагас дамжуулагчийн хоёр үйлдвэрт 20 тэрбум ам.доллар хөрөнгө оруулахаар төлөвлөв⁸. 2024 онд АНУ-ын “Интел” Тайванийн “TSMC”-тэй хамтран Аризона мужид таван нанометр чип үйлдвэрлэх бол БНСУ-ын “Самсунг”-тай хамтран Техас мужид⁹ гар

⁵ Нанометр нь 0.000000001 метр буюу хүний үсний ширхгийг 100 мянга хуваасантай тэнцэх хэмжээс юм.

⁶ Fact Sheet: Biden-Harris Administration Announcements Supply Chain Disruptions Task Force to Address Short-Term Supply Chain Discontinuities, The White House, June 8, 2021

⁷ Exclusive: Intel Reveals Plans for Massive New Ohio Factory, Fighting the Chip Shortage, The Times, Jan 20, 2022

⁸ Che-Jen Wang, “Time for a ‘Semi-Quad’ Alliance”, The Diplomat, May 28, 2021

⁹ Samsung newsroom, Samsung Electronics Announces New Advanced Semiconductor Fab Site in Taylor, Texas, Nov,

утас, 5G, хиймэл оюун ухаан зэрэг салбарт ашиглах дэвшилтэт технологид суурилсан хагас дамжуулагч үйлдвэрлэж эхлэх юм.

Үүнээс гадна 2021 оны есдүгээр сард АНУ, Австрали, Япон, БНЭУ-ын дөрвөл (Quad)¹⁰-ийн хоёр дахь удаагийн дээд хэмжээний уулзалтаар хагас дамжуулагчийн нийлүүлэлтийн аюулгүй байдлыг хангах санаачилгыг дэвшүүлсэн бөгөөд энэ хүрээнд талууд нийлүүлэлтийн эмзэг байдлыг хамтран тодорхойлно гэв. Уг мэдэгдэлд аль нэг улсыг өрсөлдөгч хэмээн заагаагүй ч БНХАУ-ын зүгээс технологийг хууль бусаар дамжуулж¹¹ буйг онцолсон байдаг. Түүнчлэн АНУ-ын Засгийн газар БНХАУ-ын Хуавэй компанийн эсрэг буюу хагас дамжуулагчтай холбоотой технологи, тоног төхөөрөмжийн экспортыг хориглосон билээ.

БНСУ. Санах ойн чипийн зах зээлд 65 хувиар тэргүүлж буй БНСУ байр сууриа бататгаж, Мүн Жэ Ин Ерөнхийлөгч 2021 онд “Хагас дамжуулагчийн К стратеги”¹²-ийг дэвшүүлэв. Энэ хүрээнд 2030 он хүртэл 452 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт¹³ хийх бөгөөд салбарын 36 мянган мэргэжилтнийг сургах, судалгаа шинжилгээний татвараас 50 хүртэлх хувь чөлөөлөх, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зардлыг 10-20 хувь хүртэл бууруулж төрөөс дэмжлэг үзүүлэх аж. Дэлхийд өрсөлдөгч “Самсунг”, “SK Hynix” бусад чипний салбарт¹⁴ тус тус 100 гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулахаар болов.

БНХАУ. Бусад улсаас хамааралтай цөөн салбарын нэг хагас дамжуулагч бөгөөд жил бүр 300 тэрбум ам.долларын хагас дамжуулагч импортолдог ба чипний хэрэглээний 16 хувийг¹⁵ дотоодоос хангадаг. Дэлхийн зах зээлд харьцангуй бага хувийг эзэлсэн хэвээр байна. Тодруулбал, чип үйлдвэрлэлийн 10 хувь, чип дизайны 20 хувь, хагас дамжуулагчийн программ хангамж, материал, хэрэгслийн 1 хувь болон логик чип зэрэг эцсийн бүтээгдэхүүний зах зээлийн 1 хүрэхгүй хувийг эзэлж¹⁶ буй.

Иймд хараат байдлаас ангижрахын тулд нэгд, БНХАУ-ын зүгээс 2014 онд хагас дамжуулагчийн үндэсний санг байгуулсан бөгөөд “Хятадад үйлдвэрлэв” (Made in China) бодлогын хүрээнд 2025 он гэхэд чип хэрэглээний 70 хувийг дотоодоос хангах, 2034 онд импортыг бүрэн орлох амбицтай зорилт тавьсан. Хоёрт, 2020 онд хагас дамжуулагчийн компаниудыг 10 жил татвараас чөлөөлсөн¹⁷. Гуравт, худалдан авах, нэгдэх (M&A) замаар гадаадаас технологи авахаас гадна хувийн хөрөнгө оруулагчдыг татах аргаар хагас дамжуулагчийн салбарт шинэчлэл хийв.

Өдгөө БНХАУ литограф, дэвшилтэт чип үйлдвэрлэлээр хэдэн арван жилээр хоцорч байгаа ба цаашид зорилгодоо хүрэхэд 300 мянган инженер бүхий чадварлаг хүний нөөц

2021

¹⁰ “Fact Sheet: Quad Leaders’ Summit”, The White House, Sep 24, 2021

¹¹ Nikkei Asia, “Quad leaders to call for securing chip supply chain”, Sep 18, 2021

¹² Remarks by President Moon Jae-in at Presentation of K-semiconductor Strategy, The Office of the President, ROK, May 13, 2021

¹³ 半导体产业成韩国战略筹码, 《经济日报》, 2021年5月31日

¹⁴ CNBC, “Governments are deploying ‘wartime-like’ efforts to win the global semiconductor race”, May 17 2021

¹⁵ 张晓兰, 黄伟熔, “制约我国半导体产业资金投入的障碍亟需破解”, 《发展研究》2020年第12期

¹⁶ Christopher A. Thomas, “Lagging but motivated: The state of China’s semiconductor industry”, The Brookings, Jan 7, 2021

¹⁷ “Zero to One: The Rise of China’s Semiconductor Industry”, Dec 1, 2021

шаардлагатай байгаа аж. Тухайлбал, БНХАУ-ын “Х-Epic”, “Amedac” компани нь АНУ-ын “Cadence”, “Synopsys” компанид ажиллаж байсан ахмад мэргэжилтнүүдийг хөлсөлсөн гэх. Нөгөөтэйгүүр, хямд ажиллах хүч, эрх зүйн орчин, бодлогоор дэмжиж буй цагт зах зээлийг тэргүүлэх нь хугацааны асуудал болоод байгаа билээ.

Тайвань. Тайванийн хагас дамжуулагчийн үйлдвэр “TSMC” дэлхийн хамгийн том гэрээт чип үйлдвэрлэгч ба зах зээлийн 55 хувийг, ухаалаг төхөөрөмжийн дэвшилтэт чипийн нийлүүлэлтийн 90 хувийг дангаараа бүрдүүлдэг аж. Дижитал эдийн засгийн эрчимжиж буй энэ үед “Тесла”-гийн цахилгаан машинаас “Apple” компанийн ухаалаг утас, “Амазон”-ы үүлэн тооцоолол хүртэл бүгд Тайваниас хамааралтай байгаа юм.

Хэдийгээр зах зээлд хожуу орсон боловч өөрийн давуу тал болох үйлдвэрлэлээр дагнасан нь дэлхийн топ брендийн гэрээт чип үйлдвэрлэгч болгов. Чипний хомсдол үүсэж байгаа энэ үед АНУ болон Японтой хамтран шинэ үйлдвэр барьж байна. Тодруулбал, АНУ-ын “Интел”-тэй хамтран Аризона¹⁸ мужид таван нанометр чип үйлдвэрлэхээр болсон ба 2024 он гэхэд Тайвань дотооддоо 3 нанометр чип үйлдвэрлэж байх юм. 2021 оны 10 дугаар сард Японы “Sony” корпорацтай хамтран Японд гэр ахуйн хэрэгсэл, машины зарим эд ангид зориулсан хуучин технологиор чип үйлдвэрлэхээр болсон ба мөн л 2024 он гэхэд ашиглалтад орох¹⁹ аж. Япон хагас дамжуулагчийн тоног төхөөрөмж, түүхий эд, сав баглаа боодлын материал болон технологийн салбарт чухал байр суурь эзэлдэг²⁰.

Цаашдын чиг хандлага

Технологийн салбарт ноёрхлын төлөөх тэмцэл үргэлжилж байгаа энэ үед цар тахлын улмаас хагас дамжуулагчийн хомсдолд орсон явдал нийлүүлэлтийн аюулгүй байдлыг хангах хийгээд дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлж, бусдаас хараат байдлаа багасгахыг улс орнууд хичээх боллоо.

Нарийн, төвөгтэй хагас дамжуулагчийн технологи эзэмшихэд инновацын судалгаа шинжилгээ, хөрөнгө оруулалт, түүхий эд, тоног төхөөрөмж, төрийн дэмжлэгээс гадна, хямд ажиллах хүч, чадварлаг хүний нөөц шаардлагатай байдаг. Иймд ойрын хугацаанд БНСУ, Тайвань 5-10 нанометр чип үйлдвэрлэлээр өрсөлдөж, арваас дээш нанометр чип АНУ, БНХАУ, ЕХ болон Зүүн Өмнөд Азийн орнууд түрэн орж ирэх боловч Азид ерөнхийдөө төвлөрөх хандлагатай байна.

АНУ холбоотон, түнш орнуудын хамтаар Энэтхэг номхон далайн бүс нутагт, ялангуяа дөрвөл болон Япон, БНСУ-ын хүрээнд хоёр болон олон талт хамтын ажиллагаагаар хагас дамжуулагчийн нийлүүлэлт, дэд бүтэц, санхүүжилт, оюуны өмчийг хамгаалах, хууль эрх зүйн орчныг чангатгах тал дээр нягт хамтарч ажиллана. Гэхдээ энэ нь АНУ, БНХАУ-ын хоорондын өрсөлдөөний цэг Тайвань болж, улмаар Хоёр эргийн харилцаа (Хятад, Тайвань) хурцадмал байдалд хүрэх эрсдэлтэй.

¹⁸ CNBC, “Inside TSMC, the Taiwanese chipmaking giant that’s building a new plant in Phoenix”, Oct 16, 2021

¹⁹ Chipmaker TSMC hails Japan plant as special case in overseas expansion, The Japan Times, Jan 13, 2022

²⁰ Why TSMC Is Looking to Japan for Its Next Semiconductor Plant, The Forbes, Oct 18, 2021

-
1. Semiconductor Industry Association Factbook 2021
 2. Yoshiaki Takayama, “Semi-conductor supply chains in the era of great power competition”, The Japan Institute of International Affairs, Strategic comments, Oct 25, 2021
 3. Eurasia Group, “The Geopolitics of Semiconductors”, Sep 2020
 4. Lee, Kleinhans, “Taiwan, Chips and Geopolitics: Part 1”, The Diplomat, Dec 10, 2020
 5. Che-jen Wang, “Time for a ‘Semi-Quad’ Alliance”, May 28, 2021
 6. Merriden Varrall, “The geopolitics of semiconductors, fundamental building blocks of our world”, KPMG, Jun 25, 2021
 7. “Geopolitics and the push for ‘made in the USA’ semiconductors, The East Asia Forum, May 19, 2021
 8. 陈梦洁, 半导体产业政策梳理及展望, 证券研究报告策略研究, 2021年2月
 9. 谭笑间, “为什么拜登的半导体新政无法成功”, 《世界知识》2021年第13期
 10. 张晓兰, 黄伟熔, “制约我国半导体产业资金投入的障碍亟需破解”, 《发展研究》2020年第12期
 11. 半导体产业成韩国战略筹码, 《经济日报》, 2021年5月31日
 12. 陈溪, “中美半导体之”, 2021年03月16日

ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Ц.ДАВААДОРЖ
Судлаач,
доктор, профессор



Д.ЭНХСАЙХАН
Докторант

ҮНДСЭН ХУУЛЬТ БАЙГУУЛЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ТҮҮНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛҮҮД

Abstract: The issue of strengthening the constitutional establishment is becoming increasingly important as Mongolia's external and internal security environment is rapidly changing, and the nature, sources and triggers of threats are becoming more diverse and complex, and the approach to global security and the ways to ensure it are gaining new content.

The key to having a national security is to have an internal security as a priority. In particular, the technology used by foreign countries to weaken the country's internal institutions, including the constitutional establishment, is not outdated, but is developing with a new context and form. There is a need to strengthen the constitutional establishment and ensure immune internal security in order to withstand current and future challenges, in this globalized world where it is very difficult for a small country to survive under strong external influences. Since the security of the constitutional establishment is a national value, it is our fundamental national interest to protect the values. The policy to protect the interest is one of the fundamental policies of the state.

The purpose of this paper is to analyze the factors that negatively affect the constitutional establishment and its constituent issues, the current and potential risks, and to scientifically determine the state policy based on modern security studies to create the necessary, sufficient and guaranteed conditions.

Keywords: national security, constitutional establishment, national unity, security, internal security, risk

XX зууны эхэн үеэс Монголын ард түмэн тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний төлөөх тэмцэл эхэлж, 1950 он хүртэл тусгаар тогтнолоо бэхжүүлэн хамгаалах үйл явц өрнөж, улмаар шинэ тулгар социалист улс орныг бэхжүүлэн цогцлоох, үндэсний аюулгүй байдал гэхээсээ улсыг аюулаас хамгаалах зайлшгүй нөхцөлүүдийг бүрдүүлэх үе шат 1990 он хүртэл явагдсан. Энэ үед социалист төр, коммунист дэглэмийн аюулгүй байдлыг хангахыг чухалд үзэж, ард иргэдийн амьжиргаа, эдийн засгийн хөгжлийг хангахуйц хүрэлцээтэй нөхцөлийг бүрдүүлж чадаагүйгээс социалист системийн бусад орны хамт гүн хямралд өртсөн билээ.

1990 оноос улс төрийн тусгаар тогтнолоо бүрэн утгаар нь олж авч ардчилсан шинэ улс орон, нийгэм, төрийг цогцлоох, зах зээлийн эдийн засгийн харилцааг бий болгох түүхэн шинэ үе эхэлж, энэ үеэс л улсыг аюулаас хамгаалах асуудлаас төр, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний аюулгүй байдал бүхий үндэсний аюулгүй байдал гэх өргөн хүрээний ойлголт бий болсон юм. Мөн уламжлалт цэрэг, дайны аюул занал, оршин тогтнохуйн аюулгүй байдал гэхээс эдийн засаг, байгаль орчин, мэдээллийн гэх мэт уламжлалт бус аюулгүй байдлыг анхаарах шаардлагатай болсон.

1992 онд батлагдсан Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт анх “үндэсний аюулгүй байдал” гэсэн нэр томъёо тусгагдаж, тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал” гэдгийг томъёолж мөн онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль¹ анх үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл явц эхэлсэн билээ. Улмаар 2001 онд батлагдсан Үндэсний аюулгүй байдлын тухай хууль², 1994 болон 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалууд батлагдаж³ өдгөө ч 28 жилийн турш төрийн бодлогын залгамж чанар, суурь болж байна.

Хэдийгээр ардчилсан төрийн институц, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, байгууллыг бий болгож үндэсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж чадсан боловч тэдгээр нь төлөвшин бэхжиж, учирч буй эрсдэл, бэрхшээлийг даван туулахад хүрэлцэхгүй, өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах хүрэлцээтэй нөхцөл болж чадахгүй байна.

Улс үндэсний аюулгүй байдлыг хангах тулгуур асуудалд тухайн улс дотооддоо аюулгүй байх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой юм. Тодруулбал, гадаад орны зүгээс аливаа улс оронд чиглэсэн бодлого хэрэгжүүлэхдээ тухайн улсын дотоод, тэр дундаа үндсэн хуульт байгууллыг сулруулах технологи хуучраагүй, харин ч шинэ агуулга, хэлбэрээр хөгжиж байна.

Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэхэд төрийн болон улс төрийн институцуудын үүрэг, оролцоо ихээхэн чухал нөлөөтэй. Олон улсын өнөө үед гарч буй өөрчлөлт, Монгол Улсын өнөөгийн хөгжлийн онцлогтой холбоотой үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал улам тулгамдсан шинжтэй боллоо. Үндэсний аюулгүй байдлаа хангаж хөгжих нь улс орны бүрэн эрхт байдлыг гол үндэс сууриа болгодог. Улс орны хөгжлийн өнөөгийн ээдрээтэй үе шатанд Монголын төр үндэсний эрх ашгаа дээдэлсэн бодлого, үйл ажиллагаа явуулах чадвартай байх явдал нь аюулгүй байдлын чухал зангилаа асуудал болжээ.

¹ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, 1992 он

² Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 он

³ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1994, 2010 он

Үндсэн хуульт байгуулал нь сул, үйл ажиллагаа нь тодорхойгүй, төлөвшин тогтоогүй байх зэрэг нь улс орны дотоодод хямралт байдал, зөрчил тэмцлийг бий болгодог тул улс үндэстнийг хэрхэн зөв, аюул эрсдэлгүй хөгжүүлэн авч явах арга ухааны тогтолцоог үндсэн хуульт байгуулал илэрхийлдэг.

Даяаршсан ертөнцөд гаднын хүчтэй нөлөөлөлд жижиг улс оршин тогтнох нэн бэрхшээлтэй байгаа энэ үед үндсэн хуульт байгууллага бататган бэхжүүлж, өнөө ба ирээдүйн сорилтыг тэсэж гарах дархлаа бүхий дотоод аюулгүй байдлыг хангах шаардлага тулгарч байна.

Үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал нь үндэсний үнэт зүйлс болдог тул, үнэт зүйлсийг хамгаалах нь үндэсний язгуур ашиг сонирхол мөн. Уг ашиг сонирхлыг хамгаалах бодлого нь төрийн суурь бодлогын нэг юм.

Энэхүү бүтээлийн зорилго нь үндсэн хуульт байгуулал, түүнийг бүрдүүлэгч асуудлуудад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс, учирч буй болон учирч болох эрсдэлийн шинжилгээг хийж, зайлшгүй шаардлагатай, хүрэлцээтэй, баталгаатай нөхцөлүүдийг бүрдүүлэх төрийн бодлогыг орчин үеийн аюулгүй байдал судлалд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлоход оршино.

1. Үндсэн хуульт байгууллын талаарх ойлголт

Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэхийн тулд эхлээд үндсэн хуульт байгуулал гэх нэр томъёог тодорхойлох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, бататган бэхжүүлэх объектоо тодорхойлох шаардлага зүй ёсоор гарч ирнэ.

Үндсэн хуульт байгуулал гэж үндсэн хуулиар хамгаалсан нийгэм, эдийн засаг, улс төр,эрх зүйн харилцааны тогтолцоо гэж онолын талаас тодорхойлсон байдаг. Товчхондоо, улс үндэстнийг хэрхэн зөв, аюул эрсдэлгүй хөгжүүлэн авч явах арга ухааны тогтолцоог үндсэн хуульт байгуулал илэрхийлдэг.⁴

Үндсэн хуульт байгууллыг төрийн байгуулалтай адилтгаж болохгүй, төрийн байгуулал бүр үндсэн хуульт байгуулал биш, харин үндсэн хуульт байгуулал бүр төрийн байгуулал байдаг гэж тодорхойлсон байна.⁵

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын 2010 оны үзэл баримтлалд “Дотоод аюулгүй байдал”-ын бүрэлдэхүүн хэсгийг боловсруулахдаа Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, хууль ёс, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс болох агуулгад тулгуурласан.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндсэн хуульт байгууллыг дотоод аюулгүй байдлыг хангах асуудлын чухал бүрэлдэхүүн гэж үзэж учирч болзошгүй, эрсдэл, түүнээс сэргийлэх даван туулах арга замуудыг тодотгож өгсөн байдаг. Үүнд:

⁴ Д.Адъяабазар “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны дүн шинжилгээ” эмхэтгэл, 118 дугаар хуудас

⁵ Үндсэн хуульт байгуулал <http://ru.wikipedia.org/wiki/конституционныйстрой>

1. Монгол Улсын үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.1).
2. Нутаг дэвсгэрийн хуваарь, сонгуулийн тогтолцоог үндэсний нийтлэг ашиг сонирхол, улс үндэсний нэгдмэл хөгжлийн зорилгод нийцүүлнэ. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.2).
3. Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авахыг завдсан аливаа оролдлоготой шийдвэртэй тэмцэнэ. Энэ чиглэлд иргэнийг сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулж, сонгууль хараат бусаар явагдах нөхцөлийг хангана. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.3).
4. Гадаадын аливаа хүчний зүгээс Монгол Улсын сонгуулийн үр дүнд нөлөөлөх оролдлого гаргахаас сэргийлэх, илрүүлж таслан зогсоох эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бэхжүүлнэ. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.4).
5. Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институт хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.5).
6. Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангана. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.6).

Иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх үзэл санааг дээдэлсэн хараат бус, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлнэ. Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх эдийн засгийн баталгаа бий болгоно. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.7).

2. Үндсэн хуульт байгуулалд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд

Үндсэн хуульт байгуулал, үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдлыг алдагдуулах үйл ажиллагаа дэлхий нийтэд өрнөж байна. Аливаа улс орныг гадаад, дотоодын хүчнээс эрхшээлдээ оруулахын тулд үндсэн хуульт байгууллыг нь сулруулах, сонгуулийн бус аргаар төрийн эрхийг олж авах арга замыг сүүлийн үед сонгох болсон. Өөрөөр хэлбэл, цэрэг зэвсгийн хүчээр дайн тулаанаар эзлэн түрэмгийлдэг жишиг хуучирч “ухаалаг” технологиор холбогдсон иргэдийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирах замаар удирдан чиглүүлэх “удирдлагатай хаос” технологи хэрэглэж, “өнгөт хувьсгал”, “хосолмол дайн” гаргаж байна.

“Өнгөт хувьсгал”: Ихэвчлэн улс төрийн сэдлээр нийгмийн сэтгэл зүйг удирдах, мэдээллийн орон зайг ашиглан олон нийтийн санаа бодолд нөлөөлж итгэл үнэмшлийг төрүүлэх нь өнгөт хувьсгалын нэг хэлбэр гэж судлаачид үздэг.⁶ Энэ төрлийн хувьсгалыг зохион байгуулахад зориулж “Өнгө, цэцэг, таних тэмдэг (уриа), цахим Hashtag”-ийг бүтээж ашиглана. “Өнгөт хувьсгал” нь улс орны удирдлагыг огцруулах, улс төрийн нам, төрийн бус байгууллага, сөрөг хүчнийг ашиглан сонгуулийн үр дүнг өөрчлөх, иргэдийн сэтгэл зүйг аливаа хэлбэрийн тэмцэлд бэлтгэх, төв талбай, олон нийтийн газруудад

⁶ Васильев.М.В. “Цветные революции” угроза современного мира <https://ppt-online.org/embed/361669>

нийтийг хамарсан цуглааныг зохион байгуулах зэрэг урьдчилсан төлөвлөсөн, шат дараалсан үйл ажиллагааг өөртөө багтаана.

Олон улсад 2000 оноос хойш нийт 24 өнгөт хувьсгал болсон бөгөөд дээрх бүх шинжийг агуулсан байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Өнгөт хувьсгал гарсан улс орнуудын жагсаалт

д/д	Улсын нэр	Өнгөт хувьсгалын оноосон нэр	Он	д/д	Улсын нэр	Өнгөт хувьсгалын оноосон нэр	Он
1	Югослав	Бульдозер	2000	13	Тунис	Жасмин, Арабын хавар	2010
2	Гүрж	Сарнай	2003	14	Египет	Цагаан, Арабын хавар	2011
3	Украин	Улбар шар	2004	15 16	Йемен	Кофе, Арабын хавар	2011
4	Ирак	Ягаан	2005	17	БНХАУ	Жасмин цэцэг	2011
5	Киргизстан	Алтанзул	2005	18	ОХУ	Цас	2011
6	Ливан	Арцат мод	2005	19	Украин	Майдан	2014
7	Кувейт	Цэнхэр	2005	20	Македон	Өнгөлөг	2016
8	Беларусь	Жинс	2006	21	Армен	Хамба хилэн	2018
9	Мяньмар	Сафрон лам нар	2007	22	Ливан	Х сар	2019
10	Иран	Ногоон	2009	23	Болив	Питита	2019
11	Молдав	Усан үзэм	2009	24	Беларус	Шаахай	2020
12	Киргизстан	Тарвас	2010				

“Хосолмол дайн”: Цэргийн болон цэргийн бус талбарт хослон явагдаж, цэрэг, улс төр, нийгэм, эдийн засаг, кибер орчин, оюун санааны бүх чиглэлд, бүс нутаг дамнан, нарийн төвөгтэй, цогц ажиллагаа хэлбэрээр зарим улс орны төр, төрийн бус бүлэглэл, этгээдүүд өдөөн, хөтлөн явуулж байна.

Түүх, соёл иргэншил, нийгмийн сэтгэлгээний хувьд ойр, дотно байсан орнуудын хувьд улс хоорондын зөрчилдөөн үүсэж, ялангуяа иргэний дайн болох үед хосолмол дайны арга замыг сонгох нь тохиромжтой хэрэгсэл болж байна. Олон нийтийн сэтгэл санаанд нөлөөлөх, жагсаал, цуглаан өдөөж тогтворгүй байдал бий болгож тухайн улсад дотроос нь аюул үүсгэж байна. Тухайлбал, стратегийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд хөрш орнууддаа хүч, эрх мэдлийн элдэв арга хэрэгслийг ашиглан хосолмол дайны үйл ажиллагааг нээлттэй зарласан дайны хэмжээнд явуулж байна.

Украины жишээ заналхийлэгч улстай нягт холбоотой, дотно харилцаатай, илүү их харилцан хамааралтай байх тусам хосолмол дайнд өртөх эрсдэл их байдаг нэгэн чухал уялдааг харуулж байна⁷.


Улс үндэстнийг дотоодын зөрчил тэмцлээр нь өдөөж удирдлага, залуургүй болгох энэхүү шинэ түрэмгийллээс хамгаалах гол баталгаа нь үндсэн хуульт байгууллаа бэхжүүлэх, хамгаалах асуудал нэн тэргүүн зэргийн ач холбогдолтой болоод байна.

⁷ www.niss.gov.mn

Засаглалын хямрал: Ардчилсан тогтолцоо, чөлөөт зах зээлийн систем нь манай улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, цаашдын хөгжлийн суурь хэдий ч олон намын систем, шашин шүтлэг, угсаатны үзлээр нийгэм талцалд орж байна. Төлөөллийн зарчимд тулгуурласан ардчилсан тогтолцоог гажуудуулж ард түмний хууль тогтоох, шийдвэр гаргах, хяналт тавих, баялгийг хуваарилах, зарцуулах эрх мэдлийг өөртөө авсан улс төр, бизнесийн “элит” давхарга үүсэж, Үндсэн хуульд заагдсан ард түмний оролцох, хүртэх эрхийг зааглаж байгаа нь даамжирвал нийгмийн тогтцын, ангийн зөрчлийн хэлбэрт хүргэх эрсдэлтэй байна.

Улс төрийн тогтолцооны талаарх иргэдийн санаа бодлыг Монгол Улс парламентын засаглалтай байгааг хэр тохиромжтой болох талаар асууж эхэлсэн. Ингэхэд 41.4 хувь нь эерэг, 36.5 хувь нь сөрөг хариулт өгч, 22.1 хувь нь хариулж мэдэхгүй байв⁸.

График 1. Парламентын засаглал тохиромжтой байгаа эсэхэд иргэдийн өгөх үнэлгээ



Гаднын оролцоо хэт нэмэгдэх, эдийн засгийн эмзэг, хараат байдал. Монгол Улсын нийт гадаад өр ДНБ-ий 58.9 хувьд хүрсэн. Монгол Улсын эдийн засаг БНХАУ-ын эдийн засгаас шууд болон шууд бус хамааралтай байдаг. 2019 оны нэгдсэн дүнгээр Монгол Улсын гадаад худалдааны 64.1 хувь /экспортын 89 хувь, импортын 44.6 хувь/ БНХАУ-аас шууд хамааралтай байна. АНУ-ын нийслэл Вашингтон хотод төвтэй “Хэритэйж” сангаас гаргасан дэлхийн 180 улс орон болон засаг захиргааны тусгай бүсийг хамруулсан “Эдийн засгийн эрх чөлөөний индекс-2020” судалгаанд Монгол Улс 100 онооноос 55.9 оноо авч 127 дугаар байрт жагссан байна.

Өөрийн орны онцлог, уламжлал, зан заншилд суурилаагүй, эрх зүйн зохицуулалтыг хуульчилж байна. Үндэсний язгуур ашиг сонирхол, уламжлал, зан заншилд суурилаагүй, нутагшуулах боломжгүй эрх зүйн зохицуулалтыг өөр бүлээс зээлдсэн, хөрсөн дээр бууж, амьдралд хэрэгжих боломжгүй, хүчээр тулгасан зохицуулалт бүхий хуулийн төсөл хэлэлцүүлэхээр санаачилж байгаа нь тодорхой асуудлуудад гаднын оролцоог нэмэгдүүлж байна.

Ард иргэдийн бухимдал нэмэгдэж байна. Эрх мэдэл, баялгийн хуваарилалтын төлөөх тэмцэл улам ширүүсэж, үүндээ бэлэнчлэх сэтгэлгээ ядуурал, нийгмийн давхаргын хэт ялгааг улс төрийн зорилгоор ашиглан ард иргэдийг намын харьяалал, газар нутаг, шашин шүтлэгээр нь талцуулан үндэсний эв нэгдлийг алдагдуулах хандлага гарахаар байна

Эдийн засгийн нөхцөл байдал улам хүндэрч, төгрөгийн ханш эрс унаж орлого буурч, ажилгүйдэл нэмэгдэн төр, засгийн амлалтыг биелэхийг ард иргэдийн зүгээс хүлээх хүлээлт, төрийн үйл ажиллагаа хоёрын хоорондох зааг ялгаа ихсэж, ядуурал, ажилгүйдэл, шударга бус байдал зэрэг нийгмийн асуудал шийдэгдэхгүй байгаа нь иргэдийг итгэл алдрах бухимдахад хүргэж байна.

⁸ “Максима консалтинг” судалгааны байгууллагын судалгаа

Иргэдийн бухимдал гүнзгийрч, төрд итгэх олон нийтийн итгэл ихээхэн алдарч, нийгмийн салбар бүрд шахуу эрх ашгаа хамгаалуулсан хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд⁹ үүсэн бий болж, төрийн бодлого шийдвэрийг эсэргүүцэх, шүүмжлэх, газар нутгаа болон тодорхой бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалах зэргээр улс төрийн зорилготой үйл ажиллагаа идэвхжиж байна. Нийгмийн халамжийн үр ашиг муутай өнөөгийн тогтолцоо нь ард иргэдийг ядуу байлган хандиваас хамааралтай, бэлэнчлэх сэтгэлгээтэй болгож байна.

Ард иргэдийн дунд санааг зовоосон асуудлууд, стресс, бухимдлыг тодруулахын тулд нийгэмд болон өөрт нь тулгамдаж байж болзошгүй хамгийн түгээмэл асуудлуудын жагсаалтыг гаргаж тус бүрээр нь хаалттай хэлбэрээр үнэлүүлж, дүнг доорх хүснэгт 2-т үзүүллээ. Ингэхдээ тус бүр хоёр түвшний эерэг болон сөрөг үнэлгээ бүхий нийт дөрвөн бүлэгт хувааж, асуудал бүрийн хоёр сөрөг үнэлгээний нийлбэрээр эрэмбэлэн жагсаасан¹⁰.

Үүнээс харахад иргэд өөрсдийн нийгэм-эдийн засгийн байдал (үнийн өсөлт, эдийн засгийн хямрал, валютын ханшийн өсөлт, ажилгүйдэл зэрэг 94.6-86.8 хувь), түүнчлэн эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлсэд (хүнсний аюулгүй байдал, амьдрах орчны бохирдол, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг 88.0-83.0 хувь) хамгийн ихээр санаа зовж буй нь харагдаж байна. Байгаль орчны бүрэн бүтэн байдал 81 хувьтай. Авлига, тусгаар тогтнол, улс төрийн тогтвортой байдал, нийгмийн шударга ёс, хуулийн хэрэгжилт болон хүний эрх, эрх чөлөө зэрэг улс төрийн шинжтэй асуудлуудын иргэдийн санааг зовоосон байдал 84.4-66.2 хувьтай байх ба ингэхдээ маш ихээр санааг зовоож буй байдлын хувь нь авлигыг (47.7 хувь) эс тооцвоос 35.7-22.4 хувьтай нэлээд буурч байна. Харьцуулахад өмнөх асуудлуудын ижил үнэлгээ 54.7-41.8 хувьтай байв.

Хүснэгт 2. Нийгэмд болон өөрт тулгамдаж буй асуудлуудын талаарх санаа зовнил

	Асуудлууд	Сөрөг нийлбэр	Маш их санаа зовж байна	Ер нь санаа зовж байна	Нэг их санаа зовохгүй байна	Надад ер нь хамаагүй	Хари улж мэдэхгүй байна	Эерэг, мэдэхгүйн нийлбэр
1	Бараа бүтээгдэхүүн үнийн өсөлт	94.6%	54.7%	39.9%	3.3%	0.3%	1.8%	5.4%
2	Эдийн засгийн байдал/хямрал	91.6%	55.6%	36.0%	3.4%	0.8%	4.2%	8.4%
3	Хүнсний аюулгүй байдал	88.0%	51.2%	36.8%	7.3%	0.6%	4.1%	12.0%
4	Амьдрах орчны аюулгүй байдал (утаа, агаарын бохирдол, хөрсний бохирдол)	87.9%	54.7%	33.2%	8.8%	0.8%	2.5%	12.1%

⁹ Улсын бүртгэлийн мэдээллийн санд 2019 оны байдлаар нийт 22074 төрийн бус байгууллага бүртгэлтэй байгаагаас 19131 нь нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, 2943 нь гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна. Нийт төрийн бус байгууллагын тоо нь 2018 оныхоос 2281 төрийн бус байгууллагаар өссөн байна.

¹⁰ “Максима консалтинг” судалгааны байгууллагын судалгаа

5	Валютын ханшийн өсөлт	87.8%	54.9%	32.9%	4.2%	1.4%	6.6%	12.2%
6	Нийгмийн ёс суртахууны доройтол	86.9%	44.1%	42.8%	7.0%	1.3%	4.8%	13.1%
7	Ажлын байрны хүрэлцээ (ажилгүйдэл)	86.8%	47.8%	39.0%	8.8%	1.6%	2.8%	13.2%
8	Авлига, хээл хахуулийн асуудал	84.4%	47.7%	36.7%	7.0%	3.3%	5.3%	15.6%
9	Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	84.3%	35.1%	49.2%	9.2%	1.4%	5.1%	15.7%
10	Эрүүл мэндийн үйлчилгээ	83.0%	41.8%	41.2%	12.3%	1.0%	3.7%	17.0%
11	Байгаль орчны бүрэн бүтэн байдал (уул уурхайн сөрөг нөлөөлөл, цөлжилт)	81.4%	45.0%	36.4%	7.3%	1.9%	9.4%	18.6%
12	Тогтвортой орлогоо хадгалах нь	79.1%	34.4%	44.7%	12.2%	1.3%	7.4%	20.9%
13	Улс орны тусгаар тогтнол	78.9%	35.7%	43.2%	12.5%	1.3%	7.3%	21.1%
14	Улс орны улс төрийн тогтвортой байдал	75.3%	30.6%	44.7%	12.8%	2.5%	9.4%	24.7%
15	(Хувийн) зээлийн эргэн төлөлт	73.9%	38.0%	35.9%	15.6%	5.1%	5.4%	26.1%
16	Нийгмийн шударга ёс хадгалагдах эсэх	71.8%	26.2%	45.6%	14.3%	3.4%	10.5%	28.2%
17	Хуулийн хэрэгжилт	71.3%	28.3%	43.0%	15.3%	3.4%	10.0%	28.7%
18	Бизнес эрхлэх боломж байгаа эсэх	68.0%	24.4%	43.6%	16.4%	4.2%	11.4%	32.0%
19	Чанартай боловсрол олох боломж	67.3%	23.3%	44.0%	22.1%	2.9%	7.7%	32.7%
20	Хувь хүний эрх, эрх чөлөө	66.2%	22.4%	43.8%	22.4%	3.0%	8.4%	33.8%
21	Орон байрны асуудал	65.5%	31.7%	33.8%	24.3%	5.0%	5.2%	34.5%
22	Гаднын хөрөнгө оруулалт саарч байгаад	61.1%	20.6%	40.5%	18.7%	5.3%	14.9%	38.9%
23	Олон улсын байдал /дайн, мөргөлдөөн, дүрвэгсэд ...	48.8%	17.0%	31.8%	25.0%	11.2%	15.0%	51.2%
24	Бусад	4.5%	2.0%	2.5%	0.2%	0.2%	-	-

Иргэд сэтгэл зүйн хувьд дээрх олон асуудалд санаа зовнихын зэрэгцээ (ингэхдээ юун түрүүнд амьжиргааны болон амьдрах орчны асуудалд) тэдний дунд бухимдсан байдал нэлээд тархмал байгаа нь дараах хоёр графикаас харагдах ба ингэснээр нийлбэртээ стрессийн түвшин нэлээд өндөр байна гэж үзэж болохоор. Тодруулбаас, өөрийгөө ямар нэг

хэмжээнд бухимдалтай байдаг гэж гуравны хоёр нь (64.2 хувь) үзэж, харин орчин тойрноо 80 хүртэл хувь нь бухимдалтай, ингэхдээ гуравны нэг нь бүр маш их бухимдалтай байна гэж үнэлсэн байна. Гэхдээ чанарын судалгаа болон бусад ажиглалтын дүнтэй харьцуулан үзэхэд респондент өөрийгөө “бухимдсан” гэж тодорхойлох нь нь зайлшгүй бухимдал гэсэн тодорхой эмоцйн томъёолол бус, харин юун түрүүнд дургүйцэл, түүнчлэн зэвүүрхлийн тодорхойлолтод илүү нийцэж байгаа нь тогтоогдсон. Тиймд маш их бухимдалтай гэсэн өөрийн (18.9 хувь) болон орчны (33.4 хувь) үнэлгээ бодит бухимдлын хэмжээг илэрхийлж байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй.¹¹

График 2. Бухимдлын үнэлгээ- өөрийн



График 3. Бухимдлын үнэлгээ – эргэн тойрны



Өмнөх үзүүлэлтийг хянахын тулд дараах илүү тодорхой асуултаар дахин үнэлүүлсэн юм. Ингэхдээ тус бүр гурван эерэг, гурван сөрөг хариултаас хоёр хүртэл хариулт сонгох боломжтой байсан бөгөөд сөрөг үнэлгээний нийлбэр 98.6, эерэг үнэлгээний нийлбэр 36.7 хувь буюу өмнөх хоёр асуултын хариултын адил эерэг-сөргийн харьцаа 1:3 гарлаа.

Цахим шинэ технологи ашиглаж хуурамч мэдээллийг зориудаар түгээн, олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлж байна. Монгол хүн эх нутагтаа оршин байгаа хэдий ч мэдээллийн шинэ ертөнц, шинэ орчинд амьдарч байна. Мэдээлэл харилцааны технологийн дэвшилээс үүдэн хүмүүсийн оюун санаа, амьдралын хэвшилд өөрчлөлт орж байна. Мэдээллийн хэрэгсэл ашиглан хувь хүний оюуны дархлаа, үндэсний эв нэгдэл, ухамсарт нөлөөлөх эрсдэлүүд үүсэж байна. Мэдээлэл өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил, дэвшилд нөлөөлөх чухал хүч болсон тул энэ баялгийг эзэмших шинэ тэмцэл өрнөж, мэдээллийн шинэ дайн чимээгүй явагдаж үр дүн нь Хойд Африк, Ойрх Дорнод, Украинд болсон үйл явдлаас харагдаж байна. Дэлхийн улс орны фейсбүүкийн платформ судалгаанд улс төрийн зорилгоор хуурамч хаягаар хяналтгүй мэдээ, мэдээлэл дамжуулдаг орны судалгааг гаргаж, энэхүү асуудалд анхааралдаа авч ажиллахгүй байгаа улс орны дунд Монгол Улсыг хамааруулсан байна.¹²

Монгол төрийн залгамж чанар алдагдах: Засгийн газрын насжилттай тэнцүү хугацаагаар төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт тогтмол өөрчлөгддөг. Үүнээс болж төрийн байгууллагуудын бүтэц үр өгөөж муутайгаар өргөжиж, төсөв зардал нэмэгдэх, улс төрийн томилгоо хүрээгээ хальж хүний нөөцийн бодлого үгүй болсноос төрийн мэргэшсэн, чадварлаг алба хаагчдын хүрээ хумигдаж, төрийн алба хаагчдын ёс зүй, ажил гүйцэтгэх чадамж доройтсон зэргээс иргэдийн төр, хууль ёсоо дээдлэх үзэл

¹¹ “Максима консалтинг” судалгааны байгууллагын судалгаа

¹² <https://www.theguardian.com/technology/2021/apr/12/facebook-fake-engagement-whistleblower-sophie-zhang>

алдагдахад хүрч байна. Иргэдээс төрийн үйлчилгээ авахдаа тэнд алба хаагчдын ёс зүй, харилцаа, чадварт нэн бухимдах, төр засгийн үйлчилгээний арга барилыг шүүмжлэх, төрийн алба хаагчдыг үл тоомсорлох хандлага хурцаар илрэх болсон.

Судалгаа тооцоогүйгээр үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудыг нэгтгэх, нийлүүлэх зэргээр бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж байгаа нь аюулгүй байдлыг хангах тогтолцооны хийдлийг бий болгож үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна. Бүтэц, зохион байгуулалт, удирдлагын өөрчлөлт, улс төрийн намуудын оролцоо, хууль эрх зүйн тооцоо судалгаагүй өөрчлөлт зэргээс шалтгаалан мэргэшсэн төрийн албаны хүний нөөцийн бодлого алдагдаж байна. Сонгуулийн үр дүнгээс хамаарч Төрийн нарийн бичгийн даргаас эхлээд үйлчилгээний албан хаагчийг оролцуулан дийлэнх нь солигддог. Энэ нь тодорхой улс төрийн намд өсөрхөх, төрийн байгууллагад талцал хуваагдлыг бий болгох, хамгийн гол нь боловсон хүчний чадамжид ноцтой хохирол учруулж байна.

Үндэсний эв нэгдэл алдагдах эрсдэл: Монгол Улсын үндэстний аюулгүй байдалд хор хохирол учруулдаг хамгийн бодитой, хамгийн том аюул бол эв нэгдэл алдрах явдал юм.

Монгол Улсын хүн ам нь улс төр, эдийн засаг, шашин шүтлэг, гадаадын соёлын түрлэг, бүлэглэлүүдийн өрсөлдөөн, баян, ядуугийн ялгаа, нутгархах үзэл, баялгийн шударга бус хуваарилалт зэргээр сөргөлдөх, хуваагдах хандлага ажиглагдаж байна. Хүйтэн дайны дараа улс орнуудын “хэн байх”-ын төлөөх хэв шинжийг өрсөлдөөн явагдаж жижиг буурай орон, соёл иргэншил бусдын, “даяаршлын” нөлөөнд замхран сарниж эхэлсэн. Хэв шинжийн хямрал бараг бүх орнуудыг хамарч байгаа гэж С. Хантингтон¹³ хэлсэн байдаг.

Монгол Улсад бүртгэлтэй шашны¹⁴ болон төрийн бус байгууллагын тоо олширч байгаа нь тэдний үйл ажиллагаа үндэсний эрх ашигт харшилсан, зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, санхүүжилт нь ил тод бус байгаа нь гадаадын төрийн болон шашны байгууллагын бодлогыг хэрэгжүүлэх, үндэстэн дамнасан гэмт хэргийн шалтгаан нь байж болзошгүй юм.

Төрөөс үндэсний эв нэгдлийг хангах бодлого хэрэгжүүлэхдээ юуны өмнө нийгмийн бүлгүүдийн адилсал, нэгдэл, бие биеэ хүлээн зөвшөөрөх эрмэлзлийг бий болгоход анхаарах шаардлагатай байна.

Дүгнэлт

Үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх нь төрийн болон улс төрийн институцуудын гол чиг үүрэг хэдий ч даяаршлын эринд нэг улс орноос шалтгаалах зүйл багасаж, олон улсын нөхцөл байдал улс төрөөс ихээхэн хамаарах болов.

¹³ С. Хантингтон, Столкновение цивилизаций, М., 2003, 15 х.

¹⁴ Монгол Улсын Улсын бүртгэлийн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан 546 шашны байгууллага байна. Үүнээс: 232 нь буддын шашны, 270 нь христ шашны, 27 нь исламын шашны, бусад шашны 17 байна. Улсын бүртгэлийн шинэчилсэн бүртгэлд хамраагаадгүй 191 шашны байгууллага байгаагаас 115 нь буддын шашны 50 нь христ шашны, 22 нь исламын шашны, бусад шашны 4 тус тус байна.

Төр, иргэн, нийгмийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, үндэсний ашиг сонирхол, үнэт зүйлс, хэв шинж, түүний эрэмбийг нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд нарийвчлан тогтоож ард түмэн, төр засаг нь зөвшилцөлд хүрч тууштай баримталж, үндэсний эв нэгдлийг гадаад, дотоод сөрөг хүчин зүйлсийн эсрэг дархлаатай, тогтвортой байлгах хүрэлцээтэй нөхцөлүүдийг бүрдүүлээгүй байна.

Үндсэн хуульт байгуулал, үндэсний эв нэгдэл, тогтвортой хөгжил, тэнцвэртэй байдлыг урт хугацаанд бий болгож, үндэсний нэгдмэл үзэл санаа, зорилго бүхий улс үндсийг (nation building) цогцлоох, үндэсний аюулгүй байдлыг баталгаатай хангах нөхцөл бүрдээгүй байна.

Даяаршил, ардчилал нэг талаас хөгжил, дэвшлийг авчирсан боловч үндэсний өөрийн онцлог, хэв шинж, тухайн улсын төрт ёсны түүхэн уламжлал, соёл, үнэт зүйлстэй зөрчилдөж, хумигдуулж байсан.

Харин өнөөгийн дангааршлын энэ ээдрээт гадаад, дотоод нөхцөл байдалд улс үндэстнүүд, улс орнууд өөрийн байр суурь, үндэсний язгуур ашиг сонирхол, үндэсний үнэт зүйлсийг тууштай баримтлахгүй бол нийгмийн тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэй байна.

Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх эсхүл түүнийг сарниулахад гадаад, дотоод улс төр, эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн олон хүчин зүйлс, эрсдэлүүд нөлөөлж байгаа нь судалгаанд харагдсан.

Энэ эрсдэлүүдийг үндсэн хуульт байгууллын нөлөөлөл, эрсдэл тохиох магадлалыг үнэлж, “Максима”, “Стратегийн судалгааны хүрээлэн”-ийн нийгэм, социологийн судалгаанд тулгуурлан хийсэн болно.

.....

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хууль
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
3. “Стратеги судлал” сэтгүүл
4. С.Хантингтон “Иргэншил хоорондын мөргөлдөөн”
5. С.Хантингтон, Столкновение цивилизаций, М., 2003
6. Васильев.М.В. “Цветные революции” угроза современного мира



Д.ЭНХМАА (Ph.D)
ҮАБЗ-ийн Ажлын албаны
Хэлтсийн дарга

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГЭЭС

Хураангуй. Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.”, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.” гэж, 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш таван жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тус тус заасны дагуу Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлсэн.

Түлхүүр үг: Хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж, хүртээмж, бодлогын шинжилгээ, үнэлгээ

Удиртгал

УИХ-аар Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалыг 2010 оны долоодугаар сарын 15-ны өдөр баталсан. Энэхүү Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалын 3.4 дэх бүлгийн 3.4.2-т “Хүнсний аюулгүй байдал” гэсэн дэд бүлгийг шинээр томъёолж өгснөөр хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн бодлогын чиглэл, стратеги тодорхой болсон.[1] Улмаар 2012 онд хүнсний чиглэлийн суурь хууль болох

¹ Монгол Улсын Их Хурал 2015 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг баталж салбарын эрх зүйн шинэчлэлийг хийж эхэлсэн.

Хүнсний тухай хуулийн 4 дүгээр зүйл. 4.1-д зааснаар хүнс нь хүний эрүүл мэндэд шаардлагатай шим тэжээллэг найрлагатай байх; хүний эрүүл мэнд, амь насанд гэм хор учруулахааргүй байх; хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх зарчмыг баримтлах зарчмаар хүнсний аюулгүй байдлыг хангана.[2] Мөн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах; үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэхийг хуульчилсан байна.[1, 6]

Хүнсний тухай хуульд үнэлгээ хийснээр уг хуулийн зохицуулалт нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэгжилтийн байдал хангалтгүй бөгөөд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг тогтоох замаар хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тогтоох юм.

Судалгааг бодлогын шинжилгээ хийх онолын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар 12.1.6 дахь хэсэгт “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу² Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг илрүүлэх, харьцуулан үнэллээ.[9]

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэсэн.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийсэн.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлын зорилго, үр дүн

Үнэлгээний ажлын зорилго нь Хүнсний тухай хуулийн хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох замаар хүнсний хангамж, аюулгүй байдал алдагдаж хүн амын дунд хоол, хүнсний хомсдолд өртсөн байдал, хоолны хордлого, халдварт өвчин гарсан тохиолдол, давтамж, түүний шалтгаан, улмаар хүн амын эрүүл мэндэд хохирол учруулсан байдлыг судлан тогтоож, хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, үүн дээр үндэслэн шаардлагатай тохиолдолд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх явдал юм.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь үнэлэх бөгөөд Хүнсний тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтоож Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын³ 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж, тогтоож чадах шалгуур үзүүлэлтийг үе шатанд харгалзуулан сонгосон.

² Хууль тогтоомжийн тухай хууль

³ www.legalinfo.mn

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Хүнсний тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн ба хэрэгжсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтоолоо. Үүнийг харьцуулах тоо баримт нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, статистик, шүүхийн шийдвэр, судалгааны бүтээл зэрэг байсан.

Хүнсний тухай хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар мөн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтоолоо.

Үнэлгээний ажлын үр дүнгээс

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан бөгөөд хүнсний аюулгүй байдлыг хүнсний хангамж, хүртээмж, хүнсний баталгаат байдал ба шимт байдлаар тодорхойлдог.[1]

Монгол Улсын жилийн эцсийн суурин хүн амын тоо 2020 онд 3253.3 мянга, жишсэн хүн амын тоо 2630.0 мянга болж, суурин хүн амын тоо өмнөх оноос 56.3 мянган хүн буюу 1.8 хувиар, жишсэн хүн амын тоо өмнөх оноос 46.5 мянган хүн буюу 1.8 хувиар тус тус өссөн байна. [ХАБ] Нийт хүн амын 67.3 хувь нь хотод, 32.7 хувь нь хөдөө байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.6 хүн ногдож байна.[22]

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг 2015 оноос эхлэн жил бүр Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг болсон.[4] Манай улсын хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2020 оны байдлаар тооцож үзвэл, улсын хэмжээнд жилд нийтдээ 182.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 153.6 мянган тонн сүү, 172.8 мянган тонн сүүн бүтээгдэхүүн, 96.0 мянган тонн гурил, 172.8 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 48.0 мянган тонн будаа, 31.7 мянган тонн сахар, чихрийн зүйл, 115.2 мянган тонн төмс, 249.6 мянган тонн хүнсний ногоо, 38.4 мянган тонн буурцагт ургамал, 192.0 мянган тонн жимс, жимсгэнэ, 19.2 мянган тонн өндөг, 22.1 мянган тонн ургамлын тос, 9.6 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна [10]

Монгол Улсын хувьд хүнсний хангамжаа дотоодын үйлдвэрийн болон импортын хүнсээр бүрдүүлдэг.

Дотоодод 2020 онд улсын хэмжээнд 1 сая тонн сүү, 649.1 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 244.3 мянган тонн төмс, 235.3 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 126.5 мянган тонн сахар, чихрийн зүйл, 121.2 мянган тонн хүнсний ногоо, 8.5 мянган тонн өндөг, 1.6 мянган тонн жимс, жимсгэнэ, 0.2 мянган тонн цөцгийн тос үйлдвэрлэсэн байна. Хүн амын хэрэгцээнд 2020 онд улсын хэмжээнд 1 сая тонн сүү, 647.8 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 262.6 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 244.3 мянган тонн төмс, 199.5 мянган тонн хүнсний ногоо нийлүүлсэн байна. [10]

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр 97.0, төмсөөр 100.0, гурилаар 98.3, хүнсний ногоогоор 60.7 хувийг тус тус хангаж байна.

Улсын хэмжээгээр 2021 оны эцэст, мал тооллогын урьдчилсан дүнгээр 67.3 сая толгой мал, үүнээс 4.3 сая адуу, 5.0 сая үхэр, 454.0 мянган тэмээ, 31.1 сая хонь, 26.5 сая ямаа тоологдсон. Манай улсын хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд нэг ямаа ногдож, зохистой харьцааг хадгалж байсан. Гэвч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой энэ уламжлалт харьцаа алдагдсаар 30 гаруй жил болж байна.[23]

Улсын хэмжээнд 2021 онд нийт 675.1 мянган га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оноос 87.2 (14.8 хувь) мянган га-аар өссөн байна. Нийт тариалсан талбайн 432.6 (64.1хувьд) мянган га-д үр тариа, 108.3 (16.0 хувь) мянган га-д таримал тэжээл, 21.4 (3.2хувь) мянган га-д төмс, 11.2 (1.7 хувь) мянган га-д хүнсний ногоо тус тус тариалсан байна. [24]

Инфляцын түвшнийг нэмэгдүүлж байгаа нэг шалтгаан бол хүнсний импорт юм. Үндэсний статистикийн мэдээгээр 2019 онд нийт гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр 47.4 хувь⁴ импортоор 52.6 хувиар бүрдүүлж байсан нь манай улсын хувьд хүнсний хангамж талаасаа хүнсний бие даасан байдал алдагдсан, хангамж тогтворгүй байдалтай байсан. Харин хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийн урьдчилсан тооцоогоор 2020 оны байдлаар авч үзэхэд хүнсний хангамжийн 53.4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 46.6⁵ хувийг импортоор бүрдүүлж байгаа нь хүнсний бие даасан байдал эрсдэлтэй түвшинд шилжсэн эерэг үзүүлэлт гарч байна. Гэхдээ энэ нь Дэлхий дахинд үүсээд байгаа Ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор үүсэж буй өөрчлөлт юм.

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтээр 2020 онд хүнсний хангамжид эзлэх импортын хувь хэмжээг тооцоход манай улс загас болон шувууны махыг 98.5 хувь, төрөл бүрийн будааг 100, жимс жимсгэнийг 96.4, өндгийг 49, ургамлын тосыг 99.9, сахар, чихрийн зүйлийг 34.4 хувийг тус тус импортолсон байна.[10]

Хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээс таримал ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хамаарал их байна. Хэдийгээр хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл сайжирч импортын хэмжээ буурч байгаа ч импортын хамааралтай байсаар байна.

Хүн ам, орон сууцны тооллогын 2020 оны дүнгээр Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын 84.0 хувь буюу 2685.5 мянган хүн шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээс ундны усаар хангагдаж байна. [7]

Хүнсний хангамжийг гурван түвшнээр илэрхийлдэг байдаг. Үүнд: импорт 10-25 хувь бол “хүнсний бие даасан байдал” хангагдсан; импорт 25,0-50 хувь бол “хүнсний бие даасан байдал” эрсдэлтэй; импорт 50,0-хувиас илүү бол “хүнсний бие даасан байдал” алдагдсан гэж үздэг байна.

⁴ УСХ-ны Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2019

⁵ УСХ-ны Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд урьдчилсан тооцоогоор 2020

Хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь импортын хамаарлыг тооцвол мах, гурил, сүү, буудай, төмсний хэрэгцээний хангалтаар хүнсний баталгаат байдлын “бие даасан”, хүнсний ногоо, өндгөөр “эрсдэлтэй”, харин төрөл бүрийн будаа, чихэр, жимс, жимсгэнэ, ургамлын тос, загасны махны хувьд импортоос хамааралтай хүнсний бие даасан байдал алдагдсан түвшинд байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан 2019 оны хүнсний аюулгүй байдал ба хоол тэжээлийн шимт байдлын түвшний тайланд (SOFI) Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлын талаарх нэг л мэдээлэл орсныг дурдвал бага болон дундаас бага орлоготой орны хувьд импортын хамаарал маш өндөр байна гэж дүгнэсэн байна. [31]

Иймд манай орны гол нэрийн хүнсний хангамжийн бие даасан байдлыг хангах зорилгоор хүнсний импортын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн дотоодын хүнсний үйлдвэрлэлийг төрийн зүгээс дорвитой дэмжих ялангуяа хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааг нь дэмжих, татварын дарамтаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт хийх нэн шаардлагатай байна.

Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP)-өөс гаргадаг “Өлсгөлөнгийн зураглал”-аар Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын түвшин 2020 онд 21.3 хувь буюу улбар шар, 2021 онд 6.1 хувь буюу ногоон зэрэглэлд үнэлэгдсэн. Нэг жилийн дотор манай улсын хүнсний аюулгүй байдалд ийм том өөрчлөлт орж чадахгүй. Тэгвэл энэхүү өөрчлөлтийн гол шалтгаан нь уг зураглалд оруулсан анхны өгөгдлийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын ХХААБ-тай хамтран шинэчлэн боловсруулсантай холбоотой юм. [30]

Олон улсын хэмжээнд хэрэгжиж буй “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын хүрээнд хүнсний аюулгүй байдлын шалгуур хоёр үзүүлэлт байдаг байна.[29] Үүний нэг үзүүлэлт нь хоол тэжээлийн дутлын хэмжээ, хоёр дахь үзүүлэлт болох хүн амын дундах хүнсний баталгаат байдал алдагдсан хувь хэмжээг үндэсний түвшинд хүнсний тэнцлээр тооцохоор заасан⁶ боловч манай улсын хувьд хүнсний тэнцлийг тооцон гаргадаггүй учир дээрх хоёр шалгуур үзүүлэлт гарах боломжгүй байгаа.

ӨНЭЗС-аар жишсэн нэг хүний хүнсний бодит улсын дундаж хэрэглээг авч үзэхэд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цөцгийн тос, сахар, чихрийн зүйлийг улсын дунджаас давж, буурцагт ургамлыг улсын дунджийн хэмжээнд хэрэглэж байна. [10]

Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, будаа, төмс, сахар, чихрийн зүйлийн хүртээмж хангалттай, бусад хүнсний бүтээгдэхүүний хүртээмж хангалтгүй буюу дутагдалтай байна. Хүн амын хүнсний хэрэгцээ нь үндсэндээ мах, махан бүтээгдэхүүн, сүү, гурил зонхилон хангагдсан хэвээр байна.

Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээг улсын дундаж бодит хэрэглээтэй харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, будаа зонхилон хангагдсан хэвээр байна. Харин жимс, жимсгэнэ, хүнсний ногооны хүртээмж хангалтгүй байна.

⁶ Food Security and Nutrition around the World in 2019

Судалгааны үр дүнгээр, бодитойгоор гарсан жишсэн нэг хүний хоногт хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийн хэмжээ нь жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах ёстой илчлэг, шим тэжээлийн нормоос давсан байна. Харин жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн хэмжээ хот, хөдөөд харилцан адилгүй байна.

Хотын хүн амын хүнснээс авах тосны хэмжээ физиологийн түвшнээс бага, хөдөөд хүнснээс авах илчлэг, уураг, тос, нүүрс усны илчлэг нормоос давсан байна. [10]

Хүнсний хүртээмжтэй байдлыг тодорхойлоход хүн амын дундах ядуурал, амьжиргааны түвшин, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, цалин, орлогын хэмжээ, төрийн зүгээс үзүүлж байгаа хөнгөлөлт, тэтгэмжийн байдлаас шууд хамааралтай болно.

Статистикийн мэдээгээр ядуурлын хамралтын түвшин 2016 онд 29.6 хувь, 2018 онд 28.4 хувь ядуурлын гүнзгийрэлт 7.2 хувь, ядуурлын мэдрэмж 2.7 хувьтай байсан бол 2020 онд 27.8 хувь болж буурсан байна.[16] Ажилгүйдлийн түвшин 2020 оны дүнгээр 7.0 хувьтай байна.[25]

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д заасан “...амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүн”-ийг мөн хуулийн 22 дугаар зүйлд заасан “...гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн”-ийг хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамруулахаар заасан.[8]

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2018 онд 263 мянга, 2019 онд 242 мянга, 2020 онд 242 мянга, 2021 онд 167 мянган иргэнийг тус тус хамруулсан байна. [15]

Хоол, хүнснээс нэг хоногт авах шимт бодис болон илчлэгийн хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээндээ хүрэхгүй байгаа талаар 2017 онд хийсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний V дугаар судалгаагаар манай хүн амын дундах амин дэм, бичил элементийн дутал өндөр хувь хэмжээтэй гарсан. Энэ нь өнөөгийн нийгмийн байдал, ядуурал, ажилгүйдэл, эрүүл зөв хооллолтын талаарх хэрэглэгчийн боловсрол дутмаг зэрэг хүчин зүйлээс хамааралтай гэсэн дүгнэлт гарсан байна.[11] Ялангуяа ядуу болон нэн ядуу хүн амын дотор хоол, хүнсний хомсдол бодитой оршиж байна гэж үзэж болохоор байна.

Хүн амын амьжиргааны доод түвшний 2020 онд мөрдөх хэмжээг аргачлалын дагуу хэрэглээний үнийн индексээр индексжүүлэн тооцсон байна. Хүн амын амьжиргааны доод түвшнийг хөдөлмөрийн хөлс, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, халамжийн хэмжээг тогтоох, төрөөс иргэдэд эд, мөнгөний тусалцаа үзүүлэхэд жишиг үзүүлэлт болгон хэрэглэдэг.[28]

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 2020 оны статистикийн мэдээгээр үйлчилгээний салбарт 677153, хөдөө аж ахуйн салбарт 257584, үйлдвэрлэлд 235719 иргэд ажиллаж байна.[25]

Манай улсын ажил эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь 2021 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Тухайлбал, мал тооллогын 2021оны урьдчилсан дүнгээр 305.4 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Малчдын тоо өмнөх оноос 6.6 мянган малчнаар буюу 2.2 хувиар өссөн дүн гарсан байна. Нийт малчдын 180.4 мянга буюу 59.1 хувь нь эрэгтэй, 125.0 мянга буюу 40.9 хувь нь эмэгтэй малчид байна. Малчдын дотор эрэгтэй малчид давамгайлж байна. [23]

Газар тариалангийн салбарт тариалан эрхэлдэг нийт 17.5 мянган өрх, 1.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна. [24]

Өрхийн амьжиргаанд нөлөөлж байгаа гол хүчин зүйлийн нэг нь өрхийн орлого юм. Үндэсний статистикийн хороо нь ӨНЭЗС-ны мэдээллээс улирал бүр өрхийн сарын дундаж орлого, зарлагын мэдээллийг тооцож гаргадаг.

Өрхийн сарын дундаж бодит нийт орлогын хэмжээ 2020 онд 1.2 сая төгрөг болж, өмнөх оноос 108.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэг өрхийн сарын мөнгөн орлого, оны үнээр 2020 онд улсын дунджаар 1.4 сая төгрөг болж, өмнөх оноос 163.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. [20]

Өрхийн орлогыг хот, хөдөөгөөр нь авч үзвэл, хотод 1.5 сая төгрөг, хөдөөд 1.2 сая төгрөг байгаа нь хотынхны орлого хөдөөгийнхөөс 232.2 (18.7 хувь) мянган төгрөгөөр илүү байна.[27]

Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцээр авч үзэхэд 2020 онд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүд сарын дундаж мөнгөн зарлагынхаа гуравны нэгийг хүнсний зүйлд зарцуулж байхад хамгийн их зарлагатай бүлгийн өрхийн сарын дундаж мөнгөн зарлагынхаа тавны нэг хүрэхгүй хувийг хүнсний зүйлдээ зарцуулж байна.

Өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлагыг задалж нэр төрлийг авч үзэхэд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүдийн хүнсний зарлагын 63.3 хувийг мах, махан бүтээгдэхүүн, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүд мах, махан бүтээгдэхүүн, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүнд хүнсний нийт зарлагынхаа 51.8 хувийг зарцуулж буй боловч мөнгөн дүнгээрээ хамгийн бага зарлагатай бүлгийнхээс дунджаар 2.6 дахин их мөнгө зарцуулж байна.

Мал тооллогын 2021 оны дүнгээр нийт малтай өрхийн 76.6 хувь буюу 188.6 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 7.6 мянга буюу 4.2 хувиар өслөө. [23]

Малчин нэг өрхөд ногдох малын тоо 2021 онд дунджаар 323 болж, өмнөх оноос 9 толгой мал буюу 2.7 хувиар буурсан байна. Малчин нэг өрхөд 20 адуу, 23 үхэр, 2 тэмээ, 150 хонь, 128 ямаа ногдож байна. Өмнөх оноос малчин нэг өрхөд ногдох үхэр нэгээр өсөж, ямаа есөөр буурч, адуу, тэмээ, хонь өөрчлөлтгүй байна.

Мал тооллогын 2021 оны дүнгээр малчин өрхийн 81.6 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 74.2 хувь нь телевизортой, 54.7 хувь нь автомашинтай, 49.0 хувь нь мотоциклтой байна гэсэн статистикийн мэдээ гарсан. Нийт малчдын 39.4 хувь нь буюу 120.4 мянган малчин зээлтэй байна⁷. Нийт малчдын 35.2 хувь буюу 107.4 мянган малчин нийгмийн даатгалд хамрагдаж байна.

Үндэсний хэмжээнд манай улс таван жил тутам “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний судалгаа хийдэг. Судалгааны дүнгээр нийт өрхийн 35 хувь нь хүнсний хангамжийн баталгаат байдал хэвийн хангагдаж байна. Харин нийт өрхийн 14 хувь хүнсний хангамжийн баталгаат байдал бага алдагдсан, 28 хувь нь дунд зэрэг алдагдсан, 23 хувьд ноцтой алдагдаж, өлсгөлөнгийн байдалд байгаа судалгааны дүн гарсан боловч

⁷ Үндэсний статистикийн мэдээ- 2019

манай улсын 15-49 насны эрэгтэйчүүдийн 49, эмэгтэйчүүдийн 46 хувь илүүдэл жин ба таргалалттай байгааг тогтоосон⁸. [11]

Гаднаас нь харахад Монгол хүн таргалан цатгалан байгаа мэт боловч амин дэм, эрдэс бодисын дуталд орсон буюу манай улсын хүн ам хоол, хүнсний далд өлсгөлөнд нэрвэгдэх эрсдэлтэй байдалд байна.

Ядуу эмзэг өрхийн хүн амын хүнсний хангамжийн баталгаат байдал алдагдахаас хамгаалах ялангуяа улирлын чанартай хүнсний хомсдол, байгаль, цаг уурын гамшиг бэрхшээлийн үед тэдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг авах шаардлагатай байгаа тул Засгийн газраас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хууль эрх зүйн орчны хувьд зарим нэг хуулийн зохицуулалт нь цогц байдлаар шийдэгдэж чадаагүй. Тухайлбал, Хүнсний тухай хуулийн есдүгээр зүйлийн 9.3-д “Хүнсийг баяжуулах, найрлагыг нь зохицуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан боловч 2018 онд зөвхөн “Баяжуулсан хүнсний тухай” хуулийг баталсан. Ингэснээр хүнсний найрлагыг зохицуулах асуудлыг орхигдуулж хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах суурь нөхцөл бүрэн хангагдах боломжгүй байгаа.

“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгааны дүнгээр өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд шаардлагатай шим тэжээллэг найрлагатай байж чадахгүй байна нөгөө талаас тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн дунд хүнс хүртэх боломж хязгаарлагдмал байдалтай байгаа харагдаж байна.

Хүнсний тухай хуульд заасан “хүнс нь хүний эрүүл мэнд, амь насанд гэм хор учруулахааргүй байх” гэсэн зарчим хангагдаж байгаа эсэхэд дүн шинжилгээг хийхэд 2016-2020 оны байдлаас харахад 2018 онд хоол хүнсээр дамжих өвчин хамгийн их буюу өвчний дэгдэлт 20 удаа бүртгэгдэж 624 хүн өвчилсний 263 буюу 42.1 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, хүний амь нас эрсдээгүй байна. 2019 онд хоол хүнсээр дамжин өвчилсөн хүний тоо хамгийн их байсан байна. Нийт хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоонд химийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогын дүн ороогүй болно. [10, 14]

Хүснэгт 1. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоо



⁸ “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний V судалгаа

Хоол, хүнснээс гаралтай хордлогот халдварт өвчний дэгдэлтийн тоо сүүлийн таван жилд буурахгүй дүнтэй байгааг дээрх хүснэгтээс харж болно. Харин өвчилсөн хүний тоо буурч байгааг цар тахалтай холбон үзэж байна.

Хоолны хордлогын үед хамтын ажиллагаатай мэргэжлийн байгууллагуудаас гарсан дүгнэлт, шинжилгээний хариу өөр хоорондоо зөрүүтэй байгаа нь байгууллага хоорондын үйл ажиллагаа уялдаа холбоогүй, мэргэжлийн хүний нөөцийн чадавх сул байгаагай холбоотой гэж үзэж байна.

Хүнсний талаарх мэдээлэл ил тод, үнэн зөв, бодит байж чадахгүй байна. Тухайлбал, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан, бүртгэл байхгүй, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох тогтолцоо бүрдээгүй, зөрчил гаргасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч (ХЧҮАЭ)-ийн талаарх мэдээлэл олон нийтэд хаагдмал, зах зээл дээр хуурамч хүнсний бүтээгдэхүүн худалдаалсаар байгаа талаарх мэдээлэл хэрэглэгчдэд хүрч очихгүй байна.

Хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсрол, зохистой хооллолтын талаарх иргэдийн мэдлэг хангалтгүй байна. Иймд хэрэглэгчийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, гэхдээ зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас харахад Хүнсний тухай хууль нь цаг үетэйгээ нийцэж практикт чухал ач холбогдолтой байгаа боловч бодит байдал дээр хууль хангалттай түвшинд хэрэгжихгүй байна гэж дүгнэсэн.

Дүгнэлт

Манай улс хүнсний хангамжаа дотоодын хүнсний үйлдвэрийн болон импортын хүнсээр бүрдүүлдэг. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн 53.4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, 46.6 хувь нь импортын хамааралтай байгаа тул хүнсний хангамж тогтворгүй буюу хүнсний бие даасан байдал эрсдэлтэй гэж үзэхээр байна.[10] Хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь импортын хамаарлыг тооцвол мах, гурил, сүү, буудай, төмсний хэрэгцээний хангалтаар хүнсний баталгаат байдлын “бие даасан”, хүнсний ногоо, өндгөөр “эрсдэлтэй”, харин төрөл бүрийн будаа, чихэр, жимс, жимсгэнэ, ургамлын тос, загасны махны хувьд импортоос хамааралтай хүнсний бие даасан байдал алдагдсан түвшинд байна.

Хүнсний хүртээмжтэй байдлыг тодорхойлоход хүн амын дундах ядуурал, амьжиргааны түвшин, ажилгүйдэл, цалин, орлогын хэмжээ, төрийн зүгээс үзүүлж байгаа хөнгөлөлт, тэтгэмжийн байдлаас шууд хамааралтай. Ялангуяа ядуу болон нэн ядуу хүн амын дотор хоол, хүнсний хомсдол бодитой оршиж байна гэж үзэж болохоор байна. Ядуурлын түвшин буурсан ч олон хүн ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр түвшинд байна. Ядууралд ойрхон хүмүүс аливаа сөрөг хямрал (эдийн засаг, үнэ, уур амьсгал, эрүүл мэнд гэх мэт) үүсэхэд эргээд ядууралд өртөх эрсдэлтэй байдалд байна. Тэгэхээр эдгээр хүмүүсийн хувьд хүнс хүртэх боломж маш хангалтгүй байна.

2017 онд хийсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний V судалгаагаар манай хүн амын дундах амин дэм, бичил элементийн дутал өндөр хувь хэмжээтэй гарч байгаа нь өнөөгийн нийгмийн байдал, ядуурал, ажилгүйдэл, эрүүл зөв хооллолтын талаарх хэрэглэгчийн боловсрол дутмаг зэрэг хүчин зүйлээс хамааралтай гэж үзсэн.

[5] Судалгааны дүнгээр нийт өрхийн 35 хувь нь хүнсний хангамжийн баталгаат байдал хэвийн хангагдаж байна. Харин нийт өрхийн 14 хувь нь хүнсний хангамжийн баталгаат байдал бага алдагдсан, 28 хувь нь дунд зэрэг алдагдсан, 23 хувьд ноцтой алдагдаж, өлсгөлөнгийн байдалд байгаа судалгааны дүн гарсан боловч манай улсын 15-49 насны эрэгтэйчүүдийн 49, эмэгтэйчүүдийн 46 хувь илүүдэл жин ба таргалалттай байгааг тогтоосон.[11]

Хэрэглэгчийн эрх зүйн болон хүнсний талаарх ерөнхий мэдлэг, боловсрол туйлын хангалтгүйгээс хэрэглэгч хариуцлагагүй байна. Мөн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч буюу үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн мэдлэг, боловсрол, ёс зүй, хариуцлагын ухамсар дутмаг байна. /Ялангуяа малчин хүн малынхаа эрүүл мэндийн асуудлыг хариуцахаар хуульчилсан боловч малчид хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байна./

Хүнсний талаарх мэдээлэл ил тод, үнэн зөв, бодит байж чадахгүй байна. Тухайлбал, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, байгууллага тус бүрдээ өөрийн мэдээллийн сантай, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох тогтолцоо хангалттай сайн бүрдээгүй, зөрчил гаргасан ХЧҮАЭ-ийн талаарх мэдээлэл олон нийтэд хаагдмал, зах зээл дээр хуурамч хүнсний бүтээгдэхүүн худалдаалсаар байгаа талаарх мэдээлэл хэрэглэгчдэд хүрч очихгүй байна гэж дүгнэж байна.

Эцэст нь дүгнээд хэлэхэд Хүнсний тухай хуулийн хэрэгжилт хангалттай хэмжээнд явагдсангүй. Ялангуяа хуулийг даган гарах зарим нэг эрх зүйн зохицуулалт дутуу, хяналт, шалгалт явуулах үйл ажиллагаа, тогтолцооны гажуудал, зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулах тогтолцоо бүрдээгүйн улмаас хуулийг хэрэгжүүлэх нөхцөл хангагдаагүй байна. Хүнсний сүлжээнд оролцдог хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид, хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хийдэг улсын байцаагчид мөн хэрэглэгчийн мэдлэг, боловсрол, хандлага зэрэг хүний хүчин зүйл, үйлдлээс шууд хамааралтай хариуцлагын тогтолцоо бас бүрдээгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байлаа.

Цаашид хүнсний хангамж, хүртээмж, хүнсний шим тэжээллэг байдал, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зохицуулалтыг өнөөгийн үүсээд байгаа цар тахлын нөхцөл байдал, хүн амын дундах хүнсний хэрэглээний нэр төрөл нэмэгдсэнтэй уялдуулан суурь хууль болох Хүнсний тухай хуульд зарим нэг зохицуулагдаагүй хүнсний аюулгүй байдлыг хангах цогц тогтолцоо, тээвэр ложистик, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил, дэвшлийг төгөлдөршүүлэх заалтыг нэмж шинэчилсэн байдлаар хуулийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

1.Монгол Улсын хууль тогтоомж

[1] 2010-07-15 ҮАБ-ын Үзэл баримтлал

[2] 2012-12-20 Хүнсний тухай хууль,

[3] 2012-12-20 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох 33 журам, дүрэм, заавар

[4] 2015-01-30 Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

[5] 2015-11-16 “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр,

[6] 2015-11-26 Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого,

[7] Ундны усны хэрэглээний тухай судалгааны тайлан, 2020

[8] 2012-01-19 Нийгмийн халамжийн тухай хууль.

[9] 2015-05-29 Хууль тогтоомжийн тухай хууль

2.Төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээ

[10] Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлт 2015-2020

[11] Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний тавдугаар судалгааны дүн 2017

[12] Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал үндэсний статистикийн мэдээ 2020, 2021

[13] Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн тайлан мэдээ 2019, 2020,2021

[14] Эрүүл мэндийн яамны статистикийн мэдээ-2018, 2019, 2020

[15] Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны тайлан мэдээ -2018, 2019, 2020, 2021

[16] Ядуурлын дүр төрх, Үндэсний статистикийн хороо, 2018, 2019, 2020

[17] Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, Дэлхийн банкны ядуурал ба тэгт байдлын дэлхийн туршлага 2018, 2020

[18] Ажиллагчдын сарын дундаж цалин, 2018, 2019, 2020

[19] Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо 2019, 2020

[20] Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Үндэсний статистикийн хороо 2020, 2021

[21] Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний талаар 2019, 2020, 2021

[22] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Хүн ам” 2020

[23] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Мал аж ахуй” 2020

[24] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Газар тариалан” 2020

[25] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалт, дундаж цалин” 2020

[26] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Хэрэглээний үнэ” 2020

[27] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Ядуурал, өрхийн орлого, зарлагын

дундаж хэрэглээ” 2020

[28] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Нийгмийн даатгал, халамж” 2020

[29] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Тогтвортой хөгжлийн зорилт” 2020

3.Олон улсын тайлан мэдээ

[30] Global Report on Food Crises 2019, 2020, 2021

[31] Food security and Nutrition around the World in 2019

[32] The State of Food and Agriculture 2019, 2020

[33] Asia and the Pacific regional overview of Food security and Nutrition 2018, 2020

4.Веб хуудас

[34] www.legalinfo.mn

[35] www.parliament.mn

[36] www.fao.org

[37] www.ifpri.org

[38] www.unicef.org

[39] www.who.int



Н.УДВАЛ (Sc.D)

Хүний аюулгүй байдлын судлаач

МОНГОЛ ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ХЭМЖҮҮРҮҮДИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА БА АЮУЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Abstract: Human security is one of the key concepts on national security strategy and foreign policy of the national states. The concept is multi-dimensional and interconnected to social development, human development, human rights and wealth. The instruments for measuring human security at national, regional and international levels are available and article mainly focuses on general dimensions of human security. The national states have been facing security challenges in social, economic, political, environmental, health and other aspects. In order to handle these challenges comparative study of international human security, of the threat and the strategic analysis are required for every country.

This article highlights importance of human security for national security and foreign policy, highlights international comparison of human security's general dimensions and provides some results of the threat analysis on these human security dimensions in Mongolia.

Keywords: Human security, Human Development Index (HDI), World Peace Index (WPI), Fragile State Index (FSI), Threat analysis, Security risks and Security vulnerability

Удиртгал

Хүний аюулгүй байдал нь бүх үндэстэн улс, бүс нутаг, олон улсын аюулгүй байдлын амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Аливаа хүн айх аюулгүй, наад захын зүйлээр дутагдах, гачигдахгүйгээр амьдрах нь хүн бүрийн суурь хэрэгцээ, эрхийн асуудал гэдгийг анх удаа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 1994 онд Хүний хөгжлийн илтгэлдээ тусгаж, хүний аюулгүй байдлын үзэл баримтлалыг гарган тавьж, түүний эдийн засгийн, эрүүл мэндийн, хүнсний, хүрээлэн байгаа орчны, улс төрийн, хамтлаг буюу олон нийтийн, хувь хүний

зэрэг 7 хүчин зүйлийг тодорхойлж, улс орнуудын хүний эрх, хөгжил, аюулгүй байдлыг хэмжих Хүний Хөгжлийн Индекс (ХХИ) гэдэг хэмжигдэхүүнийг хэрэглэх болсноор хүний аюулгүй байдал нь улс үндэстэн, бүс нутаг, олон улсын түвшний аюулгүй байдлын чухал хэмжүүр болон хэрэглэгдэж ирлээ ^{1,2,3}.

Хүний аюулгүй байдал нь улс орны хөгжил, хүний эрх, баялагтай салшгүй холбоотой ойлголт юм. Рио де Жанейрогийн Дээд хэмжээний уулзалтаар “хөгжил гэдэг ухагдахуун нь дан ганц эдийн засгийн юм уу санхүүгийн ололтоор хэмжигдэх ухагдахуун биш маш олон хэмжигдэхүүнтэй гэдэг дээр дэлхий улс орнууд зөвшилцөлд хүрсэн. Хөгжлийг дан ганцхан эдийн засгийн утгаар нь авч үзэж болохгүй, хөгжил нь олон талын, тогтвортой, тэгш, оролцоотой, хүртээмжтэй, хүн төвтэй байх ёстой, хэрвээ хөгжил тогтвортой, тэгш байдлыг хангаагүй бол энэ хямрал нь нийгмийн зөрчилд хүргэнэ. Хөгжилд хүрэхээр зорьж байгаа үр дүнг устгана” хэмээн үзсэн ⁴.

Хүний аюулгүй байдлын нэгдсэн тодорхойлолт, хэмжих хэмжүүр, судалгааны арга зүйн талаар олон улсын болон үндэстэн улсуудын түвшинд гарсан янз бүрийн үзэл баримтлал, аргачлал, хэмжүүр байдаг тухай олон жилийн турш судлаачид үзэл бодлоо илэрхийлж онол, таамаглалаа дэвшүүлсээр байна ^{5,6,7,8,9}.

Хүний аюулгүй байдалд нөлөөлөх дээр өгүүлсэн 7 хүчин зүйлээс гадна хүний аюулгүй байдлыг хэмжих Хүний хөгжлийн индекс, Дэлхийн энх тайвны индекс, Эмзэг улсуудын индекс зэрэг улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн байдалтай холбоотой ерөнхий хэмжүүрийг олон улсын түвшинд өргөн ашиглаж байна ^{10,11,12}.

Улс орнууд ажилгүйдэл, ядуурал, өлсгөлөн, гуйланчлал, өвчин, орлогын тэгш бус байдал, нийгэм эдийн засгийн ялгаатай байдал, дайн дажин, улс төр, эдийн засаг, гэр бүлийн зэрэг төрөл бүрийн хүчирхийллээс эхлээд хар тамхи, зэвсэг, хүний наймаа, хүний амь насыг бүрэлгэх гэмт хэрэг хүртэл хүний аюулгүй байдлын янз бүрийн асуудлуудтай нүүр тулж хүний аюулгүй байдлаа хангах томоохон сорилтуудтай тулгарч байна.

Монгол Улс нь хүний аюулгүй байдлынхаа ерөнхий үзүүлэлтүүдийг бусад оронтой харьцуулан судалж, тэдгээр үзүүлэлтэд аюулын, эрсдэлийн, эмзэг байдлын шинжилгээ хийх шаардлагатай байна.

Судалгааны зорилго: Монгол Улсын хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийг бусад улс оронтой харьцуулан судалж, тэдгээрийн аюулын дүн шинжилгээг хийх

Судалгааны зорилтууд:

1. Монгол Улсын Хүний Хөгжлийн Индекс (ХХИ), Дэлхийн Энх Тайвны Индекс (ДЭТИ), Эмзэг Улсуудын Индекс (ЭУИ)-ийг бусад улс орнуудын үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах
2. Монгол Улсын Хүний Хөгжлийн Индекс (ХХИ), Дэлхийн Энх Тайвны Индекс (ДЭТИ), Эмзэг Улсуудын Индекс (ЭУИ)-ийн аюулын дүн шинжилгээг хийх

ХХИ-нь улс орны хүн амын дундаж наслалт, бичиг үсэг тайлагдалт, боловсролын түвшин, амьдралын орлого зэрэг үзүүлэлтээс бүрдсэн хүний амьдралын сайн сайхан байдлын тоо хэмжигдэхүүн юм ^{1,2,3}. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний

хөгжил-2020 илтгэлд шинээр хүний нөлөөгөөр газар дэлхий дээр үүсэн бий болж буй сөрөг нөлөөллийн үзүүлэлтийг нэмж оруулахаар тусгасан. ХХИ-ээр улс орнуудыг дээгүүр, дундаж, доогуур гэж ангилан үздэг^{13,14}.

ДЭТИ-нь тухайн улс орны харьцангуй тайван байдлыг үзүүлдэг үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь улс орны дотоодын зөрчил зөрөлдөөн, хямралд эмзэг байдлын хэмжүүрээр хэмжигддэг. Жил бүр НҮБ-ын гишүүн орнуудыг энэ үзүүлэлтээр үнэлж жагсаадаг^{15,16}.

Харин ЭУИ-нь НҮБ-ын гишүүн орнуудын зөрчил ба уналтын эмзэг байдлыг бэлэн байгаа мэдээлэл дээр үндэслэн 4 бүлгийн 12 шалгуур үзүүлэлтээр жил бүр үнэлж жагсаадаг үзүүлэлт юм^{17,18,19,20}.

Судалгааны үр дүн: Нэг. Монгол Улсын ХХИ, ДЭТИ, ЭУИ-ийг бусад улс орны үзүүлэлттэй харьцуулсан судалгааны үр дүн

1.1. Хүний хөгжлийн индексийн харьцуулсан судалгаа

Улс орнуудын орлогын хэмжээ ба хөгжлийн түвшин нь ХХИ-д шууд нөлөөлдөг хүчин зүйлс юм. Улс орнуудыг өндөр орлоготой, дундаас дээш орлоготой, дундаас доогуур орлоготой, бага орлоготой гэж ангилдаг. Улс орны хөгжлийг харьцуулан судалсан болон Монгол Улсын хөгжлийг олон улсын түвшинд харьцуулсан судалгаанууд нь улс орныхоо хөгжлийг олон төрлийн үзүүлэлтээр бусад улс оронтой харьцуулж харахад үнэтэй судалгаа болсон байна^{21,22}.

График 1. Дэлхийн улс орнуудын ХХИ-ийн түвшний зэрэглэл, хувиар, 2020 он



Дэлхийн улс орнуудын ХХИ-ийн түвшинг их өндөр, өндөр, дунд, доогуур гэж ангилан үзэх бөгөөд дэлхийн улс орнуудаас 59 нь ХХИ их өндөр, 39 нь ХХИ өндөр, 38 нь ХХИ дунд, 5 нь ХХИ доогуур үзүүлэлттэй байна.

ХХИ-ээр их өндөр улс орнуудыг Норвеги, Швецарь, Австрали, Ирланд, Герман улс тэргүүлж байгаа бол хамгийн доогуур ХХИ-ийн үзүүлэлттэй улс оронд Нигер, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Өмнөд Судан, Чад ба Бурунди орж байна²³.

Эх сурвалж: <https://datatopics.worldbank.org/world-development-indicators/the-world-by-income-and-region.html>

График 2. Улс орнуудын хүний хөгжлийн зарим үзүүлэлтийн харьцуулалт, 2020 он



Эх сурвалж: <https://datatopics.worldbank.org/world-development-indicators/the-world-by-income-and-region.html>

Улс нь хамгийн өндөр ХХИ-тэй орон болохын тулд, ХХИ-ийн хүрсэн түвшнээ бууруулахгүйн тулд хир хэмжээний зай байгааг эндээс олж харахыг зорьсон. Дээрх графикаас харахад Монгол Улс нь өндөр ХХИ-тэй орон болоход нэлээд хол байгаа боловч харин ХХИ-ийн үзүүлэлтийн хүрсэн түвшнээ хадгалах, сайжруулах төрийн оновчтой бодлого явуулахгүй бол ХХИ буурах, улмаар хамгийн доод түвшинд хүрэхэд ойрхон байх өндөр эрсдэлтэй байна.

1.2. Дэлхийн Энх Тайвны Индекс (ДЭТИ)-ийн харьцуулсан судалгаа

Хүний аюулгүй байдлыг хэмжих дараагийн хэмжүүр нь Дэлхийн Энх тайвны индекс (ДЭТИ) юм. Энэ индексийг Эдийн засаг ба Энх тайвны институт хэмээх ашгийн төлөө бус тинк танк байгууллагаас жил бүр эрхлэн гаргадаг бөгөөд дэлхийн 163 орныг нийгмийн аюулгүй байдал, дотоод ба гадаадын зөрчил, гэмт хэрэг, улс төрийн тогтвортой байдал, ДНБ-д цэрэг дайны зардлын эзлэх хувь зэргийн 23 шалгуур үзүүлэлтээр тооцож гаргадаг.

График 3. Зарим орны ДЭТИ-ийг харьцуулсан байдал, 2021 он



Эх сурвалж Эдийн засаг ба Энх тайвны институт

Монгол Улс нь 2021 оны байдлаар ДЭТИ-ийн 1.78 үзүүлэлтээр 163 орноос 43 дугаарт байгаа бөгөөд Исланд (1.1), Шинэ Зеланд (1.2), Дани (1.25) улсууд хамгийн энх тайвнаар оршин амьдарч байгаа улсуудыг тэргүүлж байгаа бол Сири (3.3), Емен (3.4), Афганистан (3.6) улс хамгийн их дайн дажин, дотоод гадаадын үймээн самуунтай улс орнуудын тоонд орж байна. Сүүлийн 10 жилийн үзүүлэлтүүд нь дэлхий дахинд хүчирхийлэл нэмэгдэж энх тайван ч байдал багасаж байгааг харуулж байна хэмээн илтгэлд дурджээ ²⁴.


Монгол Улсын ДЭТИ-ийг дэлхийн хамгийн энх тайвнаар оршин амьдарч байгаа эхний 3 улс болох Исланд, Шинэ Зеланд, Дани улсын болон дайн дажин, үймээн самуунтай Афганистан, Емен, Сери улсын үзүүлэлтүүдтэй харьцуулж үзлээ. Графикаас харахад Монгол Улс нь дотоодын эв нэгдлээ бэхжүүлж, нийгэмд шударга ёсыг тогтоож, дотоодын зөрчил зөрөлдөөнийг удирдаж чадвал энх тайвнаар амар амгалан оршин тогтнох улс орон болох бүрэн боломж харагдаж байна.

1.3. Эмзэг улсуудын индекс (ЭУИ)-ийн харьцуулсан судалгаа

Хүний аюулгүй байдалд аюул занал учирч байгаа эсэхийг үзүүлдэг дараагийн үзүүлэлт бол Энх тайвны сан (Fund for Peace-FFP)-гаас эрхлэн гаргадаг The Fragile States Index (FSI) буюу Эмзэг улсуудын индекс юм. Энэ индексийг гаргахдаа нийгмийн уялдаа холбоо, эдийн засаг, улс төр болон нийтлэг шинжтэй гэсэн дөрвөн төрлийн асуудлаар тус бүр гурван шалгуур нийт 12 төрлийн зөрчлийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг ашигладаг бөгөөд эдгээр үзүүлэлт нь цаг хугацааны явцад сайжирч байна уу, дордож байна уу гэдгийг харуулж байдаг ²⁵. Тухайлбал,

- *Нийгмийн уялдаа холбооны шалгуур үзүүлэлтэд* аюулгүйн аппарат, дээд түвшний фракц бүлэглэлүүд, бүлгийн гомдол зэрэг,
- *Эдийн засгийн шалгуур үзүүлэлтэд* эдийн засгийн өсөлт саарах, эдийн засгийн тогтвортой бус, тэгш бус өсөлт, мэдлэг чадвартай, оюуны өндөр чадавхтай хүмүүс гадаад оронд гарах буюу тархи урсах зэрэг,
- *Улс төрийн шалгуур үзүүлэлтэд* төр засгийн хууль ёсны байдал, нийтийн үйлчилгээ, хүний эрх ба хууль сахих байдал зэрэг,
- *Нийгмийн шалгуур үзүүлэлтэд* хүн ам зүйн дарамт, дүрвэгсэд ба дотоод шилжилт хөдөлгөөн,
- *Нийтлэг асуудлын шалгуур үзүүлэлтэд* гадаадаас үзүүлэх арга хэмжээ зэрэг шалгуур ордог.

Зураг 1. Эмзэг улсуудын индекс (ЭУИ)-ийн дэлхийн газрын зураг




Эх сурвалж: <https://fragilestatesindex.org/>

Монгол Улсын ЭУИ-нь 52.3 буюу тогтвор багатай орны тоонд орсон байна²⁵. Монгол Улс нь ЭУИ-ээр тогтвор багатай улсын ангилалд багтахад аюулгүй аппаратын шударга бус ба найдваргүй байдал, дээд түвшний улс төр бизнесийн нам болон үндэстэн дамнасан фракц бүлэглэлүүд, нийгмийн бүлгүүдийн төр засагт итгэл

алдарсан байдал, эдийн засгийн хямрал, тогтворгүй байдал, улс төрийн сонгууль тойрсон хууль бус үйлдэл, эргэлзээ, нийтийн үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал, авлига зэрэг шалгуур үзүүлэлтүүд нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

График 4. Зарим улс орны ЭУИ-ийн харьцуулалт, 2021 он



Хамгийн өндөрт тогтвортой үзүүлэлттэй дэлхийн улс оронд Дани, Шинэ Зеланд, Исланд, Норвеги, Финланд орж байгаа бол хамгийн муу үзүүлэлттэй улс оронд Еймен, Сомали, Сири, Өмнөд Судан, Конга орж байна. Монгол Улсын ЭУИ нь Дани, Шинэ Зеланд зэрэг улсын индексээс 2.7-2.8 дахин бага байгаа нь

анхаарал татаж байна²⁵. Учир нь Монгол Улс ЭУИ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдэд гүнзгий дүн шинжилгээ хийж эмзэг байдлаа бууруулах замаар монгол хүний аюулгүй байдлыг хангах шаардлагатай.

Монгол Улс нь илүү тогтвортой улс болохын тулд аюулгүй байдлын аппаратаа илүү шударга, хараат бус болгох, төрийн бодлогыг дээд түвшний улс төр бизнесийн фракц бүлэглэлүүдийн нөлөөнөөс ангижруулах, төр ард түмний холбоог бэхжүүлэх, эдийн засгаа сэргээж, тогтвортой өсгөх, улс төрийн сонгуулиа шударга явуулах, дотоодын зах зээлээ хамгаалж, ард түмнээ ажил орлоготой болгож хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, нийгмийн үйлчилгээг хүн амдаа тэгш шударга хүргэх, авлигатай тэмцэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хоёр. Монгол Улсын Хүний Хөгжлийн Индекс (ХХИ), Дэлхийн Энх Тайвны Индекс (ДЭТИ),

Эмзэг Улсуудын Индекс (ЭУИ)-ийн аюулын дүн шинжилгээний дүн

Хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийг тодорхойлж байгаа шалгуур үзүүлэлтээс хамгийн их аюулд өртөөд байгааг нь сонгон авч Монгол Улсын хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийн аюулын шинжилгээг хийлээ^{26,27}.

Аюулын шинжилгээг хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрийн бүх шалгуур үзүүлэлтэд хийх учиртай ч эхний удаад ерөнхий хэмжүүр тус бүрээс аль хэдий аюулд өртөөд, нэн даруй аюулгүйн стратеги хэрэгжүүлэх шаардлагатай болсон эхний гурван шалгуур үзүүлэлт буюу бүрэлдэхүүн үзүүлэлтийг сонгон авсан.

Монгол Улсын хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийн аюулын үнэлгээг (I) Хүний аюулгүй байдлын аюулын үнэлгээ (II) Хүний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ (III) Хүний аюулгүй байдлын эмзэг байдлын үнэлгээ гэсэн хэсэгт хуваан судаллаа.

Хүснэгт 1. Монгол Улсын хүний аюулгүй байдлын аюулын дүн шинжилгээ

Хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүд	Учирч болзошгүй аюул заналууд
Хүний Хөгжлийн Индекс	- Боловсролын индекс буурах - Дундаж наслалтын хүйсийн зөрөө нэмэгдэх - Ядуурал гүнзгийрэх
Дэлхийн Энх Тайвны Индекс	- Бүлэглэл хоорондын зөрчил зөрөлдөөн нэмэгдэх - Нийгмийн уялдаа холбоо алдагдах - Үндэсний эв нэгдэл алдагдах
Эмзэг Улсуудын индекс	- Үндэсний язгуур эрх ашиг хохирох - Авлига гүнзгийрэх - Засаглалын хомсдол үүсэх

2.1.1 Монгол Улсын ХХИ-тэй холбоотой хүний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулууд

ҮСХ-ны нээлттэй мэдээллийн сангийн мэдээлэл дээр үндэслэж хийсэн доорх графикт Монгол Улсын 2011-2020 оны ХХИ-ийн түвшин нь жил дутам тасралтгүй өссөөр ирснийг үзүүлж байна²⁸.

График 5. Монгол Улсын ХХИ, 2011-2020 он




(Эх сурвалж: ҮСХ)

Дээрх хүснэгтэд үзүүлсэн ХХИ-ийн сүүлийн 10 жилийн үзүүлэлтийн өсөлтөд хүн амын дундаж наслалт²⁹, нэг хүнд ногдох ҮНО-ын индексийн өндөр өсөлт²⁸ нөлөөлсөн болохыг дараах графикаас харж болно.

ҮСХ-ны нээлттэй мэдээллийн сангийн мэдээлэл дээр үндэслэж Монгол Улсын ХХИ-ийн дундаж наслалтын индекс, боловсролын түвшний индекс²⁸, нэг хүнд ногдох ҮНО²⁸ зэрэг бүрэлдэхүүн индексийг сонгон авч дараагийн хүснэгтэд үзүүлэв.

График 6. Монгол Улсын ХХИ-ийн зарим бүрэлдэхүүн индексүүд, 2011-2020 он



(Эх сурвалж: УСХ)


Хүний хөгжлийн индексүүдээс хамгийн анхаарал татаж байгаа өнгөрсөн жилүүдэд эрс муудсан, сайжрал багатай байгаа үзүүлэлт нь Хүн амын боловсролын түвшний индекс юм. Энэ үзүүлэлт нь 2000-2010 он хүртэл 0.928 байсан бол огцом буурсан 2011 оны үзүүлэлттэй 2018 оны үзүүлэлт нэг түвшинд байна. Энэ нь маш муу үзүүлэлт бөгөөд Монгол Улсын боловсролын чанарын түвшин, хүний нөөцийн чадамж, оюуны сан хөмрөгт ихээхэн хохирол учрах эрсдэл байгааг харуулж байна.

Хэдийгээр манай улсын хүн амын дундаж наслалт нь уртсаж байгаа боловч дэлхийн бусад улс оронтой харьцуулахад дундаж наслалтын хүйсийн зөрөө харьцангуй их байгаа юм³⁰. Энэ зөрөө нь эрэгтэйчүүд ид насандаа нас барах эрсдэлтэй байгааг харуулж тэд эрүүл мэндийн хувьд эрсдэлт бүлэгт орох шалтгаан болж байна. Мөн нэг хүн ногдох ҮНӨ-ын хэмжээ нэмэгдэж байгаа боловч эдийн засгийн хүртээмж муутай өсөлт, ажлын байрны хомсдол, хөдөлмөрийн доогуур үнэлэмж, инфляцын өсөлт, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хязгааргүй өсөлт зэрэг бодитой хүчин зүйлсээс хамаарч хүн амын ядуурал гүнзгийрэх өндөр эрсдэл байна³¹.

Монгол Улсын хүн амын боловсролын индекс буурах, дундаж наслалтын хүйсийн зөрөө нэмэгдэх, ядуурал гүнзгийрэх зэрэг нь ХХИ-д аюул учруулж байна гэж үзэж байна.

НҮБ-ын Хүн ам зүйн газрын 2022 оны мэдээллийн сан дээр үндэслэж зарим улс орны хүн амын дундаж наслалтын байдлыг харьцуулан дараах график дээр үзүүллээ. Дэлхийн 193 орноос Монгол Улс нь хүн амын дундаж наслалтаар 135 дугаарт жагсаж байгаа бөгөөд хүн амын дундаж наслалтаараа Гон Конг, Япон, Масао улс эхний байранд жагсаж хамгийн богино наслалттай сүүлийн байрт жагссан гурван орон нь Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, Ликото улс байна.


График 7. Зарим улс орны хүн амын дундаж наслалт, 2020 он



Эх сурвалж: НУБ-ын Хүн амын газар

Монгол Улсын хүн амын дундаж наслалтын үзүүлэлт нь хүн амын дундаж наслалтаар дэлхийн улс орнуудаас хамгийн өндөр байгаа орнуудтай харьцуулахад 14.5-13.9 жилээр богино, харин дундаж наслалтын үзүүлэлт хамгийн богино байгаа улс орнуудынхаас 16.17-15.8 жилээр урт байна³⁰.

График 8. Зарим улс орны хүн амын дундаж наслалт ба эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрөө, жилээр, 2020 он



(Эх сурвалж: НУБ-ын Хүн амын газар)

Хүн амын дундаж наслалтын үзүүлэлтээс хамгийн анхаарал татаж байгаа асуудал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрөө бөгөөд Монгол Улсын энэ зөрөө нь 8.5 жил байгаа бол ОХУ, Украин, Белорус, Латви, Литви улсын энэ зөрөө манайхаас их байна³⁰. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан тусгаар улс болон Монгол

Улсад энэ үзэгдэл нь нийтлэг байгаа бөгөөд энэ нь ардчилал, зах зээлийн шилжилтийн үед эрэгтэйчүүд ид насандаа олноороо зүй бусаар нас барж байсантай болон эрэгтэйчүүд эрүүл мэндийн хувьд эмзэг бүлэгт шилжсэнтэй холбоотой юм.

2.1.2. Монгол Улсын ДЭТИ-тэй холбоотой хүний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулууд

А) Бүлэглэл хоорондын зөрчил зөрөлдөөн нэмэгдэх аюул

Монгол Улс нь өнөөдөр олон төрлийн ашиг сонирхлын огтлолцол дээр оршин тогтнож байна. Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 35 улс төрийн нам³², аймаг орон нутаг бүрийн эрх ашгийг хамгаалсан 30 нутгийн зөвлөл, банк, санхүү, уул уурхай, газар, барилга, хөдөө аж ахуй, зам харилцаа зэргийн тодорхой салбар хүрээний ашиг сонирхлоор нэгдсэн нам дамнасан 20 гаруй улс төр бизнесийн ашиг сонирхлын албан бус бүлэглэлүүд, 17673 төрийн бус ба иргэний нийгмийн байгууллага³³ байгаа бөгөөд эдгээрээс өөр олон төрлийн ашиг сонирхлын бүлгүүд байна. Эдгээр сонирхлын бүлгүүдийн нөлөө төрийн бодлого, стратегид хүчтэй нөлөөлж үндэсний эрх ашиг, хүний аюулгүй байдлын нийтлэг ашиг сонирхолтой зөрчилдөж байдаг.

Аливаа улс үндэстний төр нь улс орны төлөө, нийтийн төлөө ажилладаг институт юм. Тэнд нийтийн төлөө ажиллах сэтгэл зүрхтэй хүн ажиллаж байж улс орны болон нийтийн эрх ашигт үйлчилж чадна. Харин тэнд хувийнхаа төлөө ажилладаг хүн, ашиг хайгчид орж ажиллах юм бол төр хувьчлагдана. Төрд мэдлэг боловсрол, оюуны чадамж нэн шаардлагатай боловч түүнээс илүү нийтийн төлөө гэсэн сэтгэл зүрхтэй хүн юу юунаас чухал.

Хэрэв төр нийтийн төлөө гэсэн сэтгэл зүрхгүй хүмүүсээр дүүрэх юм бол төрийг костюмтай чөтгөрүүдийн гарт өглөө гэсэн үг. Эндээс төрийн шинэчлэл эхэлнэ. Төр бол хууль тогтоох, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй. Хуулийн засаглалыг хэрэгжүүлэх эхлэл нь эрх ашгийн эрэмбэ юм.

Хүснэгт 2. Эрх ашгийн эрэмбэ буюу нийтийн эрх ашиг³⁴.

Нийтийн эрх ашиг	Бүлэглэл болон хувийн эрх ашиг
Улс орны эрх ашиг	Бизнесийн эрх ашиг
Ард түмний эрх ашиг	Танил талын эрх ашиг
Олон нийтийн эрх ашиг	Бүлгийн эрх ашиг
Орон нутгийн эрх ашиг	Өөрийн эрх ашиг
Нийгмийн эмзэг хэсгийн эрх ашиг	Гэр бүлийн эрх ашиг

Нийтийн ба бүлэглэл, хувийн эрх ашгийн ялгааг дээрх хүснэгтэд харууллаа. Төр хуулиар засаглахдаа улс орны, ард түмний, олон нийтийн, орон нутгийн, нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих ёстой. Эс бөгөөс улс төр бизнесийн бүлэглэл, улстөрчдийн хувийн эрх ашгийг хангах хэрэгсэл болж хувирна. Эндээс бүлгийн сэтгэлгээ гэсэн ойлголт ухагдахуун гарч ирнэ.

Төр нь хуулиар засаглахдаа нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэхэд саад болдог гол зүйл нь бүлгийн сэтгэлгээ юм. Бүлгийн сэтгэлгээ гэдэг нь бүлэг хүмүүсийн үзэл бодол

ба итгэл үнэмшил бөгөөд олон бүлгийн янз бүрийн сэтгэлгээнүүд үндэсний эв нэгдэлд харшилж, төрийн хуулийн нийтийн эрх ашигт үйлчлэх үйлчилгээнд саад болно³⁵. Нийтийн эрх ашгийн төлөө бүлгийн сэтгэлгээ болон хувийн эрх ашгийг хойш нь тавьж удирдаж чаддаг тийм сэтгэл зүрхтэй хүмүүс төрд хэрэгтэй. Бүлгийн сэтгэлгээнээс төрийн албан хаагчийн ёс суртахууны бусдын нөлөөнөөс ангид байх зарчим урган гардаг.

Дээрх эрх ашгаа эрэмбэлж чадаагүйгээс, бүлгийн сэтгэлгээгээ давж чадаагүйгээс, бусдын нөлөөнд хэт автсанаас гэсэн 3 шалтгаанаар монголын улс төрийн хөгжлийн 30 жилд хуулийн засаглал маань захиалгын хууль үйлдвэрлэдэг, олигархиудын явах замыг засдаг, ард түмэнд хүртээлгүй хуулиудыг олноор үйлдвэрлэж, гарсан хууль болгоны дараа нийтийн эрх ашиг, улс орны эрх ашиг, ард түмний эрх ашиг хохирч байдаг нь бараг хэм хэмжээ болсоор ирсэн. Энэ бүхэн бүгд хүний аюулгүй байдлын Монгол Улсын ДЭТИ-д учрах аюулууд хэмээн үзлээ.

Б) Нийгмийн уялдаа холбоо алдагдах аюул

Монгол Улсын үндэсний хэмжээний нийгмийн уялдаа холбоо нь Монгол Улсын иргэн, монгол үндэстэн хүний хувьд хүн бүр улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил дэвшил, монгол хүний аюулгүй байдал, сайн сайхны төлөө гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлс, язгуур ашиг сонирхол буюу нийгмийн капитал дээр тогтоно. Энэ үнэт зүйлс, язгуур ашиг сонирхол тодорхой бусаас, бий болгоогүйгээс, нийгмийн капиталаа бүрдүүлж, холбож, уяж өгч чадаагүйгээс нийгмийн уялдаа холбоо алдагдах аюул учирч байна. Харин оронд нь бүлэглэлийн үнэт зүйлс, эрх ашгийн төлөө монгол хүмүүс олон хэсэг хуваагдан нэгдэж байна.

Нийгмийн уялдаа холбоо нь босоо тэнхлэгээр төр ард түмний холбоогоор, өөрөөр хэлбэл төр засагт итгэх ард түмний итгэлээр хэмжигддэг бол, хэвтээ тэнхлэгээр ард түмний хоорондын ижил төстэй итгэл үнэмшил, харилцан хамаарал, хамтын ажиллагаа, нэгдэл нягтралаар хэмжигдэнэ³⁶. Эдгээр хэмжүүрээр монголын нийгмийн уялдаа холбоог авч үзэх юм бол ард түмний бүх шатны төр засгийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байдаг, ихээхэн шүүмжлэлтэй ханддаг, төрд итгэх тэдний итгэл мэдэгдэхүйц суларч байгаа нь нийгмийн уялдаа холбоо сулрах томоохон шалтгааны нэг юм. Харин иргэд, нам, бүлэглэлийн үнэт зүйлд итгэж үнэмшиж хоорондоо талцан хуваагдаж, өрсөлдөж, өшилдөж, үзэн ядаж, тэмцэлдэж байгаа нь нийгмийн уялдаа холбоо сулрах үндсэн шалтгаан болж байна.

В) Үндэсний эв нэгдэл алдагдах аюул

Үндэсний эв нэгдэл нь шударга ёс дээр тогтоно. Шударга ёс байхгүй улс оронд үндэсний эв нэгдэл байхгүй. Үндэсний эв нэгдлийг нийгэмд шударга ёсыг тогтоож л бий болгоно. Тийм учраас үндэсний эв нэгдэл алдагдаж байгаа шалтгааныг шударга ёсны үзэл баримтлал, хүрээнээс хайх хэрэг гарна.

Хүснэгт 3. Монгол Улсын Шударга ёсны засаглал ба өнөөгийн байдал³³

Монгол Улсын Шударга ёсны засаглал	Өнөөгийн байдал
1.Түгээмэл шударга ёсны засаглал	Үндэсний язгуур эрх ашигт харшлах Үндэсний үнэт зүйлийн баримжаагүй Үүрэг, хариуцлагын нэгдэлгүй
2. Нийгмийн шударга ёсны засаглал	Шударгаар адил тэгш боломж бүрдүүлээгүй Шударгаар амьдрах, ажиллах боломж хомс Шударгаар нийгмийн үйлчилгээг хүртэх боломж хязгаарлагдмал
3.Эд баялгийн шударга ёсны засаглал	Шударгаар үндэсний эд баялгаа тоолж үнэлээгүй Шударгаар үндэсний эд баялгаа бүтээх боломж хомс Шударгаар үндэсний эд баялгаа захиран зарцуулах, хуваарилах боломж хязгаарлагдмал
4.Хүн хүчний шударга ёсны засаглал	Шударгаар мэдлэг, туршлага, ур чадвараа үнэлүүлэх боломж хомс Шударгаар хийсэн ажилдаа тохирсон цалин урамшуулал авах бололцоо муу
5.Гэм буруугийн шударга ёсны засаглал	Шударгаар гэм бурууг баттай тогтоох боломж хомс Шударгаар гэм буруутанд тэгш хандах боломж хомс
6.Хүрээлэн байгаа орчны шударга ёсны засаглал	Шударгаар хүрээлэн байгаа орчноо хамгаалах бололцоо бага Шударгаар хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтолтой тэмцэх боломжгүй

Нэгэнт шударга ёсны бүх засаглалын хүрээнд дээрх хүснэгтэд дурдсан ноцтой асуудлууд хуримтлагдсан учраас үндэсний эв нэгдэлд хор уршиг болохуйц ноцтой аюулууд бодитой оршиж байна.

2.1.3. Монгол Улсын ЭУИ-тэй холбоотой хүний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулууд

А) Үндэсний язгуур эрх ашиг хохирох аюул

Аливаа үндэстэн улс нь үндэсний язгуур ашиг сонирхол, үндэсний ухамсар, үндэсний үнэт зүйлстэй байх бөгөөд эдгээр нь үндэсний аюулгүй байдлынх нь тулгын гурван чулуу болж үндэстэн бүрэлдэн бэхжиж, хамгаалагдаж, оршин тогтнож байдаг^{37,38}.

Үндэсний язгуур ашиг сонирхлоо тогтоогоогүй, хуульчлаагүй, үндэсний үнэт зүйлээ итгэл үнэмшлээ болгож үндэсний ухамсраа сэргээгүй аливаа улс нь үндэстэн улсаа бүрэлдүүлж чадаагүй, үндэстэн улс нь хамгаалалтгүй байж, үндэстэн улсын тусгаар улс болон оршин тогтноход аюул нүүрлэсэн байдаг.


Үндэсний язгуур ашиг сонирхлын байр суурийг дээд түвшний бүлэглэлийн болон хувийн ашиг сонирхол эзлэн үндэстэн улс нь тэр ашиг сонирхолд үйлчилж үндэсний язгуур эрх ашиг хохирч, үндэсний аюулгүй байдал ба хүний аюулгүй байдалд ноцтой аюул занал учирдаг.

Монгол Улсын хувьд Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, Хөгжлийн банкны асуудлаас эхлээд монголын нийгэмд үүсээд байгаа бүхий л гэмт хэргийн шинж чанартай хэргүүд нь үүний тод жишээ бөгөөд улс орон дааж давшгүй өр зээлд унаж, үндэсний эдийн засгийн хүчин чадал доройтож, ажилгүйдэл ядуурал нэмэгдэж, өргөн хэрэглээний барааны үнэ хэт их нэмэгдэж, ядуурал гүнзгийрэн үндэсний аюулгүй байдал, хүний аюулгүй байдалд аюул учраад байгаа нь анхаарал татаж байна.

Б) Авлига гүнзгийрэх аюул

Авлигын эсрэг дэлхий дахины эвсэл болох Transparency International байгууллагын 2021 оны улс орнуудын Авлигын Индексээр Монгол Улсын Авлигын Индекс нь 35 болж нийт 193 орноос 110-д жагссан байна³⁹. Авлигын индекс нь 0-100 онооны хооронд байх ба Авлига бага байх тусам 100 д ойртож их байх тусам 0 руу ойртдог.

График 9. Дэлхийн зарим улс орны Авлигын индексийн харьцуулсан байдал,



2021

Дээрх график дээр дэлхийн хамгийн бага Авлигатай орнууд болон хамгийн их Авлигатай орнууд, хөрш хоёр орныхоо Авлигын индекс тэй Монгол Улсын Авлигын индексийг харьцуулан харуулав. Графикаас харахад Монгол Улс нь дэлхийн хамгийн их авлигатай орнуудын үзүүлэлттэй тун ойрхон байна. Харин дэлхийн хамгийн бага Авлигатай орнуудаас 50-53 оноогоор бага байгаа нь Авлигаас ангид байх үзүүлэлтээрээ тэдгээр орноос хол хоцорчээ.




График 10. Монгол Улсын Авлигын индекс, 2012-2021 он

График дээр Монгол Улсын авлигын индексийн 2012-2021 оны үзүүлэлтийг харуулж байна. Монгол Улсад авлигын түвшин өндөр,

тогтвортой буурахгүй байгаа нь харагдаж байна. Тогтвортой хөгжлийн зорилтын нэг нь авлигатай тэмцэх, авлигыг бууруулах зорилт байгаа бөгөөд улс төрийн хүсэл зориг, бүх нийтийн шахалт, сайн засаглал, эгэх хариуцлага, ил тод байдлаар авлигатай тэмцэх ажил үр дүнд хүрдэг болохыг олон улсын судалгаа, туршлага харуулж байна^{40,41}. Монгол Улсад авлигатай тэмцэх дорвитой арга хэмжээ авахгүй бол авлига нь үндэсний аюулгүй байдал, хүний аюулгүй байдалд аюул учруулах хэмжээнд байна.

В) Засаглалын хомсдол нүүрлэх аюул

Дэлхийн Засаглалын индекс нь Дэлхийн банкнаас 200 гаруй орныг засаглал ба авлигын байдлыг дуу хоолой ба эгэх хариуцлага, улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийллээс ангид байх, Засгийн газрын үр дүн, зохицуулалтын чанар, хууль сахиx ба авлигын хяналт гэсэн 6 үзүүлэлтээр жил бүр тодорхойлдог индикатор юм. Индикаторууд нь (-2.5)-(+2.5) -ын хооронд үнэлэгддэг бөгөөд хасах руу ойртох тусмаа эдгээр үзүүлэлт сул байгааг илтгэх бөгөөд нэмэх 2.5 руу ойртох тусмаа эдгээр үзүүлэлт хүчтэй байгааг илэрхийлдэг байна⁴².

Дээрх Дэлхийн Засаглалын индексийг илэрхийлдэг зургаан үзүүлэлт болох хууль сахиx, Засгийн газрын үр дүнтэй байдал, зохицуулалтын чанар, улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийллээс ангид байх, авлигын хяналт, дуу хоолой, эгэх хариуцлагын индексүүд нь^{43,44,45,46} Монгол Улсын хувьд 2006 оноос хойш жигдхэн сул байгаа нь ноцтой асуудал юм. Монгол Улсад Засаглалын дутагдал, засаглалын хямрал нүүрлэхэд нөлөөлж байгаа дээрх зургаан үзүүлэлтийг сайжруулах, эрүүлжүүлэх улс төрийн бодлого хэрэгтэй.

2.2. Монгол хүний аюулгүй байдлын ерөнхий үзүүлэлтүүдэд учирч болзошгүй эрсдэлүүд

Монгол хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийн үзүүлэлтэд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлов. ХХИ-ийн үзүүлэлтэд үндэсний оюуны чадавх суларч, оюуны сан хөмрөг хоосрох, үндэсний оюун санааны аюулгүй байдал алдагдах, хүйсийн тэгш байдал бүх салбарт алдагдаж эрүүл мэндийн болон хувь хүний аюулгүй байдал алдагдах, хүний эдийн засгийн аюулгүй байдал алдагдах эрсдэлүүд үүсэж болохоор байна.

ДЭТИ-ийн үзүүлэлтэд ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл нэмэгдэж хувь хүний аюулгүй байдал алдагдах, бүлгийн ашиг сонирхлын зөрчил гүнзгийрч нийтийн ашиг сонирхолд эрсдэл үүсэх, талцал хуваагдал, зөрчил зөрөлдөөн хурцдан нийгмийн аюулгүй байдал алдагдах зэрэг эрсдэлүүд үүсэж болохоор байна.

ЭУИ-ийн үзүүлэлтэд үндэсний аюулгүй байдал алдагдах, эдийн засгийн аюулгүй байдал алдагдах, төрийн аюулгүй байдал алдагдах зэрэг эрсдэл үүсэж болохоор байна.

2.3. Монгол Улсын хүний аюулгүй байдлын эмзэг байдлын үнэлгээ

Монгол Улсын хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийн зарим үзүүлэлтийн эмзэг байдлын шинжилгээг (I) аюулгүй байдлын зохистой байдал буюу учирч байгаа аюул болон түүнийг даван туулах үндэсний чадавхын тэнцвэрээр, (II) тодорхой бус байдал буюу учирч болзошгүй аюул заналыг даван туулах бодлого, стратеги байгаа эсэхээр, (III) эргэж сэргэх байдал буюу аюул занал засрах сайжрах

байдлаар үнэллээ.

Судалгаагаар хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрүүдийн зарим аюулд өртөж болзошгүй үзүүлэлт нь нэн эмзэг байна. Учир нь ХХИ, ДЭТИ, ЭУИ ийн аюулын зохистой байдал нь сул, тодорхой бус, эдгээр аюулд өртөөд байгаа үзүүлэлтийг сайжруулах талаар тодорхой стратеги байхгүй байна.

Монгол хүний аюулгүй байдлын ерөнхий үзүүлэлтүүдэд учирч байгаа аюул, эрсдэл, эмзэг байдлыг сайжруулахад чиглэсэн зарим үзүүлэлт УИХ-аар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлт хэлбэрээр туссан боловч дээрх тогтоосон аюулууд нь нэн яаралтай хэрэгжүүлэх стратегийг шаардаж байгаа тул бодлого нь тунхаглалын шинжтэй байна⁴⁷.

Дүгнэлт

1. Хүний аюулгүй байдлын ерөнхий хэмжүүрийн нэг болох ХХИ-ээр Монгол Улс нь өндөр үзүүлэлттэй орны ангилалд орж, хүн амын дундаж наслалт, нэг хүнд ногдох ҮНО зэрэг зарим бүрэлдэхүүн үзүүлэлтийн өсөлтөөс хамаарч энэ үзүүлэлт нь жилээс жилд сайжирч байгаа боловч боловсролын түвшний үзүүлэлт тодорхой ахицгүй байна. ХХИ-ийн үзүүлэлтэд боловсролын түвшний үзүүлэлт, хүн амын дундаж наслалтын хүйсийн зөрөө, ядуурал гүнзгийрэх байдал аюул учруулж болзошгүй байна. Эдгээр гурван үзүүлэлтээс болж ХХИ-ийн үзүүлэлтэд үндэсний оюуны чадавх суларч, оюуны сан хөмрөг хоосрох, үндэсний оюун санааны аюулгүй байдал алдагдах, хүйсийн тэгш байдал бүх салбарт алдагдах, эрүүл мэндийн болон хувь хүний аюулгүй байдал алдагдах, хүний эдийн засгийн аюулгүй байдал алдагдах эрсдэлүүд үүсэж болохоор байна. Монгол Улсын ХХИ-ийн аюулд өртөж болзошгүй дээр дурдсан үзүүлэлтүүд нь аюулын зохистой байдал нь сул, тодорхой бус, сайжруулж засах, хамгаалах стратеги төлөвлөгөөгүй байна.

2. Хүний аюулгүй байдлын хоёр дахь ерөнхий хэмжүүр болох ДЭТИ-ээр Монгол Улс нь харьцангуй тайван улсын ангилалд багтаж байна. Гэхдээ ДЭТИ-ийн үзүүлэлтэд дээд түвшний бүлэглэл хоорондын зөрчил, зөрөлдөөн нэмэгдэх, нийгмийн уялдаа холбоо сулрах, үндэсний эв нэгдэл алдагдах зэрэг аюулууд учирч болзошгүй байна. Энэ нөхцөлд ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл нэмэгдэж хувь хүний аюулгүй байдал алдагдах, бүлгийн ашиг сонирхлын зөрчил гүнзгийрч нийтийн ашиг сонирхолд эрсдэл үүсэх, талцал хуваагдал, зөрчил зөрөлдөөн хурцдан нийгмийн аюулгүй байдал алдагдах зэрэг эрсдэл үүсэж болохоор байна. Монгол Улсын ДЭТИ-ийн аюулд өртөж болзошгүй дээр дурдсан үзүүлэлтүүд нь аюулын зохистой байдал нь сул, тодорхой бус, сайжруулж засах, хамгаалах стратеги төлөвлөгөөгүй байна.

3. Монгол Улсын хүний аюулгүй байдлын дараагийн ерөнхий хэмжүүр болох ЭУИ-нь 52.3 буюу тогтвор багатай орны тоонд орж байна. Монгол Улс нь ЭУИ-ээр тогтвор багатай улсын ангилалд багтахад аюулгүй аппаратын шударга бус ба найдваргүй байдал, дээд түвшний улс төр бизнесийн нам болон үндэстэн дамнасан фракц бүлэглэлүүд, нийгмийн бүлгүүдийн төр засагт итгэл алдарсан байдал, эдийн засгийн хямрал, тогтворгүй байдал, улс төрийн сонгууль тойрсон хууль бус үйлдэл, эргэлзээ, нийтийн үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал, Авлига зэрэг шалгуур үзүүлэлтүүд нөлөөлж байна гэж үзэж болохоор байна. Монгол Улсын ЭУИ-ийн үзүүлэлтэд үндэсний язгуур эрх ашиг

хохирох, авлига гүнзгийрэх, засаглалын хомсдол үүсэх аюулууд учирч болзошгүй байна. Энэ нөхцөлд ЭУИ-ийн үзүүлэлтэд үндэсний аюулгүй байдал алдагдах, эдийн засгийн аюулгүй байдал алдагдах, төрийн аюулгүй байдал алдагдах зэрэг эрсдэл үүсэж болохоор байна. Монгол Улсын ЭУИ-ийн аюулд өртөж болзошгүй дээр дурдсан үзүүлэлт нь аюулын зохистой байдал нь сул, тодорхой бус, сайжруулж засах, хамгаалах стратеги төлөвлөгөөгүй байна.

-
1. A New concept of human security, Human Development Report 1994.3-4 pages. UNDP. NEW YORK. OXFORD.1994
 2. Towards sustainable human development, Human Development Report 1994.13-21 pages. UNDP. NEW YORK. OXFORD.1994
 3. New dimensions of human security, Human Development Report 1994.22-25 pages. UNDP. NEW YORK. OXFORD.1994
 4. United Nations Conference on Environment and Development, Rio de Janeiro, Brazil, 3-14 June 1992, <https://www.un.org/en/conferences/environment/rio1992>
 5. Taylor Owen. Measuring Human Security: Methodological Challenges and the Importance of Geographically Referenced Determinants. The University of Oxford, Jesus College
 6. Taylor Owen Environmental Change and Human Security: Recognizing and Acting on Hazard Impacts pp 35-64
 7. Measuring Human Security: Overcoming the Paradox Human Security Bulletin. October, Vol.2 No. 3. 2003
 8. Alexandra Homolar. Human Security Benchmarks: Governing Human Wellbeing at Distance. Article in Review of International Studies · December 2015, <https://www.researchgate.net/publication/276061625>
 9. Jennifer Leaning, M.D., S.M.H. Sam Arie, M.Sc. HUMAN SECURITY: A FRAMEWORK FOR ASSESSMENT IN CONFLICT AND TRANSITION HCPDS Working Paper Series Volume 11 Number 8. Harvard Center for Population and Development Studies
 10. Human Development Index (HDI) <https://hdr.undp.org/>
 11. Global Peace Index (GPI) https://en.wikipedia.org/wiki/Global_Peace_Index
 12. Measuring Fragility. <https://fragilestatesindex.org/>
 13. Human Development Report 2020. The next frontier Human development and the Anthropocene. [undp.org](https://hdr.undp.org/)
 14. Renewing human development for the Anthropocene. Human Development Report 2020 pages 17-45. [undp.org](https://hdr.undp.org/)
 15. Institute for Economics & Peace (June 2021). “Global Peace Index 2021: Measuring Peace in a Complex World” (PDF). Vision of Humanity. pp. 9–10. Retrieved 2021-09-03.
 16. Measuring Fragility: Risk and Vulnerability in 179 countries. <https://fragilestatesindex.org/>
 17. Measuring Fragility: Methodology. <https://fragilestatesindex.org/methodology/>
 18. Measuring Fragility: Indicators. <https://fragilestatesindex.org/indicators/>
 19. Measuring Fragility: Global Data, <https://fragilestatesindex.org/global-data/>
 20. Todaro, Michael P.; Smith, Stephen C. (2012). Economic development (11 ed.). Addison-Wesley. ISBN 978-0-13-801388-2.
 21. Б.Гэрэл.ҮСХ-ны ҮТШСГ-ын статистикч Монгол Улсын хөгжил олон улсын түвшинд харьцуулсан судалгаа, 2020 он. ҮСХ
 22. Latest human development index Ranking, 2020. <https://hdr.undp.org>

23. Global Peace Index 2021. <https://reliefweb.int/report/world/global-peace-index-2021>
24. “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох” судалгааны тайлан, undp.org
25. Introduction to Qualitative risk analysis <https://www.iso.org/standard/43170.html#:~:text=It%20is%20intended%20that%20ISO,for%20the%20purpose%20of%20certification>
26. Qualitative threat assessment methodology. Australian/New Zealand Standard for Risk Management ISO 31000:2009 (Standards Australia 2009; AZ/NZS 4360:1999) and HB 203: 2000 Environmental Risk Management – Principles and Process (Standards Australia 2009).
27. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. YCX.1212.mn
28. Хүн амын дундаж наслалт, хүйс, аймаг/нийслэлээр, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, YCX
29. Life expectancy at birth. Data based on the latest United Nations Population Division estimates.
30. Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын статистик, 2020. YCX.
31. Улс төрийн нам бүртгэсэн бүртгэл. Улсын Дээд Шүүх. <http://www.supremecourt.mn/nam>
32. Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгааны тайлан. ХЗДХЯ, Швецарын хөгжлийн агентлаг. 2017
33. Нацаг Удвал. Шударгаар засаглахуй. Эв судар. Хураангуй. 54-58 р хуудас. 2016
34. Turner, M. E.; Pratkanis, A. R. (1998). “Twenty-five years of groupthink theory and research: lessons from the evaluation of a theory” (PDF). *Organizational Behavior and Human Decision Processes*. 73 (2–3)
35. Christian Albrekt Larsen, Professor, Centre for Comparative Welfare Studies (www.ccws.dk), Aalborg University, Denmark. Social cohesion: Definition, measurement and developments <https://www.un.org/esa/socdev/egms/docs/2014/LarsenDevelopmentinsocialcohesion.pdf>
36. Zongyi Liu Krasner, Stephen D. (1978). *Defending the National Interest: Raw Materials Investments and U.S. Foreign Policy*. Princeton University Press.
37. Finnemore, Martha (1996). *National Interests in International Society*. Cornell University Press. JSTOR 10.7591/j.ctt1rv61rh.
38. CORRUPTION PERCEPTIONS INDEX. Transparency International, The Global Coalition against corruption. <https://www.transparency.org>
39. Iliott, Kimberly Ann (1997). “Corruption as an international policy problem: overview and recommendations” (PDF). Washington, DC: Institute for International Economics.
40. Blavatsky, Pavlo (18 July 2020). “Obesity of politicians and corruption in post-Soviet countries”. *Economics of Transition and Institutional Change*. 2020 (2): 343–356
41. Worldwide Governance Indicators. <http://info.worldbank.org/governance/wgi/>
42. Doss, Eric. “Sustainable Development Goal 16”. United Nations and the Rule of Law.
43. Kaufmann, D., Kraay, A. and Mastruzzi, M. (2008), “Governance matters VII: aggregate and individual governance indicators 1996-2007”, Policy Research Working Paper, The World Bank, Washington, DC
44. Rocha Menocal, A. & Sharma, B. (2008). *Joint Evaluation of Citizens’ Voice and Accountability: Synthesis Report*. London: DFID.
45. Kaufmann, Daniel; Vicente, Pedro (2005). “Legal Corruption” (PDF). World Bank. Archived from the original (PDF) on 5 May 2015.
46. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail/15406>



Х.НОМИНБОЛОР
 ҮАБЗ-ийн ССХ-ийн
 Ахлах шинжээч

УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДОЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

Abstract: *In recent years, Ulaanbaatar, the capital city of Mongolia, has become one of the most polluted cities in the world. Overcrowding and unplanned urban sprawl over the past 20 years are major causes of air pollution in Ulaanbaatar. In response to growing public concerns over air pollution, in 2017, the Government of Mongolia (GoM) approved National Program for Reducing Air and Environmental Pollution (NPRAEP) and, on May 15, 2019, implemented a ban on raw coal and introduced refined coal briquettes.*

Some indicators of air pollution in Ulaanbaatar have declined notably over the past two years compared to baseline levels of 2016. Despite GoM's efforts to reduce air pollution, Ulaanbaatar's air quality worsened significantly in the winter of 2021-2022 from the previous year. This paper provides an overview of how the air quality situation has changed since the program has started and the issues that need to be addressed.

Key words: *Air pollution, National Program for Reducing Air and Environmental Pollution (NPRAEP), human health, Ulaanbaatar*

Оршил

Агаарын бохирдол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг¹, Стокгольмын тунхаглалын 1 дүгээр зарчимд заасан Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөж байна. Улаанбаатар хот дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотын нэгд тооцогдох болоод нилээд хугацаа өнгөрчээ. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Улаанбаатар хотод өрнөсөн хүн амын хэт төвлөрөл, хотын төлөвлөлтгүй тэлэлт агаарын бохирдлын үндсэн шалтгаан болдог.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын хамгийн том эх үүсвэр нь гэр хорооллын

¹ Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэж заасан.

айл өрх, аж ахуйн нэгжүүдийн халаалтын зуух бөгөөд PM2.5 тоосонцрын 80 хувийг дангаар бий болгодог гэсэн тооцоо бий. Ажлын байр, худалдаа, үйлчилгээ төвлөрсөн Улаанбаатар хотын төв хэсэгт тээврийн хэрэгсэл, хорт бодисын ялгаруулалт ихтэй нийтийн тээврийн автобуснуудын тоо улам нэмэгдсээр байна. Хотын газар зүйн байрлал, уур амьсгал нь агаарын бохирдолд мөн нөлөөлдөг. Улаанбаатар хот нь уулаар хүрээлэгдсэн, өвөл, намрын улиралд хүйтэн, хуурай цаг агаартай тул агаарын урсгал удаан хугацаанд хот орчимд түгжигдэж, агаарын бохирдол салхинд туугдах боломжгүй болдог. Агаарын бохирдол хүн амын хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж, эрүүл мэнд, нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэн, эдийн засгийн үлэмж хэмжээний хохирол учруулдаг.

Агаар, орчны бохирдлыг бууруулахад үр дүнтэй, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, нөөцийн боломжид тулгуурлан салбар дундын зохицуулалт хийх шаардлагын үүднээс 2017 онд Монгол Улсын Засгийн газраас Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг батлан 2025 оныг хүртэл хэрэгжүүлж байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Улаанбаатар хотын агаарын бохирдлын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн, бодлогын арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарвал зохих асуудлын талаар энэ өгүүлэлд тоймлов.

Нэг. Агаарын бохирдлын өнөөгийн нөхцөл байдал

1.1. Агаар бохирдуулах бодисын хэмжээ өндөр хэвээр байна

Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авсны нэг нь 2019 оны тавдугаар сарын 15-наас эхлэн Улаанбаатар хотод түүхий нүүрсний хэрэглээг хориглосон явдал юм.² Улаанбаатар хотын агаарын бохирдол суурь түвшинтэй харьцуулахад сүүлийн 2 жилийн хугацаанд тодорхой хэмжээнд буурсан. Тухайлбал, том болон жижиг ширхэглэгт тоосонцор (PM10 ба PM2.5)-ын агууламж 2016 онтой харьцуулахад 2020 онд мэдэгдэхүйц буурсан болохыг агаарын чанарын хэмжилтүүд, судалгаанууд харуулж байна (Gantuya нар, 2020). Гэвч агаар дахь бохирдуулагч бодисуудын агууламж Монгол Улсын стандарт болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид заасан түвшнээс өндөр хэвээр, хүхэрлэг хий (SO2) болон азотын давхар исэл (NO2)-ийн агууламж дээрх хугацаанд буураагүй, нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

PM2.5, PM10 тоосонцор

Улаанбаатар хотын гадаад орчны агаар дахь бохирдуулах бодисын 2018-2021 оны өвлийн саруудын дундаж агууламжийг харьцуулахад түүхий нүүрс түлэхийг хориглосон шийдвэр гарсанаас хойш буюу 2019/2020 оны өвөл PM10 болон PM2.5 тоосонцрын агууламж өмнөх 2018/2019 оноос 19-47 хувь хүртэл буурсан бол 2020/2021, 2021/2022 оны өвлийн сард бохирдлын агууламж өмнөх жилүүдээс төдий л өөрчлөгдөөгүй байна.


² Тус тогтоолоор Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг 2019 оны тавдугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон.

Зураг 1. Улаанбаатар хотын агаар бохирдуулагч PM2.5, PM10 тоосонцрын өвлийн сарын дундаж агууламж, 2018-2021 он



Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газраас анхаарч үйл ажиллагаа явуулж байсан жилүүдэд агаарын бохирдол нэлээд буурах хандлагатай байдгийг 2014-2021 оны хоорондох Улаанбаатар хотын агаар бохирдуулагч PM10, PM2.5 бодисын агууламжийн өөрчлөлтөөс харж болно (Зураг 2). Гэхдээ аливаа үйл ажиллагааг тасралтгүй, тууштай хэрэгжүүлэхгүйгээр тогтвортой амжилтад хүрч чадахгүй юм.

Зураг 2. Улаанбаатар хотын агаар бохирдуулагч PM2.5, PM10 тоосонцрын өдрийн дундаж агууламж, 2014-2021 он




Эх сурвалж: Соёл-Эрдэнэ нар, 2021.

Химийн бохирдуулагчид: Хүхэрлэг хий (SO₂) ба азотын давхар исэл (NO₂)

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хий ялгаруулагч гол эх үүсвэр нь гэр хорооллын зуух, цахилгаан станцууд болон тээврийн хэрэгслүүд юм. Хүхэрлэг хийн улирлын хэлбэлзэл нь PM тоосонцортой төстэй бөгөөд өвлийн улиралд зуныхаас илт өндөр агууламжтай байдаг нь түүхий нүүрсний хэрэглээтэй холбоотой. 2018/2019 оны өвөлтэй харьцуулахад сайжруулсан шахмал түлш хэрэглэж эхэлсэн 2019/2020, 2020/2021 оны өвлийн улиралд хүхэрлэг хийн агууламж огцом буюу 1.8 болон 2.2 дахин нэмэгдсэн (Зураг 3).

Зураг 3. Улаанбаатар хотын агаар бохирдуулагч SO₂, NO₂ хийн өвлийн саруудын дундаж агууламж, 2018-2021 он




Агаар дахь хүхэрлэг хийн бохирдлын агууламж огцом нэмэгдсэн нь сайжруулсан шахмал түлшний найрлагатай холбоотой болохыг дараах тоонуудаас харж болно. Сайжруулсан шахмал түлшний хүхрийн агууламж ~0.9 хувь (Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), 2019) бөгөөд Монгол Улсын стандартаас хэтрэхгүй (MNS 5679:2019, <1.0% S) боловч 2019 онд нүүрсний хэрэглээг шахмал түлшээр солихоос өмнө Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн үндсэн түлш болж байсан Багануурын нүүрсний агууламжаас (0.42 хувь S) ойролцоогоор хоёр дахин их байна (Japan International Cooperation Agency (JICA), 2013). Гэвч Улаанбаатар хотын агаарт хүхэрлэг хийн агууламж ийнхүү нэмэгдэж байгаа талаарх нарийвчилсан судалгаа одоогоор байхгүй тул зохих арга хэмжээг санал болгохын тулд сайжруулсан түлшний шинж чанар (илчлэг, найрлага, үнсний агууламж гэх мэт)-ын нарийвчилсан судалгаа хийх, үйлдвэрлэлийн процессын нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай.

Нөгөөтэйгүүр, сүүлийн үед хотын хэмжээнд автомашины тоо эрс нэмэгдэж байгаагаас түлшний шаталтаас үүдэлтэй хорт бодисууд хотын агаарын бохирдолд ихээхэн хувь нэмэр оруулах төлөвтэйг Монголд хэрэглэж буй түлшний шинжилгээний үр дүн баталж байна. Тухайлбал, Баясгалан нар (2018)-ын хийсэн судалгаагаар Монгол Улсад хэрэглэж буй автобензин (117–400 ppm³ S) болон дизель түлш (1,135–1,165 ppm S) зэрэгт хүхрийн агууламж маш өндөр буюу Евро 4 стандартаас (50 ppm S) 2–8 болон 22-23 дахин хэтэрсэн байна. Иймд агаарын бохирдлыг бууруулахын тулд автомашины шатахууны чанарыг сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Одоогоор Улаанбаатар хотын хэмжээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой бусад эх үүсвэрээс хүхэрлэг хий ялгарч байгаа талаар судалгаагүй байгаа тул цаашид агаар мандал дахь хүхэрлэг хий ба хүхрийн нэгдлүүдийн эх үүсвэрийн талаар нарийвчилсан судалгааг хийх нь зүйтэй.

Улаанбаатар хотын агаар мандал дахь азотын давхар ислийн гол эх үүсвэр нь нүүрснээс гадна автомашины түлшний шаталтаас үүсэх хий байдаг. Түүхий нүүрсний хэрэглээг халж сайжруулсан шахмал түлшинд шилжсэнээс хойш өвлийн сард (10-02 дугаар сар) азотын давхар ислийн агууламж өмнөх хоёр жилийнхээс төдийлөн өөрчлөгдөөгүй (Зураг 3).

³ ppm (Parts per million): Нэгж эзлэхүүн дэх тухайн бодисын хэмжээ (1 сая нэгж доторх өчүүхэн бага бодисын хэмжээг илэрхийлэхэд хэрэглэгдэнэ).

Зураг 4. Улаанбаатар хотын агаар мандал дахь хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2)-ийн өдрийн дундаж агууламж, 2014-2021 он



Эх сурвалж: Соёл-Эрдэнэ нар, 2021

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж өвлийн үед огцом нэмэгдээд бусад үед төдийлөн багасахгүй, жилийн туршид хүлцэх агууламжийн ойролцоо хэлбэлзэх буюу түүнээс давж байгаа нь автомашин, тээврийн хэрэгслээс үүдэлтэй бохирдлын фон байгааг илтгэнэ (Зураг 4). Гэвч агаар бохирдуулагч гол бодисуудын нэг болох азотын давхар ислийн улирлын өөрчлөлт, түүний орон зайн тархалт, Улаанбаатар хотын янз бүрийн эх үүсвэрүүдийн оруулж буй хувь нэмрийн талаар хийсэн судалгаа одоогоор маш цөөн байгаа нь хангалтгүй юм.

1.2. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо буурахгүй байна

Нийслэлийн агаарын бохирдлын эх үүсвэрийн 2016 оны тооллогын дүнгээр төвийн зургаан дүүргийн гэр хороололд нийт 198 мянган айл өрх, үүнээс ердийн галлагаатай халаалтын эх үүсвэртэй 187 мянган өрх, аж ахуйн нэгж, байгууллагын 9.0 мянга гаруй нам даралтын зуух, 487.5 мянган авто тээврийн хэрэгсэл бүртгэгдэж байв.⁴

Үүнээс хойш агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо хангалттай буурсангүй, зарим эх үүсвэр өссөн байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр Улаанбаатар хотод ердийн галлагаат болон нам даралтын зуухны халаалттай 200.8 мянган өрх тоологдсон бол 2021 онд нийслэл хотод 182 усан халаалтын зуух ажиллаж байсан.

2021 оны эхний есөн сарын байдлаар Улаанбаатар хотод бүртгэлтэй 655.9 мянган тээврийн хэрэгсэл байгаа нь 2016 оны дүнтэй харьцуулбал 34, өмнөх онтой харьцуулбал 6 хувиар тус тус нэмэгджээ. Автомашины тоо олшрох тусам замын дэд бүтэц сайн хөгжөөгүй, хот төлөвлөлт муутай нийслэлд түгжрэлийг гааруулж, автомашинаас ялгарах хорт утааг улам нэмэгдүүлж байна. Автомашины хөдөлгүүрээс ялгарах утаа нүүрстөрөгчийн дутуу болон давхар исэл, хүхэрлэг хий, азотын нэгдлүүд, хөө тортог, хар тугалга, кадми, альдегид зэрэг 270 гаруй төрлийн хорт бодис агаарт ялгаруулдаг бөгөөд жилийн турш хүн амыг хордуулж байдаг.

⁴ Үүнээс 10 кВт хүртэл хүчин чадалтай 160.9 мянган зуух бүртгэгдсэний 38 хувь буюу 61,000 нь энгийн зуух, 62 хувь буюу 99.9 мянган нь сайжруулсан зуух; 11-100 кВт хүртэл хүчин чадалтай 3.1 мянган усан халаалтын зуух бүртгэгдсэнээс Баянзүрх дүүрэгт 698, Сонгинохайрхан дүүрэгт 675, Чингэлтэй дүүрэгт 505 зуух, бусад 3 дүүрэгт 354-395 зуух ашиглагдаж байв.

Зураг 5. Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо, мянган тээврийн хэрэгсэл



Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 97.5 хувийг бензин, дизель, холимог түлшээр ажилладаг автомашин бүрдүүлж, 92.2 хувь нь 7 ба түүнээс дээш жилийн насжилттай (үүнээс 73.5 хувь нь 10 ба түүнээс дээш жилийн

насжилттай) буюу бараг бүхэлдээ импортоор орж ирсэн хуучин автомашин байгаа нь Улаанбаатар хот хуучин машины хогийн цэг мэт болсныг харуулна.

1.3. Агаарын бохирдолд цаг уур, газарзүйн байршлын нөлөө

Улаанбаатар хотын агаарын бохирдолд нөлөөлж буй өөр нэг чухал хүчин зүйл бол газарзүйн болон цаг агаарын нөхцөл байдал юм. Уул-хөндийн салхины системтэй Улаанбаатар хотын цаг уурын өвөрмөц нөхцөл нь агаарын бохирдлын орон зайн тархалтад ихээхэн нөлөөлдөг. Ялангуяа байнга тохиолддог хүйтэн агаарын урсгалын нөхцөл нь Улаанбаатар хотын хойд хэсгээр байрлах гэр хорооллоос ялгарах агаар бохирдуулагчдыг хотын төв рүү зөөхөд хувь нэмэр оруулдаг. Өдрийн цагт хангалттай халж чадаагүй газрын гадарга шөнийн хугацаанд хөрж дулаанаа алдах ба тодорхой өндөр хүртэл дулаан агаар, үүний дээр дахин хүйтэн агаар оршсоноор газрын гадаргаас дээшлэх тусам агаарын температур нэмэгдэж ТЕМПЕРАТУРЫН ИНВЕРС-ийн давхарга бүрддэг⁵. Өвлийн улиралд хэдэн өдрөөр, заримдаа хэдэн долоо хоногоор ч тогтвортой байдаг температурын инверс доод хэсгийн агаарыг дээш сэлгээнд оруулалгүй өндөр агууламжтай агаарын бохирдлыг газрын гадарга орчим тогтоон барьдаг (Ганбат, Байк, 2016). Температурын инверс Улаанбаатар төдийгүй манай улсын бусад газарт ч ажиглагддаг бөгөөд хот суурингуудад агаарын бохирдлыг нөхцөлдүүлэгч болно.

Зураг 6. Агаар мандлын хэвийн болон инверсийн нөхцөл байдал



⁵ Орчих мандал (тропосфер)-д температур босоо чиглэлд буурдаг хэвийн нөхцөлд агаарын тодорхой үед температур өндрөөшөө дулаардаг аномаль тархалтыг температурын инверс гэнэ (Нацагдорж, 1989). Агаарын босоо тогтворжилтын зэрэглэлийг ИНВЕРС (шөнө дунд, шүүдэр хяруу унах, утаа газраар налах үе); КОНВЕКЦ (жин үд, яндангийн утаа эгц дээшээ олгойдох үе); ИЗОТЕРМ (өглөө, оройд агаарын дээд доод температур тэнцүү байх үе) гэж гурав ангилах бөгөөд эдгээр нь утаажилтын бүсийн өгөгдлүүдэд онцгой нөлөөлдөг.

Температурын инверс 12 болон нэгдүгээр сард хамгийн хүчтэй тогтдог ба үүнийг дагаад агаарын чанарын үзүүлэлт мууддаг. Байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан агаар мандалд тогтвортой орших системийг өөрчлөх боломжгүй тул агаарын бохирдлын эх үүсвэрийг тууштай бууруулахад хүчин чармайлт гаргах нь зөв шийдвэр байх болно. Нөгөө талаар, цэрэг стратегийн хэрэгт инверсийг дайсны дээр химийн зэвсэг хэрэглэх хамгийн таатай нөхцөл гэж үздэг. Иймд үндэсний аюулгүй байдлын үүднээс авч үзвэл Монгол Улсын хүн амын 50 гаруй хувь нь амьдран сууж буй нийслэл хотын өмнө тулгамдаж буй нийгэм, эдийн засаг, экологийн асуудлуудыг шийдвэрлэх нэг гарц нь нийслэл хотыг нүүлгэн шилжүүлэх төвөгтэй боловч алс хэтээ харсан зөв алхам байх болно.

Хоёр. Агаарын бохирдол ба хүн амын өвчлөл

Агаарын бохирдлын улмаас хүн амын дунд амьсгалын замын өвчлөл, түүн дотроо уушгины цочмог, архаг үрэвсэл, хорт хавдар, зүрх судасны эмгэг, харшлын өвчин нэмэгдэх, жирэмсэн эхчүүдэд ураг хүчилтөрөгчийн дутагдалд орох, зулбах, дутуу төрөх, бага насны хүүхдүүдийн нас баралт, бие бялдрын өсөлт, хөгжилт саарах зэрэг сөрөг нөлөө үзүүлж байна⁶. Улаанбаатар хотын хүн амын дунд цаг бусаар нас баралтад зүрх судасны өвчлөл хамгийн түгээмэл байгаа бөгөөд хөдөлмөрийн чадвар алдсан амьдралын жилүүдийн зонхилох шалтгаан нь зүрх судасны тогтолцооны өвчлөл, хүүхдийн хатгалгаа өвчин байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүн амын эрүүл мэндийн дараах үзүүлэлтүүд сайжрах учиртай. Гэвч хөтөлбөрт тусгасан эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2019 онд хөтөлбөрийн I үе шатны зорилтот түвшинд хүртэл буурч чадаагүй. Бүх үзүүлэлт суурь он буюу 2016 оны түвшнээс нэмэгдэж, 2019 онд тавьсан зорилтот түвшнээс давсан (Хүснэгт 1). Харин 2020 онд агаарын чанарын зарим үзүүлэлт сайжирсан, мөн Ковид-19 цар тахлын үеийн нийгмийн эрүүл мэндийн интервенц буюу хөл хорио, гар угаах, амны хаалт зүүх, зай барих дэглэмийн үр дүнд тодорхой хэмжээгээр буурсан юм.

Хүснэгт 1. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгасан эрүүл мэндийн үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хэрэгжилт*			
		2016	2019	2025	2017	2018	2019	2020
Амьсгалын тогтолцооны өвчин (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)	промилль	465	448	433	432	466	478	298
Зүрх судасны тогтолцооны өвчин (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)	промилль	399	393	384	412	422	427	365
Уушгины хатгалгаа (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)	промилль	239	206	146	146	241	245	131

*Үндэсний статистикийн хороо, 2021; Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн үзүүлэлт 2020

⁶ Зүрх-уушгины өвчний нас баралтын 29, уушгины хорт хавдрын нас баралтын 40 хувь нь бохирдлоос үүдэлтэй болохыг судалгаа харуулж байна.

Улаанбаатар хотын хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын тогтолцооны болон зүрх судасны тогтолцооны өвчин өндөр хувийг эзэлсээр ирсэн.

Хүснэгт 2. Улаанбаатар хотын хүн амын өвчлөлийн тэргүүлэх таван шалтгаан, дүнд эзлэх хувиар

Тэргүүлэх өвчлөлүүд	2016	2017	2018	2019	2020
Нийт	100	100	100	100	100
Амьсгалын тогтолцооны өвчин	17.7	14.2	14.3	15.2	10.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	13.2	15.4	14.4	14.9	16.7
Зүрх, судасны тогтолцооны өвчин	10.8	10.8	10.0	10.4	10.6
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	8.6	9.3	8.7	9.3	9.8
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант	8.3	8.0	9.4	9.1	8.7
Бусад	41.4	42.3	43.2	41.2	43.5

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2020. Эрүүл мэндийн үзүүлэлт 2020

Агаарын бохирдол хүн амын, ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын эрхтэн тогтолцооны өвчлөлийн шалтгаан болоод зогсохгүй ужиг өвчин үүсгэх, нярай болон нялхсын эндэгдлийн шалтгаан болдог (НҮБ-ын Хүүхдийн сан, 2016). Улаанбаатар хотод 2020 онд амьсгалын тогтолцооны нийт өвчлөлийн 31 хувийг 5 хүртэл насны хүүхдийн өвчлөл, харин нийт өвчлөлийн 11.2 хувийг уушгины хатгалгаа эзэлж байсан.

Улаанбаатар хотын хувьд зүрх судасны тогтолцооны өвчин нь хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. 2001 оноос хойш байнга нэмэгдэж байсан өвчлөл болон нас баралт 2020 онд өмнөх оноос бага зэрэг буурсан боловч 2016 онтой харьцуулахад өссөн дүнтэй бөгөөд тархинд цус харвалт, зүрхний цочмог шигдээс, даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт дийлэнх хувийг эзэлж байна. Өвчлөл, нас баралтын тоо хэмжээний үзүүлэлтэд дорвитой өөрчлөлт гараагүй байгаа нь агаарын бохирдлын нөлөө үргэлжилсээр байгааг илтгэж байна.

Ийнхүү Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд 2019 оны тавдугаар сараас сайжруулсан нүүрс хэрэглэж эхэлсэн, Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны нэгдүгээр сараас хойших хэд хэдэн удаагийн нийтийг хамарсан хөл хорио, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг цахим болон хагас цахим хэлбэрээр зохион байгуулсан, хувийн болон амьдарч, ажиллах орчны ариун цэврийг эрс сайжруулах, амны хаалт зүүх зэрэг нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хүн амын зарим өвчлөлийн тохиолдол буурсан үзүүлэлттэй байна. Гэхдээ үүнийг дээрх хугацаанд агаарын бохирдол буурсантай холбоотой гэж шууд дүгнэх боломжгүй, 2021 оны эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүдийг харгалзан, нарийвчилсан судалгаануудын үр дүнд үндэслэн дүгнэлт хийх нь зүйтэй.

Гурав. Агаарын бохирдлыг бууруулах бодлого арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилт

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлд 2008-2016 онд улсын төсвөөс 147 тэрбум гаруй төгрөг, олон улсын байгууллагын санхүүжилтээр 60.7 сая ам.доллартой тэнцэхүйц

мөнгөөр сайжруулсан зуух, түлш, нам даралтын зуухыг шинэчлэх, төвлөрсөн дулаанд холбох, эко автобус, хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, айл өрхийг хийн хэрэглээнд шилжүүлэх туршилт, судалгаа шинжилгээ хийх зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэсэн ч дорвитой үр дүнд хүрээгүй.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2017 оны нэгдүгээр сард агаарын бохирдлыг бууруулах талаар 03/03 тоот зөвлөмж гаргасны дагуу Засгийн газрын 98 дугаар тогтоолоор хот суурин газрын Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр (АОББҮХ)-ийг боловсруулан баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд орчны бохирдлыг бий болгож буй эх үүсвэрийг бууруулах, арилгахад чиглэсэн таван зорилт, 58 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд 153 арга хэмжээг 2017-2019 он, 2020-2025 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлж, бохирдлыг 2016 оны суурь түвшинтэй харьцуулахад 80 хувиар бууруулахаар төлөвлөсөн.

Хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2017-2020 онд агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр улсын болон нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг эх үүсвэрээс нийт 456.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт 3. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээрх хөрөнгийн зарцуулалт, 2017-2020 он

Санхүүжилтийн эх үүсвэр, тэрбум төгрөг	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт дүн
Нийт дүн	98.4	74.6	221.7	61.4	456.1
Улсын төсөв	65.8	24.6	124.2	58.5	273.1
Нийслэлийн төсөв	4.4	3.2	4.9	1.6	14.1
Гадаад зээл	28.2	46.8	92.6	1.3	168.9
АХБ, ЕХОБ-ны зээл	8.8	34.0	87.3	0.0	130.1
Дэлхийн банкны зээл	3.5	3.9	2.5	1.3	11.2
БНХАУ-ын зээл	15.9	8.9	2.8	0.0	27.6

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилт ойролцоогоор 4.1 тэрбум ам.доллар (9.8 их наяд төгрөг), үүний 86 хувь нь агаарын бохирдлыг бууруулахад шууд холбоотой арга хэмжээнд зарцуулагдах боловч санхүүжилтийн 80 орчим хувийн эх үүсвэр баталгаажаагүй байна.

Агаар орчны бохирдлыг бууруулахаар 199 арга хэмжээг 2017-2019 онд эхлүүлж, 91 арга хэмжээг нь дуусгахаар төлөвлөсөн ч хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбар дундын оролцоог хангаж чадаагүйн улмаас 67.8 хувь нь огт хэрэгжээгүйг 2020 онд тус хөтөлбөрт хийсэн аудитын тайланд дурдсан. Өмнө нь Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-өөс Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төсвийн зарлагад шинжилгээ хийсэн тайлан (2018)-д дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг нэгтгэсэн чухал баримт бичиг мөн боловч хамрах хүрээ нь хэт өргөн, төлөвлөсөн өртөг зардал өндөр, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүд эрэмбэ дараалалгүй, үйл ажиллагаа болон зорилтын хооронд нягт уялдаа холбоогүй, бүрэн бус байгааг шүүмжилж, эдгээр дутагдлыг арилгахгүйгээр 2025 он гэхэд агаарын бохирдлыг 80 хувиар бууруулах зорилт бодитой бус гэж дүгнэсэн байдаг. Иймд тус хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэх, бодит үр дүнд хүрэх санхүүжилтийг

бүрдүүлэх талаас анхаарах нь зүйтэйг онцолсон.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлого, хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгааг дараах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээр авч үзлээ.

3.1. Сайжруулсан шахмал түлш, зуухны талаар

Улаанбаатар хотын агаарын РМ бохирдлыг бууруулахад Дэлхийн банк (2011) болон ЖАЙКА (2017)-ын хийсэн эрчим хүчний бодлогын хувилбаруудын зардал, үр ашгийн шинжилгээ (ЗҮАШ)-гээр сайжруулсан зуух, сайжруулсан түлш арга хэмжээ нь богино болон дунд хугацаанд зардал, үр ашгийн хувьд хамгийн боломжит шийдэл гэж дүгнэсэн байдаг. Засгийн газраас 2017-2021 онд агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх, агаарын чанарын бүсэд хамаарах айл өрхүүдэд эрчим хүчний орой, шөнийн тарифын хөнгөлөлт олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Дэлхийн банк, Мянганы сорилтын сан, Цэвэр агаарын сан болон улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2011-2016 оны хооронд 176.9 мянган сайжруулсан зуух бэлтгэн, худалдан нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн (АЕГ, 2018)⁷. Гэвч дээрх хугацаанд Улаанбаатар хотод ердийн галлагаатай зуухны тоо нэмэгдсээр 2017 оны эцсийн байдлаар 100,730 болж өссөн нь зуух нийлүүлэх арга хэмжээ үр дүнтэй болсон эсэх нь эргэлзээтэйг харуулсан. Ахуйн хэрэглээний зуухны техникийн шаардлагыг бүрэн шаталттай сайжруулсан зуухны үзүүлэлттэй нийцүүлэн шинэчилсэн MNS 5216: 2016 стандартыг 2017 оны дөрөвдүгээр сараас эхлэн мөрдөж эхэлснээр Улаанбаатар хотод уламжлалт зуухыг худалдан борлуулахыг хориглосон. Тэгвэл 2021 онд гэр хорооллын 141.9 мянган өрхөд хийсэн тооллогоор дөнгөж 54.3 мянган стандарт зуух тоологдсон нь маш хангалтгүй үзүүлэлт юм.⁸

Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглохтой холбоотойгоор төрийн өмчийн “Тавантолгой түлш” ХХК-ийг 2018 онд байгуулсан бөгөөд тус компани “Энержи ресурс” компанийн баяжуулах үйлдвэрийн завсрын бүтээгдэхүүн (middling)-ийг ашиглан сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, нийслэлийн гэр хорооллын иргэд, аж ахуйн нэгжийг хангаж байна. Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа бөгөөд тус компани эхний жилдээ (2019-2020 онд) 320 мянган тонн түлш үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлсэн бол 2020-2021 онд 430 мянган тонн, 2021-2022 оны өвөл 620 мянган тонн шахмал түлш үйлдвэрлэн борлуулаад байгаа.

Шахмал түлшний хэрэглээ ийнхүү нэмэгдэж байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Нэгд, шахмал түлшний үйлдвэрлэлийн горим, түүхий эдийн орц, найрлага, хадгалалт зэргээс үүдэлтэй түлшний чанарт өөрчлөлт орсон, хоёрт, гэр хорооллын айл өрхийн зуухны дийлэнх нь шахмал түлш түлэх техникийн шаардлага хангахгүй байгаа, гуравт, борлуулалтын цэгүүд хэт олширсноор түүнд тавих хяналт алдагдсан, дөрөвт, нийслэлд шилжин ирж, гэр хороололд суурьшигсдын тоо буурахгүй байгаагаас түлшний хэрэглээ улам өссөн. Ийнхүү шахмал түлшний хэрэглээ огцом нэмэгдэж байгаагаас 2021-2022

⁷ Сайжруулсан зуухны үнийн хөнгөлөлтөд 2010-2012 онд хэрэгжсэн МСС-ийн “Цэвэр агаар” төслөөс нийт 33.0 сая ам.доллар, 2012-2016 онд хэрэгжсэн Дэлхийн банкны санхүүжилттэй “УБ цэвэр агаар” төслөөс 4.5 сая ам.доллар, Цэвэр агаарын сангаас 2011-2015 онд нийт 32.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

⁸ Б.Пүрэвсүрэн: Баянхошуу, Хайлааст, Дамбадаржаа гэсэн гурван хэсэгт агаарын бохирдол буурахгүй байна. Эх сурвалж: <https://ikon.mn/n/2egp>

оны өвлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдол эрс нэмэгдэж өмнөх хоёр жилд нийслэлчүүдийн хүрсэн багахан амжилтыг үгүй хийж орхисон гэхэд болно.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 2025 он гэхэд 2016 оны суурь түвшнээс 80 хувиар бууруулах том зорилтыг биелүүлэхийн тулд сайжруулсан шахмал түлш болон түүнийг түлэх зориулалтын сайжруулсан зуухыг ашиглах нь хамгийн ойрын шийдэл хэвээр байх болно. Үүний тулд үйлдвэрлэж буй түлшний чанарыг тогтмол сайжруулах, сайжруулсан буюу стандарт зуухны хэрэглээг нэмэгдүүлэх явдал нэн чухал юм.

3.2. Гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны хөнгөлөлтийн талаар

Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд нийслэлийн гэр хорооллын айл өрхөд 2012-2015, 2017-2020 онд шөнийн цагаар цахилгаан эрчим хүчний үнийг тэглэх, хөнгөлөх зэргээр нийт 55.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлжээ. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн 31.5 мянга буюу 23 хувь нь цахилгаанаар халаалтаа шийдсэн, 105.6 мянга буюу 77 хувь нь цахилгаан халаагуургүй байгаа бөгөөд нийт хөнгөлөлтөд хамрагдсан цахилгааны хэрэглээний 55 хувийг цахилгаан халаагууртай буюу тарифын хөнгөлөлтөд хамрагдах шаардлагатай өрхийн хэрэглээ, 45 хувийг цахилгаан халаагуургүй өрхийн хэрэглээ эзэлж байсан байна. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт хийсэн аудитын тайланд агаарын чанарын бүсэд хамаарах гэр хорооллын зорилтот айл өрхүүд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтөд хамрагдаж чадаагүй байж болохыг дурдсан.

Энхцолмон нар (2016)-ын хийсэн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогын хувилбаруудын зардал үр ашгийн шинжилгээгээр Улаанбаатар хотын гэр хорооллын бүх айл өрх цахилгаан эрчим хүч ашиглан халаалтаа шийдэх нь агаарын бохирдлыг бууруулах бодитой хувилбар биш гэдгийг харуулсан. Гэхдээ гэр хороололд, ялангуяа Улаанбаатар хотын төвийн ойр орчмын хороололд цахилгаан халаалтын шийдлийг богино хугацаанд үргэлжлүүлэх нь зүйтэй.

3.3. Гэр хорооллын айл өрхийг орон сууцжуулах хөтөлбөрийн талаар

Нийслэлийн гэр хороололд буй 200 мянган айл өрхийн нэг орчим хувь нь өөрсдөө бие даасан байдлаар цахилгаан, дулаан, бохирын дэд бүтцээ шийдсэн байдаг. Харин төрөөс бодлогоор гэр хорооллыг дахин төлөвлөх хүрээнд 25 байршилд 74 хэсэгчилсэн талбайд орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэх, эдгээрийн инженерийн шугам сүлжээг шийдвэрлэх үүрэг хүлээсэн бөгөөд энэ нь гэр хорооллын 26 хувийг хамарч байгаа юм. 2013 оны сүүлээр эхэлсэн тус хөтөлбөрийн дүнд одоогийн байдлаар 5200 айлын орон сууц баригдаад байна.

Урьдчилгаа төлбөр бүрдүүлэх, өрхийн орлого банкны шалгуурт тэнцэхгүй байх зэрэг шалтгаанаар гэр хорооллын иргэд орон сууцанд шууд шилжих боломжгүй байдаг. 2021 онд ипотекийн зээлд хамрагдсан өрхүүдийн 30 хувь нь гэр хорооллын иргэд байсан. Ипотекийн зээлийг 2030 он хүртэл идэвхтэй хэрэгжүүллээ гэхэд Улаанбаатар хотын гэр хороололд оршин суух 200 мянган өрхийг бүрэн хамруулах боломжгүй. Гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах замаар агаарын бохирдлыг бууруулах нь урт хугацаанд хэрэгжих шийдэл тул агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаа, арга хэмжээний үр нөлөөт байдлыг үндэслэн гэр хорооллын иргэдийн амьжиргааны түвшин, санхүүгийн эх үүсвэр, дэмжлэгтэй уялдуулан ойрын болон хэтийн

төлөвлөгөөг үндэслэн төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар, үр дүнг тооцож болохоор, бодлоготойгоор хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

3.4. Санхүүгийн хөшүүрэг, ногоон зээлийн талаар

Агаарын бохирдлыг бууруулах дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд асар их хэмжээний хөрөнгө төсөв, санхүүжилт шаардлагатай. Хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон хөгжлийг дэмжих зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам Монголын банкуудын холбоо, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага хооронд Монгол Улсын ногоон зээлийн санг байгуулах санамж бичгийг 2017 онд байгуулсан. Энэ хүрээнд Засгийн газар, арилжааны банкууд, Уур амьсгалын ногоон сан олон улсын байгууллагын оролцоотой Монголын ногоон санхүүгийн корпорац байгуулах ажил явагдаж байгаа. Ногоон хөгжлийг дэмжих урт хугацааны хөнгөлөлттэй хүүтэй тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бий болсноор хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, агаарын бохирдлыг бууруулах бодлого, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

Ногоон санхүүжилтийн өөр нэг эх үүсвэр бол Засгийн газар, БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороогоор дамжуулан арилжааны банкуудтай хамтран 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн «Ногоон зээл» хөтөлбөр юм. Энэ зээл нь агаар орчны бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд гэр хорооллын айл өрхийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр цахилгаан халаагуур худалдан авах, гэр, байшин сууцаа дулаалах, эко ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлэх зорилготой. 2021 оны жилийн эцсийн байдлаар тус хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар, олон улсын санхүүжилт, банкны эх үүсвэрээс нийт 256,028.7 сая төгрөгийн зээл олгогдоод байгаагаас агаарын чанарыг сайжруулах чиглэлээр 892 сая төгрөгийн зээл гарсан.

Цаашид зөвхөн улсын төсөв, олон улсын зээл тусламжийн төслүүдээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх боломжгүй тул энэ мэтчилэн хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, санхүүгийн хөшүүргүүдийг түлхүү ашигласнаар агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр, зорилтуудыг урт хугацаанд тогтвортой санхүүжүүлэх боломжтой болно.

Дөрөв. Дүгнэлт

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 2008 оноос хойш олон арга хэмжээнүүдийг Засгийн газраас авч хэрэгжүүлснээр эерэг үр дүн багагүй гарсан ч агаарын бохирдлын түвшин Монгол Улсын үндэсний стандарт болон ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээнээс олон дахин их хэвээр байна. Улмаар агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө ноцтой хэмжээнд байсаар байна.

Газарзүйн байршил, цаг агаарын өвөрмөц төлөв байдлаас шалтгаалан өвлийн цагт Улаанбаатар хотод ямар ч түлш түлсэн бохирдуулагч бодисууд нь агаарт урт хугацаанд тогтвортой орших тул зөвхөн сайжруулсан түлшээр агаарын бохирдлыг дорвитой бууруулах боломжгүй. Тиймээс бохирдуулагч эх үүсвэрүүдийг багасгах, нэмж бий болгохгүй байхад анхаарч, тэр чиглэлд хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг эрчимжүүлж урт хугацаанд тогтвортой арга хэмжээ авах нь зүйтэй.

Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо хэмжээ, ялгарлын сүүлийн үеийн тооллого одоогоор байхгүй байна. Улаанбаатар хотод ажиллаж байгаа бага, дунд оврын усан

халаалтын зуухуудын яндангийн тоог цөөлж байгаа ч гэр хорооллын айл өрхүүдийн тоо дорвитой буурахгүй хэвээр байна. Орон сууцжуулах, гэр хорооллын газрын дахин төлөвлөлт хөтөлбөрүүд үргэлжилж байгаа ч эдгээр нь богино хугацаанд үр дүн нь гарахгүй бөгөөд нөгөө талаас нийслэлд шилжин ирж гэр хороололд суурьшигчдын тоо буурахгүй байгаа тул дорвитой үр дүнд хүрэхгүй байна.

Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хамгийн сүүлийн үеийн тооллого, түүнийг хувилбарт дүн шинжилгээний анализад ашиглах талаар шинжлэх ухааны өргөн хүрээтэй судалгаа, шинжилгээ дутагдаж байна. Түүнчлэн агаарын бохирдлын эх үүсвэрүүд, тэдгээрийн химийн найрлага (тогтвортой болон цацраг идэвхит изотопууд зэрэг)-ыг илүү тодорхой болгох, эх үүсвэрийн хувь нэмрийг тодорхойлох, загварчлалын судалгаатай хослуулах зэргээр ахисан түвшний судалгаа шинжилгээг хөгжүүлэх нь шийдвэр гаргагчдад бохирдлыг бууруулах, хянах талаар бодлогын цар хүрээг тодорхойлох, илүү оновчтой арга хэмжээ авахад тустай.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээрх өмнөх төсөл, санаачилгууд төлөвлөлтийн уялдаа холбоогүй байдал, хэрэгжүүлэлт хангалтгүй, засаглал, менежмент сул байснаас төдийлөн амжилт олоогүй. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр одоо хэрэгжиж буй гол бодлого болох АОББҮХ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилт 9.8 их наяд төгрөг, үүний 80 гаруй хувь нь агаарын бохирдлыг бууруулахад шууд холбоотой арга хэмжээнд зарцуулагдах тооцоотой. 2025 он хүртэл үргэлжлэх тус хөтөлбөрийн хэрэгжилт тун хангалтгүй байгаа нь өмнөх туршлагаасаа сургамж аваагүй, дахин давтсаар байгааг илтгэнэ. Үлдсэн хугацаанд тус хөтөлбөрийн үйл ажиллагаа болон зорилтуудын хоорондын нягт уялдаа холбоог хангаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэх, бодит үр дүнд хүрэх санхүүжилтийг бүрдүүлэх талаас анхаарах нь зүйтэй.

Иргэдийг хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин ирэхийг 2017-2020 онд хязгаарласан нийслэлийн засаг даргын захирамж төдийлөн үр дүнд хүрээгүй. Цаашид хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, нийгэм, эдийн засгийн суурь нөхцөлүүдийг өөрчлөхгүйгээр захиргааны шийдвэрээр хүн амын шилжилт хөдөлгөөнийг хориглох боломжгүйг анхаарч хүн ам, нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг яаралтай батлан хэрэгжүүлэх шаардлагатай.

-
1. Аудитын Ерөнхий Газар (АЕГ). (2018). *Цэвэр агаарын сангийн аудитын тайлан*. Улаанбаатар.
 2. Bayasgalan, B., Matsumoto, T., Altangerel, O. (2018). On-board measurement and emission prediction from vehicle engines using ordinary fuel and fuel additives in Mongolia. *Journal of JSCE*(6), 118–126.
 3. Enkhtsolmon. нар. (2016). Cost Benefit Analysis of Air Pollution Abatement Options in the Ger Area, Ulaanbaatar, and Health Benefits Using Contingent Valuation. *International*

Journal of Environmental Science and Development.

4. Ganbat, G and Baik, J.J. (2016). Wintertime winds in and around the Ulaanbaatar metropolitan area in the presence of a temperature inversion. *Asia-Pac. J. Atmos. Sci.*, 52, 309-325.
5. Gantuya G, Soyol-Erdene Ts, Batbayar J. (2020). Recent improvement in particulate matter (PM) pollution in Ulaanbaatar, Mongolia. *Aerosol and Air Quality Research*(20), 2280-2288.
6. Japan International Cooperation Agency (JICA). (2013). *Capacity development project for air pollution control in Ulaanbaatar city Mongolia*. Japan International Cooperation Agency.
7. Japan International Cooperation Agency (JICA). (2017). *Capacity Development Project for Air Pollution Control in Ulaanbaatar City Phase 2 in Mongolia*. Ulaanbaatar.
8. Soyol-Erdene Ts, Gantuya G, Barkhasragchaa B,. (2021). Urban air quality studies in Mongolia: Pollution characteristics and future research needs. *Aerosol and Air Quality Research*, 21(12), 1-22.
9. Дэлхийн банк. (2011). *Air Quality in Ulaanbaatar: Improving air quality to reduce health impacts of air pollution*. Washington, DC: World Bank.
10. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ). (2019 йил 25-10). *ОХУ-ын лабораторид шинжлүүлсэн сайжруулсан түлш стандартын шаардлага хангаж байна*. Retrieved from Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар: <http://home.inspection.gov.mn/news/295/single/1975>
11. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. (2018). *НҮБХХ, 2018. Монгол Улс дахь агаарын бохирдол ба хэтийн боломж, төсвийн зарлагын шинжилгээний тайлан*.
12. НҮБ-ын Хүүхдийн сан. (2016). *Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам*.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙ

Стратегийн судалгааны хүрээлэнгээс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (ҮАБҮБ)-д үнэлгээ хийж буй ажилтай уялдуулан ҮАБҮБ-ын хууль, эрх зүйн үндэслэлийг тодотгох, зорилготой дугуй ширээний хэлэлцүүлгийг 2022 оны хоёрдугаар сарын 24-ний өдөр зохион байгуулав.



Хэлэлцүүлэгт хуульч, академич С.Нарангэрэл, Аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал, эрх зүйч О.Машбат нар үндсэн илтгэл тавьж, аюулгүй байдлын болон эрх зүйн тэргүүлэх судлаач нар оролцож, санал бодлоо нээлттэй солилцлоо. Хэлэлцүүлгийн гол зорилго нь онол, практикийн хувьд маргаантай үндсэн хоёр асуудлаар тэргүүлэх судлаачдын байр суурийг сонсох, зөвлөлдөхөд оршсон юм. Үүнд:

1. “ҮАБҮБ баримт бичгийн төрөл, эрэмбийн тухай”
2. “ҮАБҮБ-ын өөрчлөлтийн хэм хэмжээний тухай”

Хэлэлцүүлгийн зочдын бүрэлдэхүүнд Д.Мягмар (хошууч генерал), Р.Болд (ССХ-ийн зөвлөх), С.Төмөр-Очир (ССХ-ийн зөвлөх), Д.Чимэд-Юндэн (хошууч генерал), Н.Жалбажав (хошууч генерал), О.Үржин (хошууч генерал, БХЭШХ), Ч.Эрдэнэчулуун (хурандаа), Б.Эрдэнэчимэг (хурандаа, БХЭШХ), Б.Бат-Эрдэнэ (цагдаагийн хурандаа, ДХИС-ийн дэд захирал), Т.Очирбат (цагдаагийн хурандаа, ДХИС-ийн багш), С.Сүхбаатар доктор (Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ЭНБД), Б.Өнөмөнх (Хуульчдын холбооны ерөнхийлөгч), Д.Баярхүү (судлаач, нийтлэлч) нар болон Стратеги судалгааны хүрээлэнгийн удирдлага, судлаачид оролцов.

Энэхүү хэлэлцүүлэг нь ҮАБҮБ-ын төрөл, эрэмбэ, өөрчлөлтийн тухай маргааныг тасалж, эцсийн дүгнэлтийг хийхгүй бөгөөд судлаачдын байр суурь, онолын үндэслэлийг танилцуулах зорилго агуулсан болно.

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар дотоодод авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, цаашдын төлөв, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам зэрэг асуудлаар мэдээлэл, санал солилцохоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэлэлцүүлгийг УАБЗ-ийн Стратеги Судалгааны хүрээлэнд 2022 оны гуравдугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа.



Үндсэн итгэлийг БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн н. Чулуунбаатар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө сэдвээр, Эрдэнэс Таван Толгой ХК-ийн “Тэрбум мод”-ны төслийн ахлах мэргэжилтэн Б. Оргил “Сая тонн-сая мод” сэдвээр танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Тус хэлэлцүүлэгт Монгол Улсын Ерөнхий сайдын Байгаль орчин, ногоон бодлогын зөвлөх М.Бадамлянхуа, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ц.Чулуунбаатар, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал, доктор И.Түвшинтогтох, МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн багш, доктор С.Гэрэлбаатар, “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн “Тэрбум мод”-ны төслийн ахлах мэргэжилтэн Б.Оргил, “Оюу Толгой” ХК-ийн Биологийн олон янз байдлын ахлах мэргэжилтэн Т.Самданжигмэд, тус компанийн гадаад харилцааны зөвлөх Б. Ренчинпагма, “Mining Insight” сэтгүүлийн ерөнхий эрхлэгч Н.Ариунтуяа болон ССХ-ийн шинжээчид оролцов.